



ЭДИЙН ЗАСАГ
ХӨГЖЛИЙН ЯАМ

ADB

ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ЭМХЭТГЭЛ

2026



ЭДИЙН ЗАСАГ
ХӨГЖЛИЙН ЯАМ



ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ЭМХЭТГЭЛ

Улаанбаатар 2026

ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН ЭМХЭТГЭЛ

Хянасан:

Т.Баясгалан, Э.Ган-Эрдэнэ

Бэлтгэсэн:

Д.Мөнхбат

Хаяг: Эдийн засаг, хөгжлийн яам, Чингэлтэй дүүрэг,
Ж.Самбуугийн гудамж Засгийн газрын XI байр,
Улаанбаатар хот 15141, Монгол Улс

Суурин утас: +976 51261583

Азийн хөгжлийн банкны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тогтолцоо, хууль эрх зүйн орчныг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх техник туслалцааны төслийн санхүүжилтээр хэвлүүлэв.

Улаанбаатар 2026 он

I. ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

» Нэгдүгээр бүлэг: Нийтлэг үндэслэл.....	5
» Хоёрдугаар бүлэг: Түншлэлийн талаарх төрийн байгууллагын бүрэн эрх.....	10
» Гуравдугаар бүлэг: Түншлэлийн төрөл, түншлэлийн төслийн төлөвлөлт, бэлтгэл ажиллагаа болон тавих шаардлага.....	17
» Дөрөвдүгээр бүлэг: Түншлэлийн төслийг зарлах, хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах.....	27
» Тавдугаар бүлэг: Түншлэгч талуудын чиг үүрэг, эрсдэлийн удирдлага, түншлэлийн баталгаа, дэмжлэг.....	32
» Зургадугаар бүлэг: Түншлэлийн гэрээ.....	35
» Долдугаар бүлэг: Түншлэлийн төслийг хэрэгжүүлэх.....	44
» Наймдугаар бүлэг: Түншлэлийн төсөл хөгжүүлэх сан, түншлэлийн ил тод байдал, тайлагналт, хяналт.....	50
» Есдүгээр бүлэг: Бусад зүйл.....	55

II. ТҮНШЛЭЛИЙН ЖУРАМ АРГАЧЛАЛ..... 57

» Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам.....	61
1. Төслийн мэдээлэл, танилцуулга.....	68
2. Санхүү, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ.....	75
» Хувийн хэвшлийн түншлэгчийг болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам, жишиг баримт бичиг.....	83
» Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулах журам.....	89
» Түншлэлийн хүрээнд эрсдэл тооцоолох, хуваарилах аргачлал.....	98
» Түншлэлийн төслийн хэрэгжилт, санхүүжилт, зохион байгуулалт, тайлагналт болон хяналт тавих журам.....	102
» Түншлэлийн төсөл хөгжүүлэх санг удирдах, түүний хөрөнгийг захиран зарцуулах, эх үүсвэрийг бүрдүүлэх болон зарцуулалтад хяналт тавих журам.....	112
» Маргаан шийдвэрлэх зөвлөл.....	118
» Маргаан шийдвэрлэх зөвлөлийн ажиллах журам.....	119
» Түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, засгийн газрын баталгаа гаргах журам.....	125
1. Засгийн газрын үүргийн баталгааны загвар.....	129
2. Бараа, ажил, үйлчилгээг худалдан авах, олон нийтийн хэрэгцээнд ашиглах, хэрэглэх баталгааны загвар.....	130

- » Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээг хянах болон түншлэлийн гэрээ байгуулах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад санал, дүгнэлт гаргах журам..... 134

III. АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТӨСЛИЙН ХҮРЭЭНД МӨРДӨХ ЖУРАМ 137

- » Түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээ, бүрэн шижилгээ хийх журам..... 141
 - 1. Төслийн мэдээлэл, танилцуулга..... 146
 - 2. Санхүү, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ хийх аргачлал 154
- » Хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах журам..... 163
 - 1. Төслийн саналыг үнэлэх заавар 169
 - 2. Хувийн хэвшлийн түншлэгчийг сонгох сонгон шалгаруулалтын урилга..... 174
- » Зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам 211
- » Түншлэлийн гэрээ байгуулах, хэлэлцээ хийж сонгон шалгаруулалтгүй гэрээ байгуулах журам..... 215
- » Түншлэлийн төслийн хэрэгжилт, санхүүжилт, зохион байгуулалт, тайлагналт болон хяналт тавих журам..... 222



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 12 сарын 09 өдөр

Улаанбаатар хот

ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ТУХАЙ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийг хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг дэмжих, төр, хувийн хэвшил эрсдэлийн оновчтой удирдлагад суурилан түншлэлийн гэрээний дагуу урт хугацаанд үр ашигтай хамтран ажиллах болон санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд оршино.

2 дугаар зүйл.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хууль тогтоомж

2.1.Төр, хувийн хэвшлийн түншлэл /цаашид "түншлэл" гэх/-ийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт төр, хувийн хэвшил хамтран хэрэгжүүлэх түншлэлийн төслийг төлөвлөх, боловсруулах, үнэлэх, судлан шинжилсний үндсэн дээр төслийг сонгох, хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах, түншлэлийн гэрээг байгуулах болон хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцаанд үйлчилнэ.

3.2.Энэ хуульд заасан түншлэлд дараах үйл ажиллагаа хамаарахгүй:

3.2.1.батлан хамгаалах салбарын үйл ажиллагаа;

3.2.2.банк, санхүүгийн зах зээлийн бүх төрлийн үйлчилгээ, үйл ажиллагаа;

3.2.3.уул уурхайн салбарын дэд бүтцээр дамжуулан олон нийтэд үйлчилгээ үзүүлэхээс бусад ашиг олох зорилготой ашигт малтмал эрэх, хайх, олборлох, ашиглах үйл ажиллагаа;

3.2.4.хуулиар хориглосон бусад үйл ажиллагаа.

3.3.Түншлэлийн төсвийн удирдлага, санхүүжилт, тайлагналт болон болзошгүй өр төлбөрийн хяналттай холбоотой энэ хуульд зааснаас бусад асуудлыг Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хуулиар зохицуулна.

3.4.Түншлэлийн зүйлийн эзэмших, ашиглах, өмчлөх эрх нь шилжсэн, шинээр бий болсон хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг улсын бүртгэлд бүртгэх, төрийн болон орон нутгийн өмчид авахтай холбогдсон харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулиар зохицуулна.

3.5.Түншлэлийн хүрээнд бусдын эзэмшил газрыг нөхөх олговортой солих буюу эргүүлэн авах асуудлыг Газрын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.

3.6.Түншлэлийн хүрээнд ил тод байдлыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг энэ хууль болон Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар зохицуулна.

3.7.Түншлэлийн хүрээнд түншлэлийн төсөл хэрэгжүүлэгч хувийн хэвшлийн түншлэгч болон зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах, сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг энэ хуульд зааснаар зохицуулах бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн зохицуулалт хамаарахгүй.

4 дүгээр зүйл.Түншлэлийн зарчим

4.1.Түншлэлд дараах зарчмыг баримтална:

4.1.1.түншлэлийн төсөл нь нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт хэрэгжүүлэх, олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн, олон нийтэд үйлчлэх зорилгыг дэмжсэн байх;

4.1.2.төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, төсөв, санхүүгийн удирдлагад хяналт, зохицуулалтын тэнцвэрийг хангаж, хувийн хэвшилд суурилсан эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн байх;

4.1.3.түншлэл нь төр, хувийн хэвшлийн хооронд эрх, үүргийг тодорхойлж, эрсдэлийг оновчтой хуваарилах, сайн засаглалын зарчимд тулгуурлах, урт хугацаанд төсвийн зардлыг чанар, үр дүн, гүйцэтгэлд үндэслэн хуваарилах, төрийн үйлчилгээг хангах санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэх;

4.1.4.түншлэлд бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, үр ашигтай байдал болон хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн, урт хугацаанд гарах зардлын хэмнэлттэй хувилбарыг сонгон хэрэгжүүлэх;

4.1.5.хувийн хэвшлийн түншлэгчийн сонгон шалгаруулалтыг шударга, эрх тэгш, ил тод, өрсөлдөөнд суурилсан, нээлттэй, үр дүнтэй, хариуцлагатайгаар зохион байгуулж, сонгон шалгаруулалтын бүх үе шатны явц, үр дүнг нийтэд нээлттэй мэдээлж байх;

4.1.6.хувийн хэвшлийн түншлэгчийн сонгон шалгаруулалт нь энэ хууль болон холбогдох бусад журам, аргачлалд бүрэн нийцсэн байх;

4.1.7.төслийг түншлэлээр хэрэгжүүлэх эсэх шийдвэрт төсөвт үзүүлэх эрсдэлийг үнэлж, тогтоох, түншлэлийн төслийн хэрэгжилтийн явцад санхүүжилтийн гүйцэтгэлийн хяналтыг тогтмол хэрэгжүүлдэг байх;

4.1.8.түншлэл нь хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт, оролцоог дэмжих, төсөв, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх, урт хугацаанд тогтвортой байх;

4.1.9.түншлэлийн төсөл нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлсэн, ногоон эдийн засгийн хөгжлийг дэмжсэн байх.

Тайлбар: "Ногоон эдийн засаг" гэж байгаль орчны эрсдэл, доройтлыг багасгахын зэрэгцээ хүний сайн сайхан байдал, нийгмийн тэгш хүртээмжтэй байдлыг сайжруулах зорилго бүхий эдийн засгийг ойлгоно.

5 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1."барилга байгууламж" гэж энэ хуулийн хамрах хүрээнд хэрэгжих Барилгын тухай хуулийн 4.1.1-д заасныг;

5.1.2."болзошгүй өр төлбөр" гэж Төсвийн тухай хуулийн 4.1.48-д заасныг;

5.1.3."Засгийн газрын өрийн баталгаа" гэж Өрийн удирдлагын тухай хуулийн 4.1.7-д заасныг;

5.1.4."төрөөс үзүүлэх дэмжлэг" гэж түншлэлд Засгийн газраас болон аймаг, нийслэл нь энэ хуульд заасны дагуу зөвшөөрөл, хөрөнгө болон газрын асуудлыг шийдвэрлэх, төрд төлөх хураамж, төлбөрийг бууруулах, эсхүл чөлөөлөх, тусгайлан тодорхойлсон нөхцөл байдал үүссэн тохиолдолд татварын болон татварын бус бусад нөхцөлөөр үзүүлэх хөнгөлөлт, дэмжлэгийг;

Энэ заалтад 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан бөгөөд 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө ./

5.1.5."Засгийн газрын зөвшөөрөл" гэж түншлэлийн хүрээнд холбогдох хууль тогтоомжийн дагуу төрийн байгууллагаас олгох шаардлагатай зөвшөөрөл, лиценз, тусгай зөвшөөрөл, бүртгэлийг;

5.1.6."санхүүжүүлэгч" гэж хувийн хэвшлийн түншлэгчид төсөл хэрэгжүүлэхтэй холбогдуулан зээл олгож байгаа болон түншлэлийн төсөлд санхүүгийн баталгаа гаргах, санхүүгийн бусад дэмжлэг үзүүлж байгаа хувьцаа эзэмшигчээс бусад банк, санхүүгийн байгууллагыг;

5.1.7."инноваци" гэж Инновацийн тухай хуулийн 3.1.1-д заасныг;

5.1.8."нийтийн зориулалттай дэд бүтэц" гэж нийтэд зориулсан төрийн үйлчилгээний барилга байгууламж, авто зам, төмөр зам, дүүжин зам, газрын дээр, доор байрлах замын байгууламж, бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтээц бүхий байгууламжийг;

5.1.9."мөнгөний үнэ цэн" гэж түншлэлийн төслийн хэрэгжилтийн бүх үе шатанд төслийн нийт өртгөөр төслийн үйлчилгээг чанар, хүртээмж, үр ашиг, өгөөжтэй байх хувилбарыг тогтоохыг;

5.1.10."санхүүгийн чадавхад нийцсэн" гэж түншлэлийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээнд хэрэглэгчээс авах хураамж, төсвөөс санхүүжүүлэх санхүүжилт нь хэрэглэгчийн болон төсвийн чадавхад нийцсэн байх, төсвийн хувьд зардал болон болзошгүй өр төлбөрийг орлогоос шийдвэрлэх боломжтой байхыг;

5.1.11."төр, хувийн хэвшлийн түншлэл" гэж хувийн хэвшлийн түншлэгч нь төрийн түншлэгчтэй байгуулсан түншлэлийн гэрээний дагуу нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээг олон нийтэд, төрийн түншлэгчид урт хугацаанд үзүүлэх, түншлэгч талууд эрсдэлийг оновчтой хуваарилах, түншлэлийн төлбөрийг түншлэлийн төрлөөс хамаарч санхүүжүүлэн хэрэгжүүлэх замаар төслийг урт хугацаанд тогтвортой, үр ашигтай хэрэгжүүлэх хамтын ажиллагааг;

5.1.12."төрийн түншлэгч" гэж түншлэлийн гэрээг хэрэгжүүлэх тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, энэ хуулийн 13.2-т заасан түншлэлийн төслийн хувьд аймаг, нийслэлийн Засаг дарга болон түншлэлийн гэрээнд заасны дагуу энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан бусад этгээдийг;

[/Энэ заалтад 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

5.1.13."төрийн үйлчилгээ" гэж иргэдийн ая тухтай амьдрах таатай орчныг бүрдүүлэх зорилгоор дэд бүтэц, эрчим хүч, зам, тээвэр, эрүүл мэнд, боловсрол, соёл болон холбогдох бусад салбарт төрөөс иргэдэд тэгш, чанартай, үр ашигтай, хууль тогтоомж, стандартын дагуу үзүүлж байгаа олон нийтэд зориулсан үйлчилгээг;

5.1.14."төсөвт үзүүлэх нөлөө" гэж төслийг хэрэгжүүлэхэд төсөв, санхүүд үзүүлэх нөлөөллийг тооцох, шууд болон шууд бус байдлаар төлбөрийн үүрэг хариуцлагыг бий болгох болзошгүй нөхцөл байдлыг;

5.1.15."төсвийн эрсдэлийн үнэлгээ" гэж түншлэлийн төслийн төсөвт үзүүлэх нөлөө, болзошгүй өр төлбөрийг тооцсон төсвийн эрсдэлийг энэ хуулийн 9.2-т заасан загварын дагуу тооцож, судлах дүн шинжилгээг;

5.1.16."Түншлэлийн төсөл хөгжүүлэх сан" гэж төслийн урьдчилсан үнэлгээ, төслийн бүрэн шинжилгээ, түншлэлийн эх төсөл боловсруулах болон төсөвт үзүүлэх нөлөөллийн тооцоо, шинжилгээ хийхэд мэргэжлийн зөвлөх үйлчилгээ авах, төслийн бэлтгэл ажил, төлөвлөлт, сонгон шалгаруулалт, хэрэгжилт, хяналт, тайлагналттай холбогдон гарах зардлыг санхүүжүүлэх зорилгоор хуульд заасан эх үүсвэрээр бүрдүүлсэн түншлэлийн санг;

5.1.17."төслийн баримт бичиг" гэж түншлэлийн гэрээ, барилгын гэрээ, ханган нийлүүлэх гэрээ, худалдан авах ажиллагааны баталгааны гэрээ, үйлчилгээний гэрээ болон бусад дагалдах гэрээ, барилга, ашиглалт, эрх бүхий байгууллагатай байгуулсан техник хяналтын гэрээ, засвар үйлчилгээ болон төслийн удирдлагатай холбоотой бүх баримт бичгийг;

5.1.18."төслийн орлого" гэж хэрэглэгчийн төлбөр, хураамж болон түншлэлийн гэрээний хүрээнд бий болсон төслийн орлогын эх үүсвэрийг;

5.1.19."тусгай зориулалтын компани" гэж түншлэлийн гэрээний хүрээнд хувийн хэвшлийн түншлэгчийн үүргийг хүлээж, түншлэлийн төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтаар хувийн хэвшлийн түншлэгчээс үүсгэн байгуулсан төслийн компанийг;

5.1.20."түншлэлийн гэрээ" гэж төрийн болон хувийн хэвшлийн түншлэгч талуудын хооронд түншлэлийн төслийг хэрэгжүүлэхээр харилцан тохиролцож, талуудын эрх, үүрэг болон холбогдох бусад асуудлыг тодорхойлж байгуулсан иргэний эрх зүйн гэрээг;

5.1.21."түншлэлийн зүйл" гэж түншлэлийн гэрээнд хамаарах эд хөрөнгийн эрх, ажил, үйлчилгээний үр дүн, хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг;

5.1.22."түншлэлийн төсөл" гэж нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт нийтийн хэрэгцээ, шаардлагыг хангах зорилгоор хувийн хэвшлийн түншлэгч хөрөнгө оруулалт хийх, зураг төсөл боловсруулах, дэд бүтцийн барилга, байгууламжийг барих, санхүүжүүлэх, сэргээн босгох, сайжруулах, засвар арчлалт хийх, төрийн үйлчилгээг үзүүлэх, төрийн үйлчилгээний удирдлагыг хариуцах зэрэг үйл ажиллагааг багтаасан нийтэд чиглэсэн төслийг;

5.1.23."түншлэлийн эх төсөл" гэж түншлэлийн төслийн хувьд нийтийн зориулалттай дэд бүтэц, барилга байгууламж, нийгмийн суурь үйлчилгээг түншлэлээр үзүүлэхэд шаардагдах техник, эдийн засаг, санхүү, хууль, эрх зүй, нийгэм болон байгаль орчны үндэслэл, нотолгоо, тоон баримт зэргийг тусгасан төслийн баримт бичгийг;

5.1.24."түншлэлийн үе шат" гэж түншлэлийн төслийн урьдчилсан болон тохиромжтой байдлын үнэлгээ хийх, техник, эдийн засгийн үндэслэл болон түншлэлийн эх төсөл боловсруулах, түншлэлийн төслийг тодорхойлох, хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах, түншлэлийн гэрээг байгуулах, гэрээний удирдлагыг хангах, төслийг хэрэгжүүлэх буюу гэрээний дагуу нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээг үзүүлэх, төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, мониторинг хийх, төслийн үйл ажиллагаа болон үр дүнд аудит хийх, тайлагнах, хувийн хэвшлийн түншлэгч түншлэлээс гарах, дэд бүтцийг төрийн түншлэгчид шилжүүлэх зэрэг түншлэлийн төслийн төлөвлөлт, хэрэгжилтийн бүх үе шатыг;

[/Энэ заалтад 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

5.1.25."хөгжлийн бодлогын баримт бичиг" гэж Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг;

5.1.26."хувийн хэвшлийн түншлэгч" гэж төрийн түншлэгчтэй түншлэлийн гэрээ байгуулж, энэ хуульд заасан түншлэлийн төслийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Компанийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан гадаад, дотоодын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд болон хуулийн этгээдийн нэгдлийг;

5.1.27."хувийн хэвшлээс төсөл санаачлах" гэж нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт түншлэлийн үндсэн дээр хэрэгжүүлэхээр хувийн хэвшлээс энэ хуульд заасны дагуу санаачилсан төслийн саналыг;

5.1.28."хэрэглэгчийн төлбөр" гэж нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээг ашигласны төлөө хэрэглэгчээс төлөх төлбөр, хураамжийг;

5.1.29."эрсдэлийн шинжилгээ" гэж энэ хуульд заасан аргачлалын дагуу тухайн төслийн санхүү, хууль, нийгэм, байгаль орчин болон төсөвт үзүүлэх нөлөөлөл, тооцох үнэлгээ, шинжилгээг;

5.1.30."төслийн бүрэн шинжилгээ" гэж түншлэлээр хэрэгжүүлэх төслийн эдийн

засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл болон төслийн эрсдэлийг тооцох, түншлэлийн төрөл, төсөл хэрэгжих хэлбэр, хугацааг тодорхойлох зорилгоор энэ хуулийн 20.4-т заасан шинжилгээг;

5.1.31."Засгийн газрын баталгаа" гэж түншлэлийн төслийг урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэх зорилгоор энэ хуулийн 31 дүгээр зүйлд заасан Засгийн газрын хүлээсэн үүргийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТҮНШЛЭЛИЙН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮРЭН ЭРХ

6 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх

6.1.Улсын Их Хурал түншлэлийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, тухайн жилийн төсвийн төслийг батлахдаа энэ хуулийн 13.2-т зааснаас бусад түншлэлийн зорилт, арга хэмжээг хэлэлцэж, хамт батлах;

[Энэ заалтад 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан.](#)

6.1.2.Түншлэлийн төслийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлан мэдээллийг нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлантай хамт хэлэлцэх, хэрэгжилтэд хяналт тавих, чиглэл өгөх.

7 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

7.1.Засгийн газар түншлэлийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.энэ хуульд заасан төслийн бүрэн шинжилгээ хийгдсэн түншлэлээр хэрэгжүүлэх төслийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

7.1.2.хуульд өөрөөр заагаагүй бол түншлэлийг хэрэгжүүлэх нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбар, чиглэлийг батлах;

[Энэ заалтад 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан.](#)

7.1.3.түншлэлд төрөөс үзүүлэх дэмжлэг, Засгийн газрын баталгааны асуудлыг энэ хуульд заасны дагуу шийдвэрлэх;

7.1.4.түншлэлийн төслийг урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авах, чиглэл өгөх;

7.1.5.энэ хуулийн 13.2-т зааснаас бусад түншлэлийн гэрээ байгуулах эрх олгох;

[Энэ заалтад 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан ./](#)

7.1.6.түншлэлийн тухай хууль тогтоомж, түншлэлийн хэрэгжилт, үр дүн, гэрээний биелэлтийн явцад төслийн эрсдэл болон төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх тайланг хэлэлцэж, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлантай хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

7.1.7.түншлэлийг хэрэгжүүлэхэд хэрэглэгчийн төлбөрийг бодит зардалд нийцүүлэх зорилгоор хувийн хэвшлийн түншлэгчтэй тохиролцсоны дагуу зарим салбарт үнийн зохицуулалт хийх.

7.2.Засгийн газар түншлэлийн хүрээнд дараах журам, аргачлалыг баталж, мөрдүүлнэ:

7.2.1.түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам;

7.2.2.хувийн хэвшлийн түншлэгчийг болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам, жишиг баримт бичиг;

7.2.3.түншлэлийн гэрээ байгуулах журам, гэрээний стандарт загвар, гэрээний иж бүрдэл баримт бичиг;

7.2.4.түншлэлийн хүрээнд эрсдэл тооцоолох, хуваарилах аргачлал;

7.2.5.түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд энэ хуульд заасныг баримтлан төрөөс дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын баталгаа гаргах журам;

7.2.6.түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээг хянах болон түншлэлийн гэрээ байгуулах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад санал, дүгнэлт гаргах журам;

[Энэ заалтад 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан.](#)

7.2.7.түншлэлийн төслийн хэрэгжилт, санхүүжилт, зохион байгуулалт, тайлагналт болон хяналт тавих журам.

7.2.8.энэ хуулийн 13.3-т заасан журам.

[Энэ заалтыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн .](#)

7.3.Засгийн газар төр болон хувийн хэвшил хоорондын үр дүнтэй, тогтвортой түншлэлийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, төрийн байгууллагын хамтын ажиллагааг хангаж ажиллана.

8 дугаар зүйл.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

8.1.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 13.2-т зааснаас бусад түншлэлийн хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

[Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан.](#)

8.1.1.түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналд хийсэн урьдчилсан үнэлгээг хянан баталгаажуулах;

[Энэ заалтад 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан.](#)

8.1.2.урьдчилсан үнэлгээ хийсэн, түншлэлээр хэрэгжүүлэх төслийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах;

8.1.3.энэ хуулийн 20.4-т заасан төслийн бүрэн шинжилгээг хянаж, санал, дүгнэлт гарган, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал, дүгнэлтийн хамт Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;

[Энэ заалтыг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан.](#)

8.1.4.Түншлэлийн төсөл хөгжүүлэх санг удирдах, сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авах, төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг төсвийн төсөлд тусгуулах санал хүргүүлэх;

8.1.5.хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах болон түншлэлийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах;

8.1.6.түншлэлийн гэрээний хэлэлцээрт оролцох, түншлэлийн гэрээг төрийн түншлэгч талыг төлөөлж салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран байгуулах;

8.1.7.төр болон хувийн хэвшил хоорондын үр дүнтэй, тогтвортой түншлэлийн орчныг бэхжүүлэх, түншлэлийг хөгжүүлэх, түншлэлийн төсөлтэй холбогдуулан мэргэжил, арга зүйн дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

8.1.8.түншлэлийн хууль тогтоомж, түншлэлийн төслийн хэрэгжилт, гэрээний биелэлтийн талаарх жилийн тайланг боловсруулж, Засгийн газарт жил бүр танилцуулах;

8.1.9.хувийн хэвшлийн түншлэгчийг болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам, жишиг баримт бичгийг боловсруулах;

8.1.10.түншлэлийн гэрээ байгуулах журам, гэрээний стандарт загвар, гэрээний иж бүрдэл баримт бичгийг боловсруулах;

8.1.11.түншлэлийн хүрээнд эрсдэл тооцоолох, хуваарилах аргачлалыг боловсруулах;

8.1.12.түншлэлийн төслийн хэрэгжилт, санхүүжилт, зохион байгуулалт, тайлагналт болон хяналт тавих журмыг боловсруулах;

8.1.13.түншлэлийн талаарх мэдээлэл, сурталчилгааг Түншлэлийн төвтэй хамтран зохион байгуулах, түншлэлийн ил тод байдлыг хангах, түншлэлийн төслийн талаарх мэдээллийг энэ хуульд зааснаар олон нийтэд хүргэх;

8.1.14.түншлэлийн төсөлд бүрэн шинжилгээ хийх төслийн багийг Түншлэлийн төв дээр тулгуурлан энэ хуульд зааснаар байгуулах;

8.1.15.хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах, түншлэлийн гэрээний хэлэлцээрт оролцох чиг үүргийг хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтын ажлын хэсгийг энэ хуульд зааснаар байгуулах;

8.1.16.түншлэлийн гэрээ байгуулах болон түншлэлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж санал, дүгнэлт авах;

/Энэ заалтад 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

8.1.17.түншлэлийн дагуу бий болсон болон түншлэлд хамаарах аливаа хөрөнгийг түншлэлийн гэрээ, энэ хууль болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчид шилжүүлэх, бүртгэх арга хэмжээг зохион байгуулах;

8.1.18.түншлэлийн хууль тогтоомжийн хэрэгжилт, гэрээний биелэлтийг хангах, хяналт тавих.

8.2.Түншлэлийн төслийн санал хүлээн авах, бүртгэх, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг цахим системээр гүйцэтгэх бөгөөд холбогдох журмыг түншлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

/Энэ хэсгийг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

9 дүгээр зүйл. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

9.1. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 13.2-т зааснаас бусад түншлэлийн хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

9.1.1. түншлэлээр хэрэгжүүлэх төслийн төсвийн эрсдэлийн үнэлгээг хянах, тухайн төслийг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр болон төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийн талаар дүгнэлт гаргах;

9.1.2. түншлэлийн гэрээний төрлөөс хамаарч гэрээний дагуу төсвөөс санхүүжүүлэх санхүүжилтийг хэрэгжилт, гүйцэтгэлийн үнэлгээнд үндэслэн төсвийн төсөлд тусгах, төслийн санхүүжилтийг төсөвтэй уялдуулах;

9.1.3. түншлэлийн төслийн бүрэн шинжилгээнд үндэслэн түншлэлийн гэрээний хүрээнд төрөөс үзүүлэх дэмжлэгийн төрөл, Засгийн газрын өрийн баталгаа, нөхөх олговор, төсвийн эрсдэл, санхүүгийн чадавхын асуудал болон Засгийн газрын өрийн хэмжээнд үзүүлэх нөлөөллийг тооцож, дүгнэлт гаргах;

9.1.4. түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээнд үндэслэн төсвийн эрсдэл, төсөвт үзүүлэх нөлөөлөл болон хөрөнгийн эх үүсвэрийг хянаж, энэ хуулийн 14.1.1-д заасан түншлэлийн төрөлд санал, дүгнэлт, 14.1.2, 14.1.3-т заасан түншлэлийн төрөлд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл өгөх, зөвшөөрөхгүй тохиолдолд үндэслэл, тайлбарыг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

/Энэ хэсгийг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

9.1.5. түншлэлийн гэрээний төсөлтэй танилцаж, төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийн тооцоо, шинжилгээг хянах, түншлэлийн гэрээ байгуулах болон түншлэлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад санал, дүгнэлтээ түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

/Энэ заалтыг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

9.1.6. түншлэлийн төслийн хүрээнд тухайн жилийн болон түншлэлийн төслийн нийт хугацаанд хүлээсэн санхүүгийн болон төлбөрийн нийт үүргийг хянах, төсвийн төлбөрийн үүрэг бүхий түншлэлийн гэрээний хэлэлцээрт оролцох, дүгнэлт гаргах, түншлэлийн төслийн төсвийн төлөвлөлт, зардал, эрсдэлтэй холбоотой асуудлаар холбогдох төрийн байгууллагатай хамтран ажиллах, шаардлагатай мэдээллийг гаргуулж авах;

9.1.7. түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд энэ хуульд заасныг баримтлан төрөөс дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын баталгаа гаргах журмыг боловсруулах;

9.1.8. түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээг хянах болон түншлэлийн гэрээ байгуулах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад санал, дүгнэлт гаргах журмыг боловсруулах.

/Энэ заалтад 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

9.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн түншлэлийн төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл тооцох загварыг баталж, мөрдүүлнэ.

10 дугаар зүйл.Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

10.1.Энэ хуулийн 13.2-т зааснаас бусад түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

/Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

10.1.1.түншлэлээр хэрэгжүүлэх төслийн санал гаргах;

10.1.2.түншлэлээр хэрэгжүүлэх төсөлд урьдчилсан үнэлгээ хийх;

10.1.3.урьдчилсан үнэлгээний тайланг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

10.1.4.аймаг, нийслэл болон хувийн хэвслээс санаачилсан төслийн саналыг хүлээн авах, энэ хуульд зааснаар урьдчилсан үнэлгээ хийх, тухайн төслийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжийг тодорхойлох, дүгнэлт гаргах;

/Энэ заалтад 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

10.1.5.урьдчилсан үнэлгээ нь хянан баталгаажсан төслийн саналыг хөгжлийн бодлогын баримт бичигт тусгуулах;

10.1.6.түншлэлийн төсөлд бүрэн шинжилгээ хийх төслийн багийн бүрэлдэхүүнд ажиллах, төслийн багтай хамтран бүрэн шинжилгээ хийх;

10.1.7.хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллах болон түншлэлийн гэрээний хэлэлцээрт оролцох;

10.1.8.хувийн хэвшлийн түншлэгчтэй төрийн түншлэгч талыг төлөөлж түншлэлийн гэрээг энэ хуульд зааснаар байгуулах;

10.1.9.түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд төрийн түншлэгчийн чиг үүргийг энэ хууль болон гэрээнд зааснаар хэрэгжүүлэх, төслийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах;

10.1.10.түншлэлийн төслийн хэрэгжилт, гэрээний биелэлтийн талаарх жил бүрийн тайланг бэлтгэх, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

10.1.11.түншлэлийн хууль тогтоомжийн хэрэгжилт, гэрээний биелэлтийг хангах, хэрэгжилтэд хяналт тавих;

10.1.12.түншлэлийн төслийн дэлгэрэнгүй мэдээлэл, төслийн баримт бичиг, түншлэлийн гэрээ, санхүүжилтийн талаарх мэдээллийг түншлэлийн мэдээллийн нэгдсэн санд оруулах, олон нийтэд мэдээлэх, ил тод байдлыг хангах;

10.1.13.түншлэлийн төсөлд оролцогчид шаардагдах мэдээлэл, сонгон шалгаруулалтад бүрдүүлэх баримт бичиг, заавар, маягт, түншлэлийн гэрээний стандарт маягт, холбогдох мэдээллийг цахим хуудсанд байршуулах, олон нийтэд ил тод, тогтмол, хүртээмжтэй хүргэх, мэдээлэх.

11 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын бүрэн эрх

11.1. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал түншлэлийн хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1. түншлэлийн хууль тогтоомж, тухайн орон нутагт түншлэлээр хэрэгжүүлэх төслийн түншлэлийн гэрээний биелэлтэд хяналт тавих;

11.1.2. тухайн орон нутагт түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналыг Засаг даргын өргөн мэдүүлснээр хэлэлцэх;

11.1.3. тухайн орон нутагт түншлэлээр хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилтийг дэмжиж, хамтран ажиллах.

11.1.4. энэ хуулийн 13.2-т заасан түншлэлээр хэрэгжүүлэх төслийн жагсаалт батлах; [/Энэ заалтыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

11.1.5. энэ хуулийн 13.2-т заасан түншлэлээр хэрэгжүүлэх төслийн түншлэлийн гэрээ байгуулах эрхийг аймаг, нийслэлийн Засаг даргад олгох;

[/Энэ заалтыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

11.1.6. аймаг, нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, тухайн жилийн орон нутгийн төсвийн төслийг батлахдаа орон нутагт хэрэгжүүлэх түншлэлийн зорилт, арга хэмжээг хэлэлцэж, батлах;

[/Энэ заалтыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

11.1.7. түншлэлийн төслийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлан мэдээллийг орон нутгийн төсвийн гүйцэтгэлтэй хамт хэлэлцэх;

[/Энэ заалтыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

11.1.8. энэ хуулийн 32 дугаар зүйлд заасан дэмжлэгийг үзүүлэх.

[/Энэ заалтыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

11.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга түншлэлийн хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.2.1. тухайн орон нутагт түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналыг боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх;

11.2.2. энэ хуулийн 13.2.1, 13.2.2, 13.2.3, 13.2.4, 13.2.5, 13.2.6-д зааснаас бусад салбарт хэрэгжүүлэх 100 тэрбум төгрөгөөс дээш өртөгтэй түншлэлийн төслийн саналаа Түншлэлийн төвд хүргүүлэх;

[/Энэ заалтыг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

11.2.3. тухайн орон нутагт түншлэлээр хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилтийг хангах, түншлэгч талуудад дэмжлэг үзүүлэх, хамтарч ажиллах, түншлэлийн гэрээний биелэлтэд энэ хууль болон түншлэлийн гэрээнд заасны дагуу хяналт тавих;

11.2.4. төслийн бүрэн шинжилгээ хийх төслийн багийн бүрэлдэхүүнд болон түншлэлийн гэрээний хэлэлцээрт оролцох, түншлэлийн гэрээг төрийн түншлэгч талыг төлөөлж түншлэлийн болон салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран байгуулах;

11.2.5.түншлэлээр бий болсон болон түншлэлд хамаарах аливаа хөрөнгийг түншлэлийн гэрээ, энэ хууль, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу орон нутгийн өмчид шилжүүлэх, бүртгэх.

11.2.6.энэ хуулийн 13.2-т заасан төслийн түншлэлийн болон зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, төслийн хэрэгжилтэд хяналт тавих;

[/Энэ заалтыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

11.2.7.энэ хуулийн 32 дугаар зүйлд заасан дэмжлэгийг үзүүлэх;

[/Энэ заалтыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

11.2.8.түншлэлийн хууль тогтоомж, түншлэлийн төслийн хэрэгжилт, гэрээний биелэлтийг орон нутгийн төсвийн гүйцэтгэлтэй хамт аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх.

[/Энэ заалтыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

11.3.Энэ хуулийн 13.3-т заасан журмыг аймгийн саналыг авсны үндсэн дээр Нийслэлийн Засаг дарга боловсруулна.

[/Энэ хэсгийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

12 дугаар зүйл.Түншлэлийн төв, түүний чиг үүрэг

12.1.Түншлэлийн төвийг Засгийн газрын шийдвэрээр түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд байгуулна.

12.2.Түншлэлийн төв түншлэлийн хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

12.2.1.түншлэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төр болон хувийн хэвшил хоорондын үр дүнтэй, тогтвортой түншлэлийг хэрэгжүүлж, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

12.2.2.салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл болон хувийн хэвшлээс санаачилсан төслийн саналыг хүлээн авах, түншлэгч талуудад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

[/Энэ заалтыг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

12.2.3.түншлэлээр хэрэгжүүлэх төслийн урьдчилсан үнэлгээ, бүрэн шинжилгээ, техник, эдийн засгийн үндэслэл, эрсдэлийн шинжилгээ, үнэлгээг төрийн түншлэгч болон мэргэжлийн зөвлөх, төслийн багтай хамтран боловсруулах;

[/Энэ заалтад 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

12.2.4.энэ хуулийн 12.2.3-т заасан судалгаа, шинжилгээний үр дүнг салбарын болон түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулж, төслийг үнэлж, түншлэлээр хэрэгжүүлэхэд тохиромжтой эсэхийг шийдвэрлэхэд шаардлагатай мэдээллээр хангах;

12.2.5.түншлэлийн төслийн боломжийг тодорхойлж, хувийн хэвшлийн оролцоо, чадамж, сонирхлыг тандан судлах, хөрөнгө оруулагч болон бусад сонирхогч талуудад зориулсан танилцуулгыг боловсруулах;

12.2.6.судалгаа, шинжилгээ, үнэлгээ хийхэд мэргэжлийн шинжээч болон зөвлөхийн үйлчилгээ авах, гэрээ байгуулах;

12.2.7.хувийн хэвшлээс санаачилсан төсөлд тухайн хувийн хэвшлийн санхүүжилтээр төсөлд шаардлагатай дүн шинжилгээ хийж, үр дүнг салбарын болон түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах;

12.2.8.түншлэлээр хэрэгжүүлэх төслийн төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцоход санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах, мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;

12.2.9.энэ хуулийн 49.3-т заасан журмын дагуу сангийн эх үүсвэрийг Түншлэлийн төсөл хөгжүүлэх санд төвлөрүүлэх;

12.2.10.төслийн хэрэгжилтийн санхүүгийн болон эрсдэлийн хяналт шинжилгээг тайлагнах;

12.2.11.түншлэлийн төсөлд шаардлагатай мэдээлэл, журам, сонгон шалгаруулалтад бүрдүүлэх баримт бичиг, зааварчилгаа, маягт, түншлэлийн жишиг гэрээний загвар, түншлэлд оролцогч этгээдэд шаардлагатай холбогдох баримт бичгийг боловсруулах, мэдээллийг түншлэлийн мэдээллийн нэгдсэн санд тогтмол байршуулах, олон нийтэд ил тод, хүртээмжтэй хүргэх.

12.3.Түншлэлийн төв нь аж ахуйн тооцоот төрийн өмчит үйлдвэрийн газар байх бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасны дагуу Засгийн газар байгуулж, дүрмийг батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ТҮНШЛЭЛИЙН ТӨРӨЛ, ТҮНШЛЭЛИЙН ТӨСЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ, БЭЛТГЭЛ АЖИЛЛАГАА БОЛОН ТАВИХ ШААРДЛАГА

13 дугаар зүйл.Түншлэлийг хэрэгжүүлэх салбар

13.1.Түншлэлийг энэ хуулийн 3.2-т зааснаас бусад салбарт хэрэгжүүлэх нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбар, чиглэлийг энэ хуулийн 7.1.2-т зааснаар Засгийн газар батална.

13.2.Аймаг, нийслэл дараах салбарт түншлэлийн төслийг хэрэгжүүлж болно:

[/Энэ хэсгийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

[/Энэ хэсгийг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

13.2.1.эрчим хүч, дулаан хангамж;

[/Энэ заалтыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

13.2.2.хог хаягдлын менежмент;

[/Энэ заалтыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

13.2.3.гадаргын ус, саарал усны барилга байгууламж, менежмент;

[/Энэ заалтыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

13.2.4.цэвэр, бохир усны шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж;

[/Энэ заалтыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

13.2.5.хурдны зам, багтаамж ихтэй нийтийн тээвэр, тээвэр логистикийн төв;

[/Энэ заалтыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

13.2.6.хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах барилга байгууламж;

[/Энэ заалтыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн /](#)

13.2.7.100 тэрбум төгрөг болон түүнээс доош өртөгтэй төсөл.

[/Энэ заалтыг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

13.3.Энэ хуулийн 13.2-т заасан түншлэлийн төслийн хувьд хувийн хэвшлээс санаачлах, төсөлд урьдчилсан үнэлгээ болон бүрэн шинжилгээ хийх, үнэлэх, төслийг тодорхойлж, хэрэгжүүлэх шийдвэр гаргах, хувийн хэвшлийн түншлэгч болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах, түншлэлийн гэрээ байгуулах, хэлэлцээ хийж сонгон шалгаруулалтгүй гэрээ байгуулах, түншлэлийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, гэрээний биелэлт, төслийн хэрэгжилт, санхүүжилт, зохион байгуулалт, тайлагналт болон хяналт тавихтай холбогдсон журмыг Засгийн газар батлах бөгөөд журмын дагуу түншлэлийн төслийг хэрэгжүүлнэ.

[/Энэ хэсгийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн ./](#)

14 дүгээр зүйл.Түншлэлийн төрөл

13.4.Аймаг, нийслэл энэ хуулийн 14.1.2, 14.1.3-т заасан төсвөөс санхүүжүүлэх түншлэлийн төрлөөр хэрэгжүүлэх төслийн хөрөнгийн эх үүсвэр, төсөвт үзүүлэх нөлөөлөл, төсвийн эрсдэлийн талаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлийг, энэ хуулийн 14.1.1-д заасан түншлэлийн төрөлд санал, дүгнэлтийг авна.

[/Энэ хэсгийг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

14.1.Түншлэлийг санхүүжилтийн хэлбэрээс нь хамааран дараах гурван төрлөөр хэрэгжүүлнэ:

14.1.1.түншлэлийн төслийн зардлыг хэрэглэгчийн төлбөр, хураамж болон төслийн орлогоор санхүүжүүлэх;

14.1.2.түншлэлийн төслийн зардлыг түншлэлийн гэрээнд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх;

14.1.3.энэ хуулийн 14.1.1, 14.1.2-т заасны дагуу холимог төрөл.

14.2.Энэ хуулийн 14.1.1-д зааснаар хувийн хэвшлийн түншлэгчээс түншлэлийн төслийн зардлыг тухайн төслийн нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний хэрэглэгчийн төлбөр, хураамж болон төслийн орлогоор гэрээнд заасны дагуу санхүүжүүлж, хэрэгжүүлнэ.

14.3.Энэ хуулийн 14.1.2-т зааснаар хувийн хэвшлийн түншлэгчийн түншлэлийн төслийн зардлыг тухайн төслийн үр ашиг, үйлчилгээний чанар, хүртээмж, гүйцэтгэлийн үнэлгээ, төлбөрийн хуваарьт үндэслэн төсвөөс санхүүжүүлж, хэрэгжүүлнэ.

14.4.Түншлэлийн төслийн бүрэн шинжилгээний дүгнэлтээр хэрэглэгчийн төлбөр, хураамжаар төслийн зардлыг дангаар санхүүжүүлэх боломжгүй, тодорхой хэсгийг төсвөөс зайлшгүй санхүүжүүлэх шаардлагатай нь тогтоогдсон тохиолдолд энэ хуулийн 14.1.3-т заасан төрлийг хэрэгжүүлж болно.

14.5.Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ, төслийн үйл ажиллагаа, онцлогоос хамаарч энэ хуулийн 14.1-д заасан түншлэлийн төрлийг түншлэгч талуудын хооронд байгуулах түншлэлийн гэрээгээр тодорхойлно.

15 дугаар зүйл.Түншлэлийн төслийг хэрэгжүүлэх түншлэлийн гэрээний төрөл

15.1.Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн онцлогоос хамаарч түншлэлийн гэрээ дараах төрөлтэй байна:

15.1.1.зураг төсөл, төсвийг боловсруулах, барих, ашиглах, шилжүүлэх;

15.1.2.барих, ашиглах, шилжүүлэх;

15.1.3.барих, шилжүүлэх, ашиглах;

15.1.4.барих, түрээслэх, ашиглах, шилжүүлэх;

15.1.5.барих, өмчлөх, ашиглах, шилжүүлэх;

15.1.6.түрээслэх болон түрээслүүлж төрийн үйлчилгээг үзүүлэх;

15.1.7.ашиглалт болон засвар арчлалтыг хэрэгжүүлэх;

15.1.8.сэргээн засварлах, эзэмших, ашиглах, шилжүүлэх;

15.1.9.удирдлагыг хэрэгжүүлэх;

15.1.10.төслийн бүрэн шинжилгээгээр тодорхойлсон түншлэлийн гэрээний бусад төрлүүд.

15.2.Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ, төслийн үйл ажиллагаа, онцлогоос хамаарч энэ хуулийн 15.1-д заасан гэрээний төрлийг түншлэгч талуудын хооронд байгуулах түншлэлийн гэрээгээр тодорхойлно.

15.3.Энэ хуулийн хүрээнд "барих-шилжүүлэх" төрлөөр барьж байгуулаад шууд шилжүүлэх нөхцөлтэй, богино хугацаанд хэрэгжүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтаас үл ялгагдах төрлийн гэрээг байгуулах болон түншлэлээр хэрэгжүүлэхийг хориглоно.

16 дугаар зүйл.Түншлэгч талууд

16.1.Дараах этгээд төрийн түншлэгч байна:

16.1.1.Монгол Улсын яам;

16.1.2.аймаг, нийслэлийн Засаг дарга;

16.1.3.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээд.

16.2.Хувийн хэвшлийн түншлэгч нь энэ хуулийн 5.1.26-д заасан этгээд байна.

17 дугаар зүйл.Түншлэлийн төслийн үе шат

17.1.Түншлэлийн төсөл дараах үе шаттай байна:

17.1.1.төслийг төлөвлөх буюу төслийг түншлэлээр хэрэгжүүлэх эсэхийг судлан шинжлэх үе шат:

17.1.1.а.түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээ хийх;

17.1.1.б.урьдчилсан үнэлгээний дүгнэлтэд үндэслэн түншлэлээр хэрэгжүүлэх төслийг хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах.

17.1.2. түншлэлийн төсөлд бүрэн шинжилгээг хийх, үнэлэх үе шат:

[/Энэ заалтад 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

17.1.2.а.түншлэлийн төслийн дүн шинжилгээг хийх;

17.1.2.б.түншлэлийн төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах;

[/Энэ заалтад 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

17.1.2.в.түншлэлийн эх төслийг боловсруулах;

17.1.2.г.түншлэлийн төслийн эрсдэлийг судалж тодорхойлох.

17.1.3.түншлэлийн төслийг тодорхойлж, хэрэгжүүлэх шийдвэр гаргах;

17.1.4.хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах;

17.1.5.хэлэлцээр хийж, түншлэлийн гэрээ байгуулах;

17.1.6.түншлэлийн төслийг хэрэгжүүлэх, гэрээний удирдлагыг хангах төслийн хэрэгжилтийн үе шат;

17.1.7.түншлэлийн төслийн хэрэгжилтийн хяналт, үнэлгээ, мониторингийг хэрэгжүүлэх;

17.1.8.түншлэлийн гэрээ дуусгавар болох, түншлэлийн зүйлийг төрийн болон орон нутгийн өмчид авах, бүртгэх.

18 дугаар зүйл.Түншлэлийн төсөлд тавих шаардлага

18.1.Түншлэлийн төсөл нь хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг, бүсчилсэн хөгжлийн бодлого болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн байна:

[/Энэ хэсгийг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

18.1.1.энэ хуульд заасан үнэлгээ, шинжилгээ, судалгаагаар төсөл нь нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт түншлэлээр хэрэгжүүлэхэд тохиромжтой болох нь тодорхойлогдсон байх;

18.1.2.хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичиг, бүсчилсэн хөгжлийн бодлого болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн байх;

18.1.3.хөгжлийн тэргүүлэх ач холбогдолтой төсөл байх, энэ хуульд заасан түншлэлийн төрөл, хэлбэрт нийцэж байх;

18.1.4.хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтад үндэслэн дэд бүтцийг байгуулах, засвар үйлчилгээ үзүүлэх, нийтэд зориулсан төрийн үйлчилгээг гүйцэтгүүлэх замаар

төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, инноваци, шинэ технологийг нэвтрүүлэх боломжтой байх;

18.1.5.байгаль орчинд сөрөг нөлөөгүй, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад чиглэсэн, ногоон эдийн засгийн хөгжлийг дэмжсэн байх;

18.1.6.тухайн төслийн хувьд хөрөнгө оруулагч болон санхүүжүүлэгч талууд төслийг хэрэгжүүлэх сонирхолтой болохыг зах зээлийн судалгаагаар тогтоосон, өрсөлдөөнт шалгаруулалт явуулах нь тодорхой болсон байх.

18.2.Түншлэлийн гэрээ байгуулж, хэрэгжүүлэх төсөл нь дараах шаардлагыг хангасан байна:

/Энэ хэсэгт 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

18.2.1.төслийн төсөв, санхүүгийн үнэлгээ, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан байх;

/Энэ заалтад 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

18.2.2.төслийн хэмжигдэхүйц зорилтод үндэслэн төслийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон байх;

18.2.3.хууль зүйн дүн шинжилгээ, нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн шинжилгээ хийгдэж баталгаажсан байх;

18.2.4.төслийн бүрэн шинжилгээгээр түншлэлийн төслийн хүрээнд олон нийтэд үзүүлэх төрийн үйлчилгээ нь холбогдох стандартын шаардлагыг хангасан байх;

18.2.5.техникийн шаардлага, төслийн орц, гарц болон хүрэх үр дүнг тодорхойлсон байх;

18.2.6.хувийн хэвшлийн түншлэгчийн гэрээний дагуу гүйцэтгэх төслийн үйл ажиллагаа, арга хэмжээ, хамрах хүрээг тогтоосон байх;

18.2.7.төслийн үйл ажиллагаанд шаардлагатай Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу олгогдох тусгай болон энгийн зөвшөөрлийг тодорхойлсон байх;

18.2.8.төслийн эрсдэлийг үнэлж, гэрээний хүрээнд эрсдэлийг бууруулах арга хэмжээг тодорхойлсон байх;

18.2.9.төсөл хэрэгжүүлэхэд төрөөс үзүүлэх шаардлагатай дэмжлэгийн төрөл, хэлбэрийг тодорхойлсон байх;

18.2.10.төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийн тооцоо, шинжилгээ нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянагдсан байх;

18.2.11.төсөл хэрэгжих хугацаанд хувийн хэвшлийн түншлэгчийн үйл ажиллагаа, хэрэгжилт, гүйцэтгэлд гэрээний дагуу хяналт тавих, үнэлэх асуудлыг тусгасан байх;

18.2.12.түншлэлийн гэрээг байгуулахаас өмнө хувийн хэвшлийн түншлэгчтэй гэрээний хэлэлцээр хийж, гол нөхцөлийг харилцан тохиролцсон байх;

18.2.13.төслийн нийт зардлыг тухайн төслийн үе шатны бүх зардлыг оролцуулан нэгдсэн дүнгээр тодорхойлсон байх;

18.2.14.түншлэлийн төслийн дагуу үзүүлж байгаа төрийн үйлчилгээ нь нийтэд зориулсан, төлбөр нь зах зээлийн үнэтэй уялдсан, бүртгэл хийх боломжтой байх;

18.2.15.байгаль орчинд ээлтэй, инноваци, шинэ технологийг нэвтрүүлсэн байх;

/Энэ заалтад 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./

18.2.16.түншлэлийн өмчлөлийн зүйлийг зохистой удирдах зорилгоор түншлэлийн гэрээ болон төслийн баримт бичигт тавигдсан бусад шаардлагыг хангах.

18.3.Энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй төслийг түншлэлээр хэрэгжүүлэхийг хориглоно.

18.4.Энэ хуулийн 5.1.13-т заасан төрийн үйлчилгээ үзүүлэх төслөөс хамааран техник, эдийн засгийн үндэслэл шаардахгүй бөгөөд мөнгөний үнэ цэнийн шинжилгээ, төсөвт үзүүлэх нөлөөллийн шинжилгээ, эрсдэлийн шинжилгээ, хууль зүйн дүн шинжилгээ болон нийгмийн нөлөөллийн шинжилгээг хийж болно.

[/Энэ хэсгийг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн./](#)

19 дүгээр зүйл.Түншлэлийн төслийн төлөвлөлт, урьдчилсан үнэлгээ

19.1.Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл болон хувийн хэвшлээс энэ хуульд заасан нөхцөл, шаардлагад нийцсэн төслийг түншлэлээр хэрэгжүүлэх санал гаргах эрхтэй.

19.2.Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналыг түншлэлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхэд тохиромжтой эсэхийг урьдчилсан үнэлгээгээр тогтооно.

19.3.Энэ хуулийн 19.1-д заасан төслийн саналыг хүлээн авснаас хойш салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Түншлэлийн төв хамтран урьдчилсан үнэлгээг 30 хоногийн дотор хийж, дүгнэлтийг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

19.4.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянасан түншлэлээр хэрэгжүүлэх төслийг хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах асуудлыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан цаглаврын дагуу хэрэгжүүлнэ.

[/Энэ хэсэгт 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

19.5.Энэ хуульд заасны дагуу урьдчилсан үнэлгээ хийгдээгүй төслийг түншлэлийн бүрэн шинжилгээнд хамруулахыг хориглоно.

[/Энэ хэсэгт 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

20 дугаар зүйл.Түншлэлийн төслийн бүрэн шинжилгээ

20.1.түншлэлээр хэрэгжүүлэх төслийн үр ашиг, ач холбогдлыг нарийвчлан судалж тогтоох, хэрэгжүүлэх боломжийн талаар дүгнэлт гаргах, түншлэлийн төрөл, төслийг хэрэгжүүлэх гэрээний төрөл, хэлбэрийг тодорхойлох зорилгоор төслийн бүрэн шинжилгээг хийнэ.

[/Энэ хэсэгт 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

20.2.Түншлэлийн төв болон салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төслийн бүрэн шинжилгээ хийх төслийн багийг Түншлэлийн төвийн дэргэд хамтран байгуулах бөгөөд бүрэн шинжилгээ хийх хугацааг холбогдох журамд заасан байна.

[/Энэ хэсэгт 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

20.3.Энэ хуулийн 20.2-т заасан төслийн багийн бүрэлдэхүүнд түншлэлийн болон салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түншлэлийн төслөөс

хамааран холбогдох төрийн байгууллага, төсөл хэрэгжих аймаг, нийслэлийн төлөөлөл байх бөгөөд шаардлагатай бол төслийн багийн бүрэлдэхүүнд санхүү, эдийн засаг, хууль, эрх зүй, нийгэм, байгаль орчин болон холбогдох бусад салбарын үндэсний, олон улсын мэргэжлийн судлаач, зөвлөх, хөндлөнгийн хараат бус зөвлөх гишүүн оруулж болно.

/Энэ хэсгийг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./

20.4.Төслийн баг холбогдох аргачлал, журмын дагуу дараах байдлаар тухайн төслийн хэрэгцээ, шаардлага, санхүү, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл, санхүүгийн болон бусад нөөц, боломжийг бүрэн шинжилгээгээр тодорхойлж дүгнэлт гаргана:

20.4.1.мөнгөний үнэ цэнийн шинжилгээг хийх;

20.4.2. техник, эдийн засгийн үндэслэл;

/Энэ заалтад 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

20.4.3.түншлэлийн гэрээний төрөл, загвар, гол нөхцөл, төсөлд тавигдах шаардлагыг хангасан эсэх үнэлгээ;

20.4.4.хууль зүйн дүн шинжилгээ, нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн шинжилгээ;

20.4.5.төслийн эрсдэл, түүнийг бууруулах арга хэмжээг тодорхойлсон эрсдэлийн шинжилгээний дүгнэлт;

20.4.6.төслийг хэрэгжүүлэх түншлэлийн төрөл, гэрээний хэлбэр, төсөл хэрэгжих хугацаа;

20.4.7.тухайн төсөлд шаардлагатай төрөөс үзүүлэх дэмжлэгийн төрөл.

20.5.Төслийн баг түншлэлээр хэрэгжүүлэхээр санал болгосон төслийн түншлэлийн эх төслийг боловсруулна.

20.6.Энэ хуулийн 7.2.4, 9.2-т заасан аргачлал, загвар, 20.4-т заасан эрсдэлийн шинжилгээний дүгнэлтийн дагуу түншлэлээр хэрэгжүүлэх төслийн эрсдэлийг үнэлэх, хуваарилах, бууруулах, хянах зэрэг эрсдэлийн удирдлагын арга хэмжээг төлөвлөсөн байна.

20.7.Төслийн баг төслийн төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийг тооцохдоо санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах ба энэ хуулийн 9.2-т заасан загварын дагуу төслийн төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийг болон түншлэлийн гэрээний дагуу төсөвт шууд болон шууд бус төлбөрийн үүрэг, хариуцлагыг бий болгох эсэхийг тооцно.

20.8.Төслийн баг түншлэлийн төсөл нь төсвийн эрсдэлийн үнэлгээгээр өндөр эрсдэлтэй, энэ хуулийн 20.4.7-д заасан дэмжлэгийг төрөөс үзүүлэх боломжгүй гэж дүгнэсэн тохиолдолд түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналыг буцаах, хөгжлийн бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах, төслийн эх үүсвэрийг өөрчлөх талаар санал гаргана.

20.9.Төслийн баг тухайн төслийн талаар олон нийт, иргэд, төрийн болон бусад байгууллагатай хамтран хэлэлцүүлэг зохион байгуулж, саналыг авч болно.

20.10.Төслийн баг төслийн бүрэн шинжилгээний үр дүнгээс хамаарч түншлэлээр хэрэгжүүлэх зарим уялдаатай төслийг нэгтгэж нэг төсөл болгон хэрэгжүүлэх нь үр ашигтай гэж үзсэн тохиолдолд нэгтгэн хэрэгжүүлэх санал гаргаж болно.

20.11.Энэ хуулийн 20.4.2-т заасан техник, эдийн засгийн үндэслэлийг төсвийн болон хувийн хэвшлийн санхүүжилтээр боловсруулж болох бөгөөд тухайн техник, эдийн засгийн үндэслэлийг бүрэн шинжилгээ хийх шийдвэр гарахаас өмнө гурван жилийн дотор тухайн салбарын шинжлэх ухаан, технологийн, эсхүл мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж тодотгогдсон байна.

/Энэ хэсгийг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн./

21 дүгээр зүйл.Түншлэлийн төслийг тодорхойлж, шийдвэр гаргах

21.1.Түншлэлийн төслийн баг бүрэн шинжилгээгээр түншлэлээр хэрэгжүүлэхэд тохиромжтой гэж тодорхойлсон төслийг төслийн иж бүрэн баримт бичгийн хамт түншлэлийн болон салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүрэн шинжилгээ хийгдэж, дүгнэлт гарснаас хойш ажлын 5 өдөрт багтаан хүргүүлнэ.

21.2.Төслийн баг төслийн баримт бичгийн иж бүрдэлд доор дурдсан мэдээллийг тусгасан хяналтын хуудсыг хамт хүргүүлнэ:

21.2.1.энэ хуулийн 21.2-т заасан хяналтын хуудсанд төрийн түншлэгчид хамаарах дараах мэдээллийг тусгана:

21.2.1.а.санхүүгийн эх үүсвэрийн боломж, түншлэлд зөвлөгөө болон дэмжлэг үзүүлэх чадавх;

21.2.1.б.төрийн байгууллагын албан хаагч, мэргэжилтний мэдээлэл;

21.2.1.в.удирдлагын түвшинд түншлэлийг хэрэгжүүлэх сонирхол болон үзүүлэх дэмжлэгийн түвшин;

21.2.1.г.холбогдох бусад хүчин зүйл.

21.2.2.энэ хуулийн 21.2-т заасан хяналтын хуудсанд дараах түншлэлийн мэдээллийг тусгана:

21.2.2.а.төслийн мэдээлэл, танилцуулга, төсөл хэрэгжих бэлэн байдал, төслийн нийт өртөг, ашиглалтын хугацаа, хэрэгжүүлэх хуваарь;

21.2.2.б.төсөл хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага, эрсдэлийн шинжилгээ, эрсдэлийг хуваарилах санал болон бусад бүх асуудлыг тусгасан түншлэлийн эх төсөл;

21.2.2.в.түншлэлийн төрөл, төсвөөс санхүүжүүлэх санхүүжилтийн хуваарь, хэрэглэгчийн төлбөр, хураамжийн судалгаа, зардал, үр ашгийн тооцоолол, төслийн санхүүжилтийн мэдээлэл;

21.2.2.г.төслийн барилга байгууламж болон үйл ажиллагааны тодорхойлолт;

21.2.2.д.төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах төрийн байгууллага;

21.2.2.е.төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах төрөөс үзүүлэх дэмжлэгийн төрөл;

21.2.2.ё.нийгмийн хамгаалал, байгаль орчны нөлөө, жендэрийн эрх тэгш байдлыг хангах, цаг уурын эрсдэл болон сорилт, тэдгээрийг бууруулах арга хэмжээ;

21.2.2.ж.холбогдох бусад хүчин зүйл.

21.3.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түншлэлийн төслийн бүрэн шинжилгээ болон эрсдэлийн үнэлгээний тайланд үндэслэн тухайн төслийг түншлэлээр хэрэгжүүлэх саналыг Засгийн газрын шийдвэрийн төслийн хамт ажлын 15 өдөрт багтаан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

21.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн төслийн бүрэн шинжилгээний тайлан, дүгнэлт болон энэ хуульд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг ажлын 15 өдөрт багтаан түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

21.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зөвшөөрөл олгохдоо дараах тооцоо, судалгааг үндэслэл болгоно:

21.5.1.техник, эдийн засгийн үндэслэлээр батлагдсан ерөнхий нөхцөл, эрэлт, нийлүүлэлт, тариф, зах зээлийн хувьсагч үзүүлэлт, тэдгээрт хийгдсэн эрсдэлийн дүгнэлт;

[/Энэ заалтад 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

21.5.2.төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл, төрөөс үзүүлэх дэмжлэгийн хүрээнд төсөвт тусгах урсгал болон хөрөнгө оруулалтын зардал, хөнгөлөлт, тэдгээрийн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагад нийцсэн талаарх санал, дүгнэлт;

21.5.3.төрөөс үзүүлэх дэмжлэгийн хүрээнд төсөвт үзүүлэх болзошгүй өр төлбөрийн шинжилгээ, Засгийн газрын баталгаа гаргах төрөл хэлбэр, түүний Төсвийн тогтвортой байдлын тухай болон Өрийн удирдлагын тухай хуульд заасан шаардлагыг хангасан эсэх талаарх санал, дүгнэлт.

21.6.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал, дүгнэлт, зөвшөөрлийг үндэслэн түншлэлийн төслийн саналыг ажлын 5 өдөрт багтаан Засгийн газарт хүргүүлнэ.

[/Энэ хэсэгт 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

21.7.Засгийн газар энэ хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу боловсруулж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал, дүгнэлт гарсан, зөвшөөрөл олгогдсон төслийг түншлэлээр хэрэгжүүлэх эсэх шийдвэр гаргана.

[/Энэ хэсэгт 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

21.8.Түншлэлийн болон салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 21.7-д заасны дагуу батлагдсан түншлэлийн төслийг зарлах, төслийг хэрэгжүүлэх хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулна.

21.9.Хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааны хугацааг энэ хуулийн 7.2.2-т заасан сонгон шалгаруулалтын журмаар зохицуулна.

21.10.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуульд заасан төслийн бүрэн шинжилгээгээр тухайн төслийг түншлэлээр хэрэгжүүлэхэд тохиромжгүй болох нь тогтоогдсон бол төслийг төсөл санаачлагчид буцаах шийдвэр гаргана.

22 дугаар зүйл.Хувийн хэвшлээс түншлэлийн төсөл санаачлах

22.1.Нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий төслийг түншлэлээр хэрэгжүүлэхээр хувийн хэвшлээс санал гаргаж болох бөгөөд төслийн саналаа Түншлэлийн төвд хүргүүлнэ.

[/Энэ хэсэгт 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

22.2.Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хувийн хэвшлээс

гаргасан төслийн саналд урьдчилсан үнэлгээг хийж, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

/Энэ хэсгийг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./

22.3.Хувийн хэвшлээс уг төсөлтэй холбогдуулан техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, төсөл хэрэгжүүлэх зарчим, технологийн шийдлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг авч, түүнд үндэслэн тухайн төслийг түншлэлээр хэрэгжүүлэхэд тохиромжтой эсэхийг тогтоох бүрэн шинжилгээг энэ хуулийн 20.2-т заасан төслийн баг хийнэ.

/Энэ хэсэгт 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

22.4.Түншлэлийн болон салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 22.3-т зааснаар төслийн саналыг үнэлэхдээ дараах асуудлыг судалж үзнэ:

22.4.1.төсөл санаачлагчийн оюуны өмч, бизнесийн нууц болон бусад тусгай эрхийг ашиглахгүйгээр үр дүнтэй хэрэгжих боломжтой төсөл эсэх;

22.4.2.төслийг хэрэгжүүлэхэд төсвөөс аливаа төлбөрийн болон болзошгүй төлбөрийн үүрэг, хариуцлага үүсэх эсэх;

22.4.3.төслийн технологийн шийдэл нь шинэлэг эсэх.

22.5.Хувийн хэвшлээс санаачилсан төслийн саналыг үнэлэхдээ төслийн саналтай холбоотой оюуны өмч, бизнесийн нууц болон төсөл санаачлагчийн ирүүлсэн мэдээллийг зөвхөн үнэлгээ хийх албан хэрэгцээнд ашиглана.

22.6.Төсөл санаачлагч хувийн хэвшил нь төслийн саналд бүрэн шинжилгээ хийхтэй холбогдсон зардлыг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

22.7.Хувийн хэвшлээс санаачилсан төслийн саналд энэ хуульд заасан шаардлага, нөхцөл, журам нэгэн адил үйлчилнэ.

22.8.Хувийн хэвшлээс санаачилсан төслийн бүрэн шинжилгээгээр түншлэлээр хэрэгжүүлэхэд ач холбогдолгүй, үр ашиггүй гэж үзсэн бол тухайн төслийн саналыг санал гаргасан этгээдэд буцаана.

22.9.Хувийн хэвшлийн санаачилсан төсөл нь түншлэлээр хэрэгжүүлэхэд тохиромжтой болох нь тогтоогдвол тухайн төслийг хэрэгжүүлэх хувийн хэвшлийн түншлэгчийн сонгон шалгаруулалтыг энэ хуульд заасны дагуу зохион байгуулна.

22.10.Хувийн хэвшлийн төсөл санаачлагч этгээд сонгон шалгаруулалтын өрсөлдөөнд оролцохдоо бусад оролцогчийн нэгэн адил үнэлгээний шалгуурт хамаарах ба үнэлгээнд сонгон шалгаруулалтын журамд заасан давуу эрхийн оноог авах эрхтэй.

22.11.Сонгон шалгаруулалтын хугацаанд тодорхой санал ирээгүй тохиолдолд анх санал ирүүлсэн оролцогчтой хэлэлцээ хийх ба гэрээ байгуулах шийдвэрт хүрсэн тохиолдолд энэ хуульд зааснаар түншлэлийн гэрээ байгуулна.

22.12.Тухайн төсөл дэмжигдсэн эсэхээс үл хамааран энэ хуулийн 22.6-д заасан зардлыг буцаан олгохгүй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ТҮНШЛЭЛИЙН ТӨСЛИЙГ ЗАРЛАХ, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ

23 дугаар зүйл.Түншлэлийн төслийг урьдчилан зарлах

23.1.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зах зээлийн судалгаа хийх, хөрөнгө оруулалтыг татах, хувийн хэвшлийн түншлэгчийг тодорхойлох зорилгоор урьдчилсан үнэлгээ хийгдэж, хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсанаас хойш 12 хүртэлх сарын хугацаанд түншлэлийн төслүүдийг нийтэд урьдчилан зарлаж болно.

23.2.Түншлэлийн төслийг урьдчилан зарлах нь түншлэлээр хэрэгжүүлэх төслийг сонирхож байгаа олон нийтэд төслийн талаар мэдээлэл өгөх, хувийн хэвшлийн түншлэгчийн хөрөнгө оруулалтыг татах, тандан судлах зорилготой байна.

23.3.Урьдчилан зарласан түншлэлээр хэрэгжүүлэх төсөлд энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан урьдчилсан үнэлгээг зайлшгүй хийсэн байх ба энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан бүрэн шинжилгээ хийгдээгүй байж болно.

23.4.Түншлэлийн төслийг урьдчилан зарласан нь тухайн төслийг түншлэлээр хэрэгжүүлэхээр шийдвэр гарсанд тооцохгүй бөгөөд хувийн хэвшлийн түншлэгчийг сонгох сонгон шалгаруулалтыг зарлах үүрэг хүлээхгүй.

23.5.Урьдчилан зарласан түншлэлийн төслийг хэрэгжүүлэх сонирхолтой хувийн хэвшил нь энэ хуулийн 22.1-д заасны дагуу тухайн төслийг хэрэгжүүлэх сонирхлоо илэрхийлсэн саналыг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж болно.

23.6.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Түншлэлийн төвтэй хамтран түншлэлийн төслийн талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна.

24 дүгээр зүйл.Сонгон шалгаруулалт зарлах, олон нийтэд мэдээлэх

24.1.Энэ хуулийн 21.7-д заасан Засгийн газрын шийдвэрийн дагуу түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран төслийн сонгон шалгаруулалтын ажлын хэсэг /цаашид "ажлын хэсэг" гэх/-ийг тухай бүр байгуулах бөгөөд уг ажлын хэсэг түншлэлийн төслийг хэрэгжүүлэх хувийн хэвшлийн түншлэгчийг сонгох сонгон шалгаруулалт зохион байгуулна.

24.2.Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хөндлөнгийн хараат бус гишүүн оруулж болно.

[/Энэ хэсгийг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

24.3.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтын баримт бичгийг Засгийн газраас баталсан жишиг баримт бичиг, гэрээний загвар, сонгон шалгаруулалтын журам, аргачлалын дагуу боловсруулна.

24.4.Ажлын хэсэг төслийн сонгон шалгаруулалтын урилгыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын цахим хуудсанд байршуулах, сонгон шалгаруулалтын талаар танилцуулга хийх, уулзалт зохион байгуулах зэргээр олон нийтэд мэдээлэл өгөх үүрэгтэй.

24.5.Сонгон шалгаруулалт зохион байгуулахдаа оролцогчид харилцан эрх тэгш оролцох нөхцөлийг бүрдүүлж, мэдээллээр жигд хангах, шаардлага тавих, сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа ил тод байх зарчмыг баримтална.

24.6.Хувийн хэвшлийн түншлэгчийн саналыг хүлээн авах, үнэлэх үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй байх ба ажлын хэсэг сонгон шалгаруулалтын тухай мэдээллийг ил тод, нээлттэй зарлах, саадгүй олгох, өрсөлдөөний тэнцвэрийг хангах зорилгоор мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангаж ажиллана.

24.7.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хувийн хэвшлийн түншлэгчийн сонгон шалгаруулалтын үр дүнг бусад оролцогчид болон олон нийтэд нээлттэй мэдээлж, танилцуулах үүрэгтэй бөгөөд сонгон шалгаруулалтын ил тод байдлыг хангаж ажиллана.

25 дугаар зүйл.Хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах

[/Энэ зүйлийг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

25.1.Хувийн хэвшлийн түншлэгчийн шалгуур үзүүлэлтийг дараах баримт бичигт тусган сонгон шалгаруулалтын дагуу шалгаруулна:

[/Энэ хэсгийг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

25.1.1.түншлэлийн төслийн танилцуулга, төслийн ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, нийтийн зориулалттай дэд бүтцийн төслийн хувьд техник, эдийн засгийн үндэслэл, жишиг маягт, төсөл хэрэгжүүлэх төрийн түншлэгчийн талаарх мэдээлэл, тайлбар;

[/Энэ заалтыг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

25.1.2.хувийн хэвшлийн түншлэгчийн үзүүлэх үйлчилгээ, төрөөс үзүүлэх дэмжлэгийн тухай мэдээлэл;

[/Энэ заалтыг 2025 оны 11 дүгээр сарын 14 нэмэлт өөрчлөн найруулсан./](#)

25.1.3.төслийг хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн түншлэгчийн санхүү, удирдлага, хүний нөөцийн чадавх, ижил төстэй төсөл хэрэгжүүлсэн туршлага;

[/Энэ заалтыг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

25.1.4.түншлэлийн гэрээний нөхцөл;

[/Энэ заалтыг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

25.1.5.оролцогчид тавигдах шаардлага;

[/Энэ заалтыг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

25.1.6.сонгон шалгаруулах арга хэлбэр, аргачлал, оролцогчид өгөх заавар, баримт бичиг илгээх хэлбэр, хугацаа;

[/Энэ заалтыг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

25.1.7.шаардлагатай бусад баримт бичиг, мэдээлэл.

[/Энэ заалтыг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

25.2.Энэ хуулийн 24.1-д заасан ажлын хэсэг сонгон шалгаруулалтын баримт бичгийг холбогдох журмын дагуу боловсруулж, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулна.

[/Энэ хэсгийг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

25.3.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтын зарыг 30-аас доошгүй хоногийн өмнө олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

[/Энэ хэсгийг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

25.4.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтад оролцогчоос ирүүлсэн төслийн саналыг үнэлж, хамгийн сайн нөхцөлтэй саналаас эхлэн дараалуулах байдлаар сонгон шалгаруулж, шаардлага хангасан болон хангаагүй оролцогчид мэдэгдэл хүргүүлнэ.

[/Энэ хэсгийг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

25.5.Ажлын хэсэг шаардлага хангасан оролцогчтой дарааллын дагуу гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээ хийж, хувийн хэвшлийн түншлэгчийг шалгаруулна.

[/Энэ хэсгийг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

25.6.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад сонгон шалгаруулалтын үр дүнгийн талаар мэдээлж, шалгарсан оролцогчтой гэрээ байгуулах талаар санал, дүгнэлт авах хүсэлтийг хүргүүлнэ.

[/Энэ хэсгийг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

25.7.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүсэлтийг хүлээн авч, түншлэлийн гэрээ байгуулах талаар санал, дүгнэлт гаргаж, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажлын 10 өдрийн дотор хүргүүлнэ.

[/Энэ хэсгийг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

25.8.Түншлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 26.5-д заасан шийдвэрийн дагуу хувийн хэвшлийн түншлэгчтэй гэрээ байгуулж, олон нийтэд мэдээлнэ.

[Энэ хэсгийг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

25.9.Төслийн саналын баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, эсхүл бүрдэл дутуу ирүүлсэн нь оролцогчийн төслийн саналыг буцаах үндэслэл болно.

[/Энэ хэсгийг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

26 дугаар зүйл.Хувийн хэвшлийн түншлэгчийг сонгох, түншлэлийн гэрээ байгуулах шийдвэр гаргах

26.1.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 25.1-д заасан сонгон шалгаруулалтын үр дүнг тухай бүр бусад оролцогчид болон олон нийтэд нээлттэй мэдээлэх, танилцуулах үүрэгтэй.

[/Энэ хэсэгт 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

26.2.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтаар энэ хуулийн 25.5-д заасны дагуу хамгийн сайн нөхцөлтэй төслийн саналаар шалгарсан оролцогчоос эхлүүлэн хэлэлцээг хийж, үнэлгээ өгнө.

[/Энэ хэсэгт 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

26.3.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хэлэлцээний үр дүнд гэрээний нөхцөлийг хамгийн сайн харилцан тохиролцсон нэг оролцогчтой түншлэлийн гэрээ байгуулах дүгнэлт гарган, ажлын 5 өдөрт багтаан дүгнэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

26.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь сонгон шалгаруулалт, түншлэгчтэй хийсэн хэлэлцээний дүн, ажлын хэсгийн дүгнэлтийг төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийн талаас хянаж, санал, дүгнэлтийг ажлын 10 өдөрт багтаан ирүүлнэ.

[Энэ хэсэгт 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

26.5.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түншлэлийн гэрээ байгуулах тухай санал, дүгнэлтээ санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн санал, дүгнэлтийн хамт Засгийн газарт танилцуулан түншлэлийн гэрээ байгуулах эсэх шийдвэрийг гаргуулна.

[Энэ хэсгийг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

27 дугаар зүйл.Сонгон шалгаруулалтад оролцогчид тавих шаардлага

27.1.Хувийн хэвшлийн түншлэгчээр сонгон шалгаруулалтад оролцогч нь дараах үндсэн шаардлагыг хангасан байна:

27.1.1.төслийг хэрэгжүүлэх санхүүгийн чадавх, удирдлага, мэргэжлийн хүний нөөц, техник, технологийн чадвар, ажлын туршлагатай байх;

27.1.2.Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу энгийн болон тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны хувьд уг зөвшөөрлийг авах шаардлагыг хангасан байх;

27.1.3.тухайн хуулийн этгээдийг татан буулгах, дампуурлыг зарлах үйл ажиллагаа эхлээгүй, эд хөрөнгийг нь битүүмжлээгүй, үйл ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зогсоогоогүй байх;

27.1.4.сүүлийн 3 жилийн хугацаанд түншлэлийн гэрээг биелүүлээгүй тухай шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гараагүй байх;

27.1.5.хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан нь ял шийтгэлгүй, төрийн түншлэгч этгээдийн удирдах албан тушаалтантай нэгдмэл сонирхолгүй, эсхүл хамаарал бүхий этгээд биш, ашиг сонирхлын зөрчилгүй байх;

27.1.6.сонгон шалгаруулалтад оролцогч компанийн эцсийн өмчлөгч болон хараат, охин компани нь харилцан хамааралгүй байх;

27.1.7.сонгон шалгаруулалтад оролцогчид нь Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6-д заасны дагуу харилцан хамааралгүй байх.

27.2.Хувийн хэвшлийн түншлэгчээр оролцогч этгээдэд түншлэлийн төсөлтэй холбогдуулан энэ хуулийн 27.1-д зааснаас бусад тусгайлсан шаардлагыг сонгон шалгаруулалтын баримт бичгээр тогтоож болно.

27.3.Хувийн хэвшлийн түншлэгчээр оролцогч энэ хуульд заасан шаардлагыг хангасан талаарх мэдээллийг сонгон шалгаруулалтын баримт бичгийн дагуу бүрдүүлнэ.

27.4.Хувийн хэвшлийн түншлэгчээр оролцогч этгээд сонгон шалгаруулалтад оролцохдоо хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь шүүхээр тогтоогдсон бол шүүхийн эцсийн шийдвэр гарснаас хойш 5 жилийн хугацаанд түншлэлийн төсөл, үйл ажиллагаанд оролцох эрхгүй байна.

27.5.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар энэ хуулийн 27.4-т заасан эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтөлж, байгууллагын цахим санд олон нийтэд нээлттэй байршуулна.

[Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан ./](#)

27.6.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжид заасан ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд тухайн этгээдийг түншлэлд оролцуулахгүй.

----o0o----

ТАВДУГААР БҮЛЭГ

ТҮНШЛЭГЧ ТАЛУУДЫН ЧИГ ҮҮРЭГ, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, ТҮНШЛЭЛИЙН БАТАЛГАА, ДЭМЖЛЭГ

28 дугаар зүйл.Түншлэгч талуудын чиг үүрэг

28.1.Түншлэлд төрийн түншлэгч нь дараах нийтлэг чиг үүрэгтэй байна:

28.1.1.хувийн хэвшлийн түншлэгчийн үйл ажиллагаанд төслийн хэрэгжилттэй холбоотой хяналт тавих, түншлэлийн гэрээ болон холбогдох хууль тогтоомжийн дагуу аудитын байгууллагыг оролцуулах;

28.1.2.түншлэлийн гэрээний хүрээнд шаардлагатай баримт бичгийг гаргуулж авах, тухайн объектод саадгүй нэвтрэх;

28.1.3.түншлэлийн төсөл, гэрээ болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хяналт тавих, үнэлэх, дүгнэлт өгөх;

28.1.4.дэд бүтцийн байгууламжийг хувийн хэвшлийн түншлэгчид түншлэлийн гэрээний дагуу эзэмшүүлж, ашиглуулах нөхцөлийг бүрдүүлэх;

28.1.5.түншлэлийн гэрээнд заасан хугацаа, нөхцөлд үндэслэн түншлэлийн зүйлийн эрхийг хувийн хэвшлийн түншлэгчид олгох;

28.1.6.түншлэлийн гэрээнд заасны дагуу төслийн зардлыг төсвөөс санхүүжүүлэх;

28.1.7.түншлэлийн гэрээнд заасан тохиолдолд төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төрөөс үзүүлэх дэмжлэгийн арга хэмжээг хэрэгжүүлэх;

28.1.8.түншлэлийн төслөөр үзүүлэх үйлчилгээний чанар, түвшин, тэдгээрийг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг тогтоох, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, тайлагнах;

28.1.9.түншлэлийн гэрээ болон хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

28.2.Түншлэлд хувийн хэвшлийн түншлэгч нь дараах нийтлэг чиг үүрэгтэй байна:

28.2.1.түншлэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэлд суурилсан, чанартай, хүртээмжтэй гүйцэтгэх;

28.2.2.түншлэлийн төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэрийг өөрийн хөрөнгө болон санхүүгийн бусад арга хэрэгслээр бүрдүүлэх;

28.2.3.үйл ажиллагаа, удирдлагын шилдэг туршлага, инноваци, ноу-хауг тухайн салбартаа нэвтрүүлэх;

28.2.4.өөрийн болон түншлэлд оролцогч байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх;

28.2.5.түншлэлийн гэрээнд заасан нөхцөлийн дагуу түншлэлийн зүйлтэй холбоотой эрхийг хэрэгжүүлэх;

28.2.6.түншлэлийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төрийн түншлэгч этгээдийг түншлэлийн төслийн үйлчилгээний чанар хүртээмж, санхүүгийн мэдээлэл, энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай тайлан, мэдээллээр хугацаанд нь хангаж, түүний үнэн зөв, найдвартай байдлыг хариуцах;

28.2.7.түншлэлийн гэрээ болон хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

28.3.Түншлэгч талууд нь эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлж, эрсдэл хуваарилах нөхцөлийн дагуу түншлэлд тэнцвэртэй байдлыг хангаж ажиллана.

29 дүгээр зүйл.Түншлэлд оролцогч бусад этгээдийн чиг үүрэг

29.1.Түншлэлийн төслийг санхүүжүүлэгч, эсвэл санхүүжүүлэхийг сонирхогч тал нь түншлэлийн төслийг санхүүжүүлэх, татан төвлөрүүлсэн зээлийн эргэн төлөлтийн үүрэгтэй холбоотойгоор гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсан тохиолдолд санхүүжүүлэгчийн хөндлөнгөөс оролцох эрхийг энэ хууль болон түншлэлийн гэрээнд заасны дагуу хэрэгжүүлнэ.

29.2.Түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд оролцогч бусад талууд нь холбогдох хууль, түншлэлийн үндсэн болон дагалдах гэрээнд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

30 дугаар зүйл.Түншлэлийн эрсдэлийн удирдлага

30.1.Түншлэлийн түншлэгч талууд нь түншлэлээр хэрэгжүүлэх төслийн эрсдэлийг судалж тодорхойлох, хуваарилах, бууруулах болон хянах зорилгоор түншлэлийн төслийн эрсдэлийн удирдлагыг энэ хуулийн 7.2.4-т заасан аргачлалын дагуу хэрэгжүүлнэ.

30.2.Түншлэгч талуудын хооронд эрсдэлийг хуваарилах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үүссэн эрсдэлийг шийдвэрлэхтэй холбогдсон зохицуулалтыг түншлэлийн гэрээнд тусгана.

30.3.Эрсдэлийг хуваарилахад тухайн төслийн онцлогийг харгалзан үнэ болон чанарын харьцааг хадгалж, эрсдэлийг бага зардлаар илүү сайн шийдвэрлэх түншлэгч талд хуваарилах буюу эрсдэлийн хуваарилалтын зохистой байдлыг хангаж ажиллана.

30.4.Түншлэлийн төслийн онцлогоос хамаарч эрсдэлийн шинжилгээнд үндэслэн эрсдэлийг хувийн хэвшлийн түншлэгчид, эсхүл төрийн түншлэгчид, зарим хэсгийг хэрэглэгчдэд болон даатгалын компанид хуваарилж болно.

31 дүгээр зүйл.Засгийн газрын баталгаа

31.1.Засгийн газар төслийн бүрэн шинжилгээний үр дүнд үндэслэн түншлэлээр хэрэгжүүлэх төсөлд дараах баталгааг гаргаж болно:

31.1.1.түншлэлийн гэрээ болон түүнийг дагалдан байгуулагдсан гэрээ, тэдгээрийн гол нөхцөл зөрчигдөх нөхцөл үүссэн тохиолдолд түншлэлийн төсөлд төсвөөс санхүүжүүлэх үүргийн баталгаа;

31.1.2.түншлэлийн төслийг хэрэгжүүлэх явцад бий болсон бараа, ажил, үйлчилгээг худалдан авах, олон нийтийн хэрэгцээнд ашиглах, хэрэглэх баталгаа.

31.2.Энэ хуулийн 31.1-д заасан баталгааг гаргах, үүнтэй холбогдуулан хувийн хэвшлийн түншлэгчтэй холбогдох гэрээ байгуулах асуудлыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлнэ.

31.3.Энэ хуулийн 31.1-д заасан баталгаа нь Засгийн газрын өрийн баталгаанд хамаарахгүй бөгөөд уг баталгааг гаргах, гэрээ байгуулахтай холбогдсон асуудлыг энэ хуулийн 7.2.5-д заасан журмын дагуу зохицуулна.

31.4.Энэ хуульд заасан төслийн бүрэн шинжилгээгээр түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зээлд Засгийн газраас өрийн баталгаа гаргах тохиолдолд хувийн хэвшлийн түншлэгчид Засгийн газрын өрийн баталгааг Өрийн удирдлагын тухай хуульд заасан нөхцөл, шаардлага болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн гаргаж болно.

31.5.Энэ хуулийн 31.4-т зааснаар Засгийн газрын өрийн баталгаа гаргах асуудлыг Өрийн удирдлагын тухай хуульд зааснаар зохицуулна.

32 дугаар зүйл.Төрөөс үзүүлэх дэмжлэг

32.1.Засгийн газар, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын шийдвэрээр түншлэлийн гэрээний хүрээнд хувийн хэвшлийн түншлэгчид дараах дэмжлэгийг үзүүлж болно:

/Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

32.1.1.Газрын тухай хуульд заасны дагуу газар эзэмших, ашиглах эрхээр хангах;

32.1.2.төрийн үйлчилгээг үзүүлэх нөхцөлөөр хангах, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг ашиглах эрх олгох;

32.1.3.холбогдох хууль тогтоомжид заасны дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх;

32.1.4.түншлэлийн гэрээнд зааснаар төслийн санхүүжилтийн тодорхой хэсгийг төсвөөс санхүүжүүлэх;

32.1.5.шаардлагатай тохиолдолд түншлэлийн зүйлийг даатгалд хамруулах;

32.1.6.түншлэлийн төслөөр бий болгохоос бусад төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээгээр хангах;

32.1.7.хуульд заасан бусад хэлбэрээр дэмжлэг үзүүлэх.

32.2.Төрийн түншлэгч түншлэлийн гэрээний дагуу хувийн хэвшлийн түншлэгчийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай төрийн болон орон нутгийн өмчид хамаарах оюуны өмчийн онцгой эрхийг тодорхой нөхцөл, хугацаатайгаар шилжүүлж болно.

/Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан /

32.3.Түншлэлийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой төсвөөс санхүүжүүлэх нийт дүн нь төслийн нийт зардлаас хэтэрч болохгүй.

32.4.Түншлэлд төрөөс үзүүлэх дэмжлэг нь холбогдох хууль тогтоомж болон түншлэлийн гэрээний хүрээнд хэрэгжинэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭ

33 дугаар зүйл.Түншлэлийн гэрээ

33.1.Түншлэлийн гэрээ болон түүнийг дагалдан байгуулах гэрээнүүд нь тэгш эрхийн зарчимд суурилсан иргэний эрх зүйн гэрээ байх бөгөөд Захиргааны ерөнхий хуулийн зохицуулалтад үл хамаарна.

33.2.Түншлэлийн гэрээний талууд нь төрийн түншлэгч талаас тухайн төсөлд хамаарах салбарын болон түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төсөл хэрэгжих орон нутгийн байгууллагын төлөөлөл, энэ хуулийн 13.2-т заасан түншлэлийн төслийн хувьд аймаг, нийслэлийн Засаг дарга, нөгөө талаас хувийн хэвшлийн түншлэгч буюу төсөл хэрэгжүүлэгч компани, төслийн санхүүжүүлэгч хуулийн этгээд байна.

[Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

33.3.Түншлэлийн гэрээнд төрийн түншлэгч талыг төлөөлж Засгийн газрын эрх олгосноор төсөл хэрэгжүүлэх салбарын болон түншлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төсөл хэрэгжих орон нутгийг төлөөлж аймаг, нийслэлийн Засаг дарга, энэ хуулийн 13.2-т заасан түншлэлийн төслийн хувьд аймаг, нийслэлийн Засаг дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

[Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан ./](#)

33.4.Төрийн болон хувийн хэвшлийн түншлэгч талууд энэ хуульд заасан нөхцөлийн дагуу түншлэлийн гэрээ байгуулах эрхтэй бөгөөд гэрээнд түншлэгч талууд тэгш эрхтэй оролцоно.

33.5.Засгийн газар, энэ хуулийн 13.2-т заасан түншлэлийн төслийн хувьд аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал түншлэлийн гэрээг байгуулах эрх олгоно.

[Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан ./](#)

33.6.Түншлэлийн төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэлбэр, төслийн дагуу гүйцэтгэх ажлын онцлогт нийцүүлэн гэрээний төрөл, хэлбэрийг тодорхойлно.

33.7.Түншлэлийн гэрээний талууд гэрээгээр хүлээсэн үүрэг, хариуцлагыг бүрэн хариуцаж, биелүүлэх үүрэгтэй бөгөөд энэ хууль болон гэрээнд заасан чиг үүрэг, бүрэн эрхийн хүрээнд тухайн түншлэлийн харилцаанд оролцоно.

33.8.Түншлэлийн гэрээг байгуулахдаа дагалдах гэрээ, төслийн үе шат, гэрээний төлбөр, санхүүжилтийн хуваарь болон хэрэгжилтийн төлөвлөгөө, холбогдох бусад баримт бичгийг хавсралтаар оруулахаар тусгах бөгөөд эдгээр нь түншлэлийн гэрээний салшгүй хэсэг байна.

33.9.Түншлэлийн гэрээний загварыг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар батална.

33.10.Энэ хуульд заасан нөхцөл шаардлагыг хангаагүй болон энэ хуулийн 3.2-т заасан түншлэлд үл хамаарах салбарт хэрэгжих төсөлд түншлэлийн гэрээ байгуулахыг хориглоно.

34 дүгээр зүйл.Түншлэлийн гэрээний төсвөөс санхүүжүүлэх үүргийг төсөвт тусгах

34.1.Энэ хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу түншлэлийн төслийг хэрэгжүүлэхээр түншлэгч талууд харилцан тохиролцож, түншлэлийн гэрээг байгуулсан болон иргэд, олон нийт түншлэлийн төслийн бүтээгдэхүүн, үйлчилгээг авч эхэлсэн нь түншлэлтэй холбоотой төрийн түншлэгчийн хүлээх санхүүгийн болон холбогдох бусад үүргийг бүртгэх, төсвийн төсөлд тусгах үндэслэл болно.

34.2.Түншлэлийн гэрээ байгуулагдсанаар тухайн төслийн бүртгэлийг түншлэлийн мэдээллийн санд хэрэгжиж байгаа төслийн хэсэгт болон болзошгүй өр төлбөрийн бүртгэлд оруулна.

34.3.Өрийн удирдлагын тухай, Төсвийн тухай хуульд заасны дагуу түншлэлийн гэрээний төлбөрийн үүргийг хэрэгжих хугацаатай уялдуулан болзошгүй өр төлбөрт бүртгэж, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, жилийн төсвийн төсөлд тусгана.

34.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн түншлэлийн гэрээний мэдээлэл, төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийн тооцоо, шинжилгээг хянах ба түншлэлийн гэрээний дагуу төсвөөс санхүүжүүлэх санхүүжилтийг төслийн хэрэгжилт, гүйцэтгэлд үндэслэн жил бүрийн төсвийн төсөлд тусгана.

35 дугаар зүйл.Түншлэлийн гэрээний нөхцөл

35.1.Түншлэлийн гэрээний нөхцөлийг түншлэгч талуудын чиг үүрэг, тухайн төслийг хэрэгжүүлэх салбарын онцлог, нөхцөл байдалд уялдуулан уян хатан тодорхойлох бөгөөд энэ хуульд заасан түншлэлийн зарчмыг удирдлага болгоно.

35.2.Түншлэлийн гэрээнд дараах гол нөхцөлийг тусгасан байна:

35.2.1.түншлэлийн хамрах хүрээ, ажил, үйлчилгээний төрөл, хэмжээ, хувийн хэвшлийн түншлэгчийн эрх, үүрэг;

35.2.2.төслийн хугацаа, түншлэлийн зүйлийн талаарх мэдээлэл, төслийг хэрэгжүүлэх хугацаанд хамаарах эд хөрөнгийн эрх;

35.2.3.гэрээнд дагаж мөрдөх хууль тогтоомж, дүрэм журам, гэрээнд хэрэглэгдэх нэр томъёоны тайлбар;

35.2.4.түншлэлийн гэрээний талуудын эрх, үүрэг, хариуцлага;

35.2.5.түншлэгч талуудын хооронд эрсдэл хуваарилах, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх;

35.2.6.төслийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр, хэмжээ болон төлөвлөгөө;

35.2.7.түншлэлийн төрлийг тодорхойлох, төслийн зардлыг энэ хуулийн 14.1-т заасан хэлбэрээр санхүүжүүлэх;

35.2.8.төслийн зардлыг нөхөн төлөх болон орлого олох эх үүсвэр, талууд тохиролцсон тохиолдолд Засгийн газрын баталгаа, төрөөс үзүүлэх дэмжлэгийн төрөл, хэмжээ, хугацаа, нөхцөл;

35.2.9.түншлэлийн гэрээний хугацаанд төрийн үйлчилгээг төрийн болон хэрэглэгчийн санхүүгийн чадавхад нийцсэн үнээр хүргэх нөхцөл;

35.2.10.төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийг авахад төрөөс үзүүлэх дэмжлэг;

35.2.11.орлого бүрдүүлэх боломжтой төслийн хувьд түншлэлийн үйл ажиллагаа, үйлчилгээ, эсхүл барилга байгууламж болон хөрөнгөөс орох орлогын талаар түншлэгч талуудын эдлэх эрх;

35.2.12.түншлэлийн хүрээнд бий болох бараа, ажил, үйлчилгээнд тавигдах чанарын шаардлага, стандарт нөхцөл;

35.2.13.төслийн хүрээнд бий болгож байгаа бараа, ажил, үйлчилгээнд хэрэглэгчийн төлбөр, хураамж, тарифын хэмжээ тогтоох, батлах журам;

35.2.14.төслийн хүрээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээ;

35.2.15.туслан гүйцэтгэгч, түншлэлийн зүйлийн засвар, арчлалт, үйлчилгээг хариуцан гүйцэтгэх этгээдийг томилох, туслан гүйцэтгэх гэрээ байгуулах журам;

35.2.16.хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлын нөхцөл, норм, дүрэм, стандарт нөхцөлийн талаарх шаардлага;

35.2.17.хөрөнгө оруулалтаа хамгаалуулах, Монгол Улсад болон гадаад улс дахь банканд гадаад валютын данстай байх эрх, гадаад валютын арилжаа хийх, орлогыг татан төвлөрүүлэх, хөрвүүлэх нөхцөл;

35.2.18.түншлэлийн зүйлийн мөнгөний үнэ цэнийг тодорхойлох, дагалдах гэрээний нөхцөл, барилга, байгууламжийн өргөтгөл, засвар арчлалт болон үйлчилгээ нь батлагдсан загвар, тавигдсан шаардлага, чанарын стандартыг хангаж байгаа эсэхийг хянан баталгаажуулах;

35.2.19.түншлэлийн хүрээнд хувийн хэвшлийн түншлэгчийн эрх хэмжээ, үйл ажиллагааг хязгаарлах нөхцөл;

35.2.20.хувийн хэвшлийн түншлэгчээс түншлэлийг хэрэгжүүлэхэд гаргах төсөл хэрэгжүүлэх баталгаа, үнэт цаас, бусад баталгааны хэрэгсэл болон даатгалын гэрээ;

35.2.21.түншлэлийн гэрээний биелэлт, төслийн хэрэгжилт, үр дүнгийн хяналт шалгалт, мониторинг үнэлгээ хийх асуудал;

35.2.22.хувийн хэвшлийн түншлэгчийн гүйцэтгэх ажил, үйлчилгээнд холбогдох төрийн байгууллагаас тавих хяналт болон шаардлагатай тохиолдолд ажил, үйлчилгээний нөхцөлийг хязгаарлах үндэслэл;

35.2.23.түншлэлийн төслийг зүй зохистой хэрэгжүүлэх хүрээнд төрийн үйлчилгээг холбогдох хууль тогтоомжид заасан болон түншлэлийн гэрээнд тусгагдсаны дагуу хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад арга хэмжээний зохицуулалт;

35.2.24.төслийн тогтвортой байдал, байгаль орчин, нийгэм, олон нийтэд хамаарах заалтууд;

35.2.25.хувийн хэвшлийн түншлэгчийн төрийн түншлэгч талд төслийн хэрэгжилт, үйл ажиллагааны талаар тайлагнах, шаардлагатай мэдээлэл гаргаж өгөх үүрэг;

35.2.26.хувийн хэвшлийн түншлэгчийн түншлэлийг хэрэгжүүлэх санхүүгийн чадавхтай холбоотой их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл, хувьцаа эзэмшигчтэй, эсхүл бусад нэгдмэл сонирхолтой этгээдтэй байгуулах гэрээг төрийн түншлэгчийн зүгээс хянах болон зөвшөөрөх эрх;

35.2.27.түншлэлийн гэрээ болон төслийн хэрэгжилтийн мэдээллийн ил тод байдлыг хангах, мэдээллийн нууцлалтай холбоотой талуудын эрх, үүрэг;

35.2.28.түншлэлийн гэрээний дагуу шилжүүлэх хөрөнгийг эзэмших, ашиглах хугацаа, нөхцөл;

35.2.29.түншлэл дуусгавар болсны дараах талуудын эрх, үүрэг, зөрчил гаргасан нөхцөлд талуудын авах арга хэмжээ, төрийн түншлэгч болон зээлдэгчийн бусдын өмнөөс үүрэг хүлээх эрх;

35.2.30.түншлэлийн хүрээнд маргаан шийдвэрлэх журам;

35.2.31.түншлэлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах нөхцөл, түншлэлийн гэрээнээс нэг талын санаачилгаар татгалзах үндэслэл;

35.2.32.түншлэлийн гэрээний дагуу талуудын хүлээсэн үүргийн биелэлтийг дүгнэх шалгуур үзүүлэлт, үүргийг гүйцэтгээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын зохицуулалт;

35.2.33.түншлэлийн гэрээ дуусгавар болоход түншлэлийн зүйлийг буцаан шилжүүлэх, түншлэлийн гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгосон тохиолдолд талуудад олгох нөхөн төлбөрийг тооцох аргачлал;

35.2.34.түншлэлийн гэрээний талуудын бүтэн нэршил, оршин байгаа газар / хуулийн этгээдийн албан ёсны хаяг/, банкны мэдээлэл, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээдийн талаарх мэдээлэл;

35.2.35.гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл, урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдал үүссэнээр гэрээний үүргээ биелүүлээгүй, эсхүл хойшлуулсан бол талуудын хариуцлагаас чөлөөлөгдөх нөхцөл;

35.2.36.түншлэлийн гэрээг дуусгавар болгох, цуцлах үндэслэл, нөхөн олговор олгох нөхцөл, хэмжээ;

35.2.37.гэрээнд шаардлагатай холбогдох бусад нөхцөл.

35.3.Түншлэлийн гэрээгээр хэрэгжүүлэх түншлэлийн тодорхой төрөлд тусгайлсан шаардлага тавигдах тохиолдолд уг шаардлагыг холбогдох хууль тогтоомжоор тодорхойлно.

36 дугаар зүйл.Түншлэлийн гэрээний хугацаа

36.1.Түншлэлийн гэрээний хугацааг төслийг хэрэгжүүлэх салбар, төслийн үндсэн шинж болон гэрээний төрлөөс хамаарч талуудын харилцан тохиролцсоноор тогтооно.

36.2.Түншлэлийн гэрээний хугацаа 30 жилээс илүүгүй байна.

36.3.Түншлэлийн гэрээний хугацааг тогтоохдоо дараах хүчин зүйлсийг харгалзан үзнэ:

36.3.1.хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын нөхцөл, хэмжээ;

36.3.2.төслийн хүрээнд дэд бүтэц, барилга байгууламжийг барьж байгуулах, ашиглалтад оруулах, өргөтгөх, засаж сайжруулах хугацаа;

36.3.3.төслийн дэд бүтэц, барилга байгууламжийн элэгдлийн хугацаа;

36.3.4.хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартын дагуу барилга байгууламжийн ашиглалт, үйлчилгээнд тавигдах шаардлага;

36.3.5.хуулиар дэд бүтэц, үйлчилгээний салбарт тогтоосон өрсөлдөөн, зах зээлийн тогтолцоотой холбоотой бодлого.

37 дугаар зүйл.Хэлэлцээ хийж гэрээ байгуулах нөхцөл

37.1.Энэ хуулийн 13.2, 21.7-д заасан түншлэлийн төслийг хэрэгжүүлэх хувийн хэвшлийн түншлэгчтэй дараах тохиолдолд энэ хуулийн 25 дугаар зүйлд заасан сонгон шалгаруулалтгүйгээр хэлэлцээ хийж гэрээ байгуулж болно:

[Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

37.1.1.оюуны өмчийн эрхийг хамгаалах шаардлагаар ажил, үйлчилгээг зөвхөн оюуны өмчийн эрх эзэмшигчээс, эсхүл түүнээс лицензийн гэрээний дагуу ашиглах эрх авсан албан ёсны зөвхөн нэг этгээд гүйцэтгэх боломжтой болон тухайн ажил, үйлчилгээг зөвхөн нэг эх үүсвэрээс гүйцэтгэх боломжтой бусад тохиолдолд;

[/Энэ заалтад 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

37.1.2.онц байдал тогтоосон, эсхүл гамшгаас хамгаалах өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлснээс үүссэн хэрэгцээ, шаардлагыг хангахтай холбогдуулан төслийг нэн яаралтай хэрэгжүүлэх бол.

[/Энэ заалтад 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан ./](#)

37.2.Энэ хуулийн 37.1.1, 37.1.2-т заасан саналыг түншлэлийн болон салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргаж, Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх бөгөөд гэрээ байгуулах асуудлыг энэ хуулийн 7.2.3, 37.10-т заасан журмаар зохицуулна.

[/Энэ хэсгийг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./](#)

37.3.Хэлэлцээ хийж гэрээ байгуулах нөхцөлтэй түншлэлийн төслийн сонгон шалгаруулалтаас бусад харилцаа энэ хуульд заасан нөхцөл, шаардлагыг хангасан байна.

37.4.Энэ хуулийн 37.1-д зааснаас бусад тохиолдолд хэлэлцээ хийж гэрээ байгуулахыг хориглоно.

37.5.Энэ хуулийн 37.1-д заасныг зөрчиж гэрээ байгуулах шийдвэр гаргасан албан тушаалтан тухайн шийдвэртэй холбоотой хохирлыг өөрийн хөрөнгөөр төлж барагдуулах үүрэгтэй бөгөөд төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.

37.6.Энэ хуулийн 13.2-т заасан түншлэлийн төслийн хувьд энэ хуулийн 37.1.1, 37.1.2-т заасан саналыг аймаг, нийслэлийн Засаг дарга энэ хуулийн 13.3-т заасан журмын дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

[/Энэ хэсгийг 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн ./](#)

[/Энэ хэсэгт 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

37.7.нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээг хэвийн, тасралтгүй хангах нэн яаралтай нөхцөл үүссэн шалтгаанаар энэ хуульд заасан аргаар түншлэлийн төслийг зарлаж, сонгон шалгаруулах хугацааг мөрдөх боломжгүй тохиолдолд энэ хуулийн 37.1-д заасны дагуу хэлэлцээ хийж гэрээ байгуулж болох бөгөөд төслийн жагсаалтыг Улсын Их Хурал батална. [/Энэ хэсгийг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

37.8.Энэ хуулийн 37.7-д заасан түншлэлийн төслийг Засгийн газар хэрэгжүүлнэ.

[/Энэ хэсгийг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

37.9.Засгийн газар энэ хуулийн 37.8-д заасан бүрэн эрхээ аймаг, нийслэлд шилжүүлж болно.

/Энэ хэсгийг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./

37.10.Энэ хуулийн 37.8-д заасан түншлэлийн төслийн хэлэлцээг хийх, гэрээ байгуулах асуудлыг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан зохион байгуулах ба дараах журмыг баримтална:

/Энэ хэсгийг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./

37.10.1.хэлэлцээ хийж, дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах;

/Энэ заалтыг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./

37.10.2.төслийг хэрэгжүүлэх 2-оос доошгүй хувийн хэвшлийн түншлэгчид төслийн санал ирүүлэх урилга хүргүүлэх;

/Энэ заалтыг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./

37.10.3.хувийн хэвшлийн түншлэгчээс төслийн санал хүлээн авах;

/Энэ заалтыг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./

37.10.4.төслийн санал ирүүлсэн хувийн хэвшлийн түншлэгчтэй хэлэлцээ хийх;

/Энэ заалтыг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./

37.10.5.хамгийн сайн нөхцөл санал болгосон хувийн хэвшлийн түншлэгчтэй түншлэлийн гэрээ байгуулах дүгнэлт гаргах;

/Энэ заалтыг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./

37.10.6.энэ хуулийн 37.10.5-д заасан дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлж, түншлэлийн гэрээ байгуулах зөвшөөрөл авах;

/Энэ заалтыг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./

37.10.7.түншлэлийн болон салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга хамтран түншлэлийн гэрээ байгуулах, энэ хуульд заасан гэрээний хэрэгжилтэд хяналт тавих.

/Энэ заалтыг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./

37.11.Энэ хуулийн 37.9-д заасан түншлэлийн төслийг хэрэгжүүлэгч нь аймаг, нийслэлийн Засаг дарга байна.

/Энэ хэсгийг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./

37.12.Аймаг, нийслэлийн Засаг дарга хэлэлцээ хийж, гэрээ байгуулахад энэ хуулийн 13.3-т заасан журмаас гадна дараах журмыг баримтална:

/Энэ хэсгийг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./

37.12.1.хэлэлцээ хийж, дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулах;

/Энэ заалтыг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./

37.12.2.төслийг хэрэгжүүлэх 2-оос доошгүй хувийн хэвшлийн түншлэгчид төслийн санал ирүүлэх урилга хүргүүлэх;

/Энэ заалтыг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./

37.12.3.хувийн хэвшлийн түншлэгчээс төслийн санал хүлээн авах;

/Энэ заалтыг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./

37.12.4.төслийн санал ирүүлсэн хувийн хэвшлийн түншлэгчтэй хэлэлцээ хийх;

/Энэ заалтыг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./

37.12.5.хамгийн сайн нөхцөл санал болгосон хувийн хэвшлийн түншлэгчтэй түншлэлийн гэрээ байгуулах дүгнэлт гаргах;

[/Энэ заалтыг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

37.12.6.энэ хуулийн 37.12.5-д заасан дүгнэлтийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлж, түншлэлийн гэрээ байгуулах зөвшөөрөл авах;

[/Энэ заалтыг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

37.12.7.түншлэлийн гэрээ байгуулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих.

[/Энэ заалтыг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

38 дугаар зүйл.Түншлэлийн гэрээний нууцлал

38.1.Төрийн түншлэгч байгууллагын холбогдох албан тушаалтан түншлэлийн гэрээ байгуулах болон хэлэлцээ хийх явцад хувийн хэвшлийн этгээдээс ирүүлсэн хуулиар хамгаалагдсан нууцыг хадгалах үүрэгтэй.

39 дүгээр зүйл.Түншлэлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг сунгах

39.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал, дүгнэлтийг авч түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналаар дараах тохиолдолд түншлэлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ:

[/Энэ хэсэгт 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

39.1.1.түншлэлийн гэрээний агуулгын ач холбогдол бүхий харилцаа тухайн гэрээг байгуулснаас хойш бүхэлдээ, мэдэгдэхүйц өөрчлөгдсөн, гэрээний аль нэг тал гэрээний анхны зохицуулалтыг цаашид баримтлах боломжгүй болох нь тогтоогдсон бөгөөд талуудаас түншлэлийн гэрээнд өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан бол;

39.1.2.гэнэтийн болон давагдашгүй, урьдчилан таамаглаагүй нөхцөл байдлын улмаас төслийн техникийн үзүүлэлт, хөрөнгө оруулалтын тохиролцсон нийт хэмжээ өөрчлөгдсөн, хуульд зааснаар техник, эдийн засгийн үндэслэлийн тайланд өөрчлөлт орсон, эсхүл гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлс бий болсон бөгөөд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахаар талууд харилцан тохиролцсон бол;

[/Энэ заалтад 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

39.1.3.төрийн түншлэгчээс түншлэлийн гэрээний хамрах хүрээг өргөжүүлэн анхны гэрээнд тусгаагүй боловч зайлшгүй шаардлагатай ажил, үйлчилгээг хувийн хэвшлийн түншлэгчээр нэмэлтээр хийлгэх шаардлагатай болсон бол.

39.2.Энэ хуулийн 39.1.3-т заасан түншлэлийн төслийн нэмэлт ажил, үйлчилгээ дараах шаардлагыг хангасан байна:

39.2.1.эдийн засаг, техникийн шийдлийн хувьд одоо ашиглаж байгаа тоног төхөөрөмж, анхны гэрээний хүрээнд хийсэн ажил, үйлчилгээтэй уялдаатай, харилцан хамааралтай, сэлгэн ажиллуулах боломжтой байх;

39.2.2.хувийн хэвшлийн өөр түншээр хийлгэх нь нийтийн ашиг сонирхолд үл нийцэх, төрийн түншлэгчийн хувьд илүү их ажиллагаа, хугацаа шаардах, нэмэлт зардал гарахаар бол.

39.3.Түншлэлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал нь анх тохирсон гэрээний үнийн дүнг 15-аас дээш хувиар өсгөхөөр бол, эсхүл анхны гэрээнд заагаагүй ажил, үйлчилгээг хувийн хэвшлийн түншлэгч нэмэлтээр үзүүлэх үр дагавартай бол гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх талаар түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төвбайгууллагань санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төвбайгууллагаас санал, дүгнэлт авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

/Энэ хэсэгт 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

39.4.Түншлэлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа түншлэлийн гэрээний гол нөхцөлийг өөрчлөхийг хориглоно.

/Энэ хэсгийг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./

39.5.Төрийн түншлэгч түншлэлийн гэрээний хугацаа дуусгавар болох үед гэрээг дахин сунгахгүйгээр дуусгавар болгох эрхтэй бөгөөд дараах тохиолдолд гэрээний хугацааг сунгахаар талууд зөвшилцөж болно:

39.5.1.гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээний аль нэг талын хяналтаас давсан нөхцөл байдал үүссэнээс төслийн үйл ажиллагаа зогссон;

39.5.2.төрийн түншлэгчээс гаргасан түншлэлийн гэрээнд тусгагдаагүй шаардлагыг хангахад төслийн нийт өртөг өссөн бөгөөд хувийн хэвшлийн түншлэгч уг зардлыг гэрээний хугацаа сунгахгүйгээр нөхөх боломжгүй болсон.

39.6.Энэ хуулийн 36.2-т заасан хугацааг энэ хууль болон гэрээнд заасан шаардлага, үндэслэлээр Засгийн газрын зөвшөөрлийн үндсэн дээр талууд гэрээний хугацааг нэг удаа 10 хүртэлх жилээр сунгаж болно.

40 дүгээр зүйл.Түншлэлийн гэрээг цуцлах, дуусгавар болгох

40.1.Түншлэлийн гэрээ дараах тохиолдолд дуусгавар болно:

40.1.1.түншлэлийн гэрээний хүчинтэй хугацаа дуусгавар болсон бөгөөд талууд сунгах хүсэлт гаргаагүй;

40.1.2.түншлэлийн гэрээний нэг тал гэрээний үүргийг зөрчсөн, зөрчлийг арилгах үр дүнтэй арга хэмжээ аваагүй;

40.1.3.гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл бий болсон бөгөөд арилгах боломжгүй болсон;

40.1.4.хууль болон түншлэлийн гэрээнд өөрөөр заагаагүй бол хувийн хэвшлийн түншлэгч төлбөрийн чадваргүй болсон буюу татан буугдсан;

40.1.5.энэ хууль болон түншлэлийн гэрээнд заасны дагуу гэрээг цуцалсан.

40.2.Түншлэлийн гэрээнд өөрөөр заагаагүй бол түншлэлийн гэрээг дараах тохиолдолд төрийн түншлэгчийн санаачилгаар цуцална:

40.2.1.хувийн хэвшлийн түншлэгч гэрээг ноцтой зөрчсөн, гэрээгээр хүлээсэн

үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй нь гэрээнд зааснаар гэрээг цуцлах үндэслэл болсон;

40.2.2.хувийн хэвшлийн түншлэгч татан буугдсаны улмаас түншлэлийн төслийг хэрэгжүүлэх боломжгүй болсон нь нийтийн ашиг сонирхолд хохирол учруулахаар бол түүнээс урьдчилан сэргийлэх, эсхүл түүнийг арилгах зорилгоор;

40.2.3.түншлэлийн гэрээг энэ хууль болон бусад хууль тогтоомжийг зөрчиж байгуулсан нь тогтоогдсон бол.

40.3.Түншлэлийн гэрээнд өөрөөр заагаагүй бол дараах тохиолдолд хувийн хэвшлийн түншлэгчийн санаачилгаар гэрээг цуцалж болно:

40.3.1.төрийн түншлэгч байгууллагын буруутай үйл ажиллагаанаас шалтгаалж түншлэлийн төслийг түр зогсоосон;

40.3.2.төрийн түншлэгч байгууллага хувийн хэвшлийн түншлэгчийн бизнесийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцож, хувийн хэвшлийн түншлэгчийг түншлэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ цаашид биелүүлэх боломжгүйд хүргэсэн хууль бус шийдвэр гаргасан, эсхүл хориглосон арга хэмжээ авсан;

40.3.3.түншлэлийн төсөл хэрэгжүүлэхэд зориулан хувийн хэвшлийн түншлэгчид эзэмшүүлж, ашиглуулсан газар, бусад хөдлөх болон үл хөдлөх хөрөнгөд гэрээ байгуулахаас өмнө өр төлбөр байсан нь илэрсэн, эсхүл гэрээг байгуулах үед хувийн хэвшлийн түншлэгчид мэдэгдээгүй зөрчил илэрсэн бөгөөд эдгээр нь гэрээг хэвийн үргэлжлүүлэхэд боломжгүй нөхцөл байдал үүсгэсэн бол.

40.4.Түншлэлийн гэрээг цуцлахад талуудад олгох нөхөн төлбөрийг хэрхэн тооцохыг гэрээнд заах ба түншлэлийн гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын зохих үнэ цэн, гарсан зардал, тухайн талд учирсан бодит хохирлыг оруулж болно.

40.5.Энэ хууль болон түншлэлийн гэрээнд өөрөөр заагаагүй бол гэрээ дуусгавар болсноор эрх шилжүүлэх, түншлэлийн зүйлийг эзэмших, ашиглах, захиран зарцуулахтай холбогдох асуудлыг энэ хуулийн 7 дугаар бүлэгт зааснаар зохицуулна.

ДОЛДУГААР БҮЛЭГ

ТҮНШЛЭЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

41 дүгээр зүйл.Төсөл хэрэгжих газрын эрхийн асуудал

41.1.Хувийн хэвшлийн түншлэгч төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай газрыг эзэмших, ашиглах эрхийг түншлэлийн гэрээ болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу эдэлнэ.

41.2.Түншлэлийн гэрээнд төсөл хэрэгжих газрын эрх, түүнийг шилжүүлэх асуудлыг нарийвчлан тусгах бөгөөд төсөл хэрэгжүүлэх шийдвэр гарахаас өмнө төслийг хэрэгжүүлэх газрын боломжит байдлыг судалж, шаардлагатай тохиолдолд төсөл хэрэгжүүлэх газрыг солих буюу эргүүлэн авах эсэхийг шийдвэрлэсэн байна.

41.3.Төрийн түншлэгч төсөл хэрэгжүүлэх газартай холбоотой дараах үүргийг хүлээнэ:

41.3.1.төсөл хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад байгаа газрыг холбогдох хуульд заасны дагуу нөхөх олговортойгоор солих, эргүүлэн авах, шаардлагатай тохиолдолд худалдан авах;

41.3.2.төрийн өмчийн газрыг тодорхой болзол, гэрээний дагуу хувийн хэвшлийн түншлэлд ашиглуулах;

41.3.3.хувийн хэвшлийн түншлэгчийг гуравдагч этгээдийн эзэмшил газарт нэвтрэх, дамжин өнгөрөх, эзэмшил газар дээр ажил, засвар үйлчилгээ хийх нөхцөл боломжоор хангах;

41.3.4.төсөл хэрэгжүүлэх газрын нийтийн эзэмшлийн газарт түр хугацаанд сервитут тогтоох;

41.3.5.хувийн хэвшлийн түншлэгч газрыг түншлэлийн гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглахад саад учруулахгүй байх, тухайн газар дээр ажил, үйлчилгээгээ явуулах нөхцөл, боломжоор хангах;

41.3.6.төсөл хэрэгжүүлэх газрын эзэмших, ашиглах эрхийг төрийн бусад байгууллагаас хууль бусаар хураан авахгүй байх.

41.4.Хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол хувийн хэвшлийн түншлэгч нь төслийн газрыг төслийн хамрах хүрээнээс гадуур нэмэлт ашиг олох зорилгоор гуравдагч этгээдэд хэсэгчлэн түрээслэх, шилжүүлэн ашиглахыг хориглоно.

42 дугаар зүйл.Хувийн хэвшлийн түншлэгч, төсөл хэрэгжүүлэх тусгай зориулалттай компанийн бүтэц, зохион байгуулалт

42.1.Түншлэлийн гэрээнд хувийн хэвшлийн түншлэгч, эсхүл түүний нэр дэвшүүлсэн бусад компани нь төслийг хэрэгжүүлэх зорилгоор тусгай зориулалтын компани байгуулахаар зааж болно.

42.2.Төслийн тусгай зориулалтын компанийг Компанийн тухай хуулийн дагуу үүсгэн байгуулж, бүртгүүлсэн байна.

42.3.Гадаад улсад бүртгэлтэй, гадаадын хуулийн этгээд төсөл хэрэгжүүлэх тусгай зориулалттай компанийн хувьцааны зарим хэсгийг, эсхүл бүхэлд нь эзэмшиж болно.

42.4.Гадаад улсад бүртгэлтэй, гадаадын хуулийн этгээд нь Монгол Улсын хуулийн этгээдтэй хамтран хувийн хэвшлийн түншлэгчийн сонгон шалгаруулалтад оролцож, саналаа ирүүлж болно.

42.5.Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээд болон тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан хувийн хэвшлийн түншлэгчийн сонгон шалгаруулалтад оролцох эрхгүй байна.

42.6.Төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээд хувийн хэвшлийн түншлэгч компани, эсхүл тусгай зориулалттай компанийн хувьцаа эзэмшигч байж болно.

/Энэ хэсэгт 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

42.7.Төслийн хэрэгжилтийн явцад тусгай зориулалтын компанийн дүрэмд өөрчлөлт орох шаардлагатай болсон, эсхүл компанийн өмчлөгч өөрчлөгдсөн тохиолдолд төрийн түншлэгчид мэдэгдэж зөвшөөрөл авах бөгөөд зөвшөөрлийг үндэслэлгүйгээр хойшлуулж болохгүй.

42.8.Тусгай зориулалтын компанийг хуулийн этгээдээр бүртгүүлснээс хойших хугацаанд компанийн өөрийн хөрөнгийн хэмжээг өөрчлөх, төрийн түншлэгчээс зөвшөөрөл авах дүрэм, журам, эдгээрт зарчмын өөрчлөлт оруулах нөхцөлийг түншлэлийн гэрээнд заах ба эдгээр нөхцөл, журам нь анхны сонгон шалгаруулалтын баримт бичигт заасантай ижил байна.

43 дугаар зүйл.Төслийн хөрөнгийн өмчлөл, бүртгэл

43.1.Төслийн хөрөнгийн өмчлөлийн асуудлыг холбогдох хууль тогтоомж болон түншлэлийн гэрээгээр зохицуулах бөгөөд дараах байдлаар гэрээнд тусгаж болно:

43.1.1.төрийн түншлэгч этгээдэд шилжүүлэх хөрөнгө;

43.1.2.төрийн түншлэгч этгээд өөрийн сонголтоор худалдан авах хөрөнгө;

43.1.3.хувийн хэвшлийн түншлэгчийн эзэмшилд үлдэх хөрөнгө.

43.2.Түншлэлийн гэрээнд өөрөөр заагаагүй бол түншлэлийн зүйл нь төрийн болон орон нутгийн өмчид хамаарна.

43.3.Түншлэлийн зүйлийг ашиглах явцад бий болсон биет эд хөрөнгө болон оюуны өмч, оюуны үнэт зүйл нь төрийн, эсхүл орон нутгийн өмчид хамаарна.

43.4.Түншлэлийн гэрээнд өөрөөр заагаагүй бол түншлэлийн зүйлийг эзэмших, ашиглах хугацаанд олсон энэ хуулийн 43.3-т зааснаас бусад ашиг, орлого нь түншлэлийн гэрээний хугацаанд хувийн хэвшлийн түншлэгчийн өмчид хамаарна.

43.5.Түншлэлийн гэрээнд өөрөөр заагаагүй бол хувийн хэвшлийн түншлэгчид ашиглуулахаар шилжүүлсэн түншлэлийн зүйл, газар ба бусад эд хөрөнгө нь гэрээнд заасан зориулалтаар цаашид ашиглагдах боломжгүй, эсхүл шаардлагагүй болсноос бусад тохиолдолд төрийн түншлэгч болон төрийн бусад байгууллага, албан тушаалтан түншлэлийн гэрээ дуусгавар болохоос өмнө түүнийг буцаан авах, эсхүл захиран зарцуулах шийдвэр гаргахыг хориглоно.

43.6.Хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн зүйлийг гэрээнд заасан тохиолдолд гэрээний хугацаа, нөхцөл, журмын дагуу эзэмшиж, ашиглаж, барьцаалж болно.

43.7.Түншлэлийн гэрээний нөхцөлөөс хамаарч гэрээний хугацаа дуусахад хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн хүрээнд бий болсон, эсхүл түншлэлд хамаарах аливаа хөрөнгийг төрийн болон орон нутгийн өмчид гэрээнд заасны дагуу шилжүүлнэ.

43.8.Төрийн болон орон нутгийн өмчид хамаарах оюуны өмчийг түншлэлийн төсөлд нэвтрүүлснээс олсон түншлэлийн төслийн орлогын 5 хүртэлх хувийг оюуны өмчийн эрх эзэмшигчийн инноваци, судалгаа хөгжүүлэлттэй холбоотой үйл ажиллагаанд зарцуулж болно.

/Энэ хэсгийг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн./

44 дүгээр зүйл.Төслийн хөрөнгө оруулалт, барьцаа, төсөл хэрэгжүүлэх баталгаа

44.1.Хувийн хэвшлийн түншлэгч түншлэлийн төслийн хөрөнгө оруулалтыг дараах эх үүсвэрээр санхүүжүүлж болно:

44.1.1.хувийн хэвшлийн түншлэгчийн өөрийн хөрөнгө;

44.1.2.өрийн санхүүжилт;

44.1.3.төсвөөс тодорхой санхүүжилтийг гаргах;

44.1.4.бусад санхүүгийн эх үүсвэр.

44.2.Энэ хуулийн 44.1.4-т заасан эх үүсвэрт Монгол Улсын Хөгжлийн банк болон Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, хөрөнгө оруулалт хамаарахгүй.

44.3.Хувийн хэвшлийн түншлэгч хөрөнгө оруулалтын болон төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой нийт зардлыг энэ хуулийн 14.2, 14.3, 14.4-т заасны дагуу санхүүжүүлнэ.

44.4.Түншлэлийн гэрээнд түншлэлийн төслийн барьцааны зүйлийн талаар зохицуулж болох бөгөөд барьцааны зүйл нь нийтийн өмчийн зориулалттай үл хөдлөх эд хөрөнгөөс бусад хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө, эсхүл борлуулалтын авлага байж болно.

44.5.Хувийн хэвшлийн түншлэгч энэ хуулийн 44.4-т заасны дагуу барьцааны эрхээ хэрэгжүүлэхдээ төрийн түншлэгчид тухайбүрд мэдэгдэх бөгөөд төслийн үйл ажиллагааны эрх, төсөл хэрэгжүүлэх зорилгоор авсан тусгай зөвшөөрлийг барьцаалахыг хориглоно.

44.6.Хувийн хэвшлийн түншлэгч компанийн хувьцаа эзэмшигч төслийн тусгай зориулалтын компанийн хувьцааг төрийн түншлэгч зөвшөөрсөн тохиолдолд барьцаалуулж болно.

44.7.Хувийн хэвшлийн түншлэгч түншлэлийн үндсэн болон дагалдах гэрээнд заасан хугацаа, стандарт болон зардлын дагуу түншлэлийн төслийг хугацаанд нь гүйцэтгэх төсөл хэрэгжүүлэх баталгааг гаргаж, төлбөрийг гэрээнд заасны дагуу Түншлэлийн төсөл хөгжүүлэх санд, энэ хуулийн 13.2-т заасан түншлэлийн төслийн хувьд аймгийн орон нутгийн сан болон нийслэлийг хөгжүүлэх санд гэрээ байгуулахаас ажлын 5 өдрийн өмнө шилжүүлнэ.

/Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан ./

44.8.Төсөл хэрэгжүүлэх баталгааны хувь хэмжээг төслийн төрөл, гэрээний хэлбэрээс хамаарч түншлэгч талууд гэрээнд тусгаж тохиролцох бөгөөд энэ нь гэрээний нийт үнийн дүнгийн 5 хувиас илүүгүй байна.

44.9.Хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн гэрээний дагуу нийтэд зориулсан барилга байгууламжийн ашиглалт, үйлчилгээтэй холбоотой түрээс, төлбөр, хураамж авах эрхтэй бөгөөд төлбөр, хураамжийн хэмжээ тогтоох, түүнийг өөрчлөх аргачлалыг түншлэлийн гэрээнд тодорхой заана.

44.10.Төрийн түншлэгч нийтэд зориулсан барилга байгууламжийн ашиглалт, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хэрэглэгчээс төлсөн төлбөр, хураамжийг түншлэлийн гэрээнд заасны дагуу хувийн хэвшлийн түншлэгчид шилжүүлнэ.

45 дугаар зүйл.Хэрэглэгчийн төлбөрийг тогтоох

45.1.Түншлэлийн гэрээ болон түүний хавсралт баримт бичгүүдэд тухайн төслийн онцлогоос хамаарч хэрэглэгчийн төлбөр, хураамж, тарифын хэмжээг хэрхэн тогтоох, энэ талаарх түншлэлийн талуудын хүлээх эрх, үүргийг тодорхой тусгах бөгөөд хэрэглэгчийн төлбөрийн хэмжээ тогтоосон шийдвэр нь нийтэд ил тод байна.

45.2.Төрийн түншлэгч нь тухайн төслийн онцлогоос хамаарч хувийн хэвшлийн түншлэгчтэй урт хугацаанд, тогтвортой байдлыг хангаж ажиллах зорилгоор түншлэлийн гэрээнд тусгах хэрэглэгчийн төлбөрийн хэмжээг харилцан тохиролцож энэ хуулийн 7.1.7-д заасны дагуу шийдвэрлүүлж болно.

45.3.Төрийн түншлэгч нь төслийн онцлогт нийцүүлэн хэрэглэгчийн төлбөр, хураамж, тарифын хэмжээг тогтоох аргачлалыг өгөөжийн түвшин тооцох болон үнийн хязгаарлалтын, эсхүл энэ хоёрын холимог аргын хүрээнд боловсруулж, түншлэлийн гэрээнд тусгана.

45.4.Хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн гэрээгээр тогтоосон төлбөр, хураамж, тарифын хэмжээний хязгаарлалтыг дагаж мөрдөх үүрэгтэй.

45.5.Хэрэглэгчийн төлбөр, хураамжийг түншлэлийн гэрээнд тогтоохдоо нийтэд ил тод мэдээлж, хэрэгжүүлнэ.

46 дугаар зүйл.Түншлэлийн гэрээний хувийн хэвшлийн хяналтын эрхийг шилжүүлэх

46.1.Хувийн хэвшлийн түншлэгч нь төрийн түншлэгчийн зөвшөөрөлгүйгээр түншлэлийн гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ бусдад шилжүүлэхийг хориглоно.

46.2.Хувийн хэвшлийн түншлэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас төрийн түншлэгчээс гэрээг цуцлах эрхтэй болох, эсхүл гэрээг цуцлах болон гэрээнд заасан бусад нөхцөл үүссэн тохиолдолд төслийн санхүүжүүлэгч, эсхүл зээлдүүлэгч нь гэрээнд заасны дагуу санхүүжүүлэгчийн хөндлөнгөөс оролцох эрхийг хэрэгжүүлж болно.

Тайлбар: "Санхүүжүүлэгчийн хөндлөнгөөс оролцох эрх" гэдэгт санхүүжүүлэгч, эсхүл зээлдүүлэгч нь түншлэлийн гэрээний үүргээ зөрчсөн хувийн хэвшлийн түншлэгчийн эрх, үүргийг энэ хуульд заасан шаардлагыг хангасан өөр этгээдэд төрийн түншлэгчтэй зөвшилцсөний үндсэн дээр шилжүүлэхийг ойлгоно.

46.3.Түншлэлийн гэрээнд заасан тохиолдолд гэнэтийн буюу давагдашгүй нөхцөл байдлын улмаас олон нийт, хэрэглэгчдэд эрсдэл учирсан, эсхүл төрийн түншлэгчээс түншлэлийн гэрээг цуцлах нөхцөл бий болсон тохиолдолд төрийн түншлэгч нь хувийн хэвшлийн түншлэгчийн үйлчилгээ үзүүлэх эрхийг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг уг нөхцөл байдал арилах хүртэлх хугацаанд шилжүүлж авах эрхтэй.

46.4.Хувийн хэвшлийн түншлэгч компанийн хувьцаа эзэмшигч нь төсөл хэрэгжүүлж эхэлснээс хойш түншлэлийн гэрээнд тусгагдсаны дагуу нийтийн зориулалттай дэд бүтэц, барилга байгууламжийн ажил дууссанаас хойш төслийн тусгай зориулалтын компанийн хувьцааны 50 хүртэлх хувийг төрийн түншлэгчийн зөвшөөрөлтэйгөөр гуравдагч этгээдэд шилжүүлж болно.

46.5.Энэ хуулийн 46.2-т заасан тохиолдолд түншлэлийн гэрээнд төрийн түншлэгчээс гуравдагч этгээдэд эрх, үүрэг шилжүүлэх зөвшөөрөл өгөх нөхцөл болзол, гэрээний үүргийг бүхэлд нь хүлээн авсан шинэ түншийг хүлээн зөвшөөрөх, үйлчилгээ үзүүлэхэд хангалттай техникийн болон санхүүгийн чадавхтай эсэхийг нотлох шаардлагыг тодорхой заана.

46.6.Төрийн түншлэгч нь түншлэлийн төслийн бүх үе шатанд түншлэлийн гэрээнд заасан хяналтын эрхийг хэрэгжүүлнэ.

47 дугаар зүйл.Нийтийн зориулалттай дэд бүтцийн барилга байгууламжийн ашиглалт

47.1.Түншлэлийн гэрээний дагуу нийтийн зориулалттай дэд бүтцийн барилга байгууламжийг хүлээн авах, ашиглахтай холбогдсон харилцааг түншлэлийн гэрээ болон холбогдох хууль тогтоомжид зааснаар зохицуулна.

47.2.Түншлэлийн төслийн нийтийн зориулалттай дэд бүтцийн барилга байгууламжийг барьж байгуулах, ашиглалтад оруулах, турших, ашиглах, засвар үйлчилгээ болон аюулгүй байдал, чанар, стандарттай холбоотой асуудлыг түншлэлийн гэрээ болон холбогдох хууль тогтоомжид зааснаар зохицуулна.

47.3.Нийтийн зориулалттай дэд бүтцийн барилга байгууламжийн ашиглалтад төрийн түншлэгч болон тухайн салбарын мэргэжлийн байгууллага хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

47.4.Түншлэлийн гэрээнд нийтийн зориулалттай дэд бүтэц, барилга байгууламжийн төслийн ашиглалттай холбоотой дараах асуудлыг тусгана:

47.4.1.хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад тохируулан үйлчилгээний төрлийг өөрчлөх нөхцөл;

47.4.2.үйлчилгээний тасралтгүй, хүртээмжтэй байдлыг хангах шаардлага;

47.4.3.бүх үйлчлүүлэгчдэд ижил тэгш нөхцөлөөр үйлчилгээ үзүүлэх.

47.5.Хувийн хэвшлийн түншлэгчийн хариуцаж байгаа нийтийн зориулалттай дэд бүтцийн болон барилга байгууламжийн сүлжээнд бусад хэрэглэгч холбогдоход хязгаарлалт тогтоохыг хориглоно.

47.6.Төрийн түншлэгчийн зөвшөөрлөөр хувийн хэвшлийн түншлэгч нь нийтийн зориулалттай дэд бүтцийн болон барилга байгууламжийн ашиглалтын дүрэм тогтоох, мөрдүүлэх эрхтэй.

47.7.Хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн төслийг хэрэгжүүлэхдээ тухайн дэд бүтэц, төрийн үйлчилгээнд үр дүнгийн үзүүлэлтийг хангаж ажиллах үүрэгтэй.

Тайлбар: “Үр дүнгийн үзүүлэлт” гэж түншлэлийн төслийн хүрээнд үзүүлэх үйлчилгээ, стандарт болон шаардлагыг ойлгоно.

47.8.Хувийн хэвшлийн түншлэгч нь техникийн аюулгүй байдал болон түншлэлийн гэрээний нөхцөл, шаардлагыг хангаж ажиллаагүйн улмаас гарсан аливаа хохирлыг бие даан хариуцаж, өөрийн хөрөнгөөр барагдуулах үүрэгтэй.

48 дугаар зүйл.Түншлэлийн гэрээ дуусгавар болоход санхүүжилт болон эрх шилжүүлэх асуудал

48.1.Түншлэлийн гэрээ дуусгавар болсонтой холбогдуулан хувийн хэвшлийн түншлэгч нь төслийн хүрээнд эзэмшиж, ашиглаж байсан хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, инноваци, ноу-хау, оюуны өмч, техникийн бичиг баримт, төслийн үйл ажиллагаатай холбоотой эрхийг төрийн түншлэгчид шилжүүлэн өгнө.

48.2.Энэ хуулийн 48.1-д заасан ажиллагааг түншлэлийн гэрээнд заасан нөхцөл, журмын дагуу хамтарсан ажлын хэсэг зохион байгуулах бөгөөд хамтарсан ажлын хэсгийг түншлэл болон тухайн төслийн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр холбогдох мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан байгуулна.

48.3.Түншлэлийн гэрээ дуусгавар болсонтой холбоотой түншлэгч талууд болон санхүүжүүлэгч талын хүлээх санхүүгийн эрх, үүргийг түншлэлийн гэрээнд тодорхойлох бөгөөд хөрөнгө оруулалт, өр төлбөр, нөхөх олговор, нэмэлт санхүүжилт, зардлын хэтрэлт, санхүүгийн алдагдлыг хэрхэн шийдвэрлэх талаар тусгасан байна.

48.4.Энэ хуульд зааснаар гэрээ цуцалсантай холбогдуулан төслийн нэмэлт хөрөнгө оруулалт болон төслийг дахин эхлүүлэх эсэх, гуравдагч этгээдэд түншлэлийн эрх, үүргийг шилжүүлэх шийдвэрийг Засгийн газар, энэ хуулийн 13.2-т заасан түншлэлийн төслийн хувьд аймаг, нийслэлийн Засаг дарга гаргана.

/Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан /

48.5.Түншлэлийн гэрээнд уг гэрээ дуусгавар болох, эрх шилжүүлэхтэй холбогдсон дараах асуудлыг тусгана:

48.5.1.төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө шилжүүлэх журам;

48.5.2.нийтийн зориулалттай дэд бүтэц, барилга байгууламжийг ажиллуулахад шаардлагатай технологи шилжүүлэх нөхцөл болон процесс;

48.5.3.төрийн түншлэгч этгээд, эсхүл үйл ажиллагаа явуулах, засвар үйлчилгээг хариуцах эрх шилжүүлэн авсан хувийн хэвшлийн шинэ түншлэгчийн ажилтнуудын сургалт;

48.5.4.сэлбэг хэрэгслийн хангалт зэрэг төрийн түншлэгч, эсхүл үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулах дараагийн түншид эрх шилжүүлснээс хойш тодорхой хугацаанд үргэлжлүүлэн үзүүлэх үйлчилгээний нөхцөл.

НАЙМДУГААР БҮЛЭГ

ТҮНШЛЭЛИЙН ТӨСӨЛ ХӨГЖҮҮЛЭХ САН, ТҮНШЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ, ТАЙЛАГНАЛТ, ХЯНАЛТ

49 дүгээр зүйл.Түншлэлийн төсөл хөгжүүлэх сан, түүний удирдлага

49.1.Энэ хуульд заасан түншлэлийг хэрэгжүүлэх, санхүүжилтийг шийдвэрлэх, төслийн бэлтгэл ажиллагаа, судалгаа шинжилгээ, сонгон шалгаруулалт явуулах, зөвлөх үйлчилгээний зардал болон түншлэлийн төвийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх зорилгоор Түншлэлийн төсөл хөгжүүлэх сан /цаашид "Сан" гэх/-г Засгийн газрын шийдвэрээр байгуулж болно.

49.2.Сангийн удирдлагыг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

49.3.Санг удирдах, түүний хөрөнгийг захиран зарцуулах, эх үүсвэрийг бүрдүүлэх болон зарцуулалтад хяналт тавихтай холбогдсон журмыг Засгийн газар баталж, мөрдүүлнэ.

50 дугаар зүйл.Сангийн эх үүсвэр, зарцуулалт, хяналт

50.1.Сангийн хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

50.1.1.улсын төсвөөс олгосон санхүүжилт;

50.1.2.олон улсын байгууллагаас олгосон хөнгөлөлттэй зээл, тусламж, хандив, бусад санхүүжилт;

50.1.3.Сангийн хөрөнгө оруулалт болон түншлэлийн төслийн бэлтгэл ажлын төлбөр, түншлэлийн төвийн үйл ажиллагаанаас олсон орлого;

50.1.4.Засгийн газрын баталгааны шимтгэл;

50.1.5.хууль тогтоомжид нийцсэн бусад.

50.2.Сангийн хөрөнгийг дараах үйл ажиллагаанд зарцуулна:

50.2.1.түншлэлийг хөгжүүлэх, гадаад болон дотоодод сурталчлах, олон нийтэд таниулах, ил тод тогтвортой орчныг бүрдүүлэх;

50.2.2.төслийн бэлтгэл үйл ажиллагаа, төслийн бүрэн шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ;

50.2.3.Түншлэлийн төвийн үйл ажиллагаа, мэргэжлийн зөвлөх үйлчилгээний зардал;

50.2.4.хувийн хэвшлийн түншлэгчийн сонгон шалгаруулалт, хэлэлцээр хийхтэй холбоотой зардал;

50.2.5.Сангийн журамд тусгагдсан бусад үйл ажиллагааны зардал.

50.3.Төсөл боловсруулахтай холбоотой Сангийн захиран зарцуулалт, удирдлагад түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

50.4.Сангийн хөрөнгийн бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон олон улсын стандартын дагуу хөтөлнө.

50.5.Санд жил бүр төрийн аудитын байгууллагаар, гурван жил тутамд олон улсын аудитын

байгууллагаар аудит хийлгэж, шаардлагатай тохиолдолд санхүүгийн хяналт, шалгалт хийж, тайлан, дүгнэлтийг Засгийн газарт тухай бүрд танилцуулна.

50.6.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн тайлагналтыг олон нийтэд ил тод, нээлттэй байлгах үүрэгтэй бөгөөд Сангийн орлого, зарлагын тайланг тухай бүр цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

50.7.Сангийн хөрөнгийг энэ хуульд зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.

50.8.Түншлэлийн төслийн бэлтгэл ажлын төлбөрийг түншлэлийн гэрээнд заасны дагуу санд төвлөрүүлнэ.

[/Энэ хэсгийг 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар нэмсэн./](#)

51 дүгээр зүйл.Түншлэлийн ил тод байдал

51.1.Нууцын тухай хууль тогтоомж, түншлэгч талуудын гэрээнд зааснаас бусад тохиолдолд түншлэлийн үйл ажиллагаа, мэдээлэл болон бүртгэл, тайлагналт нь олон нийтэд ил тод, нээлттэй байна.

51.2.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түншлэлийн төв болон төрийн түншлэгч нь түншлэлийн ил тод байдлыг дараах хэлбэрээр хангана:

51.2.1.түншлэлийн үйл ажиллагааг тухай бүр мэдээлж, тайлагнах;

51.2.2.түншлэлийн төслүүдийг мэдээлэх, сурталчлах;

51.2.3.хувийн хэвшлийн түншлэгчийн сонгон шалгаруулалтын бүх үйл ажиллагаа, үр дүнг нийтэд нээлттэй, ил тод тогтмол мэдээлэх;

51.2.4.түншлэлийн төсөл, төрийн болон хувийн хэвшлийн түншлэгчийн талаарх мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, бүртгэл хөтлөх, тогтмол шинэчлэх;

51.2.5.түншлэлийн хууль тогтоомжийн хэрэгжилт, түншлэлийн төслүүдийн төлөвлөлт болон хэрэгжилтийн талаар Засгийн газар, түншлэлийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнах;

51.2.6.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шаардсан түншлэлтэй холбоотой мэдээллийг хүргүүлж, тайлагнах;

51.2.7.түншлэлийн чуулга уулзалт, хэлэлцүүлгээр дамжуулан түншлэлийн төслүүдийг сурталчлах, хөрөнгө оруулагчдад түншлэлийн хууль тогтоомж, журам, аргачлалын талаар мэдээлэх;

51.2.8.түншлэлийн цахим хуудас болон бусад мэдээллийн сувгаар дамжуулан түншлэлийн төслийн үнэлгээ, хэрэгжилтийн тайланг тогтмол мэдээлэх.

51.3.Түншлэлийн төв нь түншлэлийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн түншлэгч бусад этгээдтэй хамтран түншлэлийн чуулга уулзалтыг тухай бүр зохион байгуулж, олон нийт, хувийн хэвшил, төрийн байгууллага, дотоод, гадаадын хөрөнгө оруулагч, сонирхогч этгээдийн оролцоог хангана.

51.4.Түншлэлийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн түншлэгч этгээд нь Шилэн дансны тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу түншлэлийн ил тод байдлыг хангаж ажиллана.

51.5.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түншлэлийн төвөөр дамжуулан үндэсний болон олон улсын судалгаа, шинжилгээ, шилдэг туршлагад суурилсан түншлэлийг зөв, оновчтой, үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн зөвлөмж, удирдамж, зааварчилгаа агуулсан түншлэлийн гарын авлагыг боловсруулж, хэвлүүлэн түншлэлийн үйл ажиллагаанд ашиглана.

51.6.Түншлэлийн төв энэ хуулийн 51.5-д заасан түншлэлийн гарын авлагыг шинэчилж, төрийн болон хувийн хэвшлийн түншлэгч байгууллагууд, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, олон нийтэд танилцуулж, түншлэлийн талаарх ойлголтыг сурталчлан таниулж, мэдээлэх, шаардлагатай сургалт, семинарыг зохион байгуулахтай холбогдсон үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

51.7.Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь түншлэлийн төслийн талаар дараах мэдээллийг энэ хуулийн 12.2.11-д заасан мэдээллийн нэгдсэн сангийн цахим хуудсанд нийтэлнэ:

51.7.1.түншлэлийн төслийн дэлгэрэнгүй мэдээлэл;

51.7.2.түншлэлийн гэрээ болон дагалдах гэрээний дүн, хугацаа;

51.7.3.түншлэлийн хөрөнгийг ашиглах эрх, үйлчилгээ үзүүлэх үүрэг, засвар үйлчилгээтэй холбоотой эрх, үүрэг.

51.8.Тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь түншлэлийн гэрээ байгуулагдсан даруйд тухайн түншлэлийн гэрээ болон дагалдах гэрээний хуулбарыг түншлэлийн мэдээллийн нэгдсэн цахим санд байршуулж, олон нийтэд мэдээлэх үүрэгтэй.

52 дугаар зүйл.Түншлэлийн мэдээллийн сан, тайлагналт

52.1.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Түншлэлийн төв нь түншлэлийн мэдээллийн нэгдсэн санг байгуулж, мэдээллийг нэгдсэн сангийн цахим хуудсанд тухай бүрд оруулан шинэчилж, ил тод, нээлттэй байдлыг хангаж ажиллана.

52.2.Хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн төслийн мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах бөгөөд энэ хуулийн 8.2-т заасан журмын дагуу төрийн түншлэгч болон түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангана.

52.3.Тухайн төрийн захиргааны төв байгууллага нь түншлэлийн төслийн төлбөр, санхүүжилтийн талаарх мэдээлэл болон Засгийн газрын баталгаа, дэмжлэгтэй холбоотой мэдээллийг олон нийтэд мэдээлнэ.

52.4.Энэ хуулийн 52.3-т заасан мэдээлэлд дараах асуудлыг тусгана:

52.4.1.төсвөөс санхүүжүүлэх хуваарь, түншлэлийн гэрээнд тусгагдсан хөнгөлөлт, түрээсийн төлбөр, болзошгүй өр төлбөр;

52.4.2.төрөөс хувийн хэвшлийн түншлэгчид төсвөөс олгох санхүүжилт;

52.4.3.төрийн болон хувийн хэвшлийн түншлэгч этгээдийн балансад бүртгэгдсэн хөрөнгө;

52.4.4.түншлэлтэй холбогдуулан Засгийн газраас гаргасан баталгааны мэдээлэл,

үргэлжлэх хугацаа, төрөөс хүлээх санхүүгийн нийт хариуцлага болон тухайн баталгаатай холбогдон гарах төсвийн зардал.

52.5.Төрийн түншлэгч буюу тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь түншлэлээр хэрэгжүүлж байгаа төслийн талаарх мэдээллийг агуулсан тайланг жил бүрийн 04 дүгээр сарын 20-ны дотор гаргаж түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх ба түншлэлийн мэдээллийн нэгдсэн санд байршуулж, тайлагнана.

52.6.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь түншлэлийн талаарх тухайн жилийн нэгдсэн тайланг жил бүрийн 06 дугаар сарын 10-ны дотор Засгийн газарт хүргүүлнэ.

52.7.Төрийн түншлэгч энэ хуулийн 52.5-д заасан мэдээлэлд дараах асуудлыг тусгана:

52.7.1.түншлэлийн төслийн дэлгэрэнгүй мэдээлэл, хэрэгжилтийн талаарх танилцуулга;

52.7.2.түншлэлийн төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилт, хэрэглэгчийн төлбөр, хураамж болон төсвөөс санхүүжүүлэх хуваарь, дүн;

52.7.3.түншлэлийн зүйлийг ашиглах эрх, үйлчилгээ үзүүлэх үүрэг, хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмжийг өөрийн хөрөнгөнд шилжүүлэх эрх, үүрэг;

52.7.4.түншлэлийн хугацааны эцэст аливаа хөрөнгийг хүлээн авах, шилжүүлэх үүрэг;

52.7.5.гэрээг сунгах, цуцлах заалт, бусад үндсэн ашиглалт болон засвар үйлчилгээний талаарх мэдээлэл.

53 дугаар зүйл.Хувийн хэвшлийн түншлэгчийн санхүүгийн тайлан

53.1.Хувийн хэвшлийн түншлэгч буюу төсөл хэрэгжүүлэгч компани нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу гаргаж, Аудитын тухай хуульд заасны дагуу аудит хийлгэнэ.

53.2.Хувийн хэвшлийн түншлэгч буюу төсөл хэрэгжүүлэгч компани нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1-д заасан тохирох стандартыг мөрдөх бөгөөд төсөлтэй холбоотой нягтлан бодох бүртгэл, тайлан тооцоог гаргаж, төрийн түншлэгч этгээд шалгахад бэлэн байлгана.

53.3.Хувийн хэвшлийн түншлэгч буюу төсөл хэрэгжүүлэгч компани нь аудитлагдсан санхүүгийн тайлан, холбогдох бусад мэдээллийг санхүүгийн жил дууссанаас хойш 6 сарын дотор түншлэлийн төв болон төрийн түншлэгчид хүргүүлнэ.

54 дүгээр зүйл.Түншлэлийн гэрээний хяналт

54.1.Түншлэлийн гэрээний биелэлтэд төрийн түншлэгч этгээд болох төсөл хэрэгжүүлэх салбарын төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага, түншлэлийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж, уг гэрээний биелэлтийн талаар холбогдох арга хэмжээ авч, хамтран ажиллах үүрэгтэй.

54.2.Түншлэлийн гэрээ, түүний биелэлт энэ хуульд заасан нөхцөл шаардлагад нийцэж байгаа эсэх талаар түншлэгч талууд Засгийн газарт, энэ хуулийн 13.2-т заасан түншлэлийн төслийн хувьд аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тухай бүр

танилцуулах ба төслийн хэрэгжилтийн талаар олон нийтэд мэдээлэх, тайлагнах замаар хамтарч ажиллана.

[Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан ./](#)

54.3.Энэ хуулийн 55.3-д заасны дагуу Төрийн аудитын төв байгууллага түншлэлийн гэрээний биелэлтэд хяналт тавьж, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайланг Засгийн газарт, энэ хуулийн 13.2-т заасан түншлэлийн төслийн хувьд аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

[Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

55 дугаар зүйл.Түншлэлийн төслийн хэрэгжилтийн хяналт, үнэлгээ

55.1.Төрийн түншлэгч түншлэлийн явцад хяналт тавьж, төслийн хэрэгжилтийн мониторинг болон үнэлгээг гэрээнд заасны дагуу тухай бүр гүйцэтгэнтүншлэлийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад танилцуулна.

55.2.Засгийн газар, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь түншлэлийн үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилт болон Сангийн хөрөнгийн удирдлага, зарцуулалтад жил бүр Төрийн аудитын тухай хуулийн дагуу аудит хийлгэж болно.

[Энэ хэсэгт 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан./](#)

55.3.Төрийн аудитын төв байгууллага төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, түншлэлийн төслийн төлөвлөлт, хувийн хэвшлийн түншлэгчийн сонгон шалгаруулалт, түншлэлийн төслийн хэрэгжилт болон гэрээний биелэлтэд аудит хийнэ.

55.4.Төрийн түншлэгч нь төслийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавих зорилгоор хөндлөнгийн үнэлгээний байгууллагатай гэрээ байгуулан ажиллуулж болох ба тус байгууллага нь хяналт, үнэлгээний үр дүн, үнэн зөв байдалд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

56 дугаар зүйл. Гомдол гаргах, хянан шийдвэрлэх

56.1. Хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулахтай холбоотой гомдол гаргах, маргаан шийдвэрлэх асуудлыг зохицуулах, түүнчлэн уг маргааныг хянан шийдвэрлэх зорилго бүхий маргаан шийдвэрлэх зөвлөлийг Засгийн газрын шийдвэрээр байгуулна.

56.2. Энэ хуулийн 56.1-д заасан зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Засгийн газар баталж, мөрдүүлнэ.

56.3. Хувийн хэвшлийн түншлэгчийн сонгон шалгаруулалт энэ хууль болон холбогдох журам зөрчсөн гэж үзсэн бол сонгон шалгаруулалтад оролцогч энэ хуулийн 56.1-д заасан маргаан хянан шийдвэрлэх зөвлөлд гомдол гаргаж болно.

56.4. Энэ хуулийн 25.4-т заасны дагуу мэдэгдэл хүргүүлснээс хойш ажлын 5 өдөрт багтаан гомдол гаргах эрхтэй байна.

[/Энэ хэсэгт 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./](#)

56.5. Түншлэлийн төслийн сонгон шалгаруулалттай холбоотой маргаан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн хүсэлтээр үндэсний болон олон улсын шинжээчийг оролцуулж, дүгнэлт гаргуулж болох бөгөөд холбогдох зардлыг оролцогч хариуцна.

56.6. Түншлэлийн төслийн сонгон шалгаруулалттай холбоотой маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн шийдвэрийг сонгон шалгаруулалтад оролцогч хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд шүүхэд гомдол гаргах эрхтэй.

57 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэх

57.1. Түншлэлийн гэрээ болон түншлэлийн төсөлтэй холбоотой аливаа маргааныг түншлэгч талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

57.2. Түншлэгч талууд энэ хуулийн 57.1-д заасны дагуу харилцан зөвшилцөлд хүрч чадаагүй тохиолдолд маргааныг түншлэлийн гэрээнд зааснаар Монгол Улсын шүүх, эсхүл үндэсний болон гадаадын арбитрад хандан шийдвэрлүүлнэ.

58 дугаар зүйл. Хариуцлага хүлээлгэх үндэслэл

58.1. Түншлэлийн гэрээг төрийн түншлэгч болон төрийн байгууллага, албан тушаалтан хууль тогтоомж, журамд заасан эрх хэмжээгээ хэтрүүлэн байгуулсан нь тогтоогдвол тус гэрээг цуцалж, гэрээнээс үүдэлтэй хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

58.2. Төрийн түншлэгч болон төрийн байгууллагын аливаа албан тушаалтан энэ хуулийн 58.1-д заасан зөрчлийг гаргасан бол тухайн албан тушаалтныг төрийн албанаас чөлөөлөх үндэслэл болно.

58.3. Хувийн хэвшлийн түншлэгч төрийн түншлэгчийн гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй, эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас учирсан хохирлыг гэрээнд зааснаар нэхэмжлэх эрхтэй.

58.4.Түншлэлийн гэрээний оролцогч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүй, эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх нь тухайн этгээдийг гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

59 дүгээр зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

59.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн болон зөрчлийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

59.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

59.3.Энэ хуулийг зөрчсөн этгээдэд торгууль оногдуулсан нь тухайн зөрчлийг арилгах, зөрчлийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

60 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

60.1.Энэ хуулийг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

/Энэ хэсэгт 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

**ТҮНШЛЭЛИЙН ЖУРАМ
АРГАЧЛАЛ**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 404

Улаанбаатар хот

ЖУРАМ, ЖИШИГ БАРИМТ БИЧИГ, ГЭРЭЭНИЙ ЗАГВАР, АРГАЧЛАЛ БАТЛАХ ТУХАЙ

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 7.2.1, 7.2.2, 7.2.3, 7.2.4, 7.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам"-ыг 1 дүгээр хавсралт, "Хувийн хэвшлийн түншлэгчийг болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам, жишиг баримт бичиг"-ийг 2 дугаар хавсралт, "Түншлэлийн гэрээ байгуулах журам, гэрээний стандарт загвар, гэрээний иж бүрдэл баримт бичиг"-ийг 3 дугаар хавсралт, "Түншлэлийн хүрээнд эрсдэл тооцоолох, хуваарилах аргачлал"-ыг 4 дүгээр хавсралт, "Түншлэлийн төслийн хэрэгжилт, санхүүжилт, зохион байгуулалт, тайлагналт болон хяналт тавих журам"-ыг 5 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

(Энэ тогтоолын 1, 3 дугаар хавсралтад Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт тус тус орж, 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсон)

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатарт даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Уралдаант шалгаруулалтын нарийвчилсан журам, жишиг баримт бичиг, санал үнэлэх журам батлах тухай" Засгийн газрын 2012 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 103 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ тогтоолыг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД БӨГӨӨД
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 63

Улаанбаатар хот

ЖУРАМ, ЖИШИГ БАРИМТ БИЧИГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ, ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, 7.2.1, 7.2.2, 7.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хувийн хэвшлийн түншлэгчийг болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам, жишиг баримт бичиг"-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.
2. "Журам, жишиг баримт бичиг, гэрээний загвар, аргачлал батлах тухай" Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 404 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам"-д доор дурдсан агуулга бүхий 5.11 дэх хэсэг нэмсүгэй:

"5.1¹. Төрийн үйлчилгээ үзүүлэх төслөөс хамааран техник, эдийн засгийн үндэслэл шаардахгүй бөгөөд мөнгөний үнэ цэнийн шинжилгээ, төсөвт үзүүлэх нөлөөллийн шинжилгээ, эрсдэлийн шинжилгээ, хууль зүйн дүн шинжилгээ болон нийгмийн нөлөөллийн шинжилгээг хийж болно."

3. Мөн журмын 9.2 дахь хэсгийн "2 дугаар бүлэгт заасан урьдчилсан үнэлгээг хийж," гэсний дараа "түншлэлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхэд тохиромжтой гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд" гэж нэмсүгэй.

4. Мөн журмын 2.1, 2.2, 2.5, 5.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"2.1. Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, хувийн хэвшил түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналыг Түншлэлийн төвд гаргана.

2.2. Аймаг, нийслэлийн хэмжээнд түншлэлээр хэрэгжүүлэх Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 11.2.2-т заасан төслийн саналыг Түншлэлийн төвд гаргана.

2.5. Түншлэлийн төв энэ журмын 2.3 дахь хэсэгт заасан мэдээллийг тусгасан түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналыг хүлээн авна.

5.2. Төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг төсвийн болон хувийн хэвшлийн санхүүжилтээр боловсруулж болох бөгөөд тухайн техник, эдийн засгийн үндэслэлийг бүрэн шинжилгээ хийх шийдвэр гарахаас өмнө гурван жилийн дотор тухайн салбарын шинжлэх ухаан, технологийн, эсхүл мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж тодотгосон байна."

5. Мөн журмын 2.6 дахь хэсгийн "түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага" гэснийг "Түншлэлийн төв" гэж, 2.7 дахь хэсгийн "төрийн захиргааны байгууллага" гэснийг "төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, хувийн хэвшил" гэж, 2.8.2 дахь заалтын "төрийн захиргааны төв байгууллагаас" гэснийг "төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, хувийн хэвслээс" гэж, 2.15 дахь хэсгийн "төрийн захиргааны төв байгууллагад" гэснийг "төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, хувийн хэвшилд" гэж тус тус өөрчилсүгэй.

6. Мөн журмын 2.14 дэх хэсгийн "Энэ журмын 2.12-т заасан төслийн хувьд мөн журмын 2.13-т заасан саналыг харгалзан үзнэ." гэснийг, 4.1.2 дахь заалт болон 5.3, 5.4 дэх хэсгийн "урьдчилсан болон нарийвчилсан" гэснийг тус тус хассугай.

7. "Журам, жишиг баримт бичиг, гэрээний загвар, аргачлал батлах тухай" Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 404 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулах журам"-ын 1.7, 3.3, 4.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"1.7.Түншлэлийн төсөл нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 18.1, 18.2-т заасан шаардлагыг хангасан байх бөгөөд төрийн үйлчилгээ үзүүлэх төсөлд мөн хуулийн 18.4-т заасан зохицуулалтыг баримтална.

3.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь сонгон шалгаруулалт, түншлэгчтэй хийсэн хэлэлцээрийн дүн, ажлын хэсгийн дүгнэлтийг төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийн талаас нь хянаж, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 9.1.8-д заасан журмыг баримтлан түншлэлийн гэрээ байгуулах эсэх санал, дүгнэлтийг ажлын 10 өдөрт багтаан түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.7.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түншлэлийн гэрээ байгуулах тухай санал, дүгнэлтийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн санал, дүгнэлтийн хамт Засгийн газарт танилцуулж, түншлэлийн гэрээ байгуулах эсэх шийдвэрийг гаргуулна."

8. Мөн журмын 2.4.4 дэх заалтын "түншлэлийн мэдээллийн нэгдсэн санд" гэснийг "цахим системд" гэж, 3.2, 4.5, 6.6 дахь хэсгийн

"зөвшөөрөл" гэснийг "санал, дүгнэлт" гэж, 6.1 дэх хэсгийн "зөвшөөрлийг" гэснийг "санал, дүгнэлтийг" гэж, 4.6 дахь хэсгийн "зөвшөөрөл олгохдоо" гэснийг "санал, дүгнэлт ирүүлэхдээ" гэж, 6.2 дахь хэсгийн "зөвшөөрөл олгоно." гэснийг "санал, дүгнэлт ирүүлнэ." гэж, 6.5 дахь хэсгийн "зөвшөөрөлд" гэснийг "санал, дүгнэлтэд" гэж, 8.2 дахь хэсгийн "3.5-д заасан зөвшөөрлийг" гэснийг "4.7-д заасан санал, дүгнэлтийг" гэж тус тус өөрчилсүгэй.

9. "Журам, жишиг баримт бичиг, гэрээний загвар, аргачлал батлах тухай" Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 404 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийж журам"-ын 2.12, 2.13, 5.5, мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Хувийн хэвшлийн түншлэгчийг болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам, жишиг баримт бичиг", мөн тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулах журам"-ын 3.4, 3.5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД
БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД

Ж.ЭНХБАЯР

Засгийн газрын 2023 оны 11 дүгээр
сарын 15-ны өдрийн 404 дүгээр
тогтоолын 1 дүгээр хавсралт

ТҮНШЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН БҮРЭН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд түншлэлээр хэрэгжүүлэхээр хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан төсөлд түншлэлээр хэрэгжүүлэх төслийн үр ашиг, ач холбогдлыг нарийвчлан судалж тогтоох, хэрэгжүүлэх боломжийн талаар дүгнэлт гаргах, түншлэлийн төрөл, төслийг хэрэгжүүлэх гэрээний төрөл, хэлбэрийг тодорхойлох зорилгоор түншлэлийн төслийн төлөвлөлт, урьдчилсан үнэлгээ, түншлэлийн төслийн бүрэн шинжилгээ (цаашид “төслийн бүрэн шинжилгээ” гэх) хийх үйл ажиллагааг зохицуулна.

1.2.Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан утгаар ойлгоно.

Хоёр.Түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээ хийх

2.1.Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, хувийн хэвшил түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналыг Түншлэлийн төвд гаргана. (Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан)

2.2.Аймаг, нийслэлийн хэмжээнд түншлэлээр хэрэгжүүлэх Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 11.2.2-т заасан төслийн саналыг Түншлэлийн төвд гаргана. (Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан)

2.3.Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналд дараах мэдээллийг тусгасан байх бөгөөд холбогдох судалгаа, шинжилгээ, тооцоо мэдээлэл нь сүүлийн 3 жилийн дотор хийгдсэн байна:

2.3.1.төслийн мэдээлэл, танилцуулга. Энэ журмын нэгдүгээр хавсралт (Маягт 1-8)-д заасны дагуу дараах мэдээллийг бүрдүүлнэ:

- Төслийн үндсэн мэдээлэл, танилцуулга;
- Төслийн нийгмийн ач холбогдлын мэдээлэл;
- Төслийн эдийн засгийн бусад үр ашгийн талаарх мэдээлэл;
- Төсөл хэрэгжүүлэх салбарын хууль, эрх зүйн орчны мэдээлэл;
- Төслийн улс, бүс нутаг, орон нутаг, салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй нийцэж буй талаарх мэдээлэл;
- Төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдсан байдлын талаарх мэдээлэл;

- Төслийн дэд бүтцийн хэрэгцээний мэдээлэл;
- Ажлын байрны мэдээлэл;
- 2.3.2.хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө;
- 2.3.3.санхүү, хөрөнгө оруулалтын тооцоо;
- 2.3.4.санхүү, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ;
- 2.3.5.Урьдчилсан үнэлгээнд шаардлагатай бусад мэдээлэл

2.4.Энэ журмын 2.3.4-т дурдсан санхүү, эдийн засгийн үр ашгийн шинжилгээг энэ журмын хоёрдугаар хавсралтад заасан зааврын дагуу боловсруулна.

2.5.Түншлэлийн төв энэ журмын 2.3 дахь хэсэгт заасан мэдээллийг тусгасан түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналыг хүлээн авна.

(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан)

2.6.Төслийн санал нь 2.3-т заасан мэдээллийг агуулаагүй, эсхүл холбогдох тооцоо, судалгааг бүрэн боловсруулаагүй тохиолдолд Түншлэлийн төв нь тус төслийн саналыг буцааж болох бөгөөд үндэслэлийг дурдсан байна.

(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан)

2.7.Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, хувийн хэвшил нь энэ журмын 2.6-д заасан үндэслэлийг ханган боловсруулж, саналыг дахин гаргаж болно.

(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан)

2.8.Түншлэлийн төв нь салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран 30 хоногийн дотор урьдчилсан үнэлгээг дараах байдлаар хийнэ;

2.8.1.салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага урьдчилсан үнэлгээг хийхэд шаардлагатай мэдээллээр хангаж, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон тооцоо, судалгаа гаргахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлнэ;

2.8.2.түншлэлийн төв нь салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, хувийн хэвشلээс ирүүлсэн мэдээлэл болон холбогдох бусад тооцоо, судалгаанд үндэслэн урьдчилсан үнэлгээний тайлан бүхий дүгнэлтийг боловсруулж, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр хүргүүлнэ.

(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан)

2.9.Түншлэлийн төв нь урьдчилсан үнэлгээ хийхэд мэргэжил, арга зүйн туслалцаа шаардлагатай гэж үзсэн тохиолдолд мэргэжлийн зөвлөх үйлчилгээг холбогдох хууль, журмын дагуу авч болно.

2.10.Урьдчилсан үнэлгээгээр төслийн саналыг түншлэлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхэд тохиромжтой эсэхийг урьдчилсан байдлаар тогтооно.

2.11.Түншлэлээр хэрэгжүүлэх төсөл нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 18.1-д заасан нийтлэг шаардлагыг хангасан байна.

2.12.Урьдчилсан үнэлгээгээр төслийн саналыг түншлэлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхэд тохиромжтой гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага урьдчилсан үнэлгээг хянуулахаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон)

2.13.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага урьдчилсан үнэлгээний дүгнэлтийг хянаж, саналаа түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

[\(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон\)](#)

2.14.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 2.8.2-т заасан урьдчилсан үнэлгээний тайлан, дүгнэлтийг хянаж, баталгаажуулна.

[\(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон\)](#)

2.15.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 2.14-т заасны дагуу хянан баталгаажуулсан тайлан, дүгнэлтийн талаар санал гаргасан салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, хувийн хэвшилд бичгээр мэдэгдэнэ.

[\(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон\)](#)

Гурав.Түншлэлээр хэрэгжүүлэх төслийг хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах

3.1.Энэ журмын 2.14-т заасны дагуу хянан баталгаажсан түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой төслийг хөгжлийн бодлогын баримт бичигт тусгуулах асуудлыг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох хуулийн хүрээнд хэрэгжүүлнэ.

3.2.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан төслүүдийг өөрийн цахим хуудас, мэдээллийн сангаар дамжуулан 12 сар хүртэлх хугацаанд олон нийтэд зарлаж болно.

3.3.Зөвхөн урьдчилсан үнэлгээ хийгдэж, түншлэлээр хэрэгжүүлэхэд тохиромжтой гэж тогтоогдсон, хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан төсөлд бүрэн шинжилгээ хийнэ.

Дөрөв.Төслийн бүрэн шинжилгээ хийх үе шат, төслийн дүн шинжилгээ хийх

4.1.Түншлэлийн төсөлд бүрэн шинжилгээ хийх, үнэлэх ажиллагаа дараах үе шаттай байна:

4.1.1.түншлэлийн төслийн дүн шинжилгээг хийх;

4.1.2.түншлэлийн төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах;

[\(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон\)](#)

4.1.3.түншлэлийн төслийн эх хувийг боловсруулах;

4.1.4.түншлэлийн төслийн эрсдэлийг судалж тодорхойлох.

4.2.Түншлэлийн болон салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төслийн бүрэн шинжилгээ хийх төслийн багийг төсөл тус бүрээр Түншлэлийн төвийн дэргэд байгуулна.

4.3.Төслийн баг байгуулах шийдвэрт багийн бүрэлдэхүүн, чиг үүрэг, төслийн бүрэн шинжилгээ хийх хугацаа зэргийг тусгасан байна.

4.4.Төслийн баг нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүд бүхий 7-оос доошгүй тооны бүрэлдэхүүнтэй байна. Төслийн багийн бүрэлдэхүүнд дараах байгууллагын төлөөллийг оруулна:

- түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл;
- салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл;
- түншлэлийн төслөөс хамааран холбогдох төрийн байгууллагын төлөөлөл;
- Түншлэлийн төвийн төлөөлөл;
- төсөл хэрэгжих аймаг, нийслэлийн төлөөлөл;
- төслийн багийн бүрэлдэхүүний 30-аас доошгүй хувь байх санхүү, эдийн засаг, хууль, эрх зүй, нийгэм, байгаль орчин болон холбогдох бусад салбарын үндэсний, олон улсын мэргэжлийн судлаач, зөвлөх, хөндлөнгийн хараат бус зөвлөх гишүүн

4.5.Төслийн баг тухайн төслийн хүрээнд хийгдсэн ажил, баримт бичигт дүн шинжилгээ хийж, бүрэн шинжилгээ хийх ажлын цар хүрээг тодорхойлж, шаардлагатай зардлыг тооцно.

4.6.Бүрэн шинжилгээ хийхтэй холбоотой зардлыг түншлэлийн төсөл хөгжүүлэх сангаас болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

4.7.Төслийн бүрэн шинжилгээг төслийн багийг байгуулснаас хойш 6 сарын дотор хийж дуусгах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэг удаа 6 хүртэл сарын хугацаагаар сунгаж болно.

4.8.Төслийн баг тухайн төслийн талаар олон нийт, иргэд, төрийн болон бусад байгууллагатай хамтран хэлэлцүүлэг зохион байгуулж, саналыг авч болно.

Тав.Түншлэлийн төслийн урьдчилсан болон нарийвчилсантехник, эдийн засгийн үндэслэл боловсруулах

5.1.Төслийн баг болон түншлэлийн төв түншлэлийн төслийн урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл болон нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна.

5.1¹Төрийн үйлчилгээ үзүүлэх төслөөс хамааран техник, эдийн засгийн үндэслэл шаардахгүй бөгөөд мөнгөний үнэ цэнийн шинжилгээ, төсөвт үзүүлэх нөлөөллийн шинжилгээ, эрсдэлийн шинжилгээ, хууль зүйн дүн шинжилгээ болон нийгмийн нөлөөллийн шинжилгээг хийж болно.

(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор нэмсэн)

5.2.Төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг төсвийн болон хувийн хэвшлийн санхүүжилтээр боловсруулж болох бөгөөд тухайн техник, эдийн засгийн үндэслэлийг бүрэн шинжилгээ хийх шийдвэр гарахаас өмнө гурван жилийн дотор тухайн салбарын шинжлэх ухаан, технологийн, эсхүл мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж тодотгосон байна.

(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан)

5.3.Төслийн баг техник, эдийн засгийн үндэслэлийг мэргэжлийн зөвлөх үйлчилгээ авч гүйцэтгүүлж болно. Мэргэжлийн зөвлөх үйлчилгээний зардлыг Түншлэлийн төсөл хөгжүүлэх сангийн хөрөнгөөс санхүүжүүлж болно.

(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)

5.4.Техник, эдийн засгийн үндэслэлд дараах агуулгыг тусгана:

(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)

5.4.1.төслийн хэмжигдэхүйц зорилтод үндэслэн төслийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон байх;

5.4.2.хууль зүйн дүн шинжилгээ, нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн шинжилгээ хийж баталгаажуулсан байх;

5.4.3.техникийн шаардлага, төслийн орц, гарц болон хүрэх үр дүнг тодорхойлсон байх;

5.4.4.төрийн үйлчилгээ нь холбогдох стандартын шаардлагыг хангасан байх;

5.4.5.төслийн үйл ажиллагаанд шаардлагатай Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу олгогдох тусгай болон энгийн зөвшөөрлийг тодорхойлсон байх;

5.4.6.төслийн нийт зардлыг тухайн төслийн үе шатны бүх зардлыг оролцуулан нэгдсэн дүнгээр тодорхойлсон байх;

5.4.7.түншлэлийн төслийн дагуу үзүүлэх төрийн үйлчилгээ нь нийтэд зориулсан, төлбөр нь зах зээлийн үнэтэй уялдсан, бүртгэл хийх боломжтой байх;

5.4.8.байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлсэн байх;

5.4.9.санхүүгийн эх үүсвэрийн боломж, түншлэлд зөвлөгөө болон дэмжлэг үзүүлэх чадавх;

5.4.10.төслийн мэдээлэл, танилцуулга, төсөл хэрэгжих бэлэн байдал, төслийн нийт өртөг, ашиглалтын хугацаа, хэрэгжүүлэх хуваарь;

5.4.11.түншлэлийн төрөл, төсвөөс санхүүжүүлэх санхүүжилтийн хуваарь, хэрэглэгчийн төлбөр, хураамжийн судалгаа, зардал, үр ашгийн тооцоолол, төслийн санхүүжилтийн мэдээлэл;

5.4.12.төслийн барилга байгууламж болон үйл ажиллагааны тодорхойлолт;

5.4.13.төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах төрийн байгууллага;

5.4.14.төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах төрөөс үзүүлэх дэмжлэгийн төрөл;

5.4.15.төслийн онцлогоос хамаарсан шаардлагатай бусад мэдээлэл.

5.5.Нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг шаардлагатай тохиолдолд тухайн төсөл хэрэгжих салбарын хууль тогтоомжийн дагуу эрх бүхий байгууллагаар батлуулж болно.

(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон)

Зургаа.Түншлэлийн эх төслийг боловсруулах

6.1.Төслийн баг түншлэлээр хэрэгжүүлэхээр санал болгосон төслийн түншлэлийн эх төслийг боловсруулах бөгөөд дараах шинжилгээг хийнэ:

6.1.1.Мөнгөний үнэ цэнийн шинжилгээ;

6.1.2.Төслийг хэрэгжүүлэх түншлэлийн төрөл, гэрээний хэлбэр, төсөл хэрэгжих хугацаа.

6.2.Түншлэлийн эх төсөлд нийтийн зориулалттай дэд бүтэц, барилга байгууламж, нийгмийн суурь үйлчилгээг түншлэлээр үзүүлэхэд шаардагдах техник, эдийн засаг, санхүү, хууль, эрх зүй, нийгэм болон байгаль орчны нөлөөллийн үндэслэл, нотолгоо, тоон баримт зэргийг тусгасан байна.

6.3.Түншлэлийн эх төсөл боловсруулахтай холбоотой зардлыг "Түншлэлийн төсөл хөгжүүлэх сан"-аас санхүүжүүлэх бол зардлыг тооцож, холбогдох журмын дагуу шийдвэрлүүлнэ.

Долоо.Түншлэлийн төслийн эрсдэлийг судалж, тодорхойлох

7.1.Төслийн баг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 7.2.4-т заасан аргачлалын дагуу эрсдэлийн шинжилгээг гүйцэтгэж, эрсдэлийг бууруулах хүрээнд Засгийн газрын баталгаа гаргах эсэх санал гаргана.

7.2.Төслийн баг төслийн төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийг тооцохдоо санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллах ба Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 9.2-т заасан загварын дагуу төслийн төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл, мөн түншлэлийн гэрээний дагуу төсөвт шууд болон шууд бус төлбөрийн үүрэг, хариуцлагыг бий болгох эсэхийг тооцно.

7.3.Төслийн баг энэ журмын 7.1, 7.2-т тодорхойлсон эрсдэлийн үнэлгээг үндэслэн эрсдэлийн удирдлагын арга хэмжээг төлөвлөж эх төсөлд тусгана.

Найм.Дүгнэлт гаргах

8.1.Төслийн баг түншлэлийн төсөл нь энэ журмын 7.2-т заасан үнэлгээгээр өндөр эрсдэлтэй, тухайн төсөлд шаардагдах төрөөс үзүүлэх дэмжлэгийг төрөөс үзүүлэх боломжгүй гэж дүгнэсэн тохиолдолд түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналыг буцаах, хөгжлийн бодлогын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах, төслийн эх үүсвэрийг өөрчлөх талаарх саналаа түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

8.2.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн төслийг түншлэлээр хэрэгжүүлэхэд тохиромжгүй болох нь тогтоогдсон бол төслийг төсөл санаачлагчид буцаах шийдвэр гаргана.

8.3.Төслийн баг төслийн бүрэн шинжилгээний үр дүнгээс хамаарч түншлэлээр хэрэгжүүлэх зарим уялдаатай төслийг нэгтгэж нэг төсөл болгон хэрэгжүүлэх нь үр ашигтай гэж үзсэн тохиолдолд нэгтгэн хэрэгжүүлэх саналаа түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн

захиргааны төв байгууллагад гаргаж болно.

8.4.Түншлэлийн төслийн баг бүрэн шинжилгээгээр түншлэлээр хэрэгжүүлэхэд тохиромжтой гэж тодорхойлсон төслийг төслийн иж бүрэн баримт бичгийн хамт түншлэлийн болон салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүрэн шинжилгээ хийгдэж, дүгнэлт гарснаас хойш ажлын 5 өдөрт багтаан хүргүүлнэ.

Ес.Хувийн хэвшлээс түншлэлийн төсөл санаачлах

9.1.Хувийн хэвшлээс төсөл санаачлахад Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан зохицуулалтыг баримтална.

9.2.Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 9.1-д заасан саналд мөн журмын 2 дугаар бүлэгт заасан урьдчилсан үнэлгээг хийж, түншлэлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхэд тохиромжтой гэсэн дүгнэлт гарсан тохиолдолд хянан баталгаажуулахаар түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

[\(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор нэмэлт орсон\)](#)

9.3.Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын урьдчилсан үнэлгээгээр түншлэлээр хэрэгжүүлэх боломжгүй гэж тогтоогдсон, салбарын бодлого төлөвлөлт, түншлэлийн төсөлд тавигдах нийтлэг шаардлагад нийцээгүй төслийн саналыг хувийн хэвшилд буцааж болно.

“Түншлэлээр хэрэгжүүлэх
төслийн бүрэн шинжилгээ хийх журам” -ын
1 дүгээр хавсралт

ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ, ТАНИЛЦУУЛГА

Маягт 1. Төслийн үндсэн мэдээлэл

Төслийн нэр	
Төслийн зорилго	
Төслийн зорилтууд	
Санал ирүүлсэн яам, агентлаг	

№	Үзүүлэлт	Танилцуулга		
1	Төсөл хэрэгжих салбар			
2	Төсөл хэрэгжих дэд салбар			
3	Төсөл хэрэгжих байршил /Хэд хэдэн байршилд хэрэгжих төсөл бол байршил тус бүрээр мэдээллийг оруулна/	Аймаг, хот 1		
		Сум, дүүрэг 1		
		Хаяг 1		
		Аймаг, хот ... n		
		Сум, дүүрэг ... n		
		Хаяг ... n		
4	Газрын асуудал шийдэгдсэн эсэх	Үгүй бол	Шалтгаан, тайлбар	
		Тийм бол	Гэрчилгээний дугаар	
			Гэрчилгээний төрөл	Аль нэгийг сонгоно уу: а) эзэмших б) ашиглах в) өмчлөх
			Гэрчилгээ олгосон огноо	Он: ... Сар: ...Өдөр:
			Гэрчилгээ дуусах огноо	Он: ... Сар: ...Өдөр: ...
			Шийдвэр гаргасан	Аймаг /нийслэл/: Сум, дүүрэг: Албан тушаал: Нэр:
5	Төслийн нийт төсөвт өртөг: /сая. төгрөгөөр илэрхийлэх ба төслийн нийт төсөвт өртгийн дүн/	 сая.төгрөг		

6	Төсөл хэрэгжих хугацаа: /Нийт хэдэн жилийн дотор хэрэгжүүлэхээр төлөвлөж байгааг тодорхой бичих/	Бүтээн байгуулалт	
		Хугацаа:сар Эхлэх он: Дуусах он:	
		Ашиглалт, үйлчилгээ	
		Хугацаа:жил Эхлэх он: Дуусах он:	
7	Төслийн хэрэгцээ, шаардлага	Эрэлт, хэрэгцээ, шаардлага	
		Зах зээлийн өнөөгийн төлөв байдал	
8	Хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөө	Хүрээлэн буй орчинд ээлтэй технологи, менежментийн шийдэлтэй эсэх:	
		Хүрээлэн буй орчныг хамгаалах хариуцлагын тогтолцоог нэвтрүүлсэн эсэх:	
9	Бүс, орон нутгийн хөгжилд үзүүлэх нөлөө	Төсөл хэрэгжих бүс, орон нутгийн эдийн засгийн хэрэгцээ, шаардлагыг хангаж буй эсэх:	
		Төсөл хэрэгжих бүс, орон нутгийн нийгмийн хэрэгцээ, шаардлагыг хангаж буй эсэх:	
		Төсөл хэрэгжих бүс, орон нутгийн дэд бүтцийн хэрэгцээ шаардлагыг хангаж буй эсэх:	

10	Хувийн хэвшил өөрийн санаачилгаар төслийн санал ирүүлсэн бол	Байгууллагын нэр:	
		Үйл ажиллагааны чиглэл:	
		Үүсгэн байгуулагдсан огноо:	
		Туршлага, гүйцэтгэж байсан томоохон ажлын мэдээлэл:	
		Байгууллагын санхүүгийн чадавх:	
		Хувийн хэвшлийн байгууллагын хариуцсан ажилтан	Нэр: Албан тушаал: Утас /ажил, гар/: И-мэйл:
11	Төслийн өнөөгийн байдал: /Төслийн хүрээнд хийгдсэн ажлуудын талаар товч танилцуулга/		
12	Бүтээгдэхүүн, үйлчилгээний товч танилцуулга		
13	Яам, агентлагаас тухайн төслийг хариуцсан мэргэжилтэн	Нэр: Албан тушаал: Утас /ажил, гар/: И-мэйл:	

Маягт 2.Төслийн нийгмийн ач холбогдлын мэдээлэл

№	Үзүүлэлт	Танилцуулга
1	Нийгмийн/иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл	
2	Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд нөлөөлөх нөлөөлөл	
3	Иргэдийн мэдлэг, боловсролын түвшнийг дээшлүүлэхэд үзүүлэх нөлөөлөл	
4	Ядуурлыг бууруулахад нөлөөлөх нөлөөлөл	
5	Тухайн бус, орон нутгийн хөгжилд үзүүлж буй нөлөөлөл	
6	Байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл	
7	Технологи, инновацын хөгжилд нөлөөлөх нөлөөлөл /Нэвтрүүлэх дэвшилтэт техник, технологи тус бүрээр/	
8	Бусад	

Маягт 3.Төслийн эдийн засгийн бусад үр ашгийн талаарх мэдээлэл

№	Үзүүлэлт	Танилцуулга
1	Экспортод чиглэсэн	
2	Импортыг орлох	
3	Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	
4	Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих	
5	Төсөл хэрэгжих хугацаанд улсад төлөх нийт татвар, төлбөр хураамж /сая.төг/	
6	Шинээр бий болгох ажлын байрны тоо	
7	Бусад	

Маягт 4.Төсөл хэрэгжүүлэх салбарын хууль, эрх зүйн орчны мэдээлэл

№	Үзүүлэлт	Танилцуулга
Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой хууль зүйн үндэслэл, эрх зүйн орчин		
1	Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой хууль, эрх зүйн акт /Хууль, эрх зүйн актын нэр, холбогдох заалт/	
2	Төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр боловсруулах, эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулах хууль, захиргааны хэм хэмжээний акт байгаа эсэх /Хэрэв байгаа бол хууль, хэм хэмжээний актын хэрэгцээ, шаардлагын талаарх судалгаа, үндэслэлийг тодорхой бичих/	
3	Төрийн дэмжлэг, онцгой зохицуулалт /аливаа хууль, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу онцгой зохицуулалтад хамрагдах эсэх, эсхүл татварын болон татварын бус хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх, экспорт, импортын хязгаарлалт, урамшуулал эдлэх гэх мэт төрийн дэмжлэгийн хэлбэрүүд/	

Маягт 5. Төслийн улс, бүс нутаг, орон нутаг, салбарын хөгжлийн бодлого, төлөвлөлттэй нийцэж байгаа талаарх мэдээлэл

№	Үзүүлэлт	Танилцуулга
Хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилттой нийцэж байгаа эсэх		
1	Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилтуудтай нийцэх байдал /Дэлхийн тогтвортой хөгжлийн 17 чиглэлийн, 169 зорилтоос яг аль зорилтыг хангахад нөлөөлөхийг тодорхой бичнэ/	

2	Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлого 2020-2050-тай нийцэх байдал /Аль зорилтыг хангахад нөлөөлөхийг тодорхой бичнэ/	
3	10 хүртэлх жилийн дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилттой нийцэх байдал /Аль зорилтыг хангахад нөлөөлөхийг тодорхой бичнэ/	
4	5 хүртэлх жилийн дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилттой нийцэх байдал /Аль зорилтыг хангахад нөлөөлөхийг тодорхой бичнэ/	
5	"Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр"-тэй нийцэж буй байдал /Хэддүгээр заалттай хэрхэн нийцэж буйг тодорхой бичнэ/	
6	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцэж буй байдал /Хэддүгээр заалттай нийцэж буйг тодорхой бичнэ/	
7	Төсөл хэрэгжих салбарын төрөөс баримтлах бодлогод нийцэж буй байдал /Бодлогын баримт бичгийн нэр, заалтыг тодорхой бичнэ/	
8	Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын зорилттой нийцэх байдал	
9	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцэж буй байдал /Бодлогын баримт бичгийн нэр, заалтыг тодорхой бичнэ/	
10	Үндэсний хөтөлбөр болон бусад бодлогын баримт бичигтэй нийцэж буй байдал /Бусад ямар ямар бодлогын бичиг баримттай хэрхэн нийцэж буйг тодорхой бичнэ/	
Зөрчилдөж буй хууль тогтоомж байгаа эсэх		
1	Тухайн төслийг зайлшгүй хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага бий боловч зарим хууль тогтоомж, журамтай зөрчилдөж байгаа эсэх /Хэрэв тийм бол ямар хууль тогтоомжтой зөрчилдөж байгааг үндэслэл, шалтгааны хамт тодорхой бичнэ үү./	

Маягт 6.Төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдсан байдлын талаарх мэдээлэл

№	Судалгаа шинжилгээний ажил, боловсруулсан баримт бичгийн бүрдэл	Танилцуулга (Хийгдсэн судалгаа, шинжилгээг ирүүлэх)
1	Суурь судалгаа: /Хууль, эрх зүйн орчин, төслийн эрэлт, хэрэгцээ шаардлага, нөхцөл байдлын шинжилгээ гэх мэт суурь судалгаануудыг тусгах/	
2	Макро эдийн засгийн өнөөгийн байдлын шинжилгээ: /ДНБ, эдийн засгийн өсөлт, төсөл хэрэгжих салбарын ДНБ-д эзлэх хувь гэх мэт макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд шинжилгээ хийж, төсөлд/төслийн үзүүлэх нөлөөллийг урьдчилсан байдлаар томъёолно./	
3	Төсөл хэрэгжих салбар, дэд салбарын өнөөгийн байдлын шинжилгээ: /төсөл хэрэгжих салбар, дэд салбарын хөгжлийн түвшин, үр дүн, нөхцөл байдлыг тодорхойлдог үндсэн суурь үзүүлэлтүүд ямар байгаа, тэдгээрийг урт, дунд, богино хугацаандаа хэрхэн өөрчлөх зорилтыг засгийн газраас дэвшүүлсэн болох, тэдгээр зорилтоо хангах үүднээс авч хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүд, тэдгээрийн явц, үр дүн ямар байгаа зэргийг тодорхойлно./	
4	Урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл (Хийгдсэн бол ирүүлэх)	
5	Нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл (Хийгдсэн бол ирүүлэх)	
6	Бусад улсын хувьд ижил төстэй төслийн хэрэгжсэн байдлын талаарх туршлагын судалгаа	
7	Бодлогын судалгаа	
8	Зураг төсөл (Зураг төсөл хийгдсэн бол ирүүлэх)	
9	Төсөв /Төсөв хийгдсэн бол ирүүлнэ. Хийгдээгүй бол салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь урьдчилсан байдлаар төсвийг тооцоолж ирүүлнэ./	
10	Тухайн төсөл хэрэгжих салбар болон дэд салбар зэрэгт холбогдох байгууллагуудаас санал, судалгаа авсан эсэх	

Маягт 7.Төслийн дэд бүтцийн хэрэгцээний мэдээлэл /төслийн нийт хүчин чадлаар тооцно./

№	Дэд бүтэц	Хэмжих нэгж	Нийт хэрэгцээ	Одоогийн байдал	Өргөтгөх/Шинээр барих	Тайлбар
1	Эрчим хүчний хангамж					
2	Дулаан хангамж					
3	Ахуйн ус хангамж					
4	Технологийн ус хангамж					
5	Цэвэрлэх байгууламж, ариутгах татуурга					
6	Мэдээлэл, харилцаа холбоо					
7	Авто зам					
8	Төмөр зам					
9	Бусад					

Маягт 8.Ажлын байрны мэдээлэл

№	Мэргэжлийн чиглэл	Шууд ажлын байр				Шууд бус ажлын байр			
		Дотоод ажиллах хүч		Гадаад ажиллах хүч		Дотоод ажиллах хүч		Гадаад ажиллах хүч	
		T1	T2	T1	T2	T1	T2	T1	T2
1	Удирдах ажилтан								
2	Инженер технологийн ажилчид								
3	Мэргэжлийн ажилчид								
4	Бусад ажилчид								
	Нийт								

Шууд ажлын байр: Тухайн төслийг хэрэгжүүлснээр бий болгосон шууд хөдөлмөр эрхлэлт буюу шууд цалинждаг, хөдөлмөрийн гэрээ хийсэн үндсэн ажилтнууд ба төслийн талбай дээр байнга ажиллах гэрээт ажилтнууд орно.

Шууд бус ажлын байр: Тухайн төслийг хэрэгжүүлснээр бий болгосон шууд бус хөдөлмөр эрхлэлт буюу гэрээлэгчид, тухайн компанийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажилтан орно. Энэ нь урт хугацааны ажлын байр биш байж болно. Жишээ нь: Гэрээт байгууллагаас цалинждаг, төслийн ханган нийлүүлэгч байгууллага, эсхүл гэрээт байгууллагын ханган нийлүүлэгч ба гэрээлэгч байгууллагад ажилладаг.

T1	Төслийн бэлтгэл ажил хийгдэж байх хугацааны үед
	Төслийн бүтээн байгуулалт хийгдэж байх хугацааны үед
T2	Бүтээн байгуулалт дуусаж, ажиллуулах туршилтын хугацааны үед
	Туршилтын хугацааны дараа буюу үйл ажиллагаа жигдэрснээс хойших үед

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШГИЙН ШИНЖИЛГЭЭ

1.Төслийн анхны хөрөнгө оруулалтын зардлыг тооцоолох

Анхны хөрөнгө оруулалт гэдэг нь тухайн хөрөнгийг барьж бий болгох, шинэчлэн сайжруулах зэрэг төслийн бүтээн байгуулалтын үе шат хүртэлх буюу төслийн үйл ажиллагааг эхлэх хүртэл гарах дараах хөрөнгө, зардлыг ойлгоно. Тухайлбал:

- Газрын төлбөр;
- Техник, тоног төхөөрөмж;
- Тээврийн хэрэгсэл;
- Тавилга, эд хогшил;
- Компьютер, бусад хэрэгсэл;
- Анхны хөрөнгө оруулалтын бусад зардал;
- Хүүгийн капиталжуулалт (Үндсэн хөрөнгийг бий болгохтой холбогдон гарсан зээлийн хүүгийн зардлыг үндсэн хөрөнгийн өртөгт оруулан тооцож болно);
- Биет бус хөрөнгө оруулалт: Төслийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай тусгай зөвшөөрөл, зохиогчийн эрх, программ хангамж, патент зэргийг хэлнэ;
- Бэлтгэл ажиллагааны зардал: Төсөл эхлүүлэхтэй холбоотой техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, суурь судалгаа хийх, боловсон хүчин бэлтгэх, бүтээн байгуулалтын үед гарах зардлууд орно. Үүнд:
 - Бүтээн байгуулалтын үеийн даатгалын зардал: Бүтээн байгуулалт хийх явцад эрсдэлээс сэргийлэх зорилгоор даатгал хийлгэж болох бөгөөд энэхүү даатгалын зардлыг төсөвлөнө;
 - Хууль, эрх зүйн зардал: Төслийг эхлүүлэхтэй холбоотой эрх зүйн туслалцаа авах, бичиг баримт бүрдүүлэхтэй холбоотой эрх зүйн төлбөр гарах тохиолдолд энэхүү хэсэгт төсөвлөнө;
 - Бэлтгэл ажиллагааны бусад зардал: Төслийг эхлүүлэхтэй холбогдон гарах үйл ажиллагааны зардлыг энэ хэсэгт төсөвлөнө;
 - Төслийн бэлэн байдлыг хангах зардал: Төслийн техник, эдийн засгийн үндэслэл, барилга, байгууламжийн зураг төсөл, төсөв боловсруулах, БОНБ-ын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ, менежментийн төлөвлөгөө, геологи, гидрологийн зэрэг төслийн бэлэн байдлыг хангахад шаардлагатай холбогдох судалгаа, баримт бичиг боловсруулахад гарах зардлуудыг ойлгоно.

2. Үйл ажиллагааны орлого, зардлын тооцоо хийх

Төслийн хувьд ирээдүйд олох орлогыг хүчин чадал, зах зээлийн ирээдүйн төлөв байдлаас хамааруулан он тус бүрээр таамаглана. Орлогыг дараах төрлийн хувьд төсөөлнө. Үүнд: Бараа борлуулалтын орлого: Төслийн үндсэн үйл ажиллагаагаар бараа, бүтээгдэхүүн

борлуулснаас олох орлого;

Үйлчилгээ үзүүлсний орлого: Төслийн үндсэн үйл ажиллагаагаар үйлчилгээ үзүүлснээс олох орлого;

Бусад мөнгөн орлого: Бараа, бүтээгдэхүүн борлуулах болон үйлчилгээ үзүүлэх үндсэн орлогоос гадна төслийн явцад үйл ажиллагаанаас олох бусад орлого;

Төслийн нийт орлого: Дээрх гурван төрлийн орлогын нийлбэр. Төслийн цэвэр орлогын нэгтгэлийг дараах хэлбэрээр гаргаж болно.

№	Орлогын төрөл		... он	... он	... он	... он	... он
1	Бараа борлуулалтын орлого	+					
2	Үйлчилгээ үзүүлсний орлого	+					
3	Бусад мөнгөн орлого	+					
Нийт орлого		=					

Санамж: Ирээдүйд олох орлогыг тооцохдоо тухайн жил тус бүрээр ажил, үйлчилгээ үзүүлэх хүчин чадлын тоо хэмжээ болон үнэ, тарифыг үнэн зөв, бодитой тоон мэдээлэлд үндэслэн тодорхой тусгасан байх шаардлагатай.

3.Төслийн хувьд ирээдүйд гарах зардлын тооцоог дараах төрлөөр он тус бүрээр таамаглана. Үүнд:

- Үндсэн үйл ажиллагааны зардал;
- Үндсэн бус үйл ажиллагааны зардал;
- Татварын зардал: Холбогдох татварын хуулиудын дагуу тооцсон татварын зардлын тооцоолол;
- Элэгдлийн зардал: Барилга, байгууламж, бусад үндсэн хөрөнгийг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17-р зүйлд заасны дагуу доор дурдсан хугацаагаар ашиглахаар тооцож, түүний элэгдэл, хорогдлын шимтгэлийг шулуун шугамын аргаар тооцно.

№	Үндсэн хөрөнгийн бүлэг	Ашиглах хугацаа /жилээр/
1	Барилга, байгууламж	40/25
2	Машин, механизм, техник, тоног төхөөрөмж	10
3	Компьютер, түүний эд анги, программ хангамж	2
4	Ашиглах хугацаа нь тодорхойгүй биет бус хөрөнгө	10
5	Ашиглах хугацаа нь тодорхой биет бус хөрөнгө /Үүнд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл хамаарна./	Хүчин төгөлдөр байх хугацаанд
6	Бусад үндсэн хөрөнгө	10

Санамж: Холбогдох хууль, журамд өөрчлөлт орсон тохиолдолд түүнийг дагаж мөрдөнө.

Төслийн зардлын тооцооны нэгтгэлийг дараах хэлбэрээр гаргана. Төслийн онцлогоос хамааран зардлын төрөл, ангилал өөрчлөгдөж болно.

№	Зардлын төрөл	... он	... он	... он	... он	... он
1	Үндсэн үйл ажиллагааны зардал:					
1.1	Ажиллагчдын цалингийн зардал					
1.2	Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал					
1.3	Томилолтын зардал					
1.4	Бичиг хэргийн зардал					
1.5	Шуудан холбооны зардал					
1.6	Мэргэжлийн үйлчилгээний зардал					
1.7	Сургалтын зардал					
1.8	Сонин, сэтгүүл захиалгын зардал					
1.9	Даатгалын зардал					
1.10	Ашиглалтын зардал					
1.11	Засварын зардал					
1.12	Түрээсийн зардал					
1.13	Харуул хамгааллын зардал					
1.14	Цэвэрлэгээ үйлчилгээний зардал					
1.15	Тээврийн зардал					
1.16	Шатахууны зардал					
1.17	Хүүгийн зардал					
1.18	Зар сурталчилгааны зардал					
1.19	Бусад					
	Үндсэн үйл ажиллагааны нийт зардал					

4.Төслийн цэвэр ашиг, мөнгөн урсгалын тооцоо хийх

Төслийн нийт орлогын дүнгээс үндсэн үйл ажиллагааны зардал, элэгдлийн зардал, үйл ажиллагааны бус зардал, татварын зардлыг хасаж төслийн жил тутмын цэвэр ашгийг тодорхойлно.

№	Үзүүлэлт/нөлөөлөл		Түншлэлийн хугацаа /жилээр/				Дүн
	1		2	...	n		
1	Нийт орлого	+					
2	Борлуулалтын өртөг	-					
3	Үндсэн үйл ажиллагааны зардал	-					
4	Элэгдлийн зардал	-					
5	Үйл ажиллагааны ашиг	=					
6	Үйл ажиллагааны бус зардал	-					
7	Татварын өмнөх ашиг	=					
8	Орлогын албан татварын зардал	-					
9	Цэвэр ашиг	=					

Төсөл үргэлжлэх жил тутмын мөнгөн урсгалыг дараах төрлүүдээр тодорхойлно. Үүнд:

- Үйл ажиллагааны мөнгөн урсгал
- Санхүүжилтийн мөнгөн урсгал
- Хөрөнгө оруулалтын мөнгөн урсгал
- Цэвэр мөнгөн урсгал

Үйл ажиллагааны мөнгөн урсгал нь төслийн үндсэн үйл ажиллагаанаас орох мөнгөн урсгал, үйл ажиллагаанд зарцуулагдан гарах мөнгөн урсгалын зөрүүгээр тодорхойлогдоно.

Мөнгөн урсгалын төрөл	... он	... он
Мөнгөн орлогын дүн	Σ мөнгөн орлого	Σ мөнгөн орлого
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого		
Мөнгөн зарлагын дүн	Σ мөнгөн зарлага	Σ мөнгөн зарлага
Ажиллагчдад төлсөн		
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		
Бараа, материал худалдан авахад төлсөн		
Ашиглалтын зардалд төлсөн		
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн		
Даатгалын төлбөрт төлсөн		
Бусад мөнгөн зарлага		
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн урсгал	Σ мөнгөн орлого - Σ мөнгөн зарлага	Σ мөнгөн орлого - Σ мөнгөн зарлага

Санхүүжилтийн мөнгөн урсгал нь төсөвлөсөн онд зээл авах, үнэт цаас гаргах замаар орж ирэх санхүүгийн мөнгөн урсгалаас зээл төлөх, ногдол ашиг төлөх гэх мэтээр гарах мөнгөн урсгалыг хасаж тодорхойлно.

Хөрөнгө оруулалтын мөнгөн урсгал нь төсөвлөсөн онд урт хугацаанд хөрөнгө борлуулснаас олох мөнгөн орлого болон урт хугацаат хөрөнгө худалдан авахад зарцуулах мөнгөн дүнгийн зөрүүгээр тодорхойлогдоно. Анхны хөрөнгө оруулалтын зардлыг хөрөнгө оруулалтын мөнгөн урсгалын мөнгөн зарлагын дүнд тусгах шаардлагатай.

Цэвэр мөнгөн урсгал нь төсөл хэрэгжүүлсний үр дүнд жил тутам хөрөнгө оруулагчдад ногдох мөнгөн урсгал юм. Үйл ажиллагааны мөнгөн урсгал, санхүүжилтийн мөнгөн урсгал, хөрөнгө оруулалтын мөнгөн урсгалын нийлбэрээр тодорхойлогдоно.

5.Хөрөнгө оруулалтын ирээдүйд гарах зардал, олох орлогыг өнөөгийн үнэ цэнээр илэрхийлж тооцох

Төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжих төслүүдийг өнөөгийн цэвэр үнэ цэнийн арга, өгөөжийн дотоод хувиар үнэлнэ.

Төслийг үнэлэх цэвэр өнөөгийн үнэ цэнийн арга нь төслийн ирээдүйн мөнгөн

урсгалын өнөөгийн үнэ цэнэ нь анхны хөрөнгө оруулалтаа нөхөөд илүү өгөөжтэй ажиллах боломжийг үнэлнэ. Цэвэр өнөөгийн үнэ цэнийг дараах томъёогоор тооцно.

$$NPV = PV - I_0 = \sum_{t=1}^n \frac{CF_t}{(1+r)^t} - I_0$$

NPV: Өнөөгийн цэвэр үнэ цэнэ

PV: Өнөөгийн үнэ цэнэ

I_0 : Анхны хөрөнгө оруулалт

CF: Мөнгөн урсгал (Cash flow)

t: хугацааны үе

r: хорогдуулах хувь

Мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнүүдийн нийлбэрээр өнөөгийн цэвэр үнэ цэнэ гарна. Өнөөгийн цэвэр үнэ цэнэ "0"-ээс их бол төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж болно.

Хорогдуулах хувийг тухайн төсөл хэрэгжүүлэх үеийн Монголбанкны бодлогын хүү, түншлэлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн эрсдэл, эх үүсвэрийн сонголт, зах зээлийн нөхцөлийг харгалзан тогтооно.

Өгөөжийн дотоод хувь нь эдийн засаг, санхүүгийн эрсдэлээс хамаарч төслийн анхны хөрөнгө оруулалтаа нөхөх хамгийн их хорогдуулах хувийг тооцно. Өгөөжийн дотоод хувийг дараах томъёогоор тооцно.

$$\sum_{t=1}^n \frac{CF_t}{(1+IRR)^t} - I_0 = 0$$

IRR-Өгөөжийн дотоод хувь

Төслийн цэвэр мөнгөн урсгалууд өнөөгийн үнэ цэнийн нийлбэрийг "0" байлгах хорогдуулах хувийг тооцох ба энэ нь өгөөжийн дотоод хувь болно. Өгөөжийн дотоод хувь нь төслийн хорогдуулах хувиас их бол төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой гэж үзнэ.

IRR>r Төслийг түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой гэж үзнэ.

IRR<r Төслийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 14.1.2, 14.1.3-т заасан төрөл хэлбэрээр хэрэгжүүлэх эсэх талаар судална.

Мөнгөний үнэ цэнийн урьдчилсан шинжилгээний жишээ

№	Өгөгдөл		
1	Анхны хөрөнгө оруулалт	Өөрийн санхүүжилтээр	10,000.0 мян.төг
Урт хугацаат зээлээр			40,000.0 мян.төг
2	Түншлэлийн гэрээний хугацаа	Бүтээн байгуулалтын хугацаа	2 жил
Үйл ажиллагаа явагда хугацаа			8 жил
3	Хөрөнгийн элэгдлийн зардал	200.0 мян.төг	
4	Орлогын албан татварын хувь	10%	
5	Хорогдуулах хувь	13%	

Анхны хөрөнгө оруулалт /мян.төг/				
№	Зардлын төрөл	2024	2025	Нийт
1	Үндсэн хөрөнгийн дүн	12,950.0	34,550.0	47,500.0
1.1	Газрын төлбөр	1,000.0	-	1,000.0
1.2	Барилга	10,000.0	30,000.0	40,000.0
1.3	Байгууламж	-	-	-
1.4	Газрын сайжруулалт	1,500.0	-	1,500.0
1.5	Машин, тоног төхөөрөмж	-	1,700.0	1,700.0
1.6	Тээврийн хэрэгсэл	-	900.0	900.0
1.7	Тавилга, эд хогшил	-	1,000.0	1,000.0
1.8	Компьютер, бусад хэрэгсэл	-	300.0	300.0
1.9	Бусад үндсэн хөрөнгө	-	-	-
1.10	Шууд хөрөнгө оруулалттай холбогдон гарах НӨАТ	-	-	-
1.11	Хүүгийн капиталжуулалт	-	-	-
1.12	Бүтээн байгуулалтын үеийн даатгалын зардал	200.0	300.0	500.0
1.13	Хууль, эрх зүйн зардал	100.0	150.0	250.0
1.14	Бэлтгэл ажиллагааны зардал	150.0	200.0	350.0
2	Биет бус хөрөнгийн дүн	1,000.0	0.0	1,000.0
2.1	Зохиогчийн эрх	-	-	-
2.2	Компьютерын программ хангамж	350.0	-	350.0
2.3	Патент	-	-	-
2.4	Тусгай зөвшөөрөл	650.0	-	650.0
3	Эргэлтийн хөрөнгө	0.0	1,500.0	1,500.0
3.1	Мөнгөн хөрөнгө	-	1,000.0	1,000.0
3.2	Бараа, материал	-	500.0	500.0
4	Анхны хөрөнгө оруулалтын нийт зардал	13,950.0	36,050.0	50,000.0

Санамж: Ирээдүйд олох орлогыг тооцохдоо тухайн жил тус бүрээр ажил, үйлчилгээ үзүүлэх хүчин чадлын тоо хэмжээ болон үнэ тарифыг үндэслэл бүхий түүхэн мэдээлэл, судалгаан дээр суурилан ирээдүйн таамаглалыг тодорхой тусгасан байх шаардлагатай.

[illegible]

82 Үйлчилгээг хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам

1.11	Засварын зардал	150.0	150.0	150.0	150.0	150.0	150.0	150.0	150.0	1,200.0
1.12	Түрээсийн зардал	-	-	-	-	-	-	-	-	-
1.13	Харуул хамгаалалтын зардал	300.0	300.0	300.0	300.0	300.0	300.0	300.0	300.0	2,400.0
1.14	Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	400.0	400.0	400.0	400.0	400.0	400.0	400.0	400.0	3,200.0
1.15	Тээврийн зардал	400.0	400.0	400.0	400.0	400.0	400.0	400.0	400.0	3,200.0
1.16	Шатахууны зардал	300.0	300.0	300.0	300.0	300.0	300.0	300.0	300.0	2,400.0
1.17	Хүүгийн зардал	350.0	350.0	350.0	350.0	350.0	350.0	350.0	350.0	2,800.0
1.18	Зар сурталчилгааны зардал	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	400.0
Үндсэн үйл ажиллагааны нийт зардал		6,780.0	6,780.0	6,780.0	7,350.0	7,350.0	7,350.0	7,350.0	7,890.0	57,630.0

Төслийн цэвэр ашиг /мян.төг/									
№	Үзүүлэлт	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033
1	Төслийн нийт орлого	19,000.0	19,500.0	20,000.0	22,500.0	24,000.0	25,000.0	26,500.0	27,000.0
2	Үндсэн үйл ажиллагааны зардал	6,780.0	6,780.0	6,780.0	7,350.0	7,350.0	7,350.0	7,350.0	7,890.0
3	Элэгдлийн зардал	200.0	200.0	200.0	200.0	200.0	200.0	200.0	200.0
4	Үйл ажиллагааны ашиг	12,020.0	12,520.0	13,020.0	14,950.0	16,450.0	17,450.0	18,950.0	18,910.0
5	Үйл ажиллагааны бус зардал	500.0	650.0	450.0	700.0	600.0	600.0	600.0	600.0
6	Татварын өмнөх ашиг	11,520.0	11,870.0	12,570.0	14,250.0	15,850.0	16,850.0	18,350.0	18,310.0
7	Орлогын албан татварын зардал /10%/	1,152.0	1,187.0	1,257.0	1,425.0	1,585.0	1,685.0	1,835.0	1,831.0
8	Цэвэр ашиг	10,368.0	10,683.0	11,313.0	12,825.0	14,265.0	15,165.0	16,515.0	16,479.0

Үйл ажиллагааны мөнгөн урсгал /мян.төг/										
№	Мөнгөн урсгалын төрөл	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	Нийт
1	Мөнгөн орлогын дүн	19,000.0	19,500.0	20,000.0	22,500.0	24,000.0	25,000.0	26,500.0	27,000.0	183,500.0
1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	18,000.0	18,500.0	19,000.0	21,500.0	23,000.0	24,000.0	25,500.0	26,000.0	175,500.0
1.2	Бусад мөнгөн орлого	1,000.0	1,000.0	1,000.0	1,000.0	1,000.0	1,000.0	1,000.0	1,000.0	8,000.0
2	Мөнгөн зарлагын дүн	8,432.0	8,617.0	8,487.0	9,475.0	9,535.0	9,635.0	9,785.0	10,321.0	74,287.0
2.1	Ажиллагчдад төлсөн	3,500.0	3,500.0	3,500.0	4,000.0	4,000.0	4,000.0	4,000.0	4,500.0	31,000.0
2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	310.0	310.0	310.0	380.0	380.0	380.0	380.0	420.0	2,870.0
2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	770.0	770.0	770.0	770.0	770.0	770.0	770.0	770.0	5,200.0
2.4	Ашиглалтын зардалд төлсөн	250.0	250.0	250.0	250.0	250.0	250.0	250.0	250.0	2,000.0
2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	300.0	300.0	300.0	300.0	300.0	300.0	300.0	300.0	2,400.0
2.6	Хүүний төлбөрт төлсөн	350.0	350.0	350.0	350.0	350.0	350.0	350.0	350.0	2,800.0
2.7	Татварын байгууллагад төлсөн	1,152.0	1,187.0	1,257.0	1,425.0	1,585.0	1,685.0	1,835.0	1,831.0	11,957.0
2.8	Даатгалын төлбөрт төлсөн	200.0	200.0	200.0	200.0	200.0	200.0	200.0	200.0	1,600.0
2.9	Бусад мөнгөн зарлага	1,600.0	1,750.0	1,550.0	1,800.0	1,700.0	1,700.0	1,700.0	1,700.0	13,500.0
3	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	10,568.0	10,883.0	11,513.0	13,025.0	14,465.0	15,365.0	16,715.0	16,679.0	109,213.0

Өнөөгийн цэвэр үнэ цэнэ, дотоод өгөөжийн хувь											
№	Үзүүлэлт	Томьёо	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	Дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ / мян.төг/		10,568.0	10,883.0	11,513.0	13,025.0	14,465.0	15,365.0	16,715.0	16,679.0	109,213.0
2	Хорогдуулах хувь	r=13%	13%	13%	13%	13%	13%	13%	13%	13%	-
3	Өнөөгийн үнэ цэнийн коэффициент		0.885	0.783	0.693	0.613	0.543	0.480	0.425	0.376	-
4	Өнөөгийн үнэ цэнэ / мян.төг/	PV	9352.21	8522.99	7979.09	7988.48	7851.02	7380.09	7104.89	6273.97	62,452.7
5	Анхны хөрөнгө оруулалт /мян.төг/										50,000.0
6	Төслийн цэвэр өнөөгийн үнэ цэнэ / мян.төг/	NPV									12,452.7
7	Төслийг хэрэгжүүлэх боломжтой эсэх	Өнөөгийн цэвэр үнэ цэнэ "0"-ээс их байгаа тул төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой. NPV=12,452.7>0									
8	Дотоод өгөөжийн хувь /IRR/	IRR>r бол төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой гэж үзнэ. IRR=24.9%>13%									

----o0o---

ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭГЧИЙГ БОЛОН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ, ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 24-27 дугаар зүйлд заасан түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн түншлэгчийг болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулахтай холбогдсон үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2.Сонгон шалгаруулалтад Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 24.5 -д заасан зарчмыг баримтлах бөгөөд сонгон шалгаруулалтын бүх үе шат, үр дүнг нийтэд цахим системээр дамжуулан нээлттэй мэдээлнэ.

1.3.Энэ журамд дурдсан нэр томьёог Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан утгаар хэрэглэнэ.

1.4.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 37.1-д заасан сонгон шалгаруулалтгүйгээр хэлэлцээ хийж, гэрээ байгуулахад энэ журмыг мөрдөхгүй.

Хоёр.Хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсэг, түүний зохион байгуулалт, ажиллах журам

2.1.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 21.7-д заасан Засгийн газрын шийдвэрийн дагуу түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран төслийн сонгон шалгаруулалтын ажлын хэсэг (цаашид “Ажлын хэсэг” гэх)-ийг тухайн төсөл бүрд байгуулах бөгөөд уг Ажлын хэсэг түншлэлийн төслийг хэрэгжүүлэх хувийн хэвшлийн түншлэгчийг сонгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулна.

2.2.Ажлын хэсэг байгуулах шийдвэрт ажлын хэсгийн бүрэлдэхүүн, чиг үүрэг болон хугацааг тусгана.

2.3.Ажлын хэсэг нь 7-оос доошгүй, сондгой тооны бүрэлдэхүүнтэй, дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.4.Ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтад оролцогчидтой харилцах зорилгоор албан ёсны хаяг бүхий ажлын байртай байна.

2.5.Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга, Түншлэлийн төвийн төлөөллөөс оруулах бөгөөд бүрэлдэхүүний 30-аас доошгүй хувь нь хөндлөнгийн хараат бус гишүүд байж болно.

2.6.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтын баримт бичгийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 24.3-т заасан баримт бичгийн хүрээнд энэ журмын дагуу боловсруулна.

2.7.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад зайлшгүй шаардлагатай мэргэжлийн дотоодын болон гадаадын шинжээч, зөвлөх, мэргэжлийн багийг Ажлын хэсгийн дэргэд томилон ажиллуулж болно. Энэ тохиолдолд зөвлөх үйлчилгээний зардлыг түншлэлийн төсөл хөгжүүлэх сан болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

2.8.Ажлын хэсэг төслийн сонгон шалгаруулалтын урилгыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын цахим хуудсанд байршуулах, сонгон шалгаруулалтын талаар танилцуулга хийх, уулзалт зохион байгуулах зэргээр олон нийтэд мэдээлэл өгнө.

2.9.Хувийн хэвшлийн түншлэгчийн саналыг хүлээн авах, үнэлэх үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй байх ба ажлын хэсэг сонгон шалгаруулалтын тухай мэдээллийг ил тод, нээлттэй зарлах, саадгүй олгох, өрсөлдөөний тэнцвэрийг хангах зорилгоор мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангаж ажиллана.

2.10.Ажлын хэсгийн гишүүн бүр ашиг сонирхлын зөрчлийн болон албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлын нөлөөллийн мэдүүлгийг холбогдох хуулийн дагуу үнэн зөв гаргана.

Гурав.Сонгон шалгаруулалтын үе шат

3.1.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтын баримт бичгийг энэ журмын 2 дугаар хавсралтаар баталсан "Хувийн хэвшлийн түншлэгч сонгох, сонгон шалгаруулалтын жишиг баримт бичиг"-ийн дагуу боловсруулж, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулна.

3.2.Сонгон шалгаруулалтын баримт бичигт Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 25.1-д заасан мэдээллийг тусгана.

3.3.Ажлын хэсэг санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө сонгон шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Энэ тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг энэ журмын 3.1-д заасны дагуу батлуулж, сонгон шалгаруулалтад оролцох санал хүлээн авах эцсийн хугацааг нэмэлт, өөрчлөлт оруулсан өдрөөс хойш ажлын 5-аас доошгүй өдрөөр сунгана. Сонгон шалгаруулалтад оролцох санал хүлээн авах хугацаа дуусахаас 14 хоногийн дотор сонгон шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болохгүй.

3.4.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бүх оролцох хүсэлт гаргагчид нэгэн зэрэг мэдэгдэх бөгөөд энэ нэмэлт, өөрчлөлт нь тухайн баримт бичгийн салшгүй хэсэг байна.

3.5.Ажлын хэсэг энэ журмын 3.1-д заасны дагуу батлуулсан баримт бичигт тусгасан мэдээлэл бүхий сонгон шалгаруулалтын зарыг материал хүлээж авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

3.6.Хувийн хэвслээс сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ бичгээр гаргах бөгөөд ажлын хэсэг хүсэлтийг хүлээн авч, сонгон шалгаруулалтын баримт бичгийг олгоно.

3.7.Сонгон шалгаруулалтад оролцох санал ирүүлэх хугацаа нь сонгон шалгаруулалтыг нийтэд зарласнаас хойш 30 хоногоос доошгүй байх бөгөөд энэ хугацаанд ажлын хэсэг, төрийн түншлэгч байгууллага, санхүүжүүлэгч болон төсөлд хамаарах этгээдийн

төлөөллөөс бүрдсэн уулзалт, хэлэлцүүлгийг нэгээс доошгүй удаа зохион байгуулж, төсөлтэй холбогдох баримт бичгийн талаар мэдээлэл өгнө.

3.8. Сонгон шалгаруулалтад оролцогч нь сонгон шалгаруулалтын баримт бичигтэй холбоотой нэмэлт тодруулга, мэдээлэл авах хүсэлтийг санал хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө бичгээр гаргана.

3.9. Оролцогч төслийн саналаа ирүүлэхээс өмнө хүсэлт тавьсан тохиолдолд уулзалт хийх, төслийн талбайтай танилцах, тодруулга өгөх ажлыг Ажлын хэсэг зохион байгуулж болно. Энэхүү арга хэмжээг сонгон шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу хэрэгжүүлэх тэмдэглэл үйлдэн бусад оролцогчдод мэдээлнэ.

3.10. Энэ журамд заасан шаардлагыг хангасан сонгон шалгаруулалтад оролцогч сонгон шалгаруулалтын баримт бичгийн дагуу бэлтгэсэн төслийн саналаа санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө битүүмжлэн ажлын хэсэгт ирүүлэх бөгөөд саналыг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хүлээн авч, ирүүлсэн хугацааны дарааллаар бүртгэж авна.

3.11. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хугацаа хоцорсон эсхүл сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцээгүй тэмдэглэгээ, битүүмжлэлтэй оролцох саналыг хүлээж авахгүй.

3.12. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт гаргасан этгээд ирүүлсэн саналд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө саналаа шинээр ирүүлж, өмнө ирүүлсэн саналаа буцаан авна.

3.13. Ажлын хэсэг энэ журмын 3.8-д заасан хүсэлтийн хуулбар болон хариу албан бичгийг сонгон шалгаруулалтын баримт бичиг олгосон бүх оролцогчид нэгэн зэрэг бичгээр мэдээлнэ.

3.14. Ажлын хэсэг ирүүлсэн төслийн саналуудыг 30 хоногийн хугацаанд сонгон шалгаруулалтын шаардлагыг хангаж байгаа эсэхийг энэ журмын хавсралт 1-д заасан зааврын дагуу үнэлэх бөгөөд хамгийн сайн нөхцөлтэй, шаардлага хангасан саналаас эхлэн дарааллуулах байдлаар шалгаруулна.

3.15. Ажлын хэсэг үнэлгээ хийж, шалгаруулснаас хойш ажлын 5 өдрийн дотор шаардлага хангасан болон хангаагүй оролцогчид мэдэгдэл хүргүүлнэ.

3.16. Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Ажлын хэсгээс ирүүлсэн үр дүнг бусад оролцогчид болон олон нийтэд цахим хуудсаар дамжуулан нээлттэй мэдээлнэ.

3.17. Энэ журмын 3.15-д заасан мэдэгдэл хүлээж авсан оролцогч ажлын 5 өдөрт багтаан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 56.1-д заасан Маргаан шийдвэрлэх зөвлөлд гомдол гаргах эрхтэй.

3.18. Түншлэлийн төслийн сонгон шалгаруулалтад санал ирээгүй, эсхүл үнэлгээгээр шаардлага хангасан оролцогч байхгүй тохиолдолд Ажлын хэсэг түншлэлийн төсөлд хөрөнгө оруулалт татах, хувийн хэвшлийн түншлэгчийн сонирхлыг тандан судлах зорилгоор нээлттэй уулзалт, арга хэмжээ зохион байгуулж, танилцуулга хийж болох бөгөөд сонгон шалгаруулалтын баримт бичгийг сайжруулан шинэчилж, энэ журмын дагуу сонгон шалгаруулалтыг шинээр зохион байгуулна.

Дөрөв.Хувийн хэвшлийн түншлэгчийг сонгох, түншлэлийн гэрээний хэлэлцээр хийх

4.1.Ажлын хэсэг нь хамгийн сайн нөхцөл, шаардлага хангасан, шалгарсан оролцогчид мэдэгдэл хүргүүлж, энэ журмын 3.14-д заасан дарааллын дагуу доор дурдсанаар гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээ хийж, үнэлгээ өгнө:

4.1.1.Ажлын хэсэг дарааллуулсан жагсаалтын дагуу эхний оролцогчтой түншлэлийн болон холбогдох бусад гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээ хийнэ;

4.1.2.Ажлын хэсэг тухайн оролцогчтой хэлэлцээ хийх хуваарь, хэлэлцэх асуудлын жагсаалтыг урьдчилан тохиролцох бөгөөд хэлэлцээгээр тохиролцсон асуудал бүрийг гарын үсэг зурж баталгаажуулна;

4.1.3.урьдчилан тохиролцсон жагсаалтад ороогүй аливаа асуудлын талаар хэлэлцээ хийхгүй бөгөөд хэлэлцээний явцад тохиролцсон зүйлсийг эргэн авч үзэхгүй;

4.1.4.Ажлын хэсэг гэрээний нөхцөл дээр тохиролцоонд хүрээгүй тохиолдолд хэлэлцээг дуусгалгүйгээр орхиж дараагийн оролцогчтой хэлэлцээ хийх эрхтэй. Энэ тохиолдолд тухайн оролцогчтой тохиролцсон гэрээний нөхцөл нь өмнөх хэлэлцээ хийсэн оролцогчийн санал болгосон нөхцөлөөс илүү сайн байх зарчим баримтална;

4.1.5.Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хэлэлцээний үед тэмдэглэл хөтөлнө;

4.1.6.шаардлага хангасан нэг оролцогч шалгарсан тохиолдолд гэрээний хэлэлцээг зохион байгуулна.

4.2.Ажлын хэсэг энэ журмын 4.1-д заасны дагуу хийсэн хэлэлцээний үр дүнг, холбогдох баримт бичгийн хамт түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажлын 3 өдрийн дотор бичгээр мэдэгдэнэ.

4.3.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэлэлцээний үр дүнд гэрээний нөхцөлийг хамгийн сайн харилцан тохиролцсон нэг оролцогчтой түншлэлийн гэрээ байгуулах дүгнэлт гарган, ажлын 5 өдөрт багтаан дүгнэлт болон түншлэлийн гэрээ байгуулах талаар санал, дүгнэлт авах хүсэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага сонгон шалгаруулалт, түншлэгчтэй хийсэн хэлэлцээний дүн, Ажлын хэсгийн дүгнэлтийг төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийн талаас хянаж, түншлэлийн гэрээ байгуулах талаар санал, дүгнэлтээ ажлын 10 өдөрт багтаан Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.5.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн санал, дүгнэлтийг түншлэгчтэй гэрээ байгуулах санал, дүгнэлтийн хамт Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

4.6.Түншлэлийн гэрээг байгуулахад Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулах журмыг баримтална.

Тав.Зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт

5.1.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан дараах зөвлөх үйлчилгээг Түншлэлийн төв, эсхүл түүнээс эрх шилжүүлсэн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан мэргэжлийн байгууллага сонгон шалгаруулж болно:

5.1.1.төслийн урьдчилсан үнэлгээ, төслийн бүрэн шинжилгээ, түншлэлийн эх төсөл боловсруулах болон төсөвт үзүүлэх нөлөөллийн тооцоо, шинжилгээ хийхэд мэргэжлийн зөвлөх үйлчилгээ авах;

5.1.2.түншлэлийн төслийн техник хяналтын гэрээг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээ;

5.1.3.түншлэлийн гэрээнд заасан тохиолдолд төсөл хэрэгжих хугацаанд хувийн хэвшлийн түншлэгчийн үйл ажиллагаа, хэрэгжилт, гүйцэтгэлд гэрээний дагуу хяналт тавих, үнэлэх зөвлөх үйлчилгээ;

5.1.4.төрийн түншлэгч нь төслийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавих зорилгоор хөндлөнгийн үнэлгээний байгууллагатай гэрээ байгуулах зөвлөх үйлчилгээ.

5.2.Зөвлөх үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэрийг түншлэлийн төсөл хөгжүүлэх сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх бол Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл түүнээс эрх шилжүүлсэн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан мэргэжлийн байгууллага сонгон шалгаруулж болно.

5.3.Зөвлөх үйлчилгээг хуулийн этгээд, хувь хүн, тэдгээрийн түншлэл гүйцэтгэж болно.

5.4.Энэ журмын 5.1-д заасан байгууллага нь шаардлагатай зөвлөх үйлчилгээг тодорхойлж, зөвлөх үйлчилгээний зорилт, хүрэх үр дүн, үнэлгээний арга болон бусад шаардлагатай мэдээллийг агуулсан ажлын даалгавар, төсөвт өртгийг тооцож бэлтгэнэ.

5.5.Ажлын даалгавар нь түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хамт тухайн зөвлөхтэй байгуулах гэрээний салшгүй хэсэг болно.

5.6.Зөвлөх үйлчилгээний жагсаалтад орох санал ирүүлэх урилгыг өдөр тутмын болон бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

5.7.Санал ирүүлэх хугацааг 7-оос доошгүй ажлын өдрөөр тогтоох бөгөөд ирүүлсэн саналыг үндэслэн дэлгэрэнгүй жагсаалт гаргана.

5.8.Дэлгэрэнгүй жагсаалтад орсон оролцогчдоос захиалагчийн тогтоосон чадавхын үзүүлэлтийг хангасан, хамгийн сайн гэж үнэлэгдсэн 5 хүртэлх оролцогчийг сонгож, хураангуй жагсаалтад оруулна.

5.9.Хураангуй жагсаалтад багтсан оролцогчдод саналын урилга болон ажлын даалгаврыг хүргүүлнэ.

5.10.Саналын урилгад дараах зүйлийг тусгана:

5.10.1.тухайн үйлчилгээний болон санхүүжилтийн тодорхойлолт;

5.10.2.ажлын даалгавар;

5.10.3.захиалагчийн тогтоосон чадавхын шаардлага, үнэлгээний шалгуур үзүүлэлт, аргачлал;

5.10.4.уригдсан зөвлөх хуулийн этгээд, хувь хүний нэр;

5.10.5.гэрээний төсөл;

5.10.6.санал ирүүлэхэд баримтлах зааварчилгаа;

5.10.7.сонгосон үнэлгээний арга.

5.11.Зөвлөх мэргэжлийн чадвар, туршлага, хуулийн этгээдийн хувьд голлох мэргэжилтэн, үйл ажиллагааны арга барилтай холбоотой мэдээллийг тусгасан техникийн саналын хамт гэрээ хэрэгжүүлэх үнийг тусгасан санхүүгийн санал ирүүлнэ.

5.12.Захиалагчаас урьдчилан тодорхойлсон үнэлгээний аргыг ашиглан саналуудыг үнэлж, сонгосон зөвлөхтэй хэлэлцээ хийж, гэрээ байгуулна.

5.13.Зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт амжилтгүй болсон тохиолдолд энэ журамд заасны дагуу сонгон шалгаруулалтыг дахин зарлана.

5.14.Зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт 2 удаа амжилтгүй болсон тохиолдолд 5.8-д заасан сонгон шалгаруулалтын хураангуй жагсаалтад тэнцсэн оролцогчдоос хамгийн бага үнийн санал ирүүлсэн зөвлөхтэй шууд гэрээ байгуулж болно.

5.15.Энэ журмын 5.1, 5.2-т заасан байгууллага гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тайлагнана.

Зургаа.Бусад

6.1.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Түншлэлийн төв сонгон шалгаруулалтын үр дүнг бусад оролцогч болон олон нийтэд мэдээлж, танилцуулах, сонгон шалгаруулалтын ил тод байдлыг хангаж ажиллана.

6.2.Хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулахтай холбоотой гомдол гаргах, маргаан шийдвэрлэх асуудлыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 56, 57 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлүүлнэ.

----o0o----

Засгийн газрын 2023 оны 11 дүгээр
сарын 15-ны өдрийн 404 дүгээр
тогтоолын 3 дугаар хавсралт

ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт төр, хувийн хэвшил хамтран түншлэлийн төслийг хэрэгжүүлэх түншлэлийн гэрээг байгуулахад энэ журмыг баримтална.

1.2.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ (цаашид "Түншлэлийн гэрээ" гэх) байгуулахдаа Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Иргэний хууль бусад холбогдох журам болон энэ журмыг мөрдөнө.

1.3.Түншлэлийн гэрээ болон дагалдан гарах гэрээнүүд нь Захиргааны ерөнхий хуулийн зохицуулалтад үл хамаарна.

1.4.Түншлэлийн хүрээнд түншлэлийн төсөл хэрэгжүүлэгч хувийн хэвшлийн түншлэгч болон зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах, сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд зааснаар зохицуулах бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн зохицуулалт хамаарахгүй.

1.5.Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан утгаар ойлгоно.

1.6.Түншлэлийн гэрээний төслийг боловсруулахдаа энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан түншлэлийн гэрээний стандарт загварыг ашиглана.

1.7.Түншлэлийн төсөл нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 18.1, 18.2-т заасан шаардлагыг хангасан байх бөгөөд төрийн үйлчилгээ үзүүлэх төсөлд мөн хуулийн 18.4-т заасан зохицуулалтыг баримтална.

(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан)

Хоёр.Түншлэлийн гэрээ, түүний төрөл, нөхцөл, гэрээний талууд, эрх үүрэг

2.1.Түншлэлийн гэрээ нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.1.20-д заасан ёсоор төрийн түншлэгч болон хувийн хэвшлийн түншлэгч талуудын хооронд түншлэлийн төслийг хэрэгжүүлэхээр харилцан тохиролцож, талуудын эрх, үүрэг болон холбогдох бусад асуудлыг тодорхойлж байгуулсан иргэний эрх зүйн гэрээ байна.

2.2.Түншлэлийн төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэлбэр, төслийн дагуу гүйцэтгэх ажлын онцлогоос хамаарч гэрээний төрлийг тодорхойлох бөгөөд түншлэлийн гэрээ нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 15.1-д заасан төрөлтэй байна.

2.3.Түншлэлийн гэрээний талууд нь төрийн түншлэгч талаас тухайн төсөлд хамаарах

салбарын болон түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төсөл хэрэгжих орон нутгийн байгууллагын төлөөлөл, нөгөө талаас хувийн хэвшлийн түншлэгч буюу төсөл хэрэгжүүлэгч компани, төслийн санхүүжүүлэгч хуулийн этгээд байна.

2.4.Төрийн түншлэгч нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 28.1-д заасан нийтлэг чиг үүргээс гадна дараах үүрэгтэй:

2.4.1.хувийн хэвшлийн түншлэгч газрыг түншлэлийн гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглахад саад учруулахгүй байх, тухайн газар дээр ажил, үйлчилгээгээ явуулах нөхцөл, боломжоор хангах;

2.4.2.нийтэд зориулсан барилга байгууламжийн ашиглалт, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хэрэглэгчээс төлсөн төлбөр, хураамжийг түншлэлийн гэрээнд заасны дагуу хувийн хэвшлийн түншлэгчид шилжүүлэх;

2.4.3.төслийн онцлогт нийцүүлэн хэрэглэгчийн төлбөр, хураамж, тарифын хэмжээг тогтоох аргачлалыг өгөөжийн түвшин тооцох болон үнийн хязгаарлалтын, эсхүл энэ хоёрын холимог аргын хүрээнд боловсруулж, түншлэлийн гэрээнд тусгах;

2.4.4.салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь түншлэлийн гэрээ байгуулагдсан даруйд тухайн түншлэлийн гэрээ болон дагалдах гэрээний хуулбарыг цахим системд байршуулж, олон нийтэд мэдээлэх.

[\(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон\)](#)

2.5.Хувийн хэвшлийн түншлэгч нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 28.2-т заасан нийтлэг чиг үүргээс гадна дараах үүрэгтэй:

2.5.1.түншлэлийн үндсэн болон дагалдах гэрээнд заасан хугацаа, стандарт болон зардлын дагуу түншлэлийн төслийг хугацаанд нь гүйцэтгэх төсөл хэрэгжүүлэх баталгааг гаргаж, төлбөрийг гэрээнд заасны дагуу Түншлэлийн төсөл хөгжүүлэх санд гэрээ байгуулахаас ажлын 5 өдрийн өмнө шилжүүлэх;

2.5.2.түншлэлийн гэрээгээр тогтоосон төлбөр, хураамж, тарифын хэмжээний хязгаарлалтыг дагаж мөрдөх.

2.6.Түншлэлийн төслийг санхүүжүүлэгч нь түншлэлийн төслийг санхүүжүүлэх, татан төвлөрүүлсэн зээлийн эргэн төлөлтийн үүрэгтэй холбоотойгоор гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсан тохиолдолд санхүүжүүлэгчийн хөндлөнгөөс оролцох эрхийг хууль болон түншлэлийн гэрээнд заасны дагуу хэрэгжүүлнэ.

2.7.Түншлэлийн гэрээний нөхцөлийг тодорхойлохдоо түншлэгч талуудын чиг үүрэг, тухайн төслийг хэрэгжүүлэх салбарын онцлог, нөхцөл байдалтай уялдуулах бөгөөд хуульд заасан түншлэлийн зарчмыг удирдлага болгон Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 35.2-т заасан гол нөхцөлөөс гадна дараах нөхцөлийг тусгана:

2.7.1.түншлэгч талуудын хооронд эрсдэл хуваарилах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үүссэн эрсдэлийг шийдвэрлэх арга зам;

2.7.2.Засгийн газар баталгаа гаргах тохиолдолд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 31.1-д заасан Засгийн газрын баталгаа;

2.7.3.төрөөс дэмжлэг үзүүлэх тохиолдолд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 32.1-д заасан төрөөс үзүүлэх дэмжлэг;

2.7.4.түншлэлийн гэрээг цуцлахад талуудад олгох нөхөн төлбөрийг тооцох аргачлал;

2.7.5.төсөл хэрэгжих газрын эрх, түүнийг шилжүүлэх асуудал;

2.7.6.төслийг тусгай зориулалтын компани байгуулж хэрэгжүүлэх тохиолдолд тусгай зориулалтын компанийг хуулийн этгээдээр бүртгүүлснээс хойших хугацаанд компани өөрийн хөрөнгийн хэмжээг өөрчлөх, төрийн түншлэгчээс зөвшөөрөл авах журам, эдгээрт зарчмын өөрчлөлт оруулах нөхцөл;

2.7.7.төрийн түншлэгчид шилжүүлэх хөрөнгө, төрийн түншлэгч өөрийн сонголтоор худалдан авах хөрөнгө, хувийн хэвшлийн түншлэгчийн эзэмшилд үлдэх хөрөнгийн өмчлөлийн талаар талууд тохиролцсон тохиолдолд энэ талаарх зохицуулалт;

2.7.8.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 47.4-т заасан барьцааны зүйлийн талаар талууд тохиролцсон тохиолдолд энэ талаарх зохицуулалт;

2.7.9.хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн гэрээний дагуу нийтэд зориулсан барилга байгууламжийн ашиглалт, үйлчилгээтэй холбоотой түрээс, төлбөр, хураамж авах тохиолдолд төлбөр, хураамжийн хэмжээ тогтоох, түүнийг өөрчлөх аргачлал;

2.7.10.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 46.2-т заасан тохиолдолд төрийн түншлэгчээс гуравдагч этгээдэд эрх, үүрэг шилжүүлэх зөвшөөрөл өгөх нөхцөл болзол, гэрээний үүргийг бүхэлд нь хүлээн авсан шинэ түншийг хүлээн зөвшөөрөх, үйлчилгээ үзүүлэхэд тавигдах техникийн болон санхүүгийн чадавх;

2.7.11.нийтийн зориулалттай дэд бүтэц, барилга байгууламжийн төслийн ашиглалттай холбоотой Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 44.4-т заасан асуудал;

2.7.12.түншлэлийн гэрээ дуусгавар болсонтой холбоотой түншлэгч талууд болон санхүүжүүлэгч талын хүлээх санхүүгийн эрх, үүрэг;

2.7.13.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 48.5-д заасан түншлэлийн гэрээ дуусгавар болох, эрх шилжүүлэхтэй холбогдсон асуудал;

2.7.14.төрийн түншлэгчээс хэрэгжүүлэх хяналтын асуудал;

2.7.15.хувийн хэвшлийн түншлэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас төрийн түншлэгчээс гэрээг цуцлах эрхтэй болох, эсхүл гэрээг цуцлах болон гэрээнд заасан бусад нөхцөл үүссэн тохиолдолд төслийн санхүүжүүлэгч, эсхүл зээлдүүлэгч нь гэрээнд заасны дагуу санхүүжүүлэгчийн хөндлөнгөөс оролцох эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой журмыг гэрээнд тусгана.

2.8.Энэ журмын 2.7.6-д заасан нөхцөл, журам нь анхны сонгон шалгаруулалтын баримт бичигт заасантай ижил байна.

2.9.Түншлэлийн гэрээний талууд гэрээгээр хүлээсэн үүрэг, хариуцлагыг бүрэн хариуцаж, биелүүлэх үүрэгтэй бөгөөд хууль болон гэрээнд заасан чиг үүрэг, бүрэн эрхийн хүрээнд тухайн түншлэлийн харилцаанд оролцоно.

2.10.Түншлэлийн гэрээний хугацааг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 36.3-т заасан хүчин зүйл болон төслийг хэрэгжүүлэх салбар, төслийн үндсэн шинж болон гэрээний төрлөөс хамаарч талуудын харилцан тохиролцоноор тогтоох бөгөөд мөн хуулийн 36.2-т заасан гэрээний хугацаа 30 жилээс илүүгүй байна.

Гурав.Түншлэлийн гэрээ байгуулах ажлын зохион байгуулалт

3.1.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түншлэлийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулна.

3.2.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хэлэлцээрийн үр дүнд гэрээний нөхцөлийг хамгийн сайн харилцан тохиролцсон нэг оролцогчтой түншлэлийн гэрээ байгуулах дүгнэлт гарган, түншлэлийн гэрээ байгуулах санал, дүгнэлт авахаар ажлын 5 өдөрт багтаан дүгнэлт, холбогдох мэдээллийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

[\(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон\)](#)

3.3.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь сонгон шалгаруулалт, түншлэгчтэй хийсэн хэлэлцээрийн дүн, ажлын хэсгийн дүгнэлтийг төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийн талаас нь хянаж, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 9.1.8-д заасан журмыг баримтлан түншлэлийн гэрээ байгуулах эсэх санал, дүгнэлтийг ажлын 10 өдөрт багтаан түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

[\(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан\)](#)

3.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 3.3-т заасан зөвшөөрөл олгохоос татгалзсан бол үндэслэл, тайлбарыг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

[\(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон\)](#)

3.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түншлэлийн гэрээ байгуулах зөвшөөрөл олгосон тохиолдолд түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түншлэлийн гэрээ байгуулах тухай санал, дүгнэлтийг Засгийн газарт танилцуулж, түншлэлийн гэрээ байгуулах эсэх шийдвэрийг гаргуулна.

[\(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон\)](#)

3.6.Засгийн газраас түншлэлийн гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага 10 хоногийн дотор энэ журмын 3.2-т заасан гэрээний нөхцөлийг хамгийн сайн харилцан тохиролцсон нэг оролцогчид гэрээ байгуулах тухай мэдэгдлийг хүргүүлнэ.

3.7.Хувийн хэвшлийн түншлэгч түншлэлийн гэрээ байгуулахын өмнө дараах бичиг, баримт бичгийг бүрдүүлэн түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ:

3.7.1.төсөл хэрэгжүүлэх баталгааны талаарх мэдээлэл;

3.7.2.төслийн санхүүжүүлэгч, эсхүл зээлдүүлэгч байгууллагын албан бичиг, бусад нотлох баримт;

3.7.3.тусгай зориулалтын компани байгуулах тохиолдолд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, хувьцаа эзэмшигчдийн гэрээ, компанийн дүрэм;

3.7.4.консорциум байх бол бүх гишүүн хооронд байгуулсан түншлэлийн төслийг хэрэгжүүлэх хамтран ажиллах гэрээ;

3.7.5.хувийн хэвшлийн түншлэгчийг төлөөлж түншлэлийн гэрээнд гарын үсэг

зурах эрх бүхий этгээд мөн болохыг нотлох талаарх хуулийн этгээд нь нэг хувьцаа эзэмшигчтэй тохиолдолд эрх олгосон хувьцаа эзэмшигчийн шийдвэр, нэг ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчтэй тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн тогтоол, хурлын тэмдэглэл зэрэг баримт бичиг.

3.8.Хувийн хэвшлийн түншлэгч энэ журмын 3.6-д заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш 180 хоногийн дотор энэ журмын 3.7-д заасан баримт бичгийг бүрдүүлж гэрээнд гарын үсэг зурна.

3.9.Энэ журмын 3.5-д заасан Засгийн газрын гэрээ байгуулах шийдвэрт өөрөөр зааснаас бусад тохиолдолд гэрээний төсөлд өөрчлөлт оруулахыг хориглоно.

3.10.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 3.7-д заасан баримт бичгийг хүлээн авч, хянасны үндсэн дээр гэрээнд гарын үсэг зурах товыг товлон төрийн түншлэгч болон хувийн хэвшлийн түншлэгчид мэдэгдэнэ.

3.11.Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон хувийн хэвшлээс санаачилсан түншлэлээр хэрэгжүүлэх төслийн түншлэлийн гэрээнд төрийн түншлэгч талыг төлөөлж төсөл хэрэгжүүлэх салбарын болон түншлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гарын үсэг зурж баталгаажуулна. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 33.3-т зааснаар төсөл хэрэгжих орон нутгийг төлөөлж аймаг, нийслэлийн Засаг дарга түншлэлийн гэрээнд гарын үсэг зурна.

3.12.Орон нутгаас санаачилсан түншлэлээр хэрэгжих төсөлд төрийн түншлэгч талыг төлөөлж аймаг, нийслэлийн Засаг дарга Засгийн газраас эрх олгосон шийдвэрийг үндэслэн түншлэлийн болон салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран түншлэлийн гэрээг байгуулна.

3.13.Түншлэлийн гэрээнд төрийн захиргааны төв байгууллагыг төлөөлж Засгийн газрын гишүүн, түүний эрх олгосноор Төрийн нарийн бичгийн дарга, Засаг дарга, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн удирдлага, хувийн хэвшлийн түншлэгчийг төлөөлж Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.1.26-д заасан хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурна. Хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан нь хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, түүний эрх олгосноор Төлөөлөн удирдах зөвлөл, түүний эрх олгосноор гүйцэтгэх удирдлага байна.

Дөрөв.Хэлэлцээ хийж гэрээ байгуулах

4.1.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 37.1-д заасан тохиолдолд хувийн хэвшлийн түншлэгчтэй сонгон шалгаруулалтгүйгээр хэлэлцээ хийж гэрээ байгуулж болно.

4.2.Энэ журмын 4.1-д заасны дагуу сонгон шалгаруулалтгүйгээр хэлэлцээ хийж гэрээ байгуулах тохиолдолд түншлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хэлэлцээ хийж, гэрээний төсөл боловсруулах Ажлын хэсгийг томилно.

4.3.Ажлын хэсэг 7-оос доошгүй, сондгой тооны бүрэлдэхүүнтэй, дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэх бөгөөд бүрэлдэхүүнд түншлэлийн, салбарын, болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга, түншлэлийн төвийн төлөөллийг оруулж болно. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд хөндлөнгийн хараат бус гишүүн байж болно.

4.4.Ажлын хэсэг хувийн хэвшлийн түншлэгчтэй хэлэлцээ хийж, түншлэлийн гэрээний төслийг боловсруулж, дүгнэлтийн хамт түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.5.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түншлэлийн гэрээний төсөл, дүгнэлтийг хүлээн авч түншлэлийн гэрээ байгуулах санал, дүгнэлт авахаар ажлын 5 өдөрт багтаан дүгнэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. **(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)**

4.6.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түншлэлийн гэрээ байгуулах эсэх санал, дүгнэлт ирүүлэхдээ энэ журмын 3.3, 3.4-т заасан журмыг баримтална. **(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)**

4.7.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түншлэлийн гэрээ байгуулах тухай санал, дүгнэлтийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн санал, дүгнэлтийн хамт Засгийн газарт танилцуулж, түншлэлийн гэрээ байгуулах эсэх шийдвэрийг гаргуулна. **(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор өөрчлөн найруулсан)**

4.8.Засгийн газар түншлэлийн гэрээний төслийг хувийн хэвшлийн түншлэгчтэй дахин хэлэлцээ хийхээр буцаасан тохиолдолд түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 4.2-т заасан Ажлын хэсгийг шинэчлэн байгуулж хэлэлцээ хийх ажлыг үргэлжлүүлнэ.

4.9.Энэ журмын 3.14-т зааснаас бусад тохиолдолд хэлэлцээ хийж гэрээ байгуулахыг хориглох бөгөөд зөрчсөн албан тушаалтан учирсан хохирлыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 37.5-д заасны дагуу өөрийн хөрөнгөөр төлж барагдуулна.

Тав.Түншлэлийн гэрээний хэрэгжилт, хяналт

5.1.Төрийн түншлэгч нь түншлэлийн төслийн бүх үе шатад түншлэлийн гэрээнд заасан хяналтын эрхийг хэрэгжүүлнэ.

5.2.Түншлэлийн гэрээний хэрэгжилт, санхүүжилт, тайлагналт, хяналттай холбоотой харилцаанд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 7.2.7-д заасан журмыг баримтална.

Зургаа.Түншлэлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах

6.1.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түншлэлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх санал, дүгнэлтийг авна. **(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)**

6.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 7.2.6-д заасан журмын дагуу санал, дүгнэлт ирүүлнэ. **(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)**

6.3.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах тохиолдолд түншлэлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг гаргана:

6.3.1.түншлэлийн гэрээний агуулгын ач холбогдол бүхий харилцаа тухайн гэрээг байгуулснаас хойш бүхэлдээ, мэдэгдэхүйц өөрчлөгдсөн, гэрээний аль нэг тал гэрээний анхны зохицуулалтыг цаашид баримтлах боломжгүй болох нь тогтоогдсон бөгөөд талуудаас түншлэлийн гэрээнд өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан;

6.3.2.гэнэтийн болон давагдашгүй, урьдчилан таамаглаагүй нөхцөл байдлын улмаас төслийн техникийн үзүүлэлт, хөрөнгө оруулалтын тохиролцсон нийт хэмжээ өөрчлөгдсөн, хуульд зааснаар нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийн тайланд өөрчлөлт орсон, эсхүл гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлс бий болсон бөгөөд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахаар талууд харилцан тохиролцсон;

6.3.3.төрийн түншлэгчээс түншлэлийн гэрээний хамрах хүрээг өргөжүүлэн анхны гэрээнд тусгаагүй боловч зайлшгүй шаардлагатай ажил, үйлчилгээг хувийн хэвшлийн түншлэгчээр нэмэлтээр хийлгэх шаардлагатай болсон;

6.3.4.анх тохирсон гэрээний үнийн дүнг 15-аас дээш хувиар өсгөхөөр бол, эсхүл анхны гэрээнд заагаагүй ажил, үйлчилгээг хувийн хэвшлийн түншлэгч нэмэлтээр үзүүлэх үр дагавартай бол.

6.4.Энэ журмын 6.3.3-т заасан нэмэлтээр хийх ажил, үйлчилгээ нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 39.2-т заасан шаардлагыг хангасан байна.

6.5.Засгийн газар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал, дүгнэлтэд үндэслэн түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналаар түншлэлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг шийдвэрлэнэ. **(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)**

6.6.Түншлэлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал нь гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх талаар түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал, дүгнэлт авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ. **(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)**

6.7.Түншлэлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа түншлэлийн гэрээний гол нөхцөлийг өөрчлөхийг хориглоно.

6.8.Түншлэлийн гэрээний хугацаа дуусгавар болох үед талууд дараах тохиолдолд гэрээний хугацааг нэг удаа 10 хүртэлх жилээр сунгахаар зөвшилцөж болно:

6.8.1.гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээний аль нэг талын хяналтаас давсан нөхцөл байдал үүссэнээс төслийн үйл ажиллагаа зогссон;

6.8.2.төрийн түншлэгчээс гаргасан түншлэлийн гэрээнд тусгагдаагүй шаардлагыг хангахад төслийн нийт өртөг өссөн бөгөөд хувийн хэвшлийн түншлэгч уг зардлыг гэрээний хугацаа сунгахгүйгээр нөхөх боломжгүй болсон.

Долоо.Түншлэлийн гэрээ дуусгавар болох

7.1.Түншлэлийн гэрээ нь дараах тохиолдолд дуусгавар болно:

7.1.1.гэрээний хүчинтэй хугацаа дуусгавар болсон бөгөөд талууд сунгах хүсэлт гаргаагүй;

7.1.2.гэрээний нэг тал гэрээний үүргийг зөрчсөн, зөрчлийг арилгах үр дүнтэй арга хэмжээ аваагүй;

7.1.3.гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл бий болсон бөгөөд арилгах боломжгүй болсон;

7.1.4.хууль болон түншлэлийн гэрээнд өөрөөр заагаагүй бол хувийн хэвшлийн түншлэгч төлбөрийн чадваргүй болсон буюу татан буугдсан;

7.1.5.хууль болон түншлэлийн гэрээнд заасны дагуу гэрээг цуцалсан.

7.2.Түншлэлийн гэрээнд өөрөөр заагаагүй бол түншлэгч талууд түншлэлийн гэрээг хуульд заасан үндэслэлээр цуцална.

7.3.Түншлэлийн гэрээнд өөрөөр заагаагүй бол хуульд заасан үндэслэлээр талуудын санаачилгаар гэрээг цуцлах бөгөөд энэ тохиолдолд талуудад олгох нөхөн төлбөрийг хэрхэн тооцохыг гэрээнд заах ба түншлэлийн гэрээний дагуу гүйцэтгэсэн ажлын зохих үнэ цэн, гарсан зардал, тухайн талд учирсан бодит хохирлыг оруулж болно.

7.4.Түншлэлийн гэрээ дуусгавар болсонтой холбоотой түншлэгч талууд болон санхүүжүүлэгч талын хүлээх санхүүгийн эрх, үүргийг түншлэлийн гэрээнд тодорхойлох бөгөөд хөрөнгө оруулалт, өр төлбөр, нөхөх олговор, нэмэлт санхүүжилт, зардлын хэтрэлт, санхүүгийн алдагдлыг хэрхэн шийдвэрлэх талаар тусгасан байна.

7.5.Түншлэлийн гэрээ дуусгавар болсонтой холбогдуулан хувийн хэвшлийн түншлэгч нь төслийн хүрээнд эзэмшиж, ашиглаж байсан хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, инновац, ноу-хау, оюуны өмч, техникийн бичиг баримт, төслийн үйл ажиллагаатай холбоотой эрхийг төрийн түншлэгчид шилжүүлэн өгнө.

7.6.Хуульд зааснаар гэрээ цуцалсантай холбогдуулан төслийн нэмэлт хөрөнгө оруулалт болон төслийг дахин эхлүүлэх эсэх, гуравдагч этгээдэд түншлэлийн эрх, үүргийг шилжүүлэх шийдвэрийг Засгийн газар гаргана.

7.7.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг дарга түншлэлийн дагуу бий болсон болон түншлэлд хамаарах аливаа хөрөнгийг түншлэлийн гэрээ, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчид шилжүүлэх, бүртгэх арга хэмжээг зохион байгуулна.

Найм.Бусад

8.1.Түншлэлийн гэрээг монгол хэлээр үйлдэх бөгөөд гэрээний талуудын сонгон авсан бусад хэлээр үйлдэж болно.

8.2.Энэ журмын 4.7-д заасан санал, дүгнэлтийг аваагүй байгуулсан гэрээ хүчин төгөлдөр бус байна.

[\(Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон\)](#)

8.3.Түншлэлийн гэрээнд талууд гарын үсэг зурснаар сонгон шалгаруулалтад оролцогчдын сонгон шалгаруулалтын баталгааг чөлөөлнө.

8.4.Энэ журмын 3.8-д заасан хугацаанд түншлэлийн гэрээнд талууд гарын үсэг зураагүй, зурах боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд урьд зарласан сонгон шалгаруулалтыг хүчингүйд тооцож, гэрээ байгуулах мэдэгдэл хүлээж авсан оролцогчийн сонгон шалгаруулалтын баталгааг гүйцэтгэж, уг түншлэлийн төслийн сонгон шалгаруулалтыг дахин зарлана.

8.5.Төрийн түншлэгч байгууллагын холбогдох албан тушаалтан түншлэлийн гэрээ байгуулах болон хэлэлцээ хийх явцад хувийн хэвшлийн этгээдээс ирүүлсэн хуулиар хамгаалагдсан нууцыг хадгална.

8.6.Түншлэлийн гэрээ байгуулсан түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гэрээний эх хувийг дараах баримт бичгийн хамт хадгална:

8.6.1.Засгийн газраас гэрээ байгуулах эрх олгосон шийдвэр;

8.6.2.гэрээний эх хувь;

8.6.3.дагалдах гэрээ, төслийн үе шат, гэрээний төлбөр, санхүүжилтийн хуваарь, хэрэгжилтийн төлөвлөгөө;

8.6.4.гэрээний төслийн талаар хэлэлцээ хийсэн уулзалтын тэмдэглэл, бусад холбогдох баримт бичиг.

----oOo----

Засгийн газрын 2023 оны 11 дүгээр
сарын 15-ны өдрийн 404 дүгээр
тогтоолын 4 дүгээр хавсралт

ТҮНШЛЭЛИЙН ХҮРЭЭНД ЭРСДЭЛ ТООЦООЛОХ, ХУВААРИЛАХ АРГАЧЛАЛ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.1.29-д заасан эрсдэлийн шинжилгээ, 20.4-т заасан түншлэлийн төслийн бүрэн шинжилгээ, 30.1-д заасан түншлэлийн эрсдэлийн удирдлагын арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд энэхүү аргачлалыг (цаашид "аргачлал" гэх) ашиглана.

1.2.Төсвийн эрсдэлийн үнэлгээ, төсөвт үзүүлэх нөлөөг тооцоход энэ аргачлалыг ашиглахгүй бөгөөд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 9.2-т заасан загварыг ашиглана.

1.3.Аргачлалд хэрэглэсэн нэр томъёог Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан утгаар ойлгоно.

1.4.Эрсдэл тооцоолох, хуваарилах үйл ажиллагааг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан түншлэлийн төслийн бүрэн шинжилгээний үе шатад боловсруулах бөгөөд дараах үе шаттай байна.

1.4.1.эрсдэлийг тодорхойлох;

1.4.2.эрсдэлийг эрэмбэлэх;

1.4.3.эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх;

1.4.4.эрсдэлийг хуваарилах.

1.5.Эрсдэлийг хуваарилахад Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 30.3-т зааснаар төслийн онцлогийг харгалзан үнэ болон чанарын харьцааг хадгалж, эрсдэлийг бага зардлаар үр ашигтай шийдвэрлэх, түншлэгч талд хуваарилах, эрсдэлийг оновчтой хуваарилах буюу эрсдэлийн хуваарилалтын зохистой байдлыг хангана.

1.6.Эрсдэлийн шинжилгээг бодитой, оновчтой хийх зорилгоор эрсдэлийн шинжилгээ хийх бүрэлдэхүүнд бүрэн шинжилгээний төслийн багийн бүх гишүүн, Түншлэлийн төв болон төсөлтэй холбогдох бүхий л түвшний байгууллага, салбарын мэргэжилтнүүдийг оролцуулж болно.

1.7.Түншлэлийн төслийн бүрэн шинжилгээний хувьд энэхүү аргачлалаар хийгдэх төслийн эрсдэлийн шинжилгээний нэгдсэн матриц нь эцсийн үр дүн биш бөгөөд хуулийн хүрээнд хийгдэх бусад тооцоо судалгаа, нөхцөл байдал өөрчлөгдөх бүрд эрсдэлийн шинжилгээг шинээр хийнэ.

Хоёр.Эрсдэлийг тодорхойлох

2.1.Түншлэлийн төслийг бэлтгэх, хэрэгжүүлэх бүх үе шатад сөргөөр нөлөөлж болохуйц эрсдэлийг ангилал тус бүрээр тодорхойлж, жагсаалт гаргана. Энэ үед тухайн төслийн

үр нөлөө, ач холбогдлын их, бага зэргийг үл харгалзан байж болох бүхий л эрсдэлийг тусгана.

2.2.Эрсдэлийг дараах ангилалд хуваах бөгөөд түншлэлийн төслийн хэрэгжих салбар онцлогоос хамаарч төслийн ангиллыг өөрчлөн ашиглаж болно:

- төслийн газартай холбоотой /Site/: төсөл хэрэгжүүлэх газрын бэлэн байдал, чанар, зөвшөөрөл, газар зүйн онцлог, байгаль орчинтой холбоотой эрсдэл;
- зураг төсөл, барилга угсралт, ашиглалтад оруулахтай холбоотой /Design, construction and commissioning/: төслийн барилга угсралт, түүний чанар, зураг төсөлтэй холбоотой эрсдэл;
- үйл ажиллагаатай холбоотой /Operation/: төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой эрсдэл;
- эрэлт болон бусад бизнесийн үйл ажиллагаатай холбоотой /Demand and other commercial risk/: орлого, эрэлт нь тооцсон хэмжээнд хүрэхгүй байх эрсдэл;
- улс төртэй холбоотой /Political/: улс төрийн шийдвэр, нөхцөл байдлаас үүдэлтэй төсөлд сөргөөр нөлөөлөх эрсдэл;
- хууль, эрх зүйн орчны өөрчлөлттэй холбоотой /Change in legal and regulatory framework/: хууль болон зохицуулалтын орчны өөрчлөлтөөс шалтгаалж төслийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэл;
- дампууралтай холбоотой /Default/: хувийн түншлэгч болон холбоотой компаниуд төсөл хэрэгжүүлэх санхүүгийн болон техникийн чадамжгүй болох эрсдэл
- эдийн засаг болон санхүүтэй холбоотой /Economic or financial/: валютын ханш, хүү, инфляцын өөрчлөлтөөс үүсэх эрсдэл;
- давагдашгүй хүчин зүйлтэй холбоотой /Force majeure/: талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, урьдчилан сэргийлж, шинжлэх ухаан, техникийн ололтыг ашиглан даван гарах боломжгүй саад тотгор тохиолдсоны улмаас үүсэх эрсдэл;
- эд хөрөнгийн эзэмшилтэй холбоотой /Asset ownership/: дэд бүтцийн үнэ цэнэ, технологийн өөрчлөлтөөс шалтгаалах эрсдэл.

2.3.Эрсдэлийг тодорхойлох дараах нийтлэг аргуудаас ашиглана;

- өмнө хийгдсэн болон ижил төстэй төслийн мэдээлэл, мэдлэгийг ашиглах, судлах;
- салбарын мэргэжилтнүүд, оролцогч талуудтай хэлэлцэх;
- олон улсын туршлагаас ашиглах;
- Тухайн салбарт нийтлэг хэрэглэгддэг бүрэн хэмжээний жишиг жагсаалт, хяналтын хуудас /checklist/ ашиглах.

Гурав.Эрсдэлийг эрэмбэлэх

3.1.Эрсдэлийг эрэмбэлэх алхам нь нийт тодорхойлсон эрсдэлүүдийг чанарын шинжилгээний аргаар үнэлж, эрсдэлийн түвшнийг тодорхойлж, эрэмбэлэхэд оршино. Энэхүү аргын хүрээнд дараах хоёр үзүүлэлтийг ашиглана:

- тухайн эрсдэл тохиох магадлал /likelihood, probability/;
- тухайн эрсдэл тохиолдсоны дараах үр дагавар, үр нөлөө /consequence, impact/.

3.2. Эрсдэлүүдийн төсөлд үзүүлэх нөлөөг эрсдэл тус бүрээр тодорхойлох бөгөөд маш их, их, дунд, бага, маш бага гэсэн 5 түвшинд үнэлнэ. Мөн харгалзах тоон утгыг 5, 4, 3, 2, 1 гэж өгнө.

3.3. Дараа нь тухайн эрсдэлүүд тохиолдох магадлалын түвшнийг хэмжиж маш их, их, дунд, бага, маш бага /5, 4, 3, 2, 1/ утгаар үнэлнэ. Эдгээр нөлөөлөл болон магадлалын үнэлгээ нь тогтсон нийтлэг хэмжүүр, шалгуур байхгүй таамаглал тул тухайн үнэлгээ хийсэн үндэслэл, шалтгаан, тайлбарыг тэмдэглэж баримтжуулна.

3.4. Магадлал болон нөлөөллийн түвшний тоон утгын үржвэрээр эрсдэлийн түвшнийг тодорхойлно.

$$\text{Эрсдэлийн түвшин} = \text{Магадлал} * \text{Нөлөөлөл}$$

3.5. Эрсдэлийн түвшинд үндэслэн түүнд харгалзах тоон утгыг бага (1-8), дунд (9-15), их (16-25) түвшинд ангилж, цаашид авч үзэх эрсдэлүүдийг эрэмбэлж, тодорхойлно.

Дөрөв.Эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөх

4.1. Тодорхойлж эрэмбэлсэн эрсдэлүүдийг бууруулах арга хэмжээг эрсдэл тус бүр дээр төлөвлөх бөгөөд "урьдчилан сэргийлэх" болон "хохирлыг бууруулах" гэсэн арга хэмжээг авна.

4.2. Эрсдэлийг бууруулах арга хэмжээг дараах үндсэн дөрвөн төрөлд ангилна:

- эрсдэлийг хуваарилах /allocate/: эрсдэлийг төр болон хувийн хэвшлийн эрсдэлийг удирдах чадавх болон үр дүнд илүү зохицох байдлыг харгалзан хуваарилах;
- эрсдэлээс зайлсхийх /avoid/: төслийн цар хүрээ, төлөвлөлт, дизайн зэргийг оновчтой зохион байгуулж, аливаа учирч болох эрсдэлийг бууруулах;
- дасан зохицох /adapt/: аливаа сөрөг өөрчлөлтөд дасан зохицох байдлаар төлөвлөж, эрсдэлийг бууруулах;
- хүлээн зөвшөөрөх /accept/: эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардал нь тухайн эрсдэлийн хохирлоос их тохиолдолд тухайн эрсдэлийг бууруулах арга хэмжээ авалгүйгээр хүлээн зөвшөөрөх.

4.3. Эрсдэл бүр дээр холбогдох бууруулах арга хэмжээг боловсруулна.

4.4. Эрсдэлийн түвшин өндөр гарсан тохиолдолд эрсдэлээс зайлсхийх, хуваарилах арга хэмжээний төлөвлөгөөг заавал боловсруулах бөгөөд төлөвлөгөөг хэрэгжүүлснээр эрсдэлийн түвшин дунд, эсхүл бага түвшинд хүрэхээр байна.

4.5. Эрсдэлийн түвшин дунд гарсан тохиолдолд эрсдэлийг хуваарилах арга хэмжээний төлөвлөгөөг заавал боловсруулах бөгөөд төлөвлөгөөг хэрэгжүүлснээр эрсдэлд дасан зохицох түвшинд хүрэхээр байна.

4.6. Эрсдэлийн түвшин бага гарсан тохиолдолд эрсдэлийг хүлээн зөвшөөрөх, хуваарилах төлөвлөгөөг боловсруулна.

Тав.Эрсдэлийг хуваарилах

5.1. Эрсдэлийг хуваарилах үйл ажиллагаа нь тухайн эрсдэлийн сөрөг үр нөлөөг хамгийн бага түвшинд хүртэл бууруулах зорилготой байна.

5.2.Олон улсад өргөн ашиглагддаг эрсдэлийг хуваарилах гол зарчим болох төрийн болон хувийн түншлэгчийн аль илүү эрсдэлийг удирдах боломж болон үр нөлөөг аргалах чадамжийг харгалзан үзнэ.

5.3.Эрсдэл хуваарилахад дараах үндсэн нөхцөлийг харгалзан үзнэ:

- эрсдэлийн гарах магадлалыг удирдах чадавх;
- эрсдэлийн үр нөлөөг даах чадавх;
- хамгийн бага зардлаар эрсдэлийг бууруулах чадавх.

5.4.Эрэмбэлэгдсэн эрсдэлүүд тус бүрд тухайн эрсдэлийг хариуцах талыг төр, хувийн хэвшил, дундын гэсэн хувилбараар хуваарилна. Шаардлагатай тохиолдолд зарим хэсгийг хэрэглэгчдэд, эсхүл даатгалын компанид хуваарилж болно.

5.5.Төслийн эрсдэлийн нэгдсэн матрицыг дараах агуулгыг багтаан боловсруулна:

- эрсдэлийн нэр, ангилал;
- эрсдэлийн агуулга, тодорхойлолт;
- магадлал болон нөлөөлөл, эрсдэлийн түвшин;
- бууруулах арга хэмжээний төлөвлөгөө;
- эрсдэл хуваарилалт /төр, хувийн хэвшил, дундын/;
- төрөөс дэмжлэг үзүүлэх боломж, Засгийн газрын баталгааны санал;
- түншлэлийн гэрээнд тусгах санал

Жишээ:

Эрсдэлийн ангилал	Агуулга	Тодорхойлолт	Магадлал	Нөлөөлөл	Эрсдэлийн түвшин	Бууруулах арга хэмжээ	Эрсдэл хуваарьлалт	Төрийн дэмжлэг үзүүлэх боломж	Түншлэлийн гэрээнд тусгах санал
Барилга угсралт	Барилгын материалын үнэ өсөх	Инфляц, хилийн хориг зэрэг шалтгаанаар барилгын материалын үнэ өсөх, барилгын угсралтын зардал өсөх	Их /4/	Их /4/	Их /16/	Тогтвортой үнийн бэлтгэн нийлүүлэлт худалдан авалт, төсөвт өртөгт оруулан тооцох	Ихэвчлэн хувийн хэвшилд хуваарилдаг	Зарим зохицуулалт	Хувийн хэвшлийн тооцоо удалгаанд туссан байх, аливаа эрсдэлийг даах заалт гэрээнд туссан байх

Засгийн газрын 2023 оны 11 дүгээр
сарын 15-ны өдрийн 404 дүгээр
тогтоолын 5 дугаар хавсралт

ТҮНШЛЭЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, САНХҮҮЖИЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ТАЙЛАГНАЛТ БОЛОН ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Түншлэлийн төслийн хэрэгжилт, санхүүжилт, зохион байгуулалт, тайлагналт болон төслийн хэрэгжилтэд хяналт тавихад энэ журмыг баримтална.

1.2.Энэ журамд хэрэглэсэн нэр томьёог Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд зааснаар ойлгоно.

1.3.Түншлэлийн төслийн хэрэгжилт, санхүүжилт, зохион байгуулалт, тайлагналт болон хяналт тавих үйл ажиллагаанд үнэн зөв, бодитой байх, ил тод байх, шударга, хариуцлагатай байх, тасралтгүй, тогтмол хийгддэг байх зарчмыг баримтална.

Хоёр.Үйлчлэх хүрээ

2.1.Энэ журмыг дараах этгээд үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө:

- 2.1.1.түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
- 2.1.2.санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
- 2.1.3.салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
- 2.1.4.төсөл хэрэгжиж буй аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар;
- 2.1.5.хувийн хэвшлийн түншлэгч;
- 2.1.6.төрийн түншлэгчийн өмнөөс хяналт тавих, зөвлөхийн үүрэг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, тэдгээрийн түншлэл;
- 2.1.7.төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцож байгаа иргэн, хуулийн этгээд;
- 2.1.8.хуульд заасан бусад.

2.2.Түншлэлийн гэрээ болон энэ журмаар зохицуулаагүй бусад асуудлыг холбогдох хууль тогтоомж, журам, зааврыг дагаж мөрдөнө.

Гурав.Түншлэлийн төслийн хэрэгжилт

3.1.Түншлэлийн гэрээнд талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн түншлэлийн төслийг хэрэгжүүлж эхэлнэ.

3.2.Хувийн хэвшлийн түншлэгч нь холбогдох хууль тогтоомжийн дагуу түншлэлийн гэрээнд заасан төсөл хэрэгжүүлэх газрыг эзэмших, эсхүл ашиглах зөвшөөрлийг авах бөгөөд төрийн түншлэгч нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 41.3-т заасан газартай холбоотой үүрэг хүлээнэ.

3.3.Хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын санхүүжилтийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 44.1-д заасан эх үүсвэрээр санхүүжүүлэх бөгөөд санхүүжилтийг түншлэлийн гэрээнд заасан хугацаанд бүрдүүлнэ.

3.4.Хувийн хэвшлийн түншлэгч нь уралдаант шалгаруулалтад оролцохдоо ирүүлсэн түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын санхүүжилтийн саналын бүтцэд өөрчлөлт оруулах тохиолдолд энэ тухай үндэслэл бүхий саналаа салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад холбогдох баримт материалын хамт хүргүүлж, бичгээр зөвшөөрөл авна. Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага өөрчлөлт оруулах санхүүжилтийн санал нь төслийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөхүйц аливаа эрсдэлтэй байна гэж үзвэл татгалзаж болох бөгөөд үндэслэл бүхий тайлбарын хамт хариу өгнө.

3.5.Хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын санхүүжилттэй холбогдох гэрээ, бүрдүүлбэр, бусад баримт бичгийг түншлэлийн болон салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухайн санхүүжилтийн гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор ирүүлнэ.

3.6.Хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх төрлийн зөвшөөрлийг холбогдох хууль, журмын дагуу эрх бүхий байгууллагаас авах бөгөөд хэрэв хүсэлт гаргасан тохиолдолд төрийн түншлэгчийн зүгээс хуульд заасан эрх хэмжээний хүрээнд дэмжлэг үзүүлж болно.

3.7.Хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн төслийн барилга угсралт, холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалт, шинэчлэлийн ажлын зураг төслийг хийхээр заасан тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллага болон тухайн төсөл хэрэгжих салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах бөгөөд түншлэлийн гэрээнд заасан нөхцөл, шаардлага, чанарын дагуу гүйцэтгэнэ. Төрийн түншлэгч нь энэ тохиолдолд түншлэлийн гэрээнд заагаагүй аливаа үүрэг, хариуцлага хүлээлгэхгүй, түүнчлэн эрх олгохгүй.

3.8.Хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн төслийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг хийж дууссанаас хойш 3 сарын дотор төслийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэлийн тайланг гаргаж, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.9.Түншлэлийн төслийн хүрээнд байгуулсан дэд бүтэц, барилга байгууламжийг холбогдох хууль тогтоомж, түншлэлийн гэрээний дагуу ашиглалтад оруулах бөгөөд энэ тухай төрийн түншлэгчид мэдэгдэж, холбогдох төрийн байгууллагаас үйл ажиллагаа эхлүүлэх зөвшөөрөл авна.

3.10.Энэ журмын 3.9-д заасан үйл ажиллагаа эхлүүлэх зөвшөөрлийг олгох шийдвэр гарсан тохиолдолд тухайн дэд бүтэц, хөрөнгө оруулалт, барилга байгууламжийн зардалтай уялдуулан төсөл хэрэгжүүлэх баталгааны тодорхой хувийг гэрээнд заасан нөхцөлийн дагуу чөлөөлж болно.

3.11.Түншлэлийн гэрээний хугацаа дуусгавар болж, хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн хүрээнд бий болсон, эсхүл түншлэлд хамаарах аливаа хөрөнгийг түншлэлийн гэрээнд заасны дагуу шилжүүлсэн тохиолдолд төсөл хэрэгжүүлэх баталгааны хөрөнгийг гэрээнд заасны дагуу бүрэн чөлөөлнө.

3.12.Хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн гэрээний дагуу нийтэд зориулсан барилга байгууламжийн ашиглалт, үйлчилгээтэй холбоотой түрээс, төлбөр, хураамж, түүний өөрчлөлтийг түншлэлийн гэрээнд заасан хэмжээ, аргачлалын дагуу тогтоож холбогдох эрх бүхий байгууллагаар батлуулан мөрдөж ажиллана. Холбогдох эрх бүхий байгууллага нь уг шийдвэрийг өөрийн цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршуулна.

3.13.Төслийн хэрэгжилтийн явцад хувийн хэвшлийн түншлэгч тусгай зориулалтын компанийн дүрэмд өөрчлөлт оруулах шаардлагатай болсон, эсхүл компанийн өмчлөгч өөрчлөгдөх тохиолдолд гэрээнд заасны дагуу түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдэгдэж зөвшөөрөл авна. Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага уг зөвшөөрлийг ажлын 10 өдрийн дотор шийдвэрлэнэ.

3.14.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 46.2-т заасан санхүүжүүлэгчийн хөндлөнгөөс оролцох эрхийг хэрэгжүүлэх тохиолдолд түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох талуудыг оролцуулан ажлын хэсэг байгуулж, түншлэлийн гэрээнд заасан арга хэмжээ авч, Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлнэ.

3.15.Хувийн хэвшлийн түншлэгч нь нийтийн зориулалттай дэд бүтцийн болон барилга байгууламжийн ашиглалтын дүрэм тогтоох, мөрдүүлэх эрхтэй бөгөөд салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянан баталгаажуулна.

3.16.Хувийн хэвшлийн түншлэгч нь техникийн аюулгүй байдал болон түншлэлийн гэрээний нөхцөл, шаардлагыг хангаж ажиллаагүйн улмаас гарсан аливаа хохирлыг бие даан хариуцаж, өөрийн хөрөнгөөр барагдуулах бөгөөд хохирлын хэмжээг тогтоох үйл ажиллагааг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас бусад төрийн түншлэгчийг оролцуулан байгуулсан ажлын хэсэг тогтоож, хохирлыг барагдуулах ажлыг зохион байгуулна.

Дөрөв.Түншлэлийн төслийн гэрээний зохион байгуулалт

4.1.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь түншлэлийн төслийн хэрэгжилт, гэрээний биелэлтийг хангаж, нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэн, хяналт тавих бөгөөд шаардлагатай тохиолдолд албан ёсны шийдвэрийн дагуу түншлэлийн төвөөр дамжуулан хэрэгжүүлж болно.

4.2.Тухайн төсөл хэрэгжих салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төрийн түншлэгчийн чиг үүргийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон түншлэлийн гэрээнд заасны дагуу хэрэгжүүлж, төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнана. Энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор албан ёсны шийдвэрийн дагуу хариуцсан нэгж, албан тушаалтныг томилон ажиллуулж болно.

4.3.Түншлэлийн төсөл хэрэгжиж буй орон нутгийн захиргааны байгууллагаас хууль тогтоомжоор олгогдсон эрх, үүргийн хүрээнд тухайн орон нутагт хэрэгжиж буй төслийн хэрэгжилтэд хяналт тавин, түншлэлийн төслийг амжилттай хэрэгжүүлэхэд талуудад хууль тогтоомжийн дагуу газар эзэмших, ашиглах болон холбогдох бусад зөвшөөрөл олгох зэрэг дэмжлэг үзүүлэн ажиллана.

4.4.Хувийн хэвшлийн түншлэгч төрийн түншлэгчтэй харилцах албан ёсны бүтэцтэй байх бөгөөд түншлэлийн гэрээ, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар шуурхай

харилцах тогтолцоог бүрдүүлж, харилцах талуудын мэдээлэлд өөрчлөлт орох бүрд даруй мэдэгдэнэ.

4.5.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь түншлэлийн гэрээ, түншлэлийн төслийн хэрэгжилтийн мэдээллийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 51.1-д заасан Нууцын тухай хууль тогтоомж, түншлэлийн гэрээнд зааснаас бусад тохиолдолд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу нийтэд мэдээлж, ил тод байдлыг хангаж ажиллана.

4.6.Нийтийн зориулалттай дэд бүтцийн барилга байгууламжийн ашиглалтад салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон тухайн салбарын мэргэжлийн байгууллага хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Тав.Түншлэлийн төслийн санхүүжилт

5.1.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 14.1.2, 14.1.3-т заасан буюу түншлэлийн төслийн зардлыг төсвөөс санхүүжүүлэх төслийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, төслийн орлогын гүйцэтгэл, дараа жилийн санхүүжилтийн саналыг хувийн хэвшлийн түншлэгч жил бүрийн 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.2.Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэлийн үнэлгээг хийж, тухайн жилийн санхүүжилтийн саналыг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухайн жилийн 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор хүргүүлнэ.

5.3.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэлийн үнэлгээг хянаж, санхүүжилтийн саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.4.Энэ журмын 5.3-т заасан гүйцэтгэлийн үнэлгээнд шаардлагатай гэж үзвэл төрийн аудитын байгууллагаар гүйцэтгэлийн аудит хийлгэж болно.

5.5.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага санхүүжилтийн санал, гүйцэтгэлийн үнэлгээг хянаж түншлэлийн гэрээ болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу санхүүжилтийг олгоно.

5.6.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран энэ журмын 5.1-д заасан дараа жилийн төсөвт суулгах санхүүжилтийн саналыг хянана.

5.7.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 5.6-д заасны дагуу хянасан дараа жилийн төсвөөс санхүүжүүлэх саналуудыг нэгтгэн жил бүрийн 08 дугаар сарын 10-ны өдрийн дотор төсөвт тусгуулахаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.8.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 5.7-д заасан саналыг төсвийн төсөлд тусгаж, түншлэлийн төслийн санхүүжилтийг төсөвтэй уялдуулна.

Зургаа.Түншлэлийн төслийн тайлагналт

6.1.Хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн төслийн хэрэгжилт, үр дүнгийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайланг улирал тутам үнэн зөв, бодитоор гаргаж салбарын болон түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, тайлагнана. Гэрээнд заасан бол орон нутгийн байгууллагад хүргүүлж болно.

6.2.Түншлэлийн төв төрийн түншлэгч байгууллагын хэрэгцээ шаардлага, гэрээний нөхцөлд тулгуурлан тайлангийн загвар, маягт, зааварчилгааг боловсруулан ашиглаж болно.

6.3.Хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн гэрээний хугацаанд санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу үнэн зөв бүртгэн тайлагнаж, хөндлөнгийн хараат бус аудитын байгууллагаар аудит хийлгэн, түншлэлийн төв болон төрийн түншлэгчид жил бүрийн 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор хүргүүлнэ.

6.4.Хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, бусад төрийн түншлэгчийг түншлэлийн төслийн үйлчилгээний чанар, хүртээмж, санхүүгийн мэдээлэл болон Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай тайлан, мэдээллээр тогтоосон хугацаанд хангаж, үнэн зөв, найдвартай байдлыг хариуцна.

6.5.Хувийн хэвшлийн түншлэгч нь жил бүрийн 2 дугаар сард багтаан түншлэлийн төслийн хүрээнд тухайн жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

6.6.Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 6.5-д заасан төлөвлөгөөг хянан баталгаажуулж, бусад төрийн түншлэгчид хүргүүлнэ.

6.7.Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь түншлэлийн төслийн хэрэгжилт, гэрээний биелэлтийг үнэлж, холбогдох мэдээллийг тусгасан жил бүрийн тайланг бэлтгэж, (түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага) болон Түншлэлийн төвд 04 дүгээр сарын 20-ны өдрийн дотор хүргүүлнэ.

6.8.Түншлэлийн төв нь энэ журмын 6.7-д заасан тайланд үндэслэн санхүүгийн болон эрсдэлийн хяналт-шинжилгээг хийж, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажлын 15 өдрийн дотор хүргүүлнэ.

6.9.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь түншлэлийн хууль тогтоомж, түншлэлийн төслийн хэрэгжилт, гэрээний биелэлтийн талаарх жилийн тайланг нэгтгэн боловсруулж, Засгийн газарт жил бүрийн 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор хүргүүлнэ. Шаардлагатай тохиолдолд тухай бүр холбогдох мэдээллийг түншлэгч талуудаас гаргуулан авч болно.

6.10.Засгийн газар түншлэлийн төслийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлан мэдээллийг нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлантай хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

Долоо.Түншлэлийн төсөлд хяналт тавих

7.1.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түншлэлийн төсөлд хяналт тавих чиглэлээр дараах хяналт, арга хэмжээг хэрэгжүүлнэ:

7.1.1.энэ журмын 6.1, 6.3-т заасан тайланг хүлээн авч, гэрээний биелэлтэд хяналт тавих;

7.1.2.түншлэлийн төслийн хяналтыг хэрэгжүүлэхдээ салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, төрийн аудитын байгууллага, Түншлэлийн төв, төрийн өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, хяналтын чиг үүрэг хэрэгжүүлэх бусад байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төв, мэргэжлийн холбоод, мэргэшсэн инженер, зөвлөх, мэргэжлийн зөвлөх компанийг татан оролцуулах;

7.1.3.төслийн хэрэгжилттэй газар дээр нь жилд нэгээс доошгүй удаа очиж танилцах;

7.1.4.түншлэлийн төслийг амжилттай сайн хэрэгжүүлэх зорилгын хүрээнд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 7.2.2-т заасан хувийн хэвшлийн түншлэгчийг болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журмын дагуу зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах;

7.1.5.салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай харилцан зөвшилцсөний үндсэн дээр тухайн салбарт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрт хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагатай хяналтын зөвлөхийн гэрээг байгуулан хамтран ажиллах;

7.1.6.хувийн хэвшлийн түншлэгч төслийг хэрэгжүүлэх санал ирүүлэх үедээ тооцоолж байсан түншлэлийн төслийн орлого нь тооцоолсон хэмжээндээ хүрч буй эсэх, төслийн барилга угсралтын үйл ажиллагаа дууссанаас хойш төслийн гүйцэтгэлд 3-5 жил тутамд үнэлгээ хийж, холбогдох санал, дүгнэлтийг гаргах;

7.1.7.түншлэлийн төслийн хэрэгжилттэй газар дээр нь танилцах, шалгах зорилгоор төслийн талбарт ажиллах зардлыг жилд нэг удаа хувийн хэвшлийн түншлэгчээс гаргуулж болох бөгөөд энэ тухай түншлэлийн гэрээгээр нарийвчлан зохицуулах;

7.1.8.Төрийн түншлэгчээс төслийн хэрэгжилтийн явцад ирүүлсэн санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв тайлагнасан эсэхийг нягтлан шалгах бүрэн эрхтэй бөгөөд энэ хүрээнд төрийн аудитын байгууллага, олон улсын болон дотоодын аудитын байгууллага, хөндлөнгийн хараат бус зөвлөх компанийг татан оролцуулах.

7.2.Энэ журмын 7.1.8-д заасан хяналт шалгалтаар хувийн хэвшлийн түншлэгч нь санхүүгийн тайлагналаа аливаа алдаа дутагдалгүй, зөрүүгүй, үнэн зөв тайлагнасан нь тогтоогдвол тус хяналт шалгалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан зардлыг төрийн түншлэгч хариуцна.

7.3.Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

7.3.1.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 10.1.9-д заасны дагуу төслийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах;

7.3.2.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 10.1.11-д заасны дагуу холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, гэрээний биелэлтийг хангуулахад хяналт тавих;

7.3.3.өөрийн салбарт түншлэлийн гэрээгээр хэрэгжиж буй төслийн хэрэгжилтийг жилд нэгээс доошгүй удаа газар дээр нь очиж танилцан, гүйцэтгэлд хяналт тавин ажиллах бөгөөд түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хэрэгжүүлэх;

7.3.4.төслийн хэрэгжилтийг шалгахдаа өөрийн дэргэд байгуулагдсан хяналтын чиг үүрэг хэрэгжүүлэх бусад байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төв, мэргэжлийн холбоод, мэргэшсэн инженер, зөвлөх, мэргэжлийн зөвлөх компанийг татан оролцуулж болох бөгөөд тэдгээрийн гаргасан тайлан, хяналт шалгалтын үр дүнгийн үнэн зөв байдлыг бүрэн хариуцах;

7.3.5.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 10.1.12-т заасан түншлэлийн төслийн дэлгэрэнгүй мэдээлэл, төслийн явц, төслийн баримт бичиг, түншлэлийн гэрээ, санхүүжилтийн талаарх мэдээллийг хувийн хэвшлийн түншлэгчээс гаргуулан авч хянан Түншлэлийн мэдээллийн нэгдсэн санд оруулах, олон нийтэд мэдээлэх бөгөөд мэдээллийг улирал тутамд шинэчлэх.

7.4.Аймаг, нийслэл түншлэлийн төсөлд дараах хяналт, арга хэмжээг хэрэгжүүлнэ:

7.4.1.түншлэлийн болон салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага түншлэлийн төслийн хэрэгжилтэд хяналт тавих ажиллагаанд дэмжлэг үзүүлэн, бүхий л талаар хамтарч ажиллах;

7.4.2.аймаг, нийслэлийн зүгээс тухайн орон нутагт хэрэгжих төслийн хэрэгжилтэд хяналт тавих харилцааг түншлэлийн гэрээгээр нарийвчлан зохицуулах.

7.5.Хяналтын зөвлөх түншлэлийн төсөлд дараах хяналт, арга хэмжээг хэрэгжүүлнэ:

7.5.1.төслийн хэрэгжилтэд мэргэжлийн түвшинд хяналт тавьж, зөвлөх үйлчилгээ үзүүлэн, төслийн хэрэгжилтийн явц, чанар байдлын талаар үнэн зөв, бодитой тайлагнаж, тайлангийн үнэн зөв, бодит байдлыг бүрэн хариуцаж ажиллах;

7.5.2.төслийн зураг төсөл, техникийн үзүүлэлт, үзүүлэх ажил үйлчилгээнд өөрчлөлт оруулах, сайжруулах санал гаргаж болох бөгөөд саналыг түншлэлийн талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэх.

7.6.Хувийн хэвшлийн түншлэгч нь төрийн түншлэгч, төрийн аудитын байгууллага болон бусад байгууллагаас хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд төслийн хэрэгжилттэй газар дээр нь танилцах, саадгүй нэвтрэх, хяналт тавихад бүхий л талаар хамтран ажиллаж, төслийн хэрэгжилттэй холбоотой шаардсан бүхий л мэдээлэл, баримт бичгийг саадгүй гарган танилцуулна.

7.6.Төрийн аудитын байгууллага Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хэрэгжилт, түншлэлийн төслийн төлөвлөлт, хувийн хэвшлийн түншлэгчийн сонгон шалгаруулалт, түншлэлийн төслийн хэрэгжилт болон гэрээний биелэлтэд аудит хийн, хяналт тавьж, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайланг Засгийн газарт хүргүүлнэ.

7.7.Хуульд заасны дагуу хяналт хэрэгжүүлэх эрх бүхий бусад байгууллага хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд хяналт тавин, хяналтын ажлын үр дүнг түншлэлийн болон салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн хамтран ажиллаж болно.

Найм.Бусад

8.1.Төрийн түншлэгч холбогдох хууль болон энэхүү журамд заасны дагуу түншлэлийн төслийн хэрэгжилтийн талаар хяналт хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг дараах эх үүсвэрээс санхүүжүүлж болно:

8.1.1.улсын төсвийн хөрөнгө;

8.1.2.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан сангийн эх үүсвэрээс;

8.1.3.хувийн хэвшлийн түншлэгчээс;

8.1.4.түншлэлийн гэрээнд заасан хяналт хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлыг санхүүжүүлэх бусад эх үүсвэр.

8.2.Энэ журмын 7.1.8-д заасан хяналт шалгалтаар хувийн хэвшлийн түншлэгч нь санхүүгийн тайлагналаа зөрүүтэй, алдаатай тайлагнасан нь тогтоогдвол тус хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбогдон гарсан зардлыг хувийн хэвшлийн түншлэгч хариуцан төлж болох бөгөөд уг асуудлыг түншлэлийн гэрээгээр нарийвчлан зохицуулж болно.

8.3.Энэ журмын 8.2-т заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд хувийн хэвшлийн түншлэгч тухайн алдаа дутагдалтай тайланг залруулж, шинэчилсэн үнэн зөв тайланг төрийн түншлэгчид дахин хүргүүлнэ.

8.4.Түншлэлийн төслийн хэрэгжилт, санхүүжилт, зохион байгуулалт, тайлагналт болон хяналт тавихтай холбоотой үйл ажиллагааг түншлэлийн гэрээнд нарийвчлан тусгана.

8.5.Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж түншлэгч талуудын гэрээнд зааснаас бусад тохиолдолд түншлэлийн үйл ажиллагаа, мэдээлэл болон бүртгэл, тайлагналтыг түншлэлийн мэдээллийн нэгдсэн сан болон холбогдох цахим хуудсанд байршуулж, олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.

----oOo----



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 405

Улаанбаатар хот

ТҮНШЛЭЛИЙН ТӨСӨЛ ХӨГЖҮҮЛЭХ САН БАЙГУУЛАХ, ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 49.1, 49.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Түншлэлийн төсөл хөгжүүлэх санг байгуулж, Түншлэлийн төсөл хөгжүүлэх санг удирдах, түүний хөрөнгийг захиран зарцуулах, эх үүсвэрийг бүрдүүлэх болон зарцуулалтад хяналт тавих журмыг хавсралт ёсоор баталсугай.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатарт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолыг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД БӨГӨӨД
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 64

Улаанбаатар хот

ЖУРАМ, ЖИШИГ БАРИМТ БИЧИГ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР, АРГАЧЛАЛ БАТЛАХ ТУХАЙ

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 7.2.1, 7.2.2, 7.2.3, 7.2.4, 7.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээ хийх журам"-ыг 1 дүгээр хавсралт, "Хувийн хэвшлийн түншлэгчийг болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам, жишиг баримт бичиг"-ийг 2 дугаар хавсралт, "Түншлэлийн гэрээ байгуулах журам, гэрээний стандарт загвар, гэрээний иж бүрдэл баримт бичиг"-ийг 3 дугаар хавсралт, "Түншлэлийн хүрээнд эрсдэл тооцоолох, хуваарилах аргачлал"-ыг 4 дүгээр хавсралт, "Түншлэлийн төслийн хэрэгжилт, санхүүжилт, зохион байгуулалт, тайлагналт болон хяналт тавих журам"-ыг 5 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

(Энэ тогтоолын 1, 3 дугаар хавсралтад Засгийн газрын 2026 оны 63 дугаар тогтоолоор нэмэлт, өөрчлөлт тус тус орж, 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсон)

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатарт даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Уралдаант шалгаруулалтын нарийвчилсан журам, жишиг баримт бичиг, санал үнэлэх журам батлах тухай" Засгийн газрын 2012 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 103 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Энэ тогтоолыг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД БӨГӨӨД
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР

Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 15-ны
өдрийн 405 дугаар
тогтоолын хавсралт

ТҮНШЛЭЛИЙН ТӨСӨЛ ХӨГЖҮҮЛЭХ САНГ УДИРДАХ, ТҮҮНИЙ ХӨРӨНГИЙГ ЗАХИРАН ЗАРЦУУЛАХ, ЭХ ҮҮСВЭРИЙГ БҮРДҮҮЛЭХ БОЛОН ЗАРЦУУЛАЛТАД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 49.1, 49.3-т заасан “Түншлэлийн төсөл хөгжүүлэх сан” (цаашид “Сан” гэх)-г удирдах, түүний хөрөнгийг захиран зарцуулах, эх үүсвэрийг бүрдүүлэх болон зарцуулалтад хяналт тавихтай холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Сангийн хөрөнгийн бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон олон улсын стандартын дагуу хөтөлнө.

1.3.Сан нь сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, ашиглалтыг бүртгэх данстай байна.

1.4.Энэ журамд хэрэглэсэн нэр томьёог Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан утгаар ойлгоно.

Хоёр.Сангийн удирдлага, зохион байгуулалт

2.1.Сангийн удирдлагыг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

2.2.Сангийн бодлого, стратегийг тодорхойлох, сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлах, сангийн тухайн жилийн төсөв, төлөвлөгөөг батлах, гүйцэтгэлийг хянах, сангийн хөрөнгийн эх үүсвэр бүрдүүлэх чиг үүрэг бүхий орон тооны бус Удирдах хороог түншлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байгуулна.

2.3.Удирдах хороо нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүн бүхий 5 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.4.Удирдах хороо нь түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Түншлэлийн төв, энэ журмын 3.1.2-т заасан олон улсын байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

2.5.Удирдах хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байх бөгөөд хагас жилд нэгээс доошгүй удаа хуралдана.

2.6.Удирдах хорооны гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцож, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргах бөгөөд тогтоол хэлбэртэй байна.

2.7.Хуралдааны тэмдэглэлд удирдах хорооны дарга, гишүүд, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

2.8.Сангийн өдөр тутмын үйл ажиллагааг Түншлэлийн төв эрхлэн гүйцэтгэнэ.

Гурав.Сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх

3.1.Сангийн хөрөнгийг Төр, хувийн хэвшлийн тухай хуулийн 50.1-д заасан дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

3.1.1.улсын төсвөөс олгосон санхүүжилт;

3.1.2.олон улсын байгууллагаас олгосон хөнгөлөлттэй зээл, тусламж, хандив, бусад санхүүжилт;

3.1.3.Сангийн хөрөнгө оруулалт болон түншлэлийн төслийн бэлтгэл ажлын төлбөр, түншлэлийн төвийн үйл ажиллагаанаас олсон орлого;

3.1.4.Засгийн газрын баталгааны шимтгэл;

3.1.5.хууль тогтоомжид нийцсэн бусад.

3.2.Түншлэлийн төв нь Сангийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийн тооцоог гаргаж, дараа жилийн төсөвт тусгах саналаа жил бүрийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.3.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 3.2-т дурдсан саналыг харгалзан жил бүр төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг төсвийн төсөлд тусгуулах саналаа санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.4.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Түншлэлийн төв нь сангийн бусад эх үүсвэрийг бүрдүүлэх шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлнэ.

3.5.Түншлэлийн төслийн бэлтгэл ажлын төлбөр нь төсөл хөгжүүлэхэд зориулсан судалгаа, үнэлгээний ажил, зөвлөх үйлчилгээ, Түншлэлийн төвөөс үзүүлсэн үйлчилгээ болон төслийн бэлтгэл ажлыг хангахад зарцуулсан бусад шууд зардлаас бүрдэнэ. Төслийг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан хувийн хэвшлийн түншлэгч түншлэлийн гэрээнд заасан хугацааны дагуу төслийн бэлтгэл ажлын төлбөрийг Сангийн дансанд төвлөрүүлнэ.

3.6.Хувийн хэвшлийн түншлэгч түншлэлийн үндсэн болон дагалдах гэрээнд заасан хугацаа, стандарт болон зардлын дагуу түншлэлийн төслийг хугацаанд нь гүйцэтгэх төсөл хэрэгжүүлэх баталгааг гаргаж, төлбөрийг гэрээнд заасны дагуу Түншлэлийн төсөл хөгжүүлэх санд, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 13.2-т заасан аймаг, нийслэлд хэрэгжүүлэх түншлэлийн төслийн хувьд орон нутгийн болон нийслэлийг хөгжүүлэх санд гэрээ байгуулахаас ажлын 5 өдрийн өмнө тус тус шилжүүлнэ."

(Засгийн газрын 2026 оны 64 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан)

3.7.Энэ журмын 3.6-д заасан төлбөрийг тухайн түншлэлийн үндсэн болон дагалдах гэрээнд зааснаас өөр зориулалтаар ашиглах, зарцуулахыг хориглоно.

3.8.Хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн гэрээнд заасан баталгаа гаргасантай холбоотой хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд эрх бүхий байгууллагаас ирүүлсэн мэдэгдэлд үндэслэн энэ журмын 3.6-д заасан баталгааны төлбөрийг Сангийн орлого болгоно.

3.9.Хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн гэрээнд заасан баталгаа гаргасантай холбоотой хүлээсэн үүргээ биелүүлсэн тохиолдолд эрх бүхий байгууллагаас ирүүлсэн мэдэгдэлд үндэслэн энэ журмын 3.6-д заасан баталгааны төлбөрийг хувийн хэвшлийн түншлэгчид буцаан шилжүүлнэ.

3.10.Түншлэлийн төсөл нь тухайн хүсэлт гаргасан салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр хэрэгжих боломжгүй болсон тохиолдолд холбогдох санхүүжүүлсэн зардлыг тус салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Санд эргэн төвлөрүүлнэ.

Дөрөв.Сангийн хөрөнгийг захиран зарцуулах

4.1.Сангийн хөрөнгийг Төр, хувийн хэвшлийн тухай хуулийн 50.2-т заасан дараах үйл ажиллагаанд зарцуулна:

4.1.1.түншлэлийг хөгжүүлэх, гадаад болон дотоодод сурталчлах, олон нийтэд таниулах, ил тод тогтвортой орчныг бүрдүүлэх;

4.1.2.төслийн бэлтгэл үйл ажиллагаа, төслийн бүрэн шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ;

4.1.3.Түншлэлийн төвийн үйл ажиллагаа;

4.1.4.хувийн хэвшлийн түншлэгчийн сонгон шалгаруулалт, хэлэлцээр хийхтэй холбоотой зардал;

4.1.5.түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээ, төслийн бүрэн шинжилгээ, түншлэлийн эх төсөл боловсруулах болон төсөвт үзүүлэх нөлөөллийн тооцоо, шинжилгээ хийх болон бусад мэргэжлийн зөвлөх үйлчилгээний зардал;

4.1.6.түншлэлийн төслийн хэрэгжилт, тайлагналт, мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагаатай холбоотой зардал;

4.1.7.түншлэлийн төсөл хөгжүүлэхэд холбоотой бусад зардал.

4.2.Түншлэлийн төв, төрийн түншлэгч, бүрэн шинжилгээ хийх төслийн баг, сонгон шалгаруулалтын Ажлын хэсэг Сангийн хөрөнгийг ашиглах хүсэлт гаргах эрхтэй бөгөөд түншлэлийн төслийн мэдээлэл, үндэслэл, зарцуулах үйл ажиллагааны зориулалт зэргийг тусгасан хүсэлтийг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бичгээр гаргана.

4.3.Урьдчилсан үнэлгээ хийгдэж, хөгжлийн бодлогын баримт бичигт туссан, хууль, энэ журамд заасан шаардлагад нийцсэн түншлэлийн төсөлтэй холбогдох үйл ажиллагааг санхүүжүүлэх хүсэлтийг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

4.4.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүсэлтийг судлан үзэж, холбогдох шаардлагыг хангасан эсэхийг 14 хоногийн дотор үнэлж, хүсэлт гаргагчид хариу өгнө.

4.5.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь түншлэлийн Сангийн хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий этгээд нь байна.

4.6.Түншлэлийн төв Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйл ажиллагааг худалдан авах, сонгон шалгаруулах, гүйцэтгэх, үр дүнг хянахтай холбоотой арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.7.Сангийн хөрөнгийг Төр, хувийн хэвшлийн тухай хууль, энэ журамд заасан зориулалтаар зарцуулна.

Тав.Сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт, ил тод байдал

5.1.Сангийн хөрөнгийн удирдлага, эх үүсвэрийн бүрдүүлэлт болон захиран зарцуулалтад түншлэлийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хяналт тавина.

5.2.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Санд жил бүр төрийн аудитын байгууллагаар, гурван жил тутамд олон улсын аудитын байгууллагаар аудит хийлгэнэ. Шаардлагатай тохиолдолд Санд санхүүгийн хяналт, шалгалт хийх бөгөөд тайлан, дүгнэлтийг тухай бүр Засгийн газарт танилцуулна.

5.3.Энэ журмын 4.6-д заасан сонгон шалгаруулалт болон 5.2-т дурдсан олон улсын аудитын байгууллагыг нээлттэй, уралдаант сонгон шалгаруулалтын зарчмын хүрээнд холбогдох хууль тогтоомжийн дагуу сонгон шалгаруулна.

5.4.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Сангийн үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн тайлагналтыг олон нийтэд ил тод, нээлттэй байлгах үүрэгтэй бөгөөд Сангийн жилийн орлого, зарлагын тайланг тухай бүр өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлнэ.

5.5.Энэ журмын 5.4-т заасан шаардлагатай мэдээллийг Түншлэлийн төв хагас, бүтэн жилээр боловсруулж, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Зургаа.Бусад

6.1.Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, холбогдох хууль, энэ журам зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.2.Сангийн эх үүсвэрийг зарцуулах шийдвэр гаргах, сонгон шалгаруулалтад оролцох албан тушаалтан холбогдох хуульд заасан журмын дагуу ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлнэ.

6.3.Сангийн хөрөнгийн зарцуулалт, үйл ажиллагаатай холбоотой үүссэн маргааныг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргаж, шийдвэрлүүлнэ.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 11 сарын 15 өдөр

Дугаар 406

Улаанбаатар хот

МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЗӨВЛӨЛИЙГ БАЙГУУЛАХ, ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРМЫГ БАТЛАХ ТУХАЙ

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 56.1, 56.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулахтай холбоотой гомдол гаргах, маргаан шийдвэрлэх асуудлыг зохицуулах, түүнчлэн уг маргааныг хянан шийдвэрлэх зорилго бүхий "Маргаан шийдвэрлэх зөвлөл"-ийг байгуулж, Зөвлөлийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт, "Маргаан шийдвэрлэх зөвлөлийн ажиллах журам"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

(Энэ тогтоолын 2 дугаар хавсралтад Засгийн газрын 2026 оны 65 дугаар тогтоолоор өөрчлөлт орсон)

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатарт даалгасугай.

3.Энэ тогтоолыг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД БӨГӨӨД

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД

Ч.ХҮРЭЛБААТАР



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 65

Улаанбаатар хот

ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Маргаан шийдвэрлэх зөвлөлийг байгуулах, зөвлөлийн ажиллах журмыг батлах тухай" Засгийн газрын 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 406 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Маргаан шийдвэрлэх зөвлөлийн ажиллах журам"-ын 4.2 дахь хэсгийн "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 25.2.6, 25.6.8-д заасан" гэснийг "Ажлын хэсгээс сонгон шалгаруулалтад оролцогчид" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД БӨГӨӨД

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД

Ж.ЭНХБАЯР

Засгийн газрын 2023 оны 11 дүгээр
сарын 15-ны өдрийн 406 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЗӨВЛӨЛ

Дарга: -Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв
байгууллагын дотоод хяналт хариуцсан нэгжийн дарга

Гишүүд: -Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны
төв байгууллагын хууль, эрх зүйн асуудал хариуцсан
нэгжийн дарга;

-Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв
байгууллагын санхүү, хөрөнгө оруулалтын асуудал
хариуцсан нэгжийн дарга;

-Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын
тэргүүн (зөвшилцсөнөөр).

Нарийн бичгийн
дарга: -Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв
байгууллагын дотоод хяналт хариуцсан нэгжийн
мэргэжилтэн.

---o0o---

Засгийн газрын 2023 оны 11 дүгээр
сарын 15-ны өдрийн 406 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулахтай холбоотой гомдол гаргах, маргаан шийдвэрлэх зөвлөл (цаашид "Зөвлөл" гэх)-ийн үйл ажиллагаа, маргааныг хянан шийдвэрлэхтэй холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Зөвлөл нь хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулахтай холбоотой маргааныг хянан шийдвэрлэхдээ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, энэ журам болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

1.3.Зөвлөл нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх зарчмыг чанд баримтална.

Хоёр.Зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

2.1.Зөвлөл нь түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд ажиллах бөгөөд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдсэн 5 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.2.Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна.

2.3.Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь зөвлөлийн дотоод ажлыг хариуцан, зөвлөлийн хуралдааны бэлтгэлийг хангаж, хуралдааны явцын тэмдэглэл хөтөлнө.

2.4.Зөвлөл нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд дараах үйл ажиллагааг явуулна:

2.4.1.хувийн хэвшлийн түншлэгчийн сонгон шалгаруулалттай холбоотой гомдлыг хүлээн авах, хүлээн авахаас татгалзах, хянан шийдвэрлэх;

2.4.2.маргааныг хянан шийдвэрлэхэд шаардлагатай баримт бичиг, мэдээ, судалгаа, тайлбар, нотлох баримтыг холбогдох этгээдээс гаргуулж авах;

2.4.3.энэ журмын 3.2.1-д заасан хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэх.

2.5.Зөвлөл нь маргааны оролцогч талуудаас бусад этгээдэд гомдол, хүсэлтийн талаарх мэдээллийг танилцуулах үүрэг хүлээхгүй.

2.6.Зөвлөлийн гишүүн Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу гомдол, маргааныг хянан шийдвэрлэхийн өмнө ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, хэрэв ашиг сонирхлын зөрчилтэй тохиолдолд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзана.

2.7.Зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

Гурав.Маргааны оролцогч тал, тэдгээрийн эрх, үүрэг

3.1.Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд гомдол гаргагч болон хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсэг (цаашид "маргаанд холбогдогч тал" гэх) нь маргааны оролцогч талууд байна.

3.2.Гомдол гаргагч дараах эрх, үүрэгтэй:

3.2.1.түншлэлийн төслийн сонгон шалгаруулалттай холбоотой маргаан шийдвэрлэх ажиллагаанд үндэсний болон олон улсын шинжээч оролцуулах хүсэлт гаргах;

3.2.2.Зөвлөлийн шийдвэртэй танилцах;

3.2.3.Зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргах;

3.2.4.маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээчээр дүгнэлт гаргуулах тохиолдолд шинжээчийн зардлыг бүрэн хариуцах;

3.2.5.Зөвлөлийг хууль болон энэ журмын дагуу хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхийг шаардах;

3.2.6.гомдолтой холбоотой тайлбар, нотлох баримтаа үнэн зөв гаргаж өгөх;

3.2.7.энэ журмын 3.2.6-д заасан баримт бичиг орчуулгын зөрүүтэй нөхцөл байдал үүсвэл үр дагаврыг хариуцах;

3.2.8.Зөвлөлөөс маргаан хянан шийдвэрлэхэд шаардлагатай баримт бичиг, мэдээ, судалгаа, тайлбарыг нэмэлтээр шаардсан тохиолдолд гаргаж өгөх;

3.2.9.хуульд заасан бусад.

3.3.Маргаанд холбогдогч тал дараах эрх, үүрэгтэй:

3.3.1.маргаанд холбогдох тайлбар, нотлох баримтыг Зөвлөлд гарган өгөх;

3.3.2.Зөвлөлийн шийдвэртэй танилцах;

3.3.3.хуульд заасан бусад.

Дөрөв.Гомдол гаргах, түүнийг хүлээн авах, татгалзах журам

4.1.ХувийнхэвшлийнтүншлэгчийнсонгоншалгаруулалтТөр,хувийнхэвшлийнтүншлэлийн тухай хууль болон холбогдох журам зөрчсөн гэж үзсэн бол сонгон шалгаруулалтад оролцогч маргаан хянан шийдвэрлэх зөвлөлд гомдол гаргаж болох бөгөөд гомдлыг бичгээр гаргана.

4.2.Гомдлыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 25.2.6, 25.6.8-д заасан мэдэгдлийг хүргүүлснээс хойш ажлын 5 өдөрт багтаан маргаан хянан шийдвэрлэх Зөвлөлд гаргана.

4.3.Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь гомдлыг хүлээн авч, Зөвлөлийн даргад танилцуулна.

4.4.Зөвлөл нь дараах тохиолдолд гомдлыг хүлээн авахаас татгалзана:

4.4.1.Зөвлөлийн маргаан хянан шийдвэрлэх чиг үүрэгт хамаарахгүй;

4.4.2.гомдлыг хэрэгсэхгүй болгосон шүүгчийн захирамж, шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр байгаа;

4.4.3.энэ журмын 4.2-т заасан хугацааг хэтрүүлсэн.

4.5.Гомдлыг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд хариуг ажлын 5 өдрийн дотор албан бичгээр гомдол гаргагчид хүргүүлнэ.

4.6.Зөвлөлийн дарга нь гомдлыг хүлээн авахаас татгалзах үндэслэл байхгүй гэж үзсэн тохиолдолд зөвлөлийн хуралдааныг товлон хуралдуулна.

Тав.Маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа, зөвлөлийн шийдвэр

5.1.Зөвлөл нь маргааныг гомдлын хүрээнд хянаж, энэ журмын 5.7-д заасан шийдвэрийн аль нэгийг гаргана.

5.2.Зөвлөл нь гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 20 өдрийн дотор хянан шийдвэрлэх бөгөөд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл Зөвлөлийн дарга уг хугацааг нэг удаа ажлын 10 өдрөөр сунгаж болно.

5.3.Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд шинжээч оролцуулах тохиолдолд энэ журмын 5.2-т заасан хугацаа шинжээчийн дүгнэлт гарах хүртэл хугацаагаар сунгагдана.

5.4.Зөвлөл нь шийдвэр гаргах хүртэл сонгон шалгаруулалтын ажиллагааг түр зогсоож болох бөгөөд энэ талаар сонгон шалгаруулалтын ажлын хэсэгт бичгээр мэдэгдэнэ.

5.5.Зөвлөлийн гишүүдийн олонх оролцсоноор хуралдааныг хүчинтэйд тооцох ба гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

5.6.Зөвлөлийн шийдвэр тогтоол хэлбэртэй байх бөгөөд Зөвлөлийн дарга, гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна. Аль нэг гишүүн эсрэг саналтай тохиолдолд энэ талаар тэмдэглэлд тусгана.

5.7.Зөвлөл маргааныг хянан хэлэлцээд дараах шийдвэрийн аль нэгийг гаргаж энэ талаар 5.2-т заасан хугацааны дотор маргааны оролцогчдод мэдэгдэнэ:

5.7.1.сонгон шалгаруулалтыг бүхэлд нь хүчингүйд тооцох;

5.7.2.сонгон шалгаруулах ажиллагаанд гарсан зөрчлийг арилгасны үндсэн дээр сонгон шалгаруулалтыг үргэлжлүүлэхийг зөвшөөрөх;

5.7.3.сонгон шалгаруулалтын шийдвэрийг хэвээр үлдээх.

5.8.Энэ журмын 3.1-д заасан талууд Зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

Зургаа.Хариуцлага

6.1.Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 474

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 7.2.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын баталгаа гаргах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай. (Энэ тогтоолын хавсралтад Засгийн газрын 2026 оны 190 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон)

2. Энэ тогтоолын 1-д заасан журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 190

Улаанбаатар хот

ЖУРАМД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.5 дахь заалт, 31, 32 дугаар зүйлийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Журам батлах тухай" Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 474 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын баталгаа гаргах журам"-д энэ тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Засгийн газрын үүргийн баталгааны загвар" гэсэн 1 дүгээр хавсралт, энэ тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан "Бараа, ажил, үйлчилгээг худалдан авах, олон нийтийн хэрэгцээнд ашиглах, хэрэглэх баталгааны загвар" гэсэн 2 дугаар хавсралт тус тус нэмсүгэй.
2. Мөн журамд доор дурдсан агуулгатай 2.7 дахь заалт нэмсүгэй:
"2.7.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 32.2-т зааснаар төрийн түншлэгч нь түншлэлийн гэрээний дагуу хувийн хэвшлийн түншлэгчийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай төрийн болон орон нутгийн өмчид хамаарах оюуны өмчийн онцгой эрхийг тодорхой нөхцөл, хугацаатайгаар шилжүүлж болно."
3. Мөн журмын 3.2.1 дэх дэд заалтын "баталгаа" гэснийг "баталгааг энэ журмын 1 дүгээр хавсралтаар баталсан "Засгийн газрын үүргийн баталгааны загвар"-ын дагуу гаргах" гэж, 3.2.2 дахь дэд заалтын "баталгаа" гэснийг "баталгааг энэ журмын 2 дугаар хавсралтад заасан "Бараа, ажил, үйлчилгээг худалдан авах, олон нийтийн хэрэгцээнд ашиглах, хэрэглэх баталгааны загвар"-ын дагуу гаргах" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
САНГИЙН САЙД

Н.УЧРАЛ
З.МЭНДСАЙХАН

Засгийн газрын 2023 оны 12 дугаар
сарын 27-ны өдрийн 474 дүгээр
тогтоолын хавсралт

ТҮНШЛЭЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТӨРӨӨС ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, ЗАСГИЙН ГАЗРЫН БАТАЛГАА ГАРГАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Төр, хувийн хэвшлийн түншлэл (цаашид “түншлэл” гэх)-ийн төслийг хэрэгжүүлэхэд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасныг баримтлан төрөөс дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын баталгаа гаргахтай холбогдсон харилцаанд энэ журмыг баримтална.

1.2.Түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын баталгаа гаргахад Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Газрын тухай хууль, Гаалийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

1.3.Энэ журам нь Засгийн газрын өрийн баталгаанд хамаарахгүй.

Хоёр.Түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд төрөөс үзүүлэх дэмжлэг

2.1.Түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд төрөөс үзүүлэх дэмжлэг нь түншлэлийн төслийг амжилттай хэрэгжүүлэх, төслийн хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад чиглэх бөгөөд түншлэлийн төслийг төлөвлөх, батлах, гэрээ байгуулах, хэрэгжүүлэхэд түншлэгч талуудын хооронд эрсдэл хуваарилах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хөрөнгө оруулалт татах, түншлэлд оролцох сонирхлыг бий болгох зорилготой байна.

2.2.Засгийн газрын шийдвэрээр түншлэлийн гэрээний хүрээнд хувийн хэвшлийн түншлэгчид Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 32.1-д заасан дэмжлэгийг үзүүлж болох бөгөөд түншлэлд төрөөс үзүүлэх дэмжлэг нь холбогдох хууль тогтоомж болон түншлэлийн гэрээний хүрээнд хэрэгжинэ.

2.3.Төрөөс үзүүлэх дэмжлэгийн төрөл нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 20.2-т заасан төслийн багийн хийсэн төслийн бүрэн шинжилгээнд тусгагдсан байна.

2.4.Талууд тохиролцсон тохиолдолд төрөөс үзүүлэх дэмжлэгийн төрөл, хэмжээ, хугацаа, нөхцөлийг гэрээнд тусгаж, хэрэгжүүлнэ.

2.5.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 32.1.3-т заасан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх дэмжлэгийг татварын холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх бөгөөд хувийн хэвшлийн түншлэгчийн түншлэлийн төсөлтэй холбоотой орлого, ашгийн татвар, түншлэлээр бий болсон барилга байгууламж, дэд бүтцийн үл хөдлөх эд хөрөнгийн татвар, түншлэлийн төслийг санхүүжүүлэхтэй холбоотой хөрөнгө оруулалтын эх үүсвэр болох зээлийн хөрөнгийн хэмжээгээр орлогын татвар зэрэгт хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх хэлбэртэй байж болно.

2.6.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 32.1.1-д заасан газар эзэмших, ашиглах эрхээр хангах дэмжлэгийг Газрын тухай хуульд заасны дагуу хэрэгжүүлэх бөгөөд төрийн түншлэгч нь түншлэлийн төслийг хэрэгжүүлэх хугацаанд тухайн газрын талбайг эргүүлэн авах, бусад этгээдэд давхардуулан эзэмшүүлэх, ашиглуулахгүй байх асуудлыг хариуцна.

2.7.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 32.2-т зааснаар төрийн түншлэгч нь түншлэлийн гэрээний дагуу хувийн хэвшлийн түншлэгчийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай төрийн болон орон нутгийн өмчид хамаарах оюуны өмчийн онцгой эрхийг тодорхой нөхцөл, хугацаатайгаар шилжүүлж болно.

(Энэ хэсгийг Засгийн газрын 2026 оны 190 дүгээр тогтоолоор нэмсэн)

Гурав.Түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд Засгийн газрын гаргах баталгаа

3.1.Түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд Засгийн газрын гаргах баталгаа нь түншлэлийн төслийг амжилттай, урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэх зорилготой байна.

3.2. Засгийн газар түншлэлийн төслийн бүрэн шинжилгээний үр дүнд үндэслэн түншлэлээр хэрэгжүүлэх төсөлд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 31.1-д заасан дараах баталгааг гаргаж болох бөгөөд баталгааг гаргах, үүнтэй холбогдуулан хувийн хэвшлийн түншлэгчтэй холбогдох гэрээ байгуулах асуудлыг мөн хуулийн 31.2-т заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлнэ:

3.2.1.түншлэлийн гэрээ болон түүнийг дагалдан байгуулагдсан гэрээ, тэдгээрийн гол нөхцөл зөрчигдөх нөхцөл үүссэн тохиолдолд түншлэлийн төсөлд төсвөөс санхүүжүүлэх үүргийн баталгааг энэ журмын 1 дүгээр хавсралтаар баталсан "Засгийн газрын үүргийн баталгааны загвар"-ын дагуу гаргах; *(Энэ дэд заалтад Засгийн газрын 2026 оны 190 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон)*

3.2.2.түншлэлийн төслийг хэрэгжүүлэх явцад бий болсон бараа, ажил, үйлчилгээг худалдан авах, олон нийтийн хэрэгцээнд ашиглах, хэрэглэх баталгааг энэ журмын 2 дугаар хавсралтад заасан "Бараа, ажил, үйлчилгээг худалдан авах, олон нийтийн хэрэгцээнд ашиглах, хэрэглэх баталгааны загвар"-ын дагуу гаргах. *(Энэ дэд заалтад Засгийн газрын 2026 оны 190 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон)*

3.3.Энэ журмын 3.2.1-д заасан түншлэлийн төсөлд төсвөөс санхүүжүүлэх үүргийн баталгааг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 14.1.2, 14.1.3-т заасан түншлэлийг хэрэгжүүлэхэд дараах байдлаар гаргаж болно:

3.3.1.түншлэлийн төслийн зардлыг гэрээний хугацаанд хуваарилсан байдлаар буюу жил бүрийн төсвөөс үе шаттай санхүүжүүлэх;

3.3.2.түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтын тодорхой хэсгийг төсвөөс санхүүжүүлэх;

3.3.3.энэ журмын 3.3.1, 3.3.2-т заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх холимог хэлбэр.

3.4.Энэ журмын 3.3-т заасан төсвөөс санхүүжүүлэх үүргийн баталгааны дүн түншлэлийн төслийн нийт зардлаас хэтрэхгүй байх буюу мөн журмын 3.3.1, 3.3.2-т заасны дагуу тус

тусад нь болон хамтатган гаргах тохиолдолд нийлбэр дүн нь түншлэлийн төслийн нийт зардлаас илүүгүй, дүнг давхардуулаагүй байна.

3.5.Энэ журмын 3.2.2-т заасан түншлэлийн төслийг хэрэгжүүлэх явцад бий болсон бараа, ажил, үйлчилгээг худалдан авах, олон нийтийн хэрэгцээнд ашиглах, хэрэглэх баталгааг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан түншлэлийн бүх төрөлд дараах байдлаар гаргаж болно:

3.5.1.Засгийн газар түншлэлийн гэрээний хүрээнд бий болсон бараа, ажил, үйлчилгээг худалдан авахгүйгээр олон нийтийн хэрэгцээнд ашиглах, хэрэглэх;

3.5.2.Засгийн газар түншлэлийн гэрээний хүрээнд бий болсон бараа, ажил, үйлчилгээг худалдан авах, үүний үндсэн дээр олон нийтийн хэрэгцээнд ашиглах, хэрэглэх.

3.6.Засгийн газар энэ журмын 3.5-д заасан баталгааг гаргах нь төсвөөс санхүүжүүлэх аливаа үүргийг хүлээхгүй.

Дөрөв.Түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд төрөөс үзүүлэх дэмжлэг, Засгийн газрын гаргах баталгааг тодорхойлох, хэрэгжүүлэх үе шат, оролцогч байгууллагуудын чиг үүрэг

4.1.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 20.2-т заасан төслийн баг нь түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын баталгаа гаргах төрөл хэлбэрийг мөн хуулийн 20.4-т заасан бүрэн шинжилгээгээр тодорхойлж, дүгнэлт гаргасан байна.

4.2.Түншлэлийн төслийн бүрэн шинжилгээгээр тодорхойлсон тохиолдолд төрөөс дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын баталгаа гаргах асуудлыг хамтад нь шийдвэрлэж болно.

4.3.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 21.1-д заасны дагуу хүргүүлсэн түншлэлийн төслийн бүрэн шинжилгээ болон эрсдэлийн үнэлгээний тайланд үндэслэн тухайн төслийг түншлэлээр хэрэгжүүлэх саналыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мөн хуулийн 21.3-т заасны дагуу санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 4.3-т заасны дагуу ирүүлсэн түншлэлийн төслийн бүрэн шинжилгээгээр тодорхойлсон төрөөс үзүүлэх дэмжлэг, Засгийн газрын баталгааны саналтай танилцаж, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 21.4-т заасны дагуу хянасны үндсэн дээр дараах арга хэмжээ авч, хариу хүргүүлнэ:

4.4.1.зөвшөөрөх;

4.4.2.татгалзах;

4.4.3.нэмэлт тодруулга авахаар буцаах.

4.5.Энэ журмын 4.4.3-т зааснаар буцаагдсан тохиолдолд шаардлагатай мэдээллийг бэлтгэж санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дахин хүргүүлж болно.

4.6.Засгийн газраас баталгаа гаргахыг энэ журмын 4.4.1-д заасны дагуу зөвшөөрсөн бол санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мөн журмын 3.2-т заасны дагуу Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлнэ.

4.7.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 21.8-д заасны дагуу түншлэлийн төслийг хэрэгжүүлэх хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд тухайн төслийг хэрэгжүүлэхэд төрөөс үзүүлэх дэмжлэг, Засгийн газрын баталгааны талаар мэдээллийг тусгасан байх бөгөөд энэ нь хөрөнгө оруулалтыг татах, түншлэлд оролцох хувийн хэвшлийн сонирхлыг бий болгох зорилготой байна.

4.8.Түншлэгч талууд Засгийн газрын баталгаа, төрөөс үзүүлэх дэмжлэгийн төрөл, хэмжээ, хугацаа, нөхцөлийг хууль болон Засгийн газрын шийдвэрийн хүрээнд тохиролцож, түншлэлийн гэрээнд тусгана.

4.9.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 25.6.10-д заасны дагуу түншлэлийн гэрээ байгуулах зөвшөөрөл авах хүсэлтийг хүргүүлэхдээ түншлэлийн гэрээний төсөлд тусгасан төрөөс үзүүлэх дэмжлэг, Засгийн газрын баталгааны саналыг энэ журмын 4.4-т заасан төрөөс үзүүлэх дэмжлэг, Засгийн газрын баталгааны саналтай харьцуулж хүргүүлнэ.

4.10.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 4.9-д заасны дагуу ирүүлсэн хүсэлтийг хянахдаа төрөөс үзүүлэх дэмжлэг, Засгийн газрын баталгааны төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийн талаас хянасан байна.

4.11.Засгийн газар Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 26.5-д заасны дагуу түншлэлийн гэрээ байгуулах шийдвэр гаргаж, гэрээ байгуулагдсанаар түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд төрөөс үзүүлэх дэмжлэг, Засгийн газрын баталгаа шийдвэрлэгдэнэ.

4.12.Түншлэлийн төслийн гэрээнд заасны дагуу төрөөс үзүүлэх дэмжлэг, Засгийн газрын баталгааг гэрээний талууд хэрэгжүүлж ажиллана.

4.13.Төрөөс үзүүлэх дэмжлэг, Засгийн газраас баталгааны биелэлт, тайлан, үр дүнгийн мэдээллийг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурал, Засгийн газарт хүргүүлж ажиллана.

4.14.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд төрөөс үзүүлэх дэмжлэг, Засгийн газрын баталгааны мэдээлэл, түүний хэрэгжилт, үр дүн олон нийтэд ил тод, нээлттэй байна.

4.15. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 52 дугаар зүйлд заасны дагуу түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд төрөөс үзүүлсэн дэмжлэг, Засгийн газрын баталгааны мэдээлэл түншлэлийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн байна.

“Түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын баталгаа гаргах журам”-ын
1 дүгээр хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН ҮҮРГИЙН БАТАЛГААНЫ ЗАГВАР

(Энэ хавсралтыг Засгийн газрын 2026 оны 190 дүгээр тогтоолоор нэмсэн)

Баталгаа хүлээн авагч: [хувийн хэвшлийн түншлэгчийн нэр, хаягийг бичих]

Огноо: [баталгаа гаргасан огноог бичих]

Дугаар: [Засгийн газрын үүргийн баталгааны дугаар бичих]

1. Монгол Улсын Засгийн газар нь Төсвийн тухай хууль, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 31.1.1, “Журам батлах тухай” Засгийн газрын 2023 оны 474 дүгээр тогтоолоор баталсан “Түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын баталгаа гаргах журам”-ын 3.2.1-д заасныг тус тус үндэслэн энэхүү “Засгийн газрын үүргийн баталгаа” (цаашид “Баталгаа” гэх)-г гаргав.

2. Энэхүү Баталгааны хүрээнд Монгол Улсын Засгийн газар нь [төслийн нэр] төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөл (цаашид “Төсөл” гэх)-ийг хэрэгжүүлэхээр байгуулсан төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ (цаашид “Түншлэлийн гэрээ” гэх)-нд заасны дагуу нийт [мөнгөн дүн, валют]-ийг төсвөөс санхүүжүүлэх үүргийг баталгаажуулж байна.

3. Энэхүү Баталгаа нь Засгийн газрын өрийн баталгаанд хамаарахгүй бөгөөд Төслийн санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татахад дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

4. Энэхүү Баталгааны хугацаа нь ____ оны ____ дугаар сарын ____-ны өдрөөс ____ оны ____ дугаар сарын ____-ны өдөр хүртэл хүчинтэй байх ба түншлэлийн гэрээний дуусгавар болох хугацаанаас хэтрэхгүй.

5. Энэхүү Баталгаа нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцсэн бөгөөд баталгаатай холбоотой үүсэх аливаа асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

[Монгол Улсын Засгийн газар нь түншлэлийн гэрээний хүрээнд төрийн түншлэгч талаас хүлээсэн төлбөрийн болон санхүүгийн үүргийн хэрэгжилтийг баталгаажуулах бөгөөд баталгааны хэмжээ, хэрэгжилт, хамрах хүрээ, нөхцөлийг Засгийн газрын шийдвэр, түншлэлийн гэрээ болон холбогдох бусад гэрээнд заасны дагуу тодорхойлно. Ингэхдээ энэхүү Баталгаагаар хүлээх Засгийн газрын санхүүгийн үүргийн нийт хэмжээ нь төслийн нийт зардлын хэмжээнээс хэтрэхгүй байх бөгөөд баталгааны хэрэгжилт нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр болон түншлэлийн гэрээний нөхцөлд нийцсэн байна.]

Баталгаа гаргасан:

Эрх бүхий албан тушаалтны нэр:

Албан тушаалын нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Байгууллагын тэмдэг/тамга:

"Түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын баталгаа гаргах журам" -ын 2 дугаар хавсралт

БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭГ ХУДАЛДАН АВАХ, ОЛОН НИЙТИЙН ХЭРЭГЦЭЭНД АШИГЛАХ, ХЭРЭГЛЭХ БАТАЛГААНЫ ЗАГВАР

(Энэ хавсралтыг Засгийн газрын 2026 оны 190 дүгээр тогтоолоор нэмсэн)

Баталгаа хүлээн авагч: [хувийн хэвшлийн түншлэгчийн нэр, хаягийг бичих]

Огноо: [баталгаа гаргасан огноог бичих]

Дугаар: [Бараа, ажил, үйлчилгээг худалдан авах, олон нийтийн хэрэгцээнд ашиглах, хэрэглэх баталгааны дугаар бичих]

1. Монгол Улсын Засгийн газар нь Төсвийн тухай хууль, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 31.1.2, "Журам батлах тухай" Засгийн газрын 2023 оны 474 дүгээр тогтоолоор баталсан "Түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын баталгаа гаргах журам"-ын 3.2.2-т заасныг тус тус үндэслэн энэхүү "Бараа, ажил, үйлчилгээг худалдан авах, олон нийтийн хэрэгцээнд ашиглах, хэрэглэх баталгаа" (цаашид "Баталгаа" гэх)-г гаргав.

2. Энэхүү Баталгааны хүрээнд Монгол Улсын Засгийн газар нь [төслийн нэр] төр, хувийн хэвшлийн түншлэлийн төсөл (цаашид "Төсөл" гэх)-ийг хэрэгжүүлэхээр байгуулсан төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ [гэрээний дугаар] (цаашид "түншлэлийн гэрээ" гэх)-г хэрэгжүүлэх явцад бий болсон бараа, ажил, үйлчилгээг Засгийн газраас олон нийтийн хэрэгцээнд зориулан ашиглах, хэрэглэх, эсхүл худалдан авах нөхцөлийг баталгаажуулахад оршино.

3. Энэхүү Баталгаа нь Төслийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэглээг хангах, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татахад дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

4. Энэхүү Баталгаа нь түншлэлийн гэрээнд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Засгийн газарт төсвийн шууд үүрэг үүсгэхгүй.

5. Энэхүү Баталгааны хугацаа ___ оны __ дугаар сарын __-ны өдрөөс ___ оны __ дугаар сарын __-ны өдөр хүртэл хүчинтэй байх ба түншлэлийн гэрээний дуусгавар болох хугацаанаас хэтрэхгүй.

6. Энэхүү Баталгаа нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцсэн бөгөөд Баталгаатай холбоотой үүсэх аливаа асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

[Монгол Улсын Засгийн газар нь Төслийг хэрэгжүүлэх явцад бий болсон бараа, ажил, үйлчилгээг төрөөс худалдан авах нөхцөлийг хангах, эсхүл олон нийтийн хэрэгцээнд ашиглах, хэрэглэх хэлбэрээр баталгаажуулж болно. Энэхүү Баталгааны хэрэгжилт, хамрах хүрээ, нөхцөл, түүнчлэн бараа, ажил, үйлчилгээг ашиглах, хэрэглэх, эсхүл худалдан авахтай холбогдох нөхцөл, хэмжээ, хугацаа, төлбөрийн хэлбэр, үнэ тогтоох аргачлал

болон холбогдох бусад асуудлыг талуудын хооронд байгуулсан төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ болон түүнийг дагалдах бусад гэрээнд тусган, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хэрэгжүүлнэ.]

Баталгаа гаргасан:

Эрх бүхий албан тушаалтны нэр:

Албан тушаалын нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Байгууллагын тэмдэг/тамга:

----o0o---



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 475

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 7.2.6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээг хянах болон түншлэлийн гэрээ байгуулах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад санал, дүгнэлт гаргах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

(Энэ тогтоолын 1 дэх заалт болон хавсралтад Засгийн газрын 2026 оны 191 дүгээр тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон)

2. Энэ тогтоолыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
САНГИЙН САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ
Б.ЖАВХЛАН



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 191

Улаанбаатар хот

ТОГТООЛ, ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Журам батлах тухай" Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 475 дугаар тогтоолын 1 дэх заалтын, мөн тогтоолын хавсралтаар баталсан "Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээг хянах болон түншлэлийн гэрээ байгуулах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад зөвшөөрөл олгох журам"-ын нэрийн, мөн журмын Гурав дахь хэсгийн гарчгийн "зөвшөөрөл олгох" гэснийг "санал, дүгнэлт гаргах" гэж, мөн журмын 3.1 дэх заалтын "эсэх болон гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх зөвшөөрлийг" гэснийг "болон гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад санал, дүгнэлтийг" гэж тус тус өөрчилсүгэй.
2. Мөн журмын 1.2 дахь заалтын "оруулахад" гэсний дараа, Хоёр дахь хэсгийн гарчгийн "хянаж," гэсний дараа, 2.2 дахь заалтын "2.1-д заасан" гэсний дараа тус тус "санал, дүгнэлт гаргах" гэж, мөн журмын 2.1 дэх заалтын "хянаж," гэсний дараа "Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 14.1.1-д заасан түншлэлийн төрөлд санал, дүгнэлт, 14.1.2, 14.1.3-т заасан түншлэлийн төрөлд" гэж тус тус нэмсүгэй.
3. Мөн журмын 3.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:
"3.4.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 2.1-д заасан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн түншлэлийн гэрээ байгуулах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ."
4. Мөн журмын 2.2.1 дэх дэд заалтын "нарийвчилсан" гэснийг хассугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
САНГИЙН САЙД

Н.УЧРАЛ
З.МЭНДСАЙХАН

Засгийн газрын 2023 оны 12 дугаар
сарын 27-ны өдрийн 475 дугаар
тогтоолын хавсралт

ТҮНШЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН БҮРЭН ШИНЖИЛГЭЭГ ХЯНАХ БОЛОН ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ГЭРЭЭНД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХАД САНАЛ, ДҮГНЭЛТ ГАРГАХ ЖУРАМ

(Хавсралтын гарчгийг Засгийн газрын 2026 оны 191 дүгээр тогтоолоор өөрчилсөн.)

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь төр, хувийн хэвшлийн түншлэл (цаашид “түншлэл” гэх)-ийн төслийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх, түншлэлийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй, шуурхай хэрэгжүүлэхэд оршино.

1.2 Түншлэлийн гэрээ байгуулах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад санал, дүгнэлт гаргах зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцаанд энэ журмыг баримтална. **(Энэ заалтад Засгийн газрын 2026 оны 191 дүгээр тогтоолоор нэмэлт орсон)**

1.3.Энэ журмыг хэрэгжүүлэхэд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

Хоёр.Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн бүрэн шинжилгээг хянаж, санал, дүгнэлт гаргах зөвшөөрөл олгох

(Энэ гарчигт Засгийн газрын 2026 оны 191 дүгээр тогтоолоор нэмэлт орсон)

2.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 21.3-т заасны дагуу түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн төслийг түншлэлээр хэрэгжүүлэх саналтай танилцаж, тухайн төслийн бүрэн шинжилгээний тайлан, дүгнэлт болон мөн хуульд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянаж, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 14.1.1-д заасан түншлэлийн төрөлд санал, дүгнэлт, 14.1.2, 14.1.3-т заасан түншлэлийн төрөлд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг мөн хуулийн 21.4-т заасны дагуу ажлын 15 өдөрт багтаан түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. **(Энэ заалтад Засгийн газрын 2026 оны 191 дүгээр тогтоолоор нэмэлт орсон)**

2.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ журмын 2.1-д заасан санал, дүгнэлт гаргах зөвшөөрөл олгохдоо Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 21.5-д заасан дараах тооцоо, судалгааг үндэслэл болгоно: **(Энэ заалтад Засгийн газрын 2026 оны 191 дүгээр тогтоолоор нэмэлт орсон)**

2.2.1.техник, эдийн засгийн үндэслэлээр батлагдсан ерөнхий нөхцөл, эрэлт, нийлүүлэлт, тариф, зах зээлийн хувьсагч үзүүлэлт, тэдгээрт хийгдсэн эрсдэлийн дүгнэлт;

(Энэ дэд заалтад Засгийн газрын 2026 оны 191 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон)

2.2.2.төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл, төрөөс үзүүлэх дэмжлэгийн хүрээнд төсөвт тусгах урсгал болон хөрөнгө оруулалтын зардал, хөнгөлөлт, тэдгээрийн Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн тусгай шаардлагад нийцсэн талаарх санал, дүгнэлт;

2.2.3.төрөөс үзүүлэх дэмжлэгийн хүрээнд төсөвт үзүүлэх болзошгүй өр төлбөрийн шинжилгээ, Засгийн газрын баталгаа гаргах төрөл хэлбэр, түүний Төсвийн тогтвортой байдлын тухай болон Өрийн удирдлагын тухай хуульд заасан шаардлагыг хангасан эсэх талаарх санал, дүгнэлт.

2.3.Энэ журмын 2.2.2-т заасан төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 9.2-т заасан загварын дагуу тооцож, дүгнэлт гаргана.

2.4.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төслийн бүрэн шинжилгээг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан шаардлагыг хангаагүй гэж үзвэл зөвшөөрөл олгохоос татгалзах бөгөөд зөвшөөрөхгүй тохиолдолд үндэслэл, тайлбарыг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.5.Түншлэлийн төслийн бүрэн шинжилгээг хянасны үр дүнд зарим асуудлыг тодруулах, нэмэлт мэдээлэл, баримт бичиг шаардлагатай тохиолдолд нэмэлт тодруулга авахаар түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад буцааж болох бөгөөд энэ тохиолдолд дахин зөвшөөрөл авахаар ирүүлэх болон зөвшөөрөл өгөх хугацаа нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 21.3, 21.4-т зааснаар байна.

Гурав.Түншлэлийн гэрээ байгуулах болон гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах санал, дүгнэлт гаргах

(Гарчигт Засгийн газрын 2026 оны 191 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон)

3.1.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасны дагуу түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн түншлэлийн гэрээ байгуулах болон гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах хүсэлттэй танилцаж, сонгон шалгаруулалт, түншлэгчтэй хийсэн хэлэлцээний дүн, ажлын хэсгийн дүгнэлтийг төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэлийн талаас хянаж, түншлэлийн гэрээ байгуулах болон гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад санал, дүгнэлтийг мөн хуулийн 26.4-т заасны дагуу ажлын 10 өдөрт багтаан олгоно.

(Энэ заалтад Засгийн газрын 2026 оны 191 дүгээр тогтоолоор өөрчлөлт орсон)

3.2.Түншлэлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахад түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 39.1-д заасан тохиолдлыг тодорхойлж, түншлэлийн гэрээний нэмэлт, өөрчлөлтийн төслийг ирүүлэх бөгөөд түүнийг түншлэгч талууд харилцан зөвшилцөж, зөвшөөрсөн байна.

3.3.Энэ журмын 3.2-т заасан түншлэлийн гэрээний нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгасан түншлэлийн төслийн нэмэлт ажил, үйлчилгээ нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 39.2-т заасан шаардлагыг хангасан байх бөгөөд түүнийг хянан баталгаажуулж ирүүлсэн байна.

3.4.Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 2.1-д заасан санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн түншлэлийн гэрээ байгуулах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ. **(Энэ заалтад Засгийн газрын 2026 оны 191 дүгээр тогтоолоор өөрчлөн найруулсан)**

----o0o---

**АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨР, ХУВИЙН
ХЭВШЛИЙН ТҮНШЛЭЛИЙН
ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ДАГАЖ
МӨРДӨХ ЖУРМУУД**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ**

2024 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 210

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 7.2.8, 13.2, 13.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аймаг, нийслэлийн хэрэгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн хүрээнд "Түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээ, бүрэн шинжилгээ хийх журам"-ыг 1 дүгээр хавсралт, "Хувийн хэвшлийн түншлэгч болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам"-ыг 2 дугаар хавсралт, "Түншлэлийн гэрээ байгуулах, хэлэлцээ хийж сонгон шалгаруулалтгүй гэрээ байгуулах журам"-ыг 3 дугаар хавсралт, "Түншлэлийн төслийн хэрэгжилт, санхүүжилт, зохион байгуулалт, тайлагналт болон хяналт тавих журам"-ыг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.

(Энэ тогтоолын 2 дугаар хавсралтыг Засгийн газрын 2026 оны 228 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцсон бөгөөд үүнийг 2026-07-01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Засгийн газрын 2026 оны 228 дугаар тогтоолоор 1. 4 дүгээр хавсралтад нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд үүнийг 2026-07-01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.)

2. Энэ тогтоолыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд мөрдөж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, холбогдох хууль тогтоомжид заасны дагуу аймаг, нийслэлийн хэрэгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөр, Сангийн сайд Б.Жавхлан болон Засгийн газрын холбогдох гишүүдэд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД
БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД

Л.ГАНТӨМӨР

(Энэ тогтоолын 2 дугаар хавсралтыг Засгийн газрын 2026 оны 228 дугаар тогтоолоор хүчингүй болсонд тооцож, 1, 4 дүгээр хавсралтад мөн тогтоолоор нэмэлт, өөрчлөлт орсон)



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2026 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 228

Улаанбаатар хот

ЖУРАМ, АРГАЧЛАЛ БАТЛАХ, ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.8 дахь заалт, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах журам"-ыг 1 дүгээр хавсралт, "Зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам"-ыг 2 дугаар хавсралт, "Санхүү, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ хийх аргачлал"-ыг "Журам батлах тухай" Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 210 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээ, бүрэн шинжилгээ хийх журам"-ын 2 дугаар хавсралт болгон 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.
2. "Журам батлах тухай" Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 210 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээ, бүрэн шинжилгээ хийх журам"-ын 2.2.4 дэх заалтын "санхүү, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ" гэсний дараа "(энэ журмын 2 дугаар хавсралтад заасны дагуу тооцно.)" гэж, 4.10 дахь хэсгийн "сургалтад хамрагдсан байна." гэсний дараа "Сургалтыг түншлэлийн асуудал хариуцсан нэгж, байгууллага, Түншлэлийн төвөөр хийлгэж болно." гэж тус тус нэмсүгэй.
3. Мөн журмын дараах хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:
1/4.1.2 дахь заалт:
"4.1.2.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 18.4-т зааснаас бусад түншлэлийн төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах;"
2/5.1 дэх хэсэг:
"5.1.Төслийн баг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 18.4-т зааснаас бусад түншлэлийн төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна."
4. Мөн журмын 2.1 дэх хэсгийн "Засаг даргад гаргах эрхтэй." гэснийг "Засаг даргад цахим системээр гаргана." гэж, "Хавсралт 1" гэснийг "Түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээ, бүрэн шинжилгээ хийх журам"-ын Хавсралт 1" гэж тус тус өөрчилсүгэй.
5. "Журам батлах тухай" Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 210 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан "Түншлэлийн төслийн хэрэгжилт, санхүүжилт, зохион байгуулалт, тайлагналт болон хяналт тавих журам"-ын 2.1.2 дахь заалтын "Засаг даргын холбогдох нутгийн захиргааны байгууллага;" гэснийг "холбогдох байгууллага;" гэж, 2.1.4 дэх заалтын "зөвлөхийн" гэснийг "зөвлөх" гэж, 3.10 дахь хэсгийн "тухайн шатны" гэснийг "аймаг, нийслэлийн" гэж тус тус өөрчилсүгэй.

6. "Журам батлах тухай" Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 210 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээ, бүрэн шинжилгээ хийх журам"-ын 2.6 дахь хэсгийн "нутгийн захиргааны" гэснийг, "Тав" дахь хэсгийн гарчиг болон 5.2, 5.3, 5.4 дэх хэсгийн "урьдчилсан болон нарийвчилсан" гэснийг, 5.5 дахь хэсгийн "нарийвчилсан" гэснийг тус тус хассугай.
7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 210 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Хувийн хэвшлийн түншлэгч болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам"-ыг хүчингүй болсонд тооцсугай.
8. Энэ тогтоолыг дагаж мөрдөхөөс өмнө эхэлсэн түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээ, бүрэн шинжилгээ, урьдчилсан болон уралдаант сонгон шалгаруулалт, гэрээний хэлэлцээрийн ажиллагааг өмнө мөрдөгдөж байсан журмын дагуу зохион байгуулсугай.
9. Энэ тогтоолыг 2026 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Н.УЧРАЛ

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД
БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД

Ж.ЭНХБАЯР

Засгийн газрын 2024 оны 12 дугаар
сарын 04-ний өдрийн 210 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

ТҮНШЛЭЛИЙН ТӨСЛИЙН УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭ, БҮРЭН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 13.2-т заасан түншлэлийн төслийн хүрээнд аймаг, нийслэлд хэрэгжүүлэх төслийн ач холбогдол, үр ашгийг нарийвчлан судалж тогтоох, хэрэгжүүлэх боломжийн талаар дүгнэлт гаргах, аймаг, нийслэлийн хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах, түншлэлийн төрөл, гэрээний хэлбэрийг тодорхойлох зорилгоор түншлэлийн төслийн төлөвлөлтөд урьдчилсан үнэлгээ болон бүрэн шинжилгээ (цаашид “төслийн бүрэн шинжилгээ” гэх) хийхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан утгаар ойлгоно.

Хоёр.Түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээ хийх

2.1.Хувийн хэвшлийн түншлэгч нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан нөхцөл, шаардлагад нийцүүлэн тус хуулийн 13.2-т заасан салбарт түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналыг аймаг, нийслэлийн Засаг даргад цахим системээр гаргана.

2.2.Түншлэлээр хэрэгжүүлэх төслийн санал (цаашид “төслийн санал” гэх)-д дараах мэдээллийг тусгах бөгөөд төсөлд холбогдох тооцоо, шинжилгээ, судалгааг сүүлийн 3 жилийн дотор хийсэн байна:

2.2.1.төслийн мэдээлэл, танилцуулга. Энэ журмын 1 дүгээр хавсралт (Маягт 1-8)-д заасны дагуу дараах мэдээллийг бүрдүүлнэ:

- 2.2.1.1.төслийн ерөнхий мэдээлэл;
- 2.2.1.2.төслийн нийгмийн ач холбогдлын талаарх мэдээлэл;
- 2.2.1.3.төслийн эдийн засгийн үр ашгийн талаарх мэдээлэл;
- 2.2.1.4.төсөл хэрэгжүүлэх салбарын хууль, эрх зүйн орчны талаарх мэдээлэл;
- 2.2.1.5.аймаг, нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлттэй нийцэж байгаа эсэх мэдээлэл;
- 2.2.1.6.төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдсан байдлын талаарх мэдээлэл;
- 2.2.1.7.төслийн дэд бүтцийн хэрэгцээний мэдээлэл;
- 2.2.1.8.төслийн хүрээнд бий болох ажлын байрны мэдээлэл.
- 2.2.2.хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө;
- 2.2.3.санхүү, хөрөнгө оруулалтын тооцоо;
- 2.2.4.санхүү, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ (*энэ журмын 2 дугаар хавсралтад заасны дагуу тооцно.*);
- 2.2.5.урьдчилсан үнэлгээнд шаардлагатай бусад мэдээлэл.

2.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь энэ журмын 2.2-т заасан мэдээллийг тусгасан түншлэлээр хэрэгжүүлэх төслийн саналыг хүлээн авч, түншлэлийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхэд тохиромжтой эсэх талаар урьдчилсан үнэлгээг хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд ажлын хэсэг байгуулж болно.

2.4.Төслийн саналд энэ журмын 2.2-т заасан мэдээлэл дутуу, эсхүл холбогдох тооцоо, судалгааг бүрэн боловсруулаагүй тохиолдолд аймаг, нийслэлийн Засаг дарга нь тус төслийн саналыг төсөл санаачлагчид буцаах бөгөөд үндэслэлийг дурдсан байна.

2.5.Энэ журмын 2.3-т заасан урьдчилсан үнэлгээ хийх хугацаа хуанлийн 30 өдөр байна.

2.6.Аймаг, нийслэлийн холбогдох байгууллага нь урьдчилсан үнэлгээг хийхэд шаардлагатай мэдээллээр хангаж, хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон тооцоо, судалгааг хийхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлнэ.

2.7.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь урьдчилсан үнэлгээ хийхэд мэргэжил, арга зүйн туслалцаа шаардлагатай гэж үзсэн тохиолдолд мэргэжлийн зөвлөх үйлчилгээг холбогдох хууль, журмын дагуу авч болно.

2.8.Түншлэлийн төсөл нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 18.1-д заасан нийтлэг шаардлагыг хангасан байх ба тухайн салбарын бодлогын баримт бичигтэй уялдсан эсэх санал, зөвлөмжийг салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авна.

2.9.Аймаг, нийслэлийн Засаг дарга урьдчилсан үнэлгээний тайлан, дүгнэлтийг хянаж, баталгаажуулна.

Гурав.Түншлэлийн төслийг хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах

3.1.Энэ журмын 2.9-д заасны дагуу хянан баталгаажсан түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой түншлэлийн төслийг аймаг, нийслэлийн хөгжлийн бодлогын баримт бичигт тусгуулах саналыг аймаг, нийслэлийн Засаг дарга нь иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

3.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга аймаг, нийслэлийн хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан түншлэлийн төслүүдийг өөрийн цахим хуудас, мэдээллийн сангаар дамжуулан 12 сар хүртэлх хугацаанд олон нийтэд зарлана.

3.3.Урьдчилсан үнэлгээ хийгдсэн, аймаг, нийслэлийн хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан түншлэлийн төсөлд бүрэн шинжилгээг хийнэ.

Дөрөв.Түншлэлийн төсөлд бүрэн шинжилгээ хийх

4.1.Энэ журмын 3.3-т заасан шаардлага хангасан түншлэлийн төсөлд бүрэн шинжилгээ хийх, үнэлэх ажиллагаа дараах үе шаттай байна:

- 4.1.1.түншлэлийн төслийн дүн шинжилгээг хийх;
- 4.1.2.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 18.4-т зааснаас бусад түншлэлийн төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах;
- 4.1.3.түншлэлийн төслийн эх хувийг боловсруулах;
- 4.1.4.түншлэлийн төслийн эрсдэлийг судалж, тодорхойлох.

4.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь түншлэлийн төсөлд бүрэн шинжилгээ хийх төслийн баг (ажлын хэсэг)-ийг томилно.

4.3. Төслийн баг томилох шийдвэрт багийн бүрэлдэхүүн, чиг үүрэг, төслийн бүрэн шинжилгээ хийх хугацаа зэргийг тусгана.

4.4. Төслийн баг нь дарга, нарийн бичгийн дарга, гишүүд бүхий 7-оос доошгүй тооны бүрэлдэхүүнтэй байна. Төслийн багийн бүрэлдэхүүнд дараах байгууллагын төлөөллийг оруулна:

4.4.1. аймаг, нийслэлийн нутгийн захиргааны холбогдох байгууллагын төлөөлөл;

4.4.2. түншлэлийн төслөөс хамааран холбогдох төрийн байгууллагын төлөөлөл.

4.5. Төслийн багийн бүрэлдэхүүнд санхүү, эдийн засаг, хууль, эрх зүй, нийгэм, байгаль орчин болон холбогдох бусад салбарын үндэсний, олон улсын мэргэжлийн судлаач, зөвлөх, хөндлөнгийн хараат бус зөвлөхийг нээлттэй сонгон шалгаруулж гишүүнээр томилно.

4.6. Төслийн баг тухайн төслийн хүрээнд хийгдсэн ажил, баримт бичигт дүн шинжилгээ хийн, бүрэн шинжилгээ хийх ажлын цар хүрээг тодорхойлж, шаардлагатай зардлыг тооцно.

4.7. Бүрэн шинжилгээ хийхтэй холбоотой зардлыг аймаг, нийслэлийн холбогдох төсөв болон хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

4.8. Төслийн баг нь төслийн бүрэн шинжилгээг 6 сарын дотор гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд нэг удаа 6 сар хүртэл хугацаагаар сунгаж болно.

4.9. Төслийн баг тухайн төслийн талаар зорилтот бүлэг, нөлөөлөлд орж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулан олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулж, санал авна.

4.10. Төслийн багийн гишүүд нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн чиглэлээр сургалтад хамрагдсан байна. Сургалтыг түншлэлийн асуудал хариуцсан нэгж, байгууллага, Түншлэлийн төвөөр хийлгэж болно.

Тав.Түншлэлийн төслийн техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах

5.1. Төслийн баг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 18.4-т зааснаас бусад түншлэлийн төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулна.

5.2. Төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг өмнө нь боловсруулж байсан тохиолдолд энэ журмын 5.4-т заасан агуулгын хүрээнд шинэчилнэ.

5.3. Төслийн баг техник, эдийн засгийн үндэслэлийг мэргэжлийн зөвлөх үйлчилгээ авч гүйцэтгүүлж болно. Мэргэжлийн зөвлөх үйлчилгээний зардлыг энэ журмын 4.7-д заасан эх үүсвэрээс санхүүжүүлж болно.

5.4. Техник, эдийн засгийн үндэслэлд дараахыг тусгана:

5.4.1. төслийн хэмжигдэхүйц зорилтод үндэслэн төслийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлсон байх;

5.4.2. хууль зүйн дүн шинжилгээ, нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн шинжилгээ хийж баталгаажуулсан байх;

- 5.4.3.техникийн шаардлага, төслийн орц, гарц болон хүрэх үр дүнг тодорхойлсон байх;
- 5.4.4.төслийн үйл ажиллагаанд шаардлагатай Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу олгогдох зөвшөөрлийг тодорхойлсон байх;
- 5.4.5.төслийн нийт зардлыг тухайн төслийн үе шатанд шаардлагатай бүх зардлыг хамааруулан нэгдсэн дүнгээр тодорхойлсон байх;
- 5.4.6.түншлэлийн төслийн дагуу хувийн хэвшлийн түншлэгчээс үзүүлэх төрийн үйлчилгээний төлбөр нь зах зээлийн үнэтэй уялдсан, бүртгэл хийх боломжтой байх;
- 5.4.7.байгаль орчинд ээлтэй технологийг нэвтрүүлсэн байх;
- 5.4.8.санхүүгийн эх үүсвэрийн боломж, түншлэлд зөвлөгөө болон дэмжлэг үзүүлэх чадавх;
- 5.4.9.төслийн мэдээлэл, танилцуулга, төсөл хэрэгжих бэлэн байдал, ашиглалтын хугацаа, хэрэгжүүлэх хуваарь;
- 5.4.10.түншлэлийн төрөл, орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх санхүүжилтийн хуваарь, хэрэглэгчийн төлбөр, хураамжийн судалгаа, зардал, үр ашгийн тооцоолол, төслийн санхүүжилтийн мэдээлэл;
- 5.4.11.төслийн барилга байгууламж болон үйл ажиллагааны тодорхойлолт;
- 5.4.12.төсөл хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах төрийн байгууллага;
- 5.4.13.төслийг хэрэгжүүлэхэд орон нутгаас үзүүлэх дэмжлэгийн төрөл;
- 5.4.14.төслийн онцлогоос хамаарсан шаардлагатай бусад мэдээлэл.

5.5.Түншлэлийн төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг тухайн төсөл хэрэгжих салбарын хууль тогтоомжийн дагуу шинжлэх ухаан, технологийн зөвлөл, эсхүл холбогдох эрх бүхий байгууллагаар хэлэлцүүлэн батлуулна.

Зургаа.Түншлэлийн эх төслийг боловсруулах

6.1.Төслийн баг түншлэлийн төслийн эх төслийг боловсруулах бөгөөд дараах шинжилгээг хийнэ:

- 6.1.1.мөнгөний үнэ цэнийн шинжилгээ;
- 6.1.2.төслийг хэрэгжүүлэх түншлэлийн төрөл, гэрээний хэлбэр, төсөл хэрэгжүүлэх хугацаа.

6.2.Түншлэлийн эх төсөлд техник, эдийн засаг, санхүү, хууль, эрх зүй, нийгэм болон байгаль орчны нөлөөллийн үндэслэл, нотолгоо, тоон баримт зэргийг тусгана.

6.3.Түншлэлийн эх төсөл боловсруулахтай холбоотой зардлыг энэ журмын 4.7-д заасан эх үүсвэрээс санхүүжүүлэх бол зардлыг тооцож, холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлүүлнэ.

Долоо.Түншлэлийн төслийн эрсдэлийг судалж, тодорхойлох

7.1.Төслийн баг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 7.2.4-т заасан аргачлалын дагуу эрсдэлийн шинжилгээг гүйцэтгэнэ.

7.2.Төслийн баг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 9.2-т заасан загварын дагуу төслийн төсөвт үзүүлэх нөлөөлөл, эрсдэл, мөн түншлэлийн гэрээний дагуу төсөвт шууд болон шууд бус төлбөрийн үүрэг, хариуцлага бий болгох эсэхийг тооцно.

7.3.Төслийн баг энэ журмын 7.1, 7.2-т тодорхойлсон эрсдэлийн үнэлгээг үндэслэн эрсдэлийн удирдлагын арга хэмжээг төлөвлөж түншлэлийн эх төсөлд тусгана.

Найм.Санал, дүгнэлт, шийдвэр гаргах

8.1.Төслийн баг түншлэлийн төслийг энэ журмын 7.2-т заасан үнэлгээгээр өндөр эрсдэлтэй, тухайн төсөлд аймаг, нийслэлээс дэмжлэг үзүүлэх боломжгүй гэж дүгнэсэн тохиолдолд аймаг, нийслэлийн Засаг дарга төслийн саналыг төсөл санаачлагчид буцаана.

8.2.Төслийн баг төслийн бүрэн шинжилгээгээр түншлэлээр хэрэгжүүлэхэд тохиромжтой гэж дүгнэсэн тохиолдолд төслийн иж бүрэн баримт бичгийг аймаг, нийслэлийн Засаг даргад бүрэн шинжилгээ хийгдэж, санал, дүгнэлт гарснаас хойш ажлын 5 өдөрт багтаан хүргүүлнэ.

8.3.Төслийн баг төслийн баримт бичгийн иж бүрдэлд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 21.2-т заасан мэдээллийг тусгасан хяналтын хуудсыг хамт хүргүүлнэ.

8.4.Аймаг, нийслэлийн Засаг дарга төслийн бүрэн шинжилгээнд үндэслэн тухайн төслийг түншлэлээр хэрэгжүүлэх санал, дүгнэлтийг түншлэл болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудад зөвшилцөхөөр хүргүүлнэ. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох мэдээллийг хүлээж авснаас хойш ажлын 10 өдрийн дотор түншлэлээр хэрэгжүүлэх гэж буй төсөл Төсвийн тухай хуульд нийцэж байгаа эсэхийг хянаж, хариу өгнө. Түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ажлын 10 өдрийн дотор түншлэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль болон Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд нийцэж байгаа эсэхийг хянаж, хариу өгнө.

8.5.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ журмын 8.4-т заасны дагуу санхүү, төсвийн асуудал болон түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр төслийг түншлэлээр хэрэгжүүлэх санал, дүгнэлтийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

8.6.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ журмын 8.5-д заасан санал, дүгнэлтийг хэлэлцэж, төслийг түншлэлээр хэрэгжүүлэх эсэх шийдвэрийг гаргана.

8.7.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас төслийг түншлэлээр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд аймаг, нийслэлийн Засаг дарга төслийг хэрэгжүүлэх хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулна.

“Түншлэлийн төслийн урьдчилсан үнэлгээ,
бүрэн шинжилгээ хийх
журам”-ын Хавсралт 1

ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ, ТАНИЛЦУУЛГА

Маягт 1.Төслийн үндсэн мэдээлэл

Төслийн нэр	
Төслийн зорилго	
Төслийн зорилтууд	
Санал байгууллагууд	

№	Үзүүлэлт		Танилцуулга	
1	Төсөл хэрэгжих салбар			
2	Төсөл хэрэгжих дэд салбар			
3	Төсөл хэрэгжих байршил /Хэд хэдэн байршилд хэрэгжих төсөл бол байршил тус бүрээр мэдээллийг оруулна/	Аймаг, хот 1		
		Сум, дүүрэг 1		
		Хаяг 1		
		Аймаг, хот ... n		
		Сум, дүүрэг ... n		
		Хаяг ... n		
4	Газрын асуудал шийдэгдсэн эсэх	Үгүй бол	Шалтгаан, тайлбар	
		Тийм бол	Гэрчилгээний дугаар	
			Гэрчилгээний төрөл	Аль нэгийг сонгоно уу: а) эзэмших б) ашиглах в) өмчлөх
			Гэрчилгээ олгосон огноо	он: ... сар: ...өдөр:
			Гэрчилгээ дуусах огноо	он: ... сар: ...өдөр: ...
			Шийдвэр гаргасан	Аймаг /нийслэл/: Сум, дүүрэг: Албан тушаал: Нэр:
5	Төслийн нийт төсөвт өртөг: /сая.төгрөгөөр илэрхийлэх ба төслийн нийт төсөвт өртгийн дүн/		 сая.төгрөг	

6	Төсөл хэрэгжих хугацаа: /Нийт хэдэн жилийн дотор хэрэгжүүлэхээр төлөвлөж байгааг тодорхой бичих/	Бүтээн байгуулалт	
		Хугацаа:сар Эхлэх он: Дуусах он:	
		Ашиглалт, үйлчилгээ	
		Хугацаа:жил Эхлэх он: Дуусах он:	
7	Төслийн хэрэгцээ, шаардлага	Эрэлт, хэрэгцээ, шаардлага	
		Зах зээлийн өнөөгийн төлөв байдал	
8	Хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөө	Хүрээлэн буй орчинд ээлтэй технологи, менежментийн шийдэлтэй эсэх:	
		Хүрээлэн буй орчныг хамгаалах хариуцлагын тогтолцоог нэвтрүүлсэн эсэх:	

9	Бүс, орон нутгийн хөгжилд үзүүлэх нөлөө	Төсөл хэрэгжих бүс, орон нутгийн эдийн засгийн хэрэгцээ, шаардлагыг хангаж буй эсэх:	
		Төсөл хэрэгжих бүс, орон нутгийн нийгмийн хэрэгцээ, шаардлагыг хангаж буй эсэх:	
		Төсөл хэрэгжих бүс, орон нутгийн дэд бүтцийн хэрэгцээ шаардлагыг хангаж буй эсэх:	
10	Хувийн хэвшил өөрийн санаачилгаар төслийн санал ирүүлсэн бол	Байгууллагын нэр:	
		Үйл ажиллагааны чиглэл:	
		Үүсгэн байгуулагдсан огноо:	
		Туршлага, гүйцэтгэж байсан томоохон ажлын мэдээлэл:	
		Байгууллагын санхүүгийн чадавх:	
		Хувийн хэвшлийн байгууллагын хариуцсан ажилтан	Нэр: Албан тушаал: Утас /ажил, гар/: И-мэйл:
12	Төслийн өнөөгийн байдал: /Төслийн хүрээнд хийгдсэн ажлуудын талаар товч танилцуулга/		

13	Бүтээгдэхүүн, үйлчилгээний товч танилцуулга	
14	Аймаг, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын тухайн төсөл хариуцсан мэргэжилтэн	Нэр: Албан тушаал: Утас /ажил, гар/: И-мэйл:

Маягт 2.Төслийн нийгмийн ач холбогдлын мэдээлэл

№	Үзүүлэлт	Танилцуулга
1	Нийгмийн/иргэдийн эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл	
2	Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд нөлөөлөх нөлөөлөл	
3	Иргэдийн мэдлэг, боловсролын түвшнийг дээшлүүлэхэд үзүүлэх нөлөөлөл	
4	Ядуурлыг бууруулахад нөлөөлөх нөлөөлөл	
5	Тухайн бус, орон нутгийн хөгжилд үзүүлж буй нөлөөлөл	
6	Байгаль орчны нөлөөлөх нөлөөлөл	
7	Технологи, инновацын хөгжилд нөлөөлөх нөлөөлөл /Нэвтрүүлэх дэвшилтэт техник, технологи тус бүрээр/	
8	Бусад	

Маягт 3.Төслийн эдийн засгийн үр ашгийн талаарх мэдээлэл

№	Үзүүлэлт	Танилцуулга
1	Экспортод чиглэсэн	
2	Импортыг орлох	
3	Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	
4	Дотоодын үйлдвэрлэлийг дэмжих	
5	Төсөл хэрэгжих хугацаанд улсад төлөх нийт татвар, төлбөр хураамж /сая. төг/	
6	Шинээр бий болгох ажлын байрны тоо	
7	Бусад	

Маягт 4.Төсөл хэрэгжүүлэх салбарын хууль, эрх зүйн орчны мэдээлэл

№	Үзүүлэлт	Танилцуулга
Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой хууль зүйн үндэслэл, эрх зүйн орчин		
1	Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотой хууль, эрх зүйн акт /Хууль, эрх зүйн актын нэр, холбогдох заалт/	
2	Төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр боловсруулах, эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулах хууль, захиргааны хэм хэмжээний акт байгаа эсэх /Хэрэв байгаа бол хууль, хэм хэмжээний актын хэрэгцээ, шаардлагын талаарх судалгаа, үндэслэлийг тодорхой бичих/	
3	Төрийн дэмжлэг, онцгой зохицуулалт /аливаа хууль, журам, хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу онцгой зохицуулалтад хамрагдах эсэх, эсхүл татварын болон татварын бус хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх, экспорт, импортын хязгаарлалт, урамшуулал эдлэх гэх мэт төрийн дэмжлэгийн хэлбэрүүд/	

Маягт 5.Төсөл хөгжлийн бодлого, төлөвлөлттэй нийцэж байгаа талаарх мэдээлэл

№	Үзүүлэлт	Танилцуулга
Хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилттой нийцэж байгаа эсэх		
1	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого 2050-тай нийцэх байдал /Аль зорилтыг хангахад нөлөөлөхийг тодорхой бичнэ/	
2	10 хүртэлх жилийн дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилттой нийцэх байдал /Аль зорилтыг хангахад нөлөөлөхийг тодорхой бичнэ/	
3	5 хүртэлх жилийн дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилттой нийцэх байдал /Аль зорилтыг хангахад нөлөөлөхийг тодорхой бичнэ/	
4	"Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр"-тэй нийцэж буй байдал /Хэддүгээр заалттай хэрхэн нийцэж буйг тодорхой бичнэ/	
5	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцэж буй байдал /Бодлогын баримт бичгийн нэр, заалтыг тодорхой бичнэ/	
6	Тухайн аймаг, нийслэлийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй нийцэж буй байдал	

**Маягт 6.Төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хангагдсан
байдлын талаарх мэдээлэл**

№	Судалгаа шинжилгээний ажил, боловсруулсан баримт бичгийн бүрдэл	Танилцуулга /Хийгдсэн судалгаа, шинжилгээг ирүүлэх/
1	Суурь судалгаа: /Хууль, эрх зүйн орчин, төслийн эрэлт, хэрэгцээ шаардлага, нөхцөл байдлын шинжилгээ гэх мэт суурь судалгаануудыг тусгах/	
2	Макро эдийн засгийн өнөөгийн байдлын шинжилгээ: /ДНБ, эдийн засгийн өсөлт, төсөл хэрэгжих салбарын ДНБ-д эзлэх хувь гэх мэт макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд шинжилгээ хийж, төсөлд/төслийн үзүүлэх нөлөөллийг урьдчилсан байдлаар томъёолно/	
3	Төсөл хэрэгжих салбар, дэд салбарын өнөөгийн байдлын шинжилгээ /төсөл хэрэгжих салбар, дэд салбарын хөгжлийн түвшин, үр дүн, нөхцөл байдлыг тодорхойлдог үндсэн суурь үзүүлэлтүүд ямар байгаа, тэдгээрийг урт, дунд, богино хугацаанд хэрхэн өөрчлөх зорилтыг Засгийн газраас дэвшүүлсэн болон тэдгээр зорилтоо хангах үүднээс авч хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүд, тэдгээрийн явц, үр дүн ямар байгаа зэргийг тодорхойлно/	
4	Урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл /Хийгдсэн бол ирүүлэх/	
5	Нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл /Хийгдсэн бол ирүүлэх/	
6	Бусад улсын хувьд ижил төстэй төслийн хэрэгжсэн байдлын талаарх туршлагын судалгаа	
7	Бодлогын судалгаа	
8	Зураг төсөл /Зураг төсөл хийгдсэн бол ирүүлэх/	
9	Төсөв /Төсөв хийгдсэн бол ирүүлнэ. Хийгдээгүй бол төсөл санаачилсан байгууллага урьдчилсан байдлаар төсвийг тооцоолж ирүүлнэ/	
10	Холбогдох байгууллагуудаас санал, судалгаа авсан эсэх	

**Маягт 7.Төслийн дэд бүтцийн хэрэгцээний мэдээлэл
/төслийн нийт хүчин чадлаар тооцно/**

№	Дэд бүтэц	Хэмжих нэгж	Нийт хэрэгцээ	Одоогийн байдал	Өргөтгөх/ Шинээр барих	Тайлбар
1	Эрчим хүчний хангамж					
2	Дулаан хангамж					
3	Ахуйн ус хангамж					
4	Технологийн ус хангамж					
5	Цэвэрлэх байгууламж, ариутгах татуурга					
6	Мэдээлэл, харилцаа холбоо					
7	Авто зам					
8	Төмөр зам					
9	Бусад					

Тайлбар: Тухайн түншлэлийн төслийн онцлогоос хамаарч дээрх хүснэгтэд заасан дэд бүтцийн мэдээллийг бүрэн бөглөх шаардлагагүй.

Маягт 8.Ажлын байрны мэдээлэл

№	Мэргэжлийн чиглэл	Шууд ажлын байр				Шууд бус ажлын байр			
		Дотоод ажиллах хүч		Гадаад ажиллах хүч		Дотоод ажиллах хүч		Гадаад ажиллах хүч	
		T1	T2	T1	T2	T1	T2	T1	T2
1	Удирдах ажилтан								
2	Инженер технологийн ажилчид								
3	Мэргэжлийн ажилчид								
4	Бусад ажилчид								
Нийт									

Шууд ажлын байр: Тухайн төслийг хэрэгжүүлснээр бий болгосон шууд хөдөлмөр эрхлэлт буюу шууд цалин авдаг, хөдөлмөрийн гэрээ байгуулсан үндсэн ажилтнууд ба төслийн талбай дээр байнга ажиллах гэрээт ажилтнууд орно.

Шууд бус ажлын байр: Тухайн төслийг хэрэгжүүлснээр бий болгосон шууд бус хөдөлмөр эрхлэлт буюу гэрээлэгчид, тухайн компанийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх ажилтан орно. Энэ нь урт хугацааны ажлын байр биш байж болно. Жишээ нь: Гэрээт байгууллагаас цалин авдаг, төслийн ханган нийлүүлэгч байгууллага, эсхүл гэрээт байгууллагын ханган нийлүүлэгч ба гэрээлэгч байгууллагад ажилладаг гэх мэт.

Засгийн газрын 2026 оны 06 дугаар
сарын 03-ны өдрийн 228 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт

“Түншлэлийн төслийн урьдчилсан
үнэлгээ, бүрэн шинжилгээ хийх
журам”-ын Хавсралт 2

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШГИЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ

1.Төслийн анхны хөрөнгө оруулалтын зардлыг тооцоолох

Анхны хөрөнгө оруулалт гэдэг нь тухайн хөрөнгийг барьж бий болгох, шинэчлэн сайжруулах зэрэг төслийн бүтээн байгуулалтын үе шат хүртэлх буюу төслийн үйл ажиллагааг эхлэх хүртэл гарах дараах хөрөнгө, зардлыг ойлгоно. Тухайлбал:

- Газрын төлбөр;
- Техник, тоног төхөөрөмж;
- Тээврийн хэрэгсэл;
- Тавилга, эд хогшил;
- Компьютер, бусад хэрэгсэл;
- Анхны хөрөнгө оруулалтын бусад зардал;
- Хүүгийн капиталжуулалт (Үндсэн хөрөнгийг бий болгохтой холбогдон гарсан зээлийн хүүгийн зардлыг үндсэн хөрөнгийн өртөгт оруулан тооцож болно);
- Биет бус хөрөнгө оруулалт: Төслийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардлагатай тусгай зөвшөөрөл, зохиогчийн эрх, программ хангамж, патент зэргийг хэлнэ;
- Бэлтгэл ажиллагааны зардал: Төсөл эхлүүлэхтэй холбоотой техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах, суурь судалгаа хийх, боловсон хүчин бэлтгэх, бүтээн байгуулалтын үед гарах зардлууд орно. Үүнд:
 - Бүтээн байгуулалтын үеийн даатгалын зардал: Бүтээн байгуулалт хийх явцад эрсдэлээс сэргийлэх зорилгоор даатгал хийлгэж болох бөгөөд энэхүү даатгалын зардлыг төсөвлөнө;
 - Хууль, эрх зүйн зардал: Төслийг эхлүүлэхтэй холбоотой эрх зүйн туслалцаа авах, бичиг баримт бүрдүүлэхтэй холбоотой эрх зүйн төлбөр гарах тохиолдолд энэхүү хэсэгт төсөвлөнө;
 - Бэлтгэл ажиллагааны бусад зардал: Төслийг эхлүүлэхтэй холбогдон гарах үйл ажиллагааны зардлыг энэ хэсэгт төсөвлөнө;
- Төслийн бэлэн байдлыг хангах зардал: Төслийн техник, эдийн засгийн үндэслэл, барилга, байгууламжийн зураг төсөл, төсөв боловсруулах, БОНБ-ын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ, менежментийн төлөвлөгөө, геологи, гидрологийн зэрэг төслийн бэлэн байдлыг хангахад шаардлагатай холбогдох судалгаа, баримт бичиг боловсруулахад гарах зардлуудыг ойлгоно.

2.Үйл ажиллагааны орлого, зардлын тооцоо хийх

Төслийн хувьд ирээдүйд олох орлогыг хүчин чадал, зах зээлийн ирээдүйн төлөв байдлаас хамааруулан он тус бүрээр таамаглана. Орлогыг дараах төрлийн хувьд төсөөлнө. Үүнд:

-Бараа борлуулалтын орлого: Төслийн үндсэн үйл ажиллагаагаар бараа, бүтээгдэхүүн борлуулснаас олох орлого;

-Үйлчилгээ үзүүлсний орлого: Төслийн үндсэн үйл ажиллагаагаар үйлчилгээ үзүүлснээс олох орлого;

-Бусад мөнгөн орлого: Бараа, бүтээгдэхүүн борлуулах болон үйлчилгээ үзүүлэх үндсэн орлогоос гадна төслийн явцад үйл ажиллагаанаас олох бусад орлого;

-Төслийн нийт орлого: Дээрх гурван төрлийн орлогын нийлбэр. Төслийн цэвэр орлогын нэгтгэлийг дараах хэлбэрээр гаргаж болно.

№	Орлогын төрөл		... он	... он	... он	... он
1.	Бараа борлуулалтын орлого	+				
2.	Үйлчилгээ үзүүлсний орлого	+				
3.	Бусад мөнгөн орлого	+				
Нийт орлого		=				

Санамж: Ирээдүйд олох орлогыг тооцохдоо тухайн жил тус бүрээр ажил, үйлчилгээ үзүүлэх хүчин чадлын тоо хэмжээ болон үнэ, тарифыг үнэн зөв, бодитой тоон мэдээлэлд үндэслэн тодорхой тусгасан байх шаардлагатай.

3.Төслийн хувьд ирээдүйд гарах зардлын тооцоог дараах төрлөөр он тус бүрээр таамаглана. Үүнд:

-Үндсэн үйл ажиллагааны зардал;

-Үндсэн бус үйл ажиллагааны зардал;

-Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардал;

-Татварын зардал: Холбогдох татварын хуулиудын дагуу тооцсон татварын зардлын тооцоолол;

-Элэгдлийн зардал: Барилга, байгууламж, бусад үндсэн хөрөнгийг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17-р зүйлд заасны дагуу доор дурдсан хугацаагаар ашиглахаар тооцож, түүний элэгдэл, хорогдлын шимтгэлийг шулуун шугамын аргаар тооцно.

№	Үндсэн хөрөнгийн бүлэг	Ашиглах хугацаа (жилээр)
1.	Барилга, байгууламж	40/25
2.	Машин, механизм, техник, тоног төхөөрөмж	10
3.	Компьютер, түүний эд анги, программ хангамж	2
4.	Ашиглах хугацаа нь тодорхойгүй биет бус хөрөнгө	10
5.	Ашиглах хугацаа нь тодорхой биет бус хөрөнгө /Үүнд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл хамаарна./	Хүчин төгөлдөр байх хугацаанд
6.	Бусад үндсэн хөрөнгө	10

Санамж: Холбогдох хууль, журамд өөрчлөлт орсон тохиолдолд түүнийг дагаж мөрдөнө.

Төслийн зардлын тооцооны нэгтгэлийг дараах хэлбэрээр гаргана. Төслийн онцлогоос хамааран зардлын төрөл, ангилал өөрчлөгдөж болно.

№	Зардлын төрөл	... он	... он	... он	... он
1	Үндсэн үйл ажиллагааны зардал:				
1.1	Ажиллагчдын цалингийн зардал				
1.2	Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал				
1.3	Томилолтын зардал				
1.4	Бичиг хэргийн зардал				
1.5	Шуудан холбооны зардал				
1.6	Мэргэжлийн үйлчилгээний зардал				
1.7	Сургалтын зардал				
1.8	Сонин, сэтгүүл захиалгын зардал				
1.9	Даатгалын зардал				
1.10	Ашиглалтын зардал				
1.11	Засварын зардал				
1.12	Түрээсийн зардал				
1.13	Харуул хамгаалалтын зардал				
1.14	Цэвэрлэгээ үйлчилгээний зардал				
1.15	Тээврийн зардал				
1.16	Шатахууны зардал				
1.17	Хүүгийн зардал				
1.18	Зар сурталчилгааны зардал				
1.19	Бусад				

4.Төслийн цэвэр ашиг, мөнгөн урсгалын тооцоо хийх

Төслийн нийт орлогын дүнгээс үндсэн үйл ажиллагааны зардал, элэгдлийн зардал, үйл ажиллагааны бус зардал, татварын зардлыг хасаж төслийн жил тутмын цэвэр ашгийг тодорхойлно.

№	Үзүүлэлт/нөлөөлөл		Түншлэлийн хугацаа (жилээр)				Дүн
			1	2	...	n	
1.	Нийт орлого	+					
2.	Борлуулалтын өртөг	-					
3.	Үндсэн үйл ажиллагааны зардал	-					
4.	Элэгдлийн зардал	-					
5.	Үйл ажиллагааны ашиг	=					
6.	Үйл ажиллагааны бус зардал	-					
7.	Татварын өмнөх ашиг	=					
8.	Орлогын албан татварын зардал	-					
9.	Цэвэр ашиг	=					

Төсөл үргэлжлэх жил тутмын мөнгөн урсгалыг дараах төрлөөр тодорхойлно. Үүнд:

- Үйл ажиллагааны мөнгөн урсгал
- Санхүүжилтийн мөнгөн урсгал
- Хөрөнгө оруулалтын мөнгөн урсгал
- Цэвэр мөнгөн урсгал

Үйл ажиллагааны мөнгөн урсгал нь төслийн үндсэн үйл ажиллагаанаас орох мөнгөн урсгал, үйл ажиллагаанд зарцуулагдан гарах мөнгөн урсгалын зөрүүгээр тодорхойлогдоно.

Мөнгөн урсгалын төрөл	... он	... он
Мөнгөн орлогын дүн	мөнгөн орлого	мөнгөн орлого
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого		
Мөнгөн зарлагын дүн	мөнгөн зарлага	мөнгөн зарлага
Ажиллагчдад төлсөн		
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		
Бараа, материал худалдан авахад төлсөн		
Ашиглалтын зардалд төлсөн		
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		

Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн		
Даатгалын төлбөрт төлсөн		
Бусад мөнгөн зарлага		
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн урсгал	мөнгөн орлого мөнгөн зарлага	мөнгөн орлого мөнгөн зарлага

Санхүүжилтийн мөнгөн урсгал нь төсөвлөсөн онд зээл авах, үнэт цаас гаргах замаар орж ирэх санхүүгийн мөнгөн урсгалаас зээл төлөх, ногдол ашиг төлөх гэх мэтээр гарах мөнгөн урсгалыг хасаж тодорхойлно.

Хөрөнгө оруулалтын мөнгөн урсгал нь төсөвлөсөн онд урт хугацаанд хөрөнгө борлуулснаас олох мөнгөн орлого болон урт хугацаат хөрөнгө худалдан авахад зарцуулах мөнгөн дүнгийн зөрүүгээр тодорхойлогдоно. Анхны хөрөнгө оруулалтын зардлыг хөрөнгө оруулалтын мөнгөн урсгалын мөнгөн зарлагын дүнд тусгах шаардлагатай.

Цэвэр мөнгөн урсгал нь төсөл хэрэгжүүлсний үр дүнд жил тутам хөрөнгө оруулагчдад ногдох мөнгөн урсгал юм. Үйл ажиллагааны мөнгөн урсгал, санхүүжилтийн мөнгөн урсгал, хөрөнгө оруулалтын мөнгөн урсгалын нийлбэрээр тодорхойлогдоно.

5.Хөрөнгө оруулалтын ирээдүйд гарах зардал, олох орлогыг өнөөгийн үнэ цэнээр илэрхийлж тооцох

- Төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжих төслүүдийг өнөөгийн цэвэр үнэ цэнийн арга, өгөөжийн дотоод хувиар үнэлнэ.
- Төслийг үнэлэх цэвэр өнөөгийн үнэ цэнийн арга нь төслийн ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэн нь анхны хөрөнгө оруулалтаа нөхөөд илүү өгөөжтэй ажиллах боломжийг үнэлнэ. Цэвэр өнөөгийн үнэ цэнийг дараах томъёогоор тооцно.

$$NPV = PV - I_0 = \sum_{t=1}^n \frac{CF_t}{(1+r)^t} - I_0$$

NPV: Өнөөгийн цэвэр үнэ цэнэ

PV: Өнөөгийн үнэ цэнэ

I_0 : Анхны хөрөнгө оруулалт

CF: Мөнгөн урсгал (Cash flow)

t: хугацааны үе

r: хорогдуулах хувь

- Мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнүүдийн нийлбэрээр өнөөгийн цэвэр үнэ цэн гарна. Өнөөгийн цэвэр үнэ цэнэ "0"-ээс их бол төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж болно.
- Хорогдуулах хувийг тухайн төсөл хэрэгжүүлэх үеийн Монгол банкны бодлогын хүү, түншлэлээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн эрсдэл, эх үүсвэрийн сонголт, зах зээлийн нөхцөлийг харгалзан тогтооно.
- Өгөөжийн дотоод хувь нь эдийн засаг, санхүүгийн эрсдэлээс хамаарч төслийн анхны хөрөнгө оруулалтаа нөхөх хамгийн их хорогдуулах хувийг тооцно. Өгөөжийн дотоод хувийг дараах томъёогоор тооцно.

$$\sum_{t=1}^n \frac{CF_t}{(1 + IRR)^t} - I_0 = 0$$

IRR-Өгөөжийн дотоод хувь

Төслийн цэвэр мөнгөн урсгалууд өнөөгийн үнэ цэнийн нийлбэрийг "0" байлгах хорогдуулах хувийг тооцох ба энэ нь өгөөжийн дотоод хувь болно. Өгөөжийн дотоод хувь нь төслийн хорогдуулах хувиас их бол төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой гэж үзнэ.

IRR>r Төслийг түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой гэж үзнэ.

IRR<r Төслийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 14.1.2, 14.1.3-т заасан төрөл хэлбэрээр хэрэгжүүлэх эсэх талаар судална.

Мөнгөний үнэ цэнийн урьдчилсан шинжилгээний жишээ

№	Өгөгдөл:		
1.	Анхны хөрөнгө оруулалт	Өөрийн санхүүжилтээр	10,000.0 мян.төг
		Урт хугацаат зээлээр	40,000.0 мян.төг
2.	Түншлэлийн гэрээний хугацаа	Бүтээн байгуулалтын хугацаа	2 жил
		Үйл ажиллагааны хугацаа	8 жил
3.	Хөрөнгийн элэгдлийн зардал	200.0 мян.төг	
4.	Орлогын албан татварын хувь	10%	
5.	Хорогдуулах хувь	13%	

Анхны хөрөнгө оруулалт (мян.төг)				
№	Зардлын төрөл	2024	2025	Нийт
1	Үндсэн хөрөнгийн дүн	12,950.0	34,550.0	47,500.0
1.1	Газрын төлбөр	1,000.0	-	1,000.0
1.2	Барилга	10,000.0	30,000.0	40,000.0
1.3	Байгууламж	-	-	-
1.4	Газрын сайжруулалт	1,500.0	-	1,500.0
1.5	Машин, тоног төхөөрөмж	-	1,700.0	1,700.0
1.6	Тээврийн хэрэгсэл	-	900.0	900.0
1.7	Тавилга, эд хогшил	-	1,000.0	1,000.0
1.8	Компьютер, бусад хэрэгсэл	-	300.0	300.0
1.9	Бусад үндсэн хөрөнгө	-	-	-
1.10	Шууд хөрөнгө оруулалттай холбогдон гарах НӨАТ	-	-	-
1.11	Хүүгийн капиталжуулалт	-	-	-
1.12	Бүтээн байгуулалтын үеийн даатгалын зардал	200.0	300.0	500.0
1.13	Хууль, эрх зүйн зардал	100.0	150.0	250.0
1.14	Бэлтгэл ажиллагааны зардал	150.0	200.0	350.0

2	Биет бус хөрөнгийн дүн	1,000.0	0.0	1,000.0
2.1	Зохиогчийн эрх	-	-	-
2.2	Компьютерын программ хангамж	350.0	-	350.0
2.3	Патент	-	-	-
2.4	Тусгай зөвшөөрөл	650.0	-	650.0
3	Эргэлтийн хөрөнгө	0.0	1,500.0	1,500.0
3.1	Мөнгөн хөрөнгө	-	1,000.0	1,000.0
3.2	Бараа, материал	-	500.0	500.0
4	Анхны хөрөнгө оруулалтын нийт зардал	13,950.0	36,050.0	50,000.0

Орлогын төсөөлөл /мян.төг/										
№	Орлогын төрөл	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	Нийт
1	Бараа борлуулалтын орлого	18,000.0	18,500.0	19,000.0	21,500.0	23,000.0	24,000.0	25,500.0	26,000.0	175,500.0
2	Үйлчилгээ үзүүлсний орлого	-	-	-	-	-	-	-	-	-
3	Бусад мөнгөн орлого	1,000.0	1,000.0	1,000.0	1,000.0	1,000.0	1,000.0	1,000.0	1,000.0	8,000.0
4	Нийт орлого	19,000.0	19,500.0	20,000.0	22,500.0	24,000.0	25,000.0	26,500.0	27,000.0	183,500.0

Санамж: Ирээдүйд олох орлогыг тооцохдоо тухайн жил тус бүрээр ажил, үйлчилгээ үзүүлэх хүчин чадлын тоо хэмжээ болон үнэ тарифыг үндэслэл бүхий түүхэн мэдээлэл, судалгаан дээр суурилан ирээдүйн таамаглалыг тодорхой тусгасан байх шаардлагатай.

[illegible]

1.14	Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	400.0	400.0	400.0	400.0	400.0	400.0	400.0	400.0	3,200.0
1.15	Тээврийн зардал	400.0	400.0	400.0	400.0	400.0	400.0	400.0	400.0	3,200.0
1.16	Шатахууны зардал	300.0	300.0	300.0	300.0	300.0	300.0	300.0	300.0	2,400.0
1.17	Хүүгийн зардал	350.0	350.0	350.0	350.0	350.0	350.0	350.0	350.0	2,800.0
1.18	Зар сурталчилгааны зардал	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	400.0
Үндсэн үйл ажиллагааны нийт зардал		6,780.0	6,780.0	6,780.0	7,350.0	7,350.0	7,350.0	7,350.0	7,890.0	57,630.0

Төслийн цэвэр ашиг /мян.төг/										
№	Үзүүлэлт	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	Нийт
1	Төслийн нийт орлого	19,000.0	19,500.0	20,000.0	22,500.0	24,000.0	25,000.0	26,500.0	27,000.0	183,500.0
2	Үндсэн үйл ажиллагааны зардал	6,780.0	6,780.0	6,780.0	7,350.0	7,350.0	7,350.0	7,350.0	7,890.0	57,630.0
3	Элэгдлийн зардал	200.0	200.0	200.0	200.0	200.0	200.0	200.0	200.0	1,600.0
4	Үйл ажиллагааны ашиг	12,020.0	12,520.0	13,020.0	14,950.0	16,450.0	17,450.0	18,950.0	18,910.0	124,270.0
5	Үйл ажиллагааны бус зардал	500.0	650.0	450.0	700.0	600.0	600.0	600.0	600.0	4,700.0
6	Татварын өмнөх ашиг	11,520.0	11,870.0	12,570.0	14,250.0	15,850.0	16,850.0	18,350.0	18,310.0	119,570.0
7	Орлогын албан татварын зардал /10%/	1,152.0	1,187.0	1,257.0	1,425.0	1,585.0	1,685.0	1,835.0	1,831.0	11,957.0
8	Цэвэр ашиг	10,368.0	10,683.0	11,313.0	12,825.0	14,265.0	15,165.0	16,515.0	16,479.0	107,613.0

[illegible]

2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	300.0	300.0	300.0	300.0	300.0	300.0	300.0	300.0	2,400.0
2.6	Хүүний төлбөрт төлсөн	350.0	350.0	350.0	350.0	350.0	350.0	350.0	350.0	2,800.0
2.7	Татварын байгууллагад төлсөн	1,152.0	1,187.0	1,257.0	1,425.0	1,585.0	1,685.0	1,835.0	1,831.0	11,957.0
2.8	Даатгалын төлбөрт төлсөн	200.0	200.0	200.0	200.0	200.0	200.0	200.0	200.0	1,600.0
2.9	Бусад мөнгөн зарлага	1,600.0	1,750.0	1,550.0	1,800.0	1,700.0	1,700.0	1,700.0	1,700.0	13,500.0
3	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	10,568.0	10,883.0	11,513.0	13,025.0	14,465.0	15,365.0	16,715.0	16,679.0	109,213.0

Өнөөгийн цэвэр үнэ цэнэ, дотоод өгөөжийн хувь											
№	Үзүүлэлт	Томьёо	2026	2027	2028	2029	2030	2031	2032	2033	Дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ /мян.төг/		10,568.0	10,883.0	11,513.0	13,025.0	14,465.0	15,365.0	16,715.0	16,679.0	109,213.0
2	Хорогдуулах хувь	$r=13\%$	13%	13%	13%	13%	13%	13%	13%	13%	-
3	Өнөөгийн үнэ цэнийн коэффициент		0.885	0.783	0.693	0.613	0.543	0.480	0.425	0.376	-
4	Өнөөгийн үнэ цэнэ /мян.төг/	PV	9352.21	8522.99	7979.09	7988.48	7851.02	7380.09	7104.89	6273.97	62,452.7
5	Анхны хөрөнгө оруулалт /мян. төг/										50,000.0
6	Төслийн цэвэр өнөөгийн үнэ цэнэ /мян.төг/	NPV									12,452.7
7	Төслийг хэрэгжүүлэх боломжтой эсэх	Өнөөгийн цэвэр үнэ цэнэ "0"-ээс их байгаа тул төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой. NPV=12,452.7>0									
8	Дотоод өгөөжийн хувь /IRR/	IRR>r бол төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой гэж үзнэ. IRR=24.9%>13%									

Засгийн газрын 2026 оны
06 дугаар сарын 03-ны өдрийн
228 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 13.2-т заасан салбарын хүрээнд аймаг, нийслэлээс хэрэгжүүлэх түншлэлийн төсөлд хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 24-27 дугаар зүйлд заасан хувийнхэвшлийнтүншлэгчийгсонгохсонгоншалгаруулалт(цаашид"сонгоншалгаруулалт" гэх)-ыг зохион байгуулах, түншлэлийн гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээр хийхэд энэ журмыг баримтална.

1.3.Сонгон шалгаруулалтад Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 24.5-д заасан зарчмыг баримтлах бөгөөд сонгон шалгаруулалтын үе шат, үйл ажиллагаа, үр дүнг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.

1.4.Энэ журамд дурдсан нэр томьёог Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан утгаар хэрэглэнэ.

1.5.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 37.1-д заасан сонгон шалгаруулалтгүйгээр хэлэлцээ хийж, гэрээ байгуулахад энэ журмыг хэрэглэхгүй.

Хоёр.Сонгон шалгаруулалтын ажлын хэсэг

2.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга сонгон шалгаруулалтын ажлын хэсэг (цаашид "Ажлын хэсэг" гэх)-ийг төсөл тус бүрээр байгуулах бөгөөд уг Ажлын хэсэг сонгон шалгаруулалтыг цахим системээр зохион байгуулна.

2.2.Ажлын хэсэг байгуулах шийдвэрт Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, чиг үүрэг болон удирдамжийг тусгана.

2.3.Ажлын хэсэг нь 7-оос доошгүй, сондгой тооны бүрэлдэхүүнтэй байх бөгөөд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.4.Ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтыг зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагаанд ашиглах цахим шуудан, утасны дугаар, албан ёсны хаягтай байна.

2.5.Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аймаг, нийслэлийн холбогдох байгууллагын төлөөлөл орох бөгөөд санхүү, эдийн засаг, хууль, эрх зүй, нийгэм, байгаль орчин болон холбогдох бусад салбарын мэргэжилтэн, судлаач, зөвлөх, хөндлөнгийн хараат бус зөвлөх гишүүнийг оруулна.

2.6.Аймаг, нийслэлийн Засаг дарга сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад зайлшгүй шаардлагатай дотоодын болон гадаадын шинжээч, зөвлөх, мэргэжлийн багийг Ажлын хэсгийн дэргэд томилон ажиллуулж болно. Энэ тохиолдолд холбогдох зардлыг аймаг, нийслэлийн төсөв болон хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

2.7.Ажлын хэсэг төслийн сонгон шалгаруулалтын урилгыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж, түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын цахим хуудсанд байршуулан, сонгон шалгаруулалтын талаар танилцуулга хийх, уулзалт зохион байгуулах зэргээр олон нийтэд мэдээлэл өгнө.

2.8.Хувийн хэвшлийн түншлэгчийн саналыг хүлээн авах, үнэлэх үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй байх ба Ажлын хэсэг сонгон шалгаруулалтын тухай мэдээллийг ил тод, нээлттэй зарлах, саадгүй олгох, өрсөлдөөний тэнцвэрийг хангах зорилгоор мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангаж ажиллана.

2.9.Ажлын хэсгийн гишүүн ашиг сонирхлын зөрчилгүй байх бөгөөд албан үүргээ хэрэгжүүлэх явцад үүссэн эсхүл, үүсэж болзошгүй ашиг сонирхлын зөрчил, нөлөөллийн мэдүүлгийг холбогдох хуулийн дагуу үнэн зөв гаргана.

2.10.Ажлын хэсгийн гишүүн төр, хувийн хэвшлийн түншлэлийн чиглэлээр шаардлагатай мэдлэг, чадавх олгох сургалтад хамрагдсан байна.

2.11.Түншлэлийн төслийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад холбогдох төрийн байгууллага шаардлагатай мэдээллээр хангаж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

Гурав.Сонгон шалгаруулалтын баримт бичиг

3.1.Ажлын хэсэг энэ журмын 2 дугаар хавсралтаар баталсан жишиг баримт бичгийн дагуу сонгон шалгаруулалтын баримт бичгийг боловсруулж, аймаг, нийслэлийн Засаг даргаар батлуулна.

3.2.Сонгон шалгаруулалтын баримт бичигт Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 25.1-д заасан мэдээллийг тусгана.

3.3.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтын урилга, баримт бичгийг боловсруулахдаа техникийн саналын босго оноо, давуу эрхийн оноог урьдчилан заасан байна.

3.4.Давуу эрхийн оноо нь техникийн болон санхүүгийн саналын үнэлгээний нийт онооны 10 хувиас илүүгүй байна.

3.5.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтыг 30-аас доошгүй хоногийн өмнө дотоодын, эсхүл олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд нээлттэй мэдээлж, аймаг, нийслэлийн албан ёсны цахим хуудсанд байршуулна.

3.6.Ажлын хэсэг сонгон шалгаруулалт зарласан хугацаанд төрийн түншлэгч байгууллагатай хамтран 1-ээс доошгүй удаа уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, төсөлтэй холбогдох баримт бичгийн талаар мэдээлэл өгнө.

3.7.Сонгон шалгаруулалтад оролцох санал хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас 14 хоногийн өмнө сонгон шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Энэ тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг аймаг, нийслэлийн Засаг даргаар батлуулж, санал хүлээн авах эцсийн хугацааг ажлын 5-аас доошгүй өдрөөр сунгана.

3.8.Сонгон шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлт нь тухайн баримт бичгийн салшгүй хэсэг байх бөгөөд Ажлын хэсэг оруулсан нэмэлт өөрчлөлтийг бүх оролцогчид нэгэн зэрэг мэдэгднэ.

Дөрөв.Сонгон шалгаруулалтад оролцогч

4.1.Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтийг сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан хугацаа, шаардлагын дагуу цахим системээр гаргах бөгөөд хүсэлтийг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хүлээн авч, цахим системийн хугацааны дарааллаар бүртгэж, оролцогчийн бүртгэлийг цахимаар баталгаажуулна.

4.2.Сонгон шалгаруулалтад оролцогч Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 27.1-д заасан үндсэн шаардлагыг хангасан байх бөгөөд тусгайлсан шаардлагыг сонгон шалгаруулалтын баримт бичгээр тогтоож болно.

4.3.Сонгон шалгаруулалтын баримт бичгийг бүртгүүлсэн оролцогчид цахимаар хүргүүлнэ.

4.4.Сонгон шалгаруулалтад оролцогч нь сонгон шалгаруулалтын баримт бичигтэй холбоотой нэмэлт тодруулга, мэдээлэл авах хүсэлтийг санал хүлээн авах хугацаа дуусахаас 10-аас доошгүй хоногийн өмнө цахимаар гаргаж болно.

4.5.Ажлын хэсэг энэ журмын 4.4-д заасан хүсэлтийн хариуг ажлын 2 өдрийн дотор нийт бүртгүүлсэн оролцогчдод нэгэн зэрэг цахимаар хүргүүлнэ.

4.6.Хувийн хэвшлийн төсөл санаачлагч сонгон шалгаруулалтын өрсөлдөөнд оролцохдоо бусад оролцогчийн нэгэн адил үнэлгээний шалгуурт хамаарах ба үнэлгээнд сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан давуу эрхийн оноог өгнө.

Тав.Төслийн санал хүлээн авах, нээх

5.1.Энэ журмын 4.3-т заасан бүртгүүлсэн оролцогч сонгон шалгаруулалтын баримт

бичгийн дагуу бэлтгэсэн төслийн саналаа санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө цахимаар хүргүүлэх бөгөөд Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга төслийн саналыг цахимаар ирүүлсэн хугацааны дарааллаар бүртгэнэ.

5.2.Оролцогч нь сонгон шалгаруулалтад хүргүүлэх төслийн санал бүхий цахим мэдээллийг нууц үгээр хамгаалах бөгөөд нууц үгийг төслийн санал нээх үед ажлын хэсэгт өгнө.

5.3.Сонгон шалгаруулалтад оролцогч төслийн санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө цахимаар хүргүүлсэн төслийн саналдаа нэмэлт, өөрчлөлт оруулж, өмнөх саналыг хүчингүйд тооцсон мэдэгдлийг гаргаж болох ба саналыг нэмэлт оруулсан өдрөөр бүртгэнэ.

5.4.Ажлын хэсэг төслийн санал хүлээн авах эцсийн хугацаа дууссан өдөр сонгон шалгаруулалтад ирүүлсэн төслийн санал нээх ажиллагааг цахим системээр Ажлын хэсгийн гишүүдийг байлцуулан зохион байгуулж дараах ажиллагааг хийнэ:

5.4.1.Ажлын хэсэг төслийн санал авах эцсийн хугацаанаас хоцорсон, сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцээгүй тэмдэглэгээ хийсэн, нууц үггүй ирүүлсэн төслийн саналыг хүчингүйд тооцох;

5.4.2.Ажлын хэсэг төслийн санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө ирүүлсэн, сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцсэн, нууц үг бүхий төслийн саналыг үнэлж, төслийн санал ирүүлсэн оролцогчийн жагсаалт гаргах;

5.4.3.оролцогчоос өгсөн нууц үгийг ашиглан түүнээс ирүүлсэн төслийн саналыг нээх.

5.5.Ажлын хэсэг төслийн санал ирүүлсэн оролцогчийн жагсаалтыг аймаг, нийслэлийн албан ёсны цахим хуудсанд нээлттэй байршуулж, сонгон шалгаруулалтын ил тод байдлыг хангаж ажиллана.

5.6.Сонгон шалгаруулалтад нэг оролцогч төслийн санал ирүүлсэн тохиолдолд тухайн оролцогчтой энэ журмын 6.1.2-т заасны дагуу хэлэлцээ хийнэ.

5.7.Сонгон шалгаруулалтад оролцогчдоос санал ирээгүй, эсхүл үнэлгээгээр шаардлага хангасан оролцогч гараагүй тохиолдолд Ажлын хэсэг сонгон шалгаруулалтын баримт бичгийг сайжруулан шинэчилж, энэ журмын дагуу сонгон шалгаруулалтыг шинээр зохион байгуулна.

Зургаа.Хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах

6.1.Ажлын хэсэг ирүүлсэн төслийн саналуудыг энэ журмын 1 дүгээр хавсралтаар баталсан зааврын дагуу 30 хоногийн хугацаанд сонгон шалгаруулалтын шаардлагыг

хангаж байгаа эсэхийг үнэлэх бөгөөд хамгийн сайн нөхцөлтэй, шаардлага хангасан саналаас эхлэн дарааллуулах байдлаар шалгаруулж, дараах арга хэмжээг авна:

6.1.1.Ажлын хэсэг үнэлгээ хийж, шалгаруулснаас хойш ажлын 5 өдрийн дотор шаардлага хангасан болон хангаагүй оролцогчид мэдэгдэл хүргүүлэх;

6.1.2.энэ журмын 6.2-т заасан гомдол гаргах хугацаа дууссаны дараа хамгийн сайн нөхцөлтэй төслийн саналаар шалгарсан оролцогчоос эхлүүлэн түншлэлийн гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээр хийх мэдэгдэл хүргүүлж, дарааллын дагуу хэлэлцээр хийж, үнэлгээ өгөх бөгөөд тухай бүр тэмдэглэл хөтөлж албажуулна;

6.1.3.хэлэлцээрийн үр дүнд гэрээний нөхцөлийг хамгийн сайн харилцан тохиролцсон нэг оролцогчтой түншлэлийн гэрээ байгуулах, эсхүл гэрээний нөхцөлийг хангасан оролцогч оролцоогүй үндэслэлээр сонгон шалгаруулалтыг хүчингүй болгох дүгнэлт гарган, уг дүгнэлтийг ажлын 5 өдөрт багтаан хийсэн хэлэлцээрийн үр дүн, холбогдох баримт бичгийн хамт аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх;

6.1.4.сонгон шалгаруулалтын үр дүнгийн талаар аймаг, нийслэлийн болон холбогдох бусад цахим хуудсаар нээлттэй мэдээлж, сонгон шалгаруулалтын ил тод байдлыг хангаж ажиллах.

6.2.Энэ журмын 6.1.1-т заасан шаардлага хангаагүй талаар мэдэгдэл хүлээж авсан оролцогч Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 56.1-д заасан маргаан шийдвэрлэх зөвлөлд ажлын 5 өдрийн дотор гомдол гаргах эрхтэй.

6.3.Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга энэ журмын 6.1.2-т заасан хэлэлцээрийн үед тэмдэглэл хөтлөх бөгөөд хэлэлцээрээр тохиролцсон асуудал бүрээр оролцогчид гарын үсэг зурж баталгаажуулна.

6.4.Ажлын хэсэг гэрээний нөхцөл дээр тохиролцоонд хүрээгүй тохиолдолд дараагийн оролцогчтой хэлэлцээр хийнэ. Энэ тохиолдолд тухайн оролцогчтой тохиролцсон гэрээний нөхцөл нь өмнөх хэлэлцээр хийсэн оролцогчийн санал болгосон нөхцөлөөс илүү сайн байх зарчмыг баримтална.

6.5.Төслийн саналын баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, эсхүл иж бүрдэл дутуу ирүүлсэн нь оролцогчийн төслийн саналыг буцаах үндэслэл болно.

Долоо.Түншлэлийн гэрээ байгуулах шийдвэр гаргах

7.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ журмын 6.1.3-т заасан дүгнэлт, хийсэн хэлэлцээрийн үр дүн, холбогдох баримт бичгийг үндэслэн гэрээний нөхцөлийг хамгийн сайн харилцан тохиролцсон нэг оролцогчтой түншлэлийн гэрээ байгуулах дүгнэлтийг түншлэлийн гэрээний төслийн хамт ажлын ажлын 5 хоногт багтаан аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

7.2.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ журмын 7.1-д заасан дүгнэлтийг хэлэлцэж, түншлэлийн гэрээ байгуулах эсэхийг ажлын 10 өдрийн дотор шийдвэрлэнэ. Түншлэлийн гэрээ байгуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд гэрээ байгуулах эрхийг аймаг, нийслэлийн Засаг даргад олгоно.

7.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ журмын 7.2-т заасан шийдвэрийг үндэслэн гэрээний нөхцөлийг хамгийн сайн харилцан тохиролцсон оролцогчид түншлэлийн гэрээ байгуулах мэдэгдлийг ажлын 5 өдрийн дотор хүргүүлж, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулна.

Найм.Бусад

8.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга сонгон шалгаруулалтын явц, үр дүн, шийдвэрийн талаарх мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлж, цахим хуудаст холбогдох мэдээллийг тухай бүр байршуулна.

8.2.Хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулахтай холбоотой гомдол гаргах, маргаан шийдвэрлэх асуудлыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 56, 57 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

-----oOo-----

"Хувийн хэвшлийн түншлэгчийг
сонгон шалгаруулах журам"-ын
Хавсралт 1

ТӨСЛИЙН САНАЛЫГ ҮНЭЛЭХ ЗААВАР

1. Сонгон шалгаруулалтад ирүүлсэн төслийн санал (цаашид "төслийн санал" гэх)-ыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, "Хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах журам", сонгон шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу үнэлж, оролцогчдын дарааллуулсан жагсаалт гаргахад сонгон шалгаруулалтын үнэлгээний зорилго оршино.

2. Төслийн саналыг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

2.1. үндсэн болон тусгайлсан шаардлага;

2.2. техникийн санал;

2.3. санхүүгийн санал.

3. Ажлын хэсэг төслийн саналыг дараах тохиолдолд үнэлэхээс татгалзах бөгөөд үнэлэхээс татгалзсан төслийн саналыг тэнцээгүйд тооцно:

3.1. сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцээгүй, төслийн саналын иж бүрдэл бүрэн бус;

3.2. төслийн санал хуурамч, зарим мэдээллийг нуун дарагдуулсан, эсхүл оролцогч сонгон шалгаруулалтын үед тавигдсан үндсэн шаардлага болон чадварын шалгууртай холбоотой ямар нэг өөрчлөлт гарсныг мэдэгдээгүй, мэдэгдсэн хэдий ч тухайн өөрчлөлт нь оролцогчийг үндсэн шаардлага болон чадварын шалгуурыг хангахгүй болгож байгаа.

4. Төслийн санал үндсэн шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянан үзэж, "шаардлага хангасан/шаардлага хангаагүй" гэсэн үнэлгээг тавина. Зөвхөн "шаардлага хангасан" үнэлгээ авсан төслийн саналд санхүүгийн болон техникийн саналын үнэлгээ хийнэ. "шаардлага хангаагүй" үнэлгээ авсан төслийн саналыг сонгон шалгаруулалтад тэнцээгүйд тооцно.

5. Үндсэн шаардлагыг хангасан эсэхийг дараах мэдээлэл, нотлох баримтыг үндэслэн тогтооно:

5.1. хуулийн этгээд, эсхүл түншлэл, түүний гишүүдийг бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, эсхүл үүсгэн байгуулагдсаныг нотлох түүнтэй адилтгах бусад баримт бичиг;

5.2. төслийн санал гаргагч, эсхүл түншлэл, түүний гишүүдийг төлөөлөх эрх олгосон этгээдийн итгэмжлэл;

5.3. түншлэлийн талуудын хамтран ажиллахаа илэрхийлсэн гэрээний хуулбар;

5.4.төслийн санал гаргагчдад өгөх зааварчилгааны үндсэн шаардлагад дурдагдсан нөхцөл байдал өмнө нь үүсэж байсан бол энэ тухайгаа Ажлын хэсэгт мэдэгдэж, холбогдох байгууллагын гаргасан шийдвэр, тухайн нөхцөл байдал арилсан тухай баримт, нотолгоог ирүүлнэ.

6.Төслийн саналыг үнэлэхэд эхлээд техникийн саналыг, техникийн саналд тэнцсэн оролцогчийн санхүүгийн саналыг үнэлнэ.

7.Төслийн саналыг "Маягт 1.Төслийн саналыг хянах" маягтын дагуу хянана.

8.Техникийн саналын үнэлгээ нь техникийн үзүүлэлт, үйл ажиллагааны үнэлгээ, үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийн үнэлгээ, түншлэлийн гэрээний төслийн ерөнхий нөхцөлийн үнэлгээ, байгаль орчныг хамгаалах шаардлагын үнэлгээ зэргээс бүрдэнэ. Төслийн техникийн саналыг "Маягт 2.Техникийн саналыг үнэлэх" маягтын дагуу үнэлнэ.

9.Техникийн саналын шалгуур үзүүлэлт тус бүрээр 10 хүртэл бүхэл оноо тавьж, авсан оноонуудыг жигнэн нэгтгэх замаар 100 онооноос авах дундаж оноог тооцож гаргана.

10.Техникийн саналын үнэлгээнд 60 буюу түүнээс дээш оноо авсан оролцогчийг тэнцсэнд тооцно.

11.Санхүүгийн саналын үнэлгээ нь санхүүгийн загварын үнэлгээ, төслийн зардлын үнэлгээ, төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, түүний хэлбэр, хэмжээний үнэлгээ, санхүүжилтийн төлөвлөгөөний үнэлгээ, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөний үнэлгээ зэргээс бүрдэнэ. Төслийн саналын санхүүгийн саналыг "Маягт 3. Санхүүгийн саналыг үнэлэх" маягтын дагуу үнэлнэ.

12.Төслийн саналын үнэлгээний нийт оноонд техникийн саналын эзлэх жинг 30-80%, санхүүгийн саналын эзлэх жин 70%-20% байх бөгөөд тухайн төслийн онцлогийг харгалзан нийт оноонд эзлэх жинг Ажлын хэсэг тогтооно.

13.Санхүүгийн саналын шалгуур үзүүлэлт тус бүрээр 10 хүртэл бүхэл оноо тавьж, авсан оноонуудыг жигнэн нэгтгэх замаар 100 онооноос авах дундаж оноог тооцож гаргана.

14.Техникийн болон санхүүгийн саналын үнэлгээний оноог жигнэн нэгтгэж төслийн саналын үнэлгээний оноог гаргана.

15.Хувийн хэвшлийн төсөл санаачлагч этгээд сонгон шалгаруулалтад оролцсон тохиолдолд сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан давуу эрхийн оноог техникийн болон санхүүгийн саналын үнэлгээний нийт оноог жигнэн нэгтгэж гаргасан оноон дээр нэмж тооцно.

16.Ажлын хэсгийн гишүүн тус бүрийн өгсөн оноог нарийн бичгийн дарга нэгтгэн

дундажлан төслийн саналын үнэлгээний оноог гаргана.

17.Төслийн саналын үнэлгээний оноонд үндэслэн оролцогчдын дараалуулсан жагсаалт гаргана.

18.Хувийн хэвшлийн санаачилсан төслийн хувьд тухайн хувийн хэвшлийн төсөл санаачлагчийн сонгон шалгаруулалтад ирүүлсэн саналыг үнэлэхэд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 22.10-т заасны дагуу сонгон шалгаруулалтын баримт бичигт урьдчилан зааж давуу эрхийн оноог олгоно.

19.Үнэлгээнд ашиглах хүснэгтүүд

Хүснэгт 1.Онооны тайлбар

Тайлбар	Оноо
Шалгуурыг хангаагүй	1-4
Зарим шаардагдах туршлага, чадавх байгаа ч зайлшгүй хангах шалгуурыг хангаагүй	5-6
Зайлшгүй хангасан байх шалгуур үзүүлэлтүүдийг хангасан	7-8
Зайлшгүй хангасан байх шалгуур үзүүлэлтүүдээс давсан	9-10

Хүснэгт 2.Техникийн саналыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд

Шалгуур үзүүлэлтүүд	Жин (хувь)
Техникийн үзүүлэлт, үйл ажиллагааны үнэлгээ: Оролцогчийн ирүүлсэн техникийн төлөвлөгөө, түншлэлийн гэрээний хавсралт болох зураг төсөл, техникийн үзүүлэлтүүд, барилгын ажлын төлөвлөгөө, шалгах, хүлээлгэн өгөх төлөвлөгөө, ашиглалтын үеийн засвар, үйлчилгээний төлөвлөгөө, хөрөнгө шилжүүлэх үеийн нөхцөл, тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөө, шилжүүлэн өгөх төлөвлөгөө зэрэгт үндэслэн үнэлгээ хийнэ. Төслийн онцлогоос хамаарч тухайн салбарын хууль тогтоомжоор шаардсан тусгай зөвшөөрөл, мэргэжлийн дүгнэлт, горимын тооцоог техникийн саналд хавсаргана.	(хувь)
Үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж: Оролцогчийн ирүүлсэн түншлэлийн гэрээний хавсралт болох ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, шилжүүлэн өгөх төлөвлөгөө зэрэгт үндэслэн үнэлгээ хийнэ.	(хувь)
Түншлэлийн гэрээний төслийн ерөнхий нөхцөлийн үнэлгээ: Оролцогчийн ирүүлсэн төслийн гэрээнүүдийн төсөлд оруулсан өөрчлөлтийн тоймд үндэслэн үнэлгээ хийнэ.	(хувь)
Байгаль орчныг хамгаалах шаардлага хангаж байгаа эсэх: Оролцогчийн ирүүлсэн түншлэлийн гэрээний хавсралт болох ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн үнэлгээ хийнэ.	(хувь)
Нийт	100

Хүснэгт 3.Санхүүгийн саналыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд

Шалгуур үзүүлэлтүүд ¹	Жин (хувь)
Санхүүгийн загварын үнэлгээ: Оролцогчийн ирүүлсэн санхүүгийн загварт үндэслэн түншлэлийн гэрээний хугацаанд гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний үнэ, төлбөрийн тухайн үеийн нийт хэмжээ, тэдгээрийн өнөөгийн үнэ цэнийг харгалзан үзэж үнэлгээг хийнэ.	(хувь)
Төслийн зардлын үнэлгээ: Оролцогчийн ирүүлсэн төслийн зардлын задаргаанд үндэслэн зураг төсөл, барилгын ажлын өртөг, урсгал зардал, нийт хөрөнгө оруулалтын хэмжээ, өнөөгийн үнэ цэнийг харгалзан үзэж үнэлгээг хийнэ.	(хувь)
Төрөөс үзүүлэх санхүүгийн дэмжлэг, түүний хэлбэр, хэмжээ: Оролцогчийн ирүүлсэн түншлэлийн гэрээний төсөл, санхүүгийн загварт үндэслэн үнэлгээг хийнэ.	(хувь)
Санхүүжилтийн төлөвлөгөө: Оролцогчийн ирүүлсэн санхүүжилтийн төлөвлөгөөнд үндэслэн үнэлгээг хийнэ.	(хувь)
Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөө: Оролцогчийн ирүүлсэн бусад санхүүгийн мэдээлэлд үндэслэн үнэлгээг хийнэ.	(хувь)
Нийт	100

20.Ашиглагдах маягтууд

Маягт 1.Төслийн саналыг хянах

Төслийн нэр: Төслийн дугаар: Огноо, цаг:

Оролцогчийн нэр	Зааварчилгааны дагуу бэлдсэн эсэх	Төслийн саналын бүрдэл бүрэн эсэх	Төслийн саналын мэдүүлэг шаардлага хангаж байгаа эсэх	Төслийн саналын баталгаа шаардлага хангаж байгаа эсэх	Шаардлага хангасан/ Шаардлага хангаагүй
Оролцогч 1					
Оролцогч 2					

Ажлын хэсгийн гишүүн/Дарга/Нарийн бичиг: Нэр: Гарын үсэг

Маягт 2.Техникийн саналыг үнэлэх

Төслийн нэр: Төслийн дугаар: Огноо, цаг:

Техникийн санал		Оролцогч 1		Оролцогч 2	
Шалгуур үзүүлэлт	Жин	оноо	үнэлгээ	оноо	үнэлгээ
Техникийн үзүүлэлт, үйл ажиллагааны үнэлгээ	(хувь)				
Үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж	(хувь)				
Түншлэлийн гэрээний төслийн ерөнхий нөхцөлийн үнэлгээ					
Байгаль орчныг хамгаалах шаардлага хангаж байгаа эсэх					
Техникийн саналын нийлбэр оноо					

Ажлын хэсгийн гишүүн/Дарга/Нарийн бичиг: Нэр: Гарын үсэг

Маягт 3.Санхүүгийн саналыг үнэлэх

Төслийн нэр: Төслийн дугаар: Огноо, цаг:

Санхүүгийн санал		Оролцогч 1		Оролцогч 2	
Шалгуур үзүүлэлт	Жин	оноо	үнэлгээ	оноо	үнэлгээ
Санхүүгийн загварын үнэлгээ	(хувь)				
Төслийн зардлын үнэлгээ	(хувь)				
Санхүүжилтийн төлөвлөгөө	(хувь)				
Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөө	(хувь)				
Санхүүгийн саналын нийлбэр оноо					

Ажлын хэсгийн гишүүн/Дарга/Нарийн бичиг: Нэр: Гарын үсэг

"Хувийн хэвшлийн түншлэгчийг
сонгон шалгаруулах журам"-ын
Хавсралт 2

ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭГЧИЙГ СОНГОХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН УРИЛГА

Огноо:

Сонгон шалгаруулалтын нэр: [төслийн нэр]

Сонгон шалгаруулалтын дугаар: [төслийн дугаар]

[Төрийн түншлэгчийн нэр] нь Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээд, түүний нэгдлийг [төслийн нэр]-ийн [түншлэлийн төрөл] төрлийн сонгон шалгаруулалтад урьж байна.

[Түншлэлийн зүйлийн тодорхойлолт]

Сонгон шалгаруулалтыг нэг үе шаттайгаар цахимаар зохион байгуулна.

Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй этгээд нь [оролцогчид тавих үндсэн шаардлага] чадвартай байна.

Сонгон шалгаруулалтын баримт бичгийг энэхүү урилгын дагуу оролцох хүсэлтээ албан бичгээр цахимаар ирүүлсэн [төлбөр төлсөн] этгээдэд олгоно.

Сонгон шалгаруулалтад оролцох саналыг [оролцох санал хүлээн авах эцсийн хугацаа]-аас өмнө хүлээн авна.

Оролцох санал гаргагчийн сонгон шалгаруулалтын баримт бичгийн дагуу ирүүлсэн саналыг үнэлж, сонгон шалгаруулалтын баримт бичгийн шалгуур үзүүлэлтийг хамгийн сайн хангасан [оролцох санал гаргагчийг хязгаарлах тоо] хүртэлх санал гаргагчийг сонгон шалгаруулалтад оруулна.

Сонгон шалгаруулалтад Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээдийн нэгдэл оролцож болох бөгөөд тус түншлэлийг хэрэгжүүлэх зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл бүхий хуулийн этгээд (төслийн компани)-ийг байгуулж болно.

Сонирхсон этгээд оролцох хүсэлтээ дараах хаягаар ирүүлнэ үү.

[Төрийн түншлэгчийн нэр]

[Хаяг]

[Хариуцах ажилтны нэр]

[Утас, факсын дугаар]

[И-мэйл хаяг]

САНАМЖ

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 13.3-т заасны дагуу хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулахад энэ жишиг баримт бичгийг баримтална.

Энэхүү жишиг баримт бичгийн дагуу төслийн санал боловсруулах бөгөөд зөвхөн сонгон шалгаруулалтын оролцогчдод олгоно.

Энэхүү сонгон шалгаруулалтын жишиг баримт бичгийн санамж болон бүлэг, зүйлийн оноосон нэр нь зөвхөн уг баримт бичгийг ойлгоход хялбар болгох зорилготой.

**ХУВИЙН ХЭВШЛИЙН ТҮНШЛЭГЧИЙГ СОНГОХ
СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЖИШИГ БАРИМТ БИЧИГ**

Сонгон шалгаруулалтын нэр: [төслийн нэр]

Сонгон шалгаруулалтын баримт бичгийн дугаар: [төслийн дугаар]

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН БАРИМТ БИЧГИЙГ

Баталсан: [аймаг, нийслэлийн Засаг дарга]

Боловсруулсан: [ажлын хэсгийн дарга]

[ажлын хэсгийн гишүүд]

[ажлын хэсгийн нарийн бичгийн дарга]

Ажлын хэсгийн хаяг, утас:

Ажлын хэсгийн дарга, нарийн бичгийн даргын цахим шуудан:

ГАРЧИГ

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ.....	15
1.1. Сонгон шалгаруулалтын баримт бичгийн зорилго.....	15
1.2. Нэр томъёоны тайлбар.....	15
1.3. Төслийн танилцуулга.....	16
1.4. Төрийн түншлэгч.....	16
1.5. Зохицуулах байгууллага.....	17
2. ТҮНШЛЭЛИЙН ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ.....	17
2.1. Төслийн үндэслэл.....	17
2.2. Төслийн цар хүрээ, хувийн хэвшлийн үзүүлэх үйлчилгээ.....	17
2.3. Төслийн байршил, газар.....	17
2.4. Байгаль орчин, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдал, ажиллах хүч.....	17
2.5. Шаардлагатай зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл.....	17
2.6. Түншлэлийн төслийн гол хүчин зүйл.....	18
2.7. Аймаг, нийслэлээс үзүүлэх дэмжлэг.....	18
2.8. Ажлын даалгавар.....	18
2.9. Техникийн тодорхойлолт.....	18
3. ОРОЛЦОГЧИД ӨГӨХ ЗААВАР.....	18
3.1. Албан ёсны хэл.....	18
3.2. Цахим харилцаа, ил тод байдал.....	18
3.3. Мэдэгдэл, нотолгоо.....	18
3.4. Оролцогчийн зардал.....	19
3.5. Оролцогчийн батламжлал.....	19
3.6. Сонгон шалгаруулалтын үе шат, хуваарь.....	19
3.7. Оролцох хүсэлт хүлээн авах, оролцогчоор бүртгэх.....	20
3.8. Оролцогчид тавих шаардлага.....	20
3.9. Оролцогчид тавих үндсэн шаардлага.....	20
3.10. Оролцогчид тавих тусгайлсан шаардлага.....	22
3.11. Оролцогч хамтран оролцох.....	22
3.12. Тусгай зориулалтын компани.....	22
3.13. Төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилт.....	23
3.14. Сонгон шалгаруулалтын баримт бичиг олгох, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох.....	23
3.15. Төслийн талбайтай танилцах.....	24
3.16. Оролцогч тодруулга хүсэх.....	24

3.17. Ажлын хэсэг тодруулга хүсэх.....	24
3.18. Төслийн санал хүлээн авахаас өмнөх уулзалт	24
3.19. Төслийн саналын иж бүрдэл.....	25
3.20. Төслийн баталгааны шаардлага.....	25
3.21. Техникийн саналын багц бэлтгэх.....	26
3.22. Санхүүгийн саналын багц бэлтгэх.....	27
3.23. Төслийн саналд нэмэлт өөрчлөлт оруулах, буцаан авах.....	29
3.24. Төслийн санал хүчинтэй байх хугацаа.....	29
3.25. Төслийн санал хүлээн авах	29
3.26. Төслийн санал нээх	30
3.27. Нууцлал	30
4. ТӨСЛИЙН САНАЛЫН ҮНЭЛГЭЭ	30
4.1. Үнэлгээний дараалал.....	30
4.2. Төслийн саналаас татгалзах эрх.....	30
4.3. Давуу эрхийн оноо	31
4.4. Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд.....	31
4.5. Үндсэн шаардлагыг үнэлэх	31
4.6. Техникийн саналын үнэлгээ.....	31
4.7. Санхүүгийн саналын үнэлгээ	32
4.8. Түншлэлийн гэрээ байгуулах хэлэлцээ хийх	33
4.9. Түншлэлийн гэрээг байгуулах зардал болон эрсдэл	33
5. ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭ	34
5.1. Танилцуулга.....	34
5.2. Түншлэлийн гэрээ	34
5.3. Нэмэлт гэрээ	34
6. ХАВСРАЛТУУД	35
6.1. Төслийн саналын маягт.....	35
Маягт 1	35
Маягт 2	36
Маягт 3	37
Маягт 4	38
Маягт 5	39
Маягт 6	40
Маягт 7.....	41
Маягт 8	42

1.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.1.Сонгон шалгаруулалтын баримт бичгийн зорилго

Сонгон шалгаруулалтын баримт бичиг (цаашид “энэхүү баримт бичиг” гэх)-т түншлэлийн төслийн ерөнхий мэдээлэл, дэлгэрэнгүй мэдээлэл, оролцогчид өгөх зааварчилгаа, төслийн саналын үнэлгээ, түншлэлийн гэрээний төсөл болон төслийн саналын маягтуудыг тусгасан болно. Ажлын хэсэг оролцогчоос цахимаар ирүүлсэн төслийн саналыг Төр, хувийн хэвлийн тухай хууль, “Хувийн хэвшлийн түншлэгч болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам”-ын дагуу үнэлж, шалгарсан оролцогчдын жагсаалт гаргаж, хамгийн сайн нөхцөлтэй саналаас эхлүүлэн түншлэлийн гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээ хийж, хувийн хэвшлийн түншлэгчийг шалгаруулахад энэхүү баримт бичгийг ашиглана.

1.2.Нэр томъёоны тайлбар

Энэхүү баримт бичигт тусгаагүй нэр томъёог Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан утгаар ойлгоно.

1.2.1.“түншлэлийн төсөл” гэж Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 13.2-т заасан салбарт хэрэгжүүлэх, тус хуулийн 5.1.22-т тодорхойлсон төсөл (цаашид “төсөл” гэх)-ийг;

1.2.2.“сонгон шалгаруулалт” гэж Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 25 зүйлд заасны дагуу төслийг хэрэгжүүлэх хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулахыг;

1.2.3.“төрийн түншлэгч” гэж Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 16.1.2-т заасан аймаг, нийслэлийн Засаг дарга (цаашид “Засаг дарга” гэх) болон 16.1.3-т заасан бусад этгээдийг;

1.2.4.“сонгон шалгаруулалтын ажлын хэсэг” гэж Засаг даргаас томилж байгуулсан, сонгон шалгаруулалтыг холбогдох журмын дагуу цахим системээр зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг (цаашид “ажлын хэсэг” гэх)-ийг;

1.2.5.“цахим систем” гэж Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 8.2-т заасны дагуу төслийн санал хүлээн авах, бүртгэх, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, мэдээлэл солилцох, мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллагааг гүйцэтгэх цахим систем, цахим шуудан болон бусад цахим хэрэгсэлийг;

1.2.6.“сонгон шалгаруулалтын баримт бичиг” гэж Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 27.1-д заасан шалгуур үзүүлэлтүүд, шаардлагатай бусад мэдээллийг тусган журмаар тогтоосон жишиг баримт бичгийн дагуу ажлын хэсгээс боловсруулан Засаг даргаар батлуулсан сонгон шалгаруулалтын баримт бичиг (цаашид “Сонгон шалгаруулалтын баримт бичиг” гэх)-ийг;

1.2.7."хувийн хэвшлийн түншлэгч" гэж сонгон шалгаруулалтын баримт бичгийн хүрээнд сонгон шалгаруулалтад шалгарч, түншлэлийн гэрээ байгуулсан оролцогч буюу Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.1.26-д заасныг;

1.2.8."гишүүн компани" гэж хувийн хэвшлийн түншлэгчийг бүрдүүлж буй, түүнд орж түншээр ажиллаж хуулийн этгээдийг;

1.2.9."тусгай зориулалтын компани" гэж төслийн хүрээнд түншлэлийн гэрээнд заасны дагуу хувийн хэвшлийн түншлэгчийн үүргийг хүлээж, төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтаар хувийн хэвшлийн түншлэгчээс сонгон шалгаруулалтын үе шатанд буюу түүнээс хойш үүсгэн байгуулсан төслийн компанийг;

1.2.10."зохицуулах байгууллага" гэж төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл олгох, үнэ тариф тогтоох, түншлэлийн зүйл, эсхүл түүгээр үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон дүрэм, журмыг батлах, мөрдүүлэх үүрэг бүхий төрийн байгууллагыг;

1.2.11."оролцох хүсэлт" гэж сонгон шалгаруулалтын урилгын дагуу сонгон шалгаруулалтад оролцохоор Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээд, түүний нэгдлээс ирүүлсэн хүсэлтийг;

1.2.12."төслийн санал" гэж оролцох хүсэлт гаргасан этгээд сонгон шалгаруулалтын баримт бичгийн дагуу бэлтгэн, цахимаар ирүүлсэн төслийн саналыг;

1.2.13."оролцогч" гэж сонгон шалгаруулалтад төслийн санал ирүүлсэн этгээдийг;

1.2.14."түншлэлийн гэрээ" гэж сонгон шалгаруулалтын хүрээнд оролцогчтой түншлэлийн гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээ хийж, шалгарсан хувийн хэвшлийн түншлэгчтэй төслийг хэрэгжүүлэхээр харилцан тохиролцож, талуудын эрх, үүрэг болон бусад нөхцөлийг тусган хууль болон холбогдох журмын дагуу байгуулах иргэний эрх зүйн гэрээг.

1.3.Төслийн танилцуулга

[Төсөл нь улс болон аймаг, нийслэлийн хөгжлийн бодлого, бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр, бүсийн тэргүүлэх чиглэлтэй нийцсэн байна]

[Төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан хууль тогтоомж, бодлого шийдвэр, барилгын ажлыг гүйцэтгэх хугацаа, төсөвлөсөн нийт өртөг гэх мэт мэдээллийг дэлгэрэнгүй тусгах]

1.4.Төрийн түншлэгч

[Төслийн нэр]-ийн төрийн түншлэгч нь [аймаг, нийслэл] байна.

[Аймаг, нийслэлийн танилцуулга, төслийг хэрэгжүүлэх талаар хуулиар олгогдсон эрх, үүргийн танилцуулга, тайлбар]

[Төрийн түншлэгчээс ажлын хэсэг томилсон шийдвэр, ажлын хэсэгт олгогдсон эрх, үүргийн талаар танилцуулга, тайлбар]

[Ажлын хэсгийн хаяг, ажлын хэсгийн нарийн бичгийн дарга болон хариуцсан ажилтны утас, цахим шуудан, цахим системийн мэдээлэл]

1.5.Зохицуулах байгууллагуудын эрх, үүрэг, хариуцлагыг тусгах

[Төслийн нэр]-ийн зохицуулах байгууллагад дараах байгууллага орно:

[Зохицуулах байгууллагуудын нэр]

[Зохицуулах байгууллагуудын төсөлд гүйцэтгэх үүрэг, хууль, эрх зүйн үндэслэл]

2.ТҮНШЛЭЛИЙН ТӨСЛИЙН МЭДЭЭЛЭЛ

2.1.Төслийн үндэслэл

[Төслийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан хууль, төрөөс баримталж байгаа бодлого, шийдвэр гэх мэт мэдээллийг дэлгэрэнгүй оруулах]

2.2.Төслийн цар хүрээ, хувийн хэвшлийн үзүүлэх үйлчилгээ

Хувийн хэвшлийн түншлэгч нь төслийг [Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан түншлэлийн гэрээний төрөл] төрлөөр хэрэгжүүлж [төслийн хүрээнд хийгдэх зураг төсөл, барилгын ажил, хөрөнгө оруулалт, ашиглалтын үйл ажиллагаа, засвар арчлалтын гэх мэт ажлуудыг тодорхойлж бичих] ажлуудыг гүйцэтгэнэ.

Хувийн хэвшлийн түншлэгчийн төслийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь түншлэлийн зүйлийн [зураг төсөл боловсруулах, санхүүжүүлэх, барих, ашиглах болон засварлах гэх мэт батлагдсан түншлэлийн төрлийн дагуу тохирох үйл ажиллагаа] үйл ажиллагаа байх бөгөөд эдгээрийг түншлэлийн гэрээ, дагалдах бусад нэмэлт гэрээнүүдэд нарийвчлан тусгана. Хувийн хэвшлийн түншлэгч нь төслийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг өөрчлөхгүй.

2.3.Төслийн байршил, газар

Төсөл хэрэгжих байршил нь [харьяалагдах засаг захиргааны нэгж]-ийн нутаг дэвсгэр [байрлал, байршил зүйн бусад тодорхойлолт] байна.

Төслийн газрыг хувийн хэвшлийн түншлэгчид [төсөл хэрэгжүүлж эхлэх өдөр] эхлэн [түншлэлийн гэрээний хугацаа] хугацаатай Газрын тухай хуульд заасан нөхцөлөөр олгоно.

[түншлэлийн зүйлийн байршлыг зэргэлдээ газар, газар эзэмшигчдийн мэдээллийн хамт харуулсан газрын зургийг хавсаргах]

2.4.Байгаль орчин, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдал, ажиллах хүч

[Төсөл хэрэгжүүлэхтэй холбогдуулан хувийн хэвшлийн түншлэгчийн дагаж мөрдөх байгаль орчин, эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдал, ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль тогтоомж, стандартын шаардлагуудыг тусгах]

2.5.Шаардлагатай зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл

Хувийн хэвшлийн түншлэгч төсөл хэрэгжүүлэхтэй холбоотойгоор шаардагдах зөвшөөрөл болон тусгай зөвшөөрлийг авах, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн ажиллах үүрэг хүлээнэ.

2.6.Түншлэлийн төслийн гол хүчин зүйл

[Төслийн хэрэгжих хугацаа, санхүүжилтийн төрөл, түншлэлийн зүйлийн талаарх мэдээлэл, түншлэлийн төрөл, төслийн зардлыг санхүүжүүлэх хэлбэр, түншлэлийн гэрээний гол нөхцөлүүд, хувийн хэвшлийн түншлэгчийн эрх үүрэг, эрсдэл хуваарилалт, төслийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр, хэмжээ болон төлөвлөгөө]

2.7.Аймаг, нийслэлээс үзүүлэх дэмжлэг

[Аймаг, нийслэлээс үзүүлэх дэмжлэгийн тухай мэдээлэл]

2.8.Ажлын даалгавар

[Ажлын даалгавар]

2.9.Техникийн тодорхойлолт

Төслийн техникийн шаардлага, дэд бүтцийн мэдээлэл, төлөвлөлт, дизайн, хүлээгдэж буй үр дүн, барилга угсралт, үйл ажиллагаа, ашиглалтын үеийн шаардлага тодорхойлолт, чанарын стандарт, үйлчилгээний шалгуур үзүүлэлт, техник технологийн шалгуур үзүүлэлтүүд.

[техник-эдийн засгийн үндэслэл, бусад судалгааны материалын талаарх мэдээллийг тусгах]

3.ОРОЛЦОГЧИД ӨГӨХ ЗААВАР

3.1.Албан ёсны хэл

Сонгон шалгаруулалттай холбоотой аливаа үйл ажиллагаа явуулах, албан хэрэг хөтлөхөд Монгол хэлний тухай хуульд заасан төрийн албан ёсны хэл болох монгол хэлээр явуулна. Сонгон шалгаруулалттай холбоотойгоор монгол хэлээр харилцах ба шаардлагатай тохиолдолд англи хэлийг ашиглаж болно. Төслийн саналыг монгол болон англи хэлээр бэлтгэж ирүүлж болох бөгөөд зөрүү гарах тохиолдолд монгол хэлийг баримтална.

3.2.Цахим харилцаа, ил тод байдал:

3.2.1.Оролцогч сонгон шалгаруулалтын баримт бичгийн 1.4-т заасан ажлын хэсгийн хаягаар цахимаар харилцаж, ажлын хэсгийн нарийн бичгийн даргад мэдэгдэнэ;

3.2.2.Сонгон шалгаруулалтын талаарх мэдээллийг [аймаг, нийслэлийн] болон холбогдох бусад цахим хуудсанд нээлттэй байршуулж, сонгон шалгаруулалтын ил тод байдлыг хангаж ажиллана.

3.3.Мэдэгдэл, нотолгоо:

3.3.1.Сонгон шалгаруулалтын аливаа мэдээллийг оролцогчдод цахимаар мэдэгдэж, олон нийтэд нээлттэй мэдээлж, цахим хуудсанд байршуулсан тохиолдолд мэдээллийг тухайн хугацаанд нь оролцогчид хүргэсэнд тооцно;

3.3.2.Сонгон шалгаруулалтын баримт бичгийн дагуу оролцогч аливаа мэдээллийг өгсөн тохиолдолд эх сурвалжийг заах буюу холбогдох нотлох баримтыг хавсаргана. Мэдээллийг магадлах зорилгоор төрийн түншлэгчээс тавьсан шаардлагын дагуу оролцогч холбогдох баримт, нотолгоог ажлын хэсэгт ирүүлнэ.

3.4.Оролцогчийн зардал:

3.4.1.Сонгон шалгаруулалтад оролцох, төслийн санал бэлтгэх, ажлын хэсэгт хүргүүлэх болон сонгон шалгаруулалттай холбоотой бусад бүх зардлыг оролцогч өөрөө хариуцна;

3.4.2.Оролцогч сонгон шалгаруулалтад шалгарсан эсэх, сонгон шалгаруулалт амжилттай дууссан эсэхээс үл хамаарч аль ч тохиолдолд төрийн түншлэгч, ажлын хэсэг нь оролцогчоос гаргасан зардлыг нөхөн төлөх үүрэг хүлээхгүй.

3.5.Оролцогчийн батламжлал:

3.5.1.Оролцогч төслийн санал ирүүлснээр Сонгон шалгаруулалтын баримт бичиг, төслийн гэрээнүүдийн төсөлтэй сайтар танилцаж ойлгосон, Монгол Улсын хууль тогтоомжийг судалсан бөгөөд тэдгээр хууль тогтоомжийг дагаж мөрдөх нь төслийн

гэрээний дагуу хийгдэх үйл ажиллагааг гүйцэтгэхэд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй болохыг хүлээн зөвшөөрч, баталгаажуулж байгааг илэрхийлнэ. Оролцогч нь төрийн түншлэгчийн төлөөлөл, эсхүл ажлын хэсгийн гишүүнтэй хийсэн аливаа аман яриа, хэлцэл нь төслийн гэрээний дагуу хүлээсэн нөхцөл, үүргүүдэд нөлөө үзүүлэх буюу өөрчлөлт оруулахгүй гэдгийг хүлээн зөвшөөрнө;

3.5.2.Оролцогч сонгон шалгаруулалтын баримт бичигт тусгасан мэдээллийг өөрийнхөөрөө тайлбарлан ойлгох бөгөөд төрийн түншлэгч, түүний ажилтан, ажлын хэсэг, түүний гишүүн үүнтэй холбогдуулан ямар нэг хариуцлага хүлээхгүй. Оролцогч аливаа баримт бичиг, төслийн талбайг үзэж шалгахдаа алдаа гаргасан, орхигдуулсан байх нь төслийн санал, төслийн гэрээнээс хамааран хүлээх аливаа үүрэг, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

3.6.Сонгон шалгаруулалтын үе шат, хуваарь

3.6.1.Сонгон шалгаруулалтыг нэг үе шаттайгаар дараах хуваарийн¹ дагуу цахимаар зохион байгуулна:

Хийгдэх ажил	Огноо:
Оролцох хүсэлт хүлээн авах, оролцогчоор бүртгэх, сонгон шалгаруулалтын баримт бичиг олгож эхлэх;	[огноо]
Төслийн санал хүлээн авахаас өмнөх уулзалт хийх;	[огноо, цаг]
Төслийн санал хүлээн авах эцсийн хугацаа, төслийн санал нээх;	[огноо, цаг]
Оролцогчдыг үнэлж, шаардлага хангасан эсэх мэдэгдэл хүргүүлэх, оролцогчдын дарааллуулсан жагсаалт гаргах;	[огноо]
Дарааллуулсан жагсаалтын дагуу хамгийн сайн нөхцөлтэй төслийн саналаас эхлүүлэн түншлэлийн гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээ хийж, сонгон шалгаруулах;	[огноо]
Түншлэлийн гэрээний нөхцөлийг хамгийн сайн тохиролцсон нэг оролцогчтой түншлэлийн гэрээ байгуулах дүгнэлт гарган, Засаг даргад хүргүүлэх.	[огноо]

3.7.Оролцох хүсэлт хүлээн авах, оролцогчоор бүртгэх:

3.7.1.Оролцогч сонгон шалгаруулалтын урилгад заасан хугацаа, нөхцөлийн дагуу оролцох хүсэлтийг цахимаар гаргах ба хүсэлтийг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга цахим системийн хугацааны дарааллаар бүртгэж, оролцогчоор бүртгэснийг цахимаар баталгаажуулна;

3.7.2.Техникийн шалтгааны улмаас хугацаа хоцорсон оролцох хүсэлтийг ажлын хэсэг хүлээн авсан нь төслийн санал хүлээн авах эцсийн хугацааг сунгах үндэслэл болохгүй.

¹ Ажлын хэсэг сонгон шалгаруулалтын хуваарьт өөрчлөлт оруулж болох бөгөөд уг өөрчлөлтөө Засаг даргаар батлуулна.

3.8.Оролцогчид тавих шаардлага:

3.8.1.Оролцогч нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 27.1, 27.4-27.6-д заасан үндсэн болон бусад шаардлага, Сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан тусгайлсан шаардлагыг хангасан байна;

3.8.2.Оролцогч нь сонгон шалгаруулалтын шаардлагыг хангасан талаарх баримт, мэдээллийг Сонгон шалгаруулалтын баримт бичгийн дагуу бүрдүүлнэ;

3.8.3.Оролцогч шаардлага хангасан талаарх мэдээлэлд өөрчлөлт гарсан тохиолдолд 5 хоногийн дотор ажлын хэсэгт мэдэгдэх үүрэгтэй. Ажлын хэсэг тухайн өөрчлөлтөөс хамаарч оролцогч шаардлага хангаж байгаа эсэхийг нягтална. Оролцогч тухайн өөрчлөлтийн талаар 5 хоногийн дотор ажлын хэсэгт мэдэгдээгүй, эсхүл нуун дарагдуулсан нь илэрсэн тохиолдолд сонгон шалгаруулалтаас хасах үндэслэл болно;

3.8.4.Оролцогчоос сонгон шалгаруулалтын үед хуурамч мэдээлэл, баримт нотолгоо ирүүлсэн нь илэрсэн тохиолдолд төрийн түншлэгч төслийн саналд үндэслэн байгуулсан аливаа гэрээ, хэлэлцээг цуцлах эрхтэй бөгөөд гэрээ, хэлэлцээг цуцалснаас учирсан хохирлыг оролцогч хариуцна.

3.9.Оролцогчид тавих үндсэн шаардлага

Дараах тохиолдолд оролцогчид тавих үндсэн шаардлагыг хангаагүй гэж үзнэ:

3.9.1.төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа, дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу дээр дурдсантай адилтгах нөхцөл байдал үүссэн;

3.9.2.Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татварын өртэй;

3.9.3.сүүлийн 3 жилийн хугацаанд худалдан авах ажиллагаанд оролцохдоо гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасныг шүүх, эрх бүхий байгууллага тогтоосон;

3.9.4.илт худал мэдээлэл ирүүлснийг эрх бүхий байгууллага тогтоосон;

3.9.5.сонгон шалгаруулалтад хоёр буюу түүнээс дээш оролцогчийн хууль ёсны төлөөлөгч нь нэг этгээд бол;

3.9.6.сүүлийн 3 жилийн хугацаанд Авлигын эсрэг хууль, Өрсөлдөөний тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан авлига, залилан мэхлэх, зохиомол тохиролцоо хийх, айлган сүрдүүлэх үйлдлийн аль нэгэнд холбогдож гэм буруутай нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон;

3.9.7.төслийг хэрэгжүүлэх санхүүгийн чадавх, удирдлага, мэргэжлийн хүний нөөц, техник, технологийн чадвар, ажлын туршлагагүй;

3.9.8.Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу энгийн болон тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх аж ахуйн үйл ажиллагааны хувьд уг зөвшөөрлийг авах шаардлагыг хангаагүй;

3.9.9.сүүлийн 3 жилийн хугацаанд түншлэлийн гэрээг биелүүлээгүй тухай шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарсан;

3.9.10.хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан нь ял шийтгэлтэй, төрийн түншлэгч этгээдийн удирдах албан тушаалтантай нэгдмэл сонирхолтой, эсхүл хамаарал бүхий этгээд, ашиг сонирхлын зөрчилтэй байх;

3.9.11.сонгон шалгаруулалтад оролцогч компанийн эцсийн өмчлөгч болон хараат, охин компани нь харилцан хамааралтай;

3.9.12.сонгон шалгаруулалтад оролцогчид нь Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.6-д заасны дагуу харилцан хамааралтай;

3.9.13.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд орсон;

3.9.14.нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжид заасан ашиг сонирхлын зөрчил үүссэн;

3.9.15.төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээд болон тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан, сонгон шалгаруулалтад оролцсон;

3.9.16.төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээд хувийн хэвшлийн түншлэгч компани, эсхүл тусгай зориулалттай компанийн хувьцаа эзэмшигч болсон.

3.10.Оролцогчид тавих тусгайлсан шаардлага

[Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 27.2-т заасны дагуу тусгайлсан шаардлагыг тогтоож болно]

3.11.Оролцогч хамтран оролцох

3.11.1.Монгол Улсын болон гадаад улсын хуулийн этгээдийн нэгдлээс бүрдсэн түншлэл, консорциум, төслийн баг болон бусад хэлбэртэй хамтрал нь хуулийн этгээд байгуулахгүйгээр, түншээр хамтран ажиллах гэрээний үндсэн дээр сонгон шалгаруулалтад оролцож болох бөгөөд дараах шаардлагыг хангасан байна:

3.11.1.1.түншээр хамтран ажиллах гэрээг байгуулж, бүх гишүүд хамтран болон гишүүд тус тусдаа хүлээх эрх, үүрэг, хариуцлагыг гэрээнд тусгасан байх;

3.11.1.2.аль нэг болон бүх гишүүний нэрийн өмнөөс үүрэг хүлээх, зааварчилгаа хүлээн авах, төрийн түншлэгчтэй харилцах, төлбөр тооцоо хийхэд тэдгээрийг төлөөлөх эрх бүхий нэг гишүүнийг итгэмжлэлээр томилсон байх.

3.11.2.Энэхүү баримт бичгийн 3.11.1-д заасан хамтрал нь түншээр хамтран ажиллах гэрээний үндсэн дээр төсөл хэрэгжүүлэх зорилготой төслийн компани байгуулж сонгон шалгаруулалтад оролцож болох бөгөөд дараах шаардлагыг хангасан байна:

3.11.2.1.төслийн компани, гишүүд хамтдаа болон гишүүд тус тусдаа хүлээх эрх, үүрэг, хариуцлагыг гэрээнд тусгасан байх;

3.11.2.2.төслийн компанийн гүйцэтгэх удирдлагад аль нэг болон бүх гишүүний нэрийн өмнөөс үүрэг хүлээх, зааварчилгаа хүлээн авах, төрийн түншлэгчтэй харилцах, төлбөр тооцоо хийхэд тэдгээрийг төлөөлөх эрхийг итгэмжлэлээр олгосон байх.

3.11.3.Энэ журмын 3.11.1, 3.11.2-т заасан хамтрал, төслийн компанийг нэг оролцогч гэж үзэх ба тухайн оролцогчийн гишүүн нь өөр оролцогчийн гишүүнээр, эсхүл бие даан оролцож болохгүй;

3.11.4.Оролцогч нь төслийн санал ирүүлэхдээ ажлын хэсгийн зөвшөөрлийг урьдчилан авахгүйгээр гишүүдийн бүтэц, зохион байгуулалтыг өөрчилсөн, эсхүл гишүүн нь өөр оролцогчийн гишүүн компаниар төслийн санал ирүүлсэн тохиолдолд сонгон шалгаруулалтаас хасах үндэслэл болно.

/Тайлбар: Сонгон шалгаруулалтын шалгуур үзүүлэлтүүд нь оролцогчдын нэгдлийг бүрдүүлж буй бүх этгээдэд хамаарна/.

3.12.Тусгай зориулалтын компани

3.12.1.Хувийн хэвшлийн түншлэгч, эсхүл түүний нэр дэвшүүлсэн бусад компани сонгон шалгаруулалтын үед тусгай зориулалтын компани байгуулж болох бөгөөд энэ тухай түншлэлийн гэрээнд зааж болно.

3.12.2.Тусгай зориулалтын компанийг хуулийн этгээдээр бүртгүүлснээс хойших хугацаанд компанийн өөрийн хөрөнгийн хэмжээг өөрчлөх, төрийн түншлэгчээс зөвшөөрөл авах дүрэм, журам, эдгээрт зарчмын өөрчлөлт оруулахад дараах нөхцөлийг дагаж мөрднө:

3.12.2.1.төслийн хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангах, цахимаар түргэн шуурхай харилцах, 10 хоногийн дотор эсхүл тогтоосон хугацаанд хариу өгөх, ийнхүү хариу өгөх хугацаа өнгөрснөөс хойш 10 хоног өнгөрсөн тохиолдолд зөвшөөрсөнд тооцох зарчмыг баримтлах;

3.12.2.2.түншлэлийн гэрээний нөхцөлийг сонгон шалгаруулалтын үеийн хэлэлцээгээр харилцан тохиролцсон нөхцөлөөс дордуулахгүй байх;

3.12.3.Төслөөс хамааруулан төслийн бэлтгэл хангах үүднээс газар эзэмших эрх, тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөл болон бусад шаардлагатай эрх, зөвшөөрөл, баримт бичгийг тусгай зориулалтын компанийн нэр дээр авч, түншлэлийн гэрээ байгуулагдсаны дараа тусгай зориулалтын компанийн хувьцааг бүхэлд нь буюу хэсэгчлэн хувийн хэвшлийн түншлэгчид шилжүүлэх нөхцөлтэйгээр тусгай зориулалтын компани байгуулах этгээдээр Төр, хувийн хэвийн түншлэлийн тухай хуулийн 42.6-д заасан компанийг нэр дэвшүүлж болно.

3.13.Төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилт:

3.13.1.Төслийн саналд төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтийг ямар хугацаанд хэрхэн бүрдүүлэх, ямар санхүүгийн арга хэрэгсэл ашиглах талаар заана;

3.13.2.Төслийн нийт өртөгт хууль, журамд заасан захиалагчийн хяналтын зардал, аудитын зардал болон гарч болзошгүй бусад зардал, төсөл хөгжүүлэлт, хяналтын зардлыг оруулан тооцно;

3.13.3.Төслийн хөрөнгө оруулалт, санхүүжилтыг үр ашигтай зохион байгуулах, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах, мэргэжлийн удирдлага, хяналтыг хэрэгжүүлэх үүднээс хөрөнгө оруулалтын сангийн болон бусад бүтцийг ашиглахаар зааж болно;

3.13.4.Төслийн зардлыг төсвөөс, эсхүл төсвөөс болон төслийн орлогоор санхүүжүүлэх холимог төрлөөр хэрэгжүүлэх төслийн хөрөнгийн эх үүсвэр, төсөвт үзүүлэх нөлөөлөл, төсвийн эрсдэлийн талаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл олгоогүйн улмаас оролцогчид учирсан аливаа эдийн болон эдийн бус хохирол, үүрэг, хариуцлага, төлбөр, зардал болон бусад зүйлийг оролцогч өөрөө хариуцна.

3.14.Сонгон шалгаруулалтын баримт бичиг олгох, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох:

3.14.1.Сонгон шалгаруулалтад бүртгүүлсэн оролцогчид сонгон шалгаруулалтын баримт бичгийг цахимаар олгож, олон нийтэд нээлттэй мэдээлж, аймаг, нийслэлийн цахим хуудсанд байршуулна;

3.14.2.Ажлын хэсэг төслийн санал хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас 14-өөс доошгүй хоногийн өмнө Сонгон шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Энэ тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг Засаг даргаар батлуулж, санал хүлээн авах эцсийн хугацааг ажлын 5 өдрөөс багагүй хугацаагаар сунгана;

3.14.3.Сонгон шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлт нь тухайн баримт бичгийн салшгүй хэсэг болох бөгөөд уг нэмэлт өөрчлөлтийг бүх оролцогчид нэгэн зэрэг цахимаар мэдэгдэнэ;

3.14.4.Засаг дарга сонгон шалгаруулалтын аль ч үед сонгон шалгаруулалтын баримт бичгийг хүчингүй болгох эрхтэй бөгөөд үүнээс үүдэн оролцогчид учирсан аливаа зардал, хохирлыг оролцогч өөрөө хариуцахыг хүлээн зөвшөөрч, төслийн санал гаргасан гэж үзнэ.

3.15.Төслийн талбайтай танилцах

3.15.1.Оролцогч төслийн талбай, түүний байршил, орчин тойрны нөхцөл байдалтай газар дээр нь судлан танилцаж, төслийн санал бэлтгэхэд шаардлагатай мэдээллийг гаргуулан авч болно. Төслийн талбайтай газар дээр нь очиж танилцахтай холбогдон гарах аливаа зардал, эрсдэлийг оролцогч хариуцна.

3.16.Оролцогч тодруулга хүсэх

3.16.1.Оролцогч нь аливаа тодруулга авах хүсэлтийг цахимаар ирүүлж, ажлын хэсгийн нарийн бичгийн даргад мэдэгдэнэ. Тодруулга авах хүсэлтийг төслийн санал хүлээн авах эцсийн хугацаанаас хамгийн багадаа 10 хоногийн өмнө ирүүлэх бөгөөд хоцорч ирүүлсэн хүсэлтэд хариу өгөхгүй.

3.16.2.Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь тодруулгын хүсэлтийг ажлын хэсгийн даргад танилцуулах бөгөөд ажлын хэсгийн дарга тодруулгыг бүх оролцогчид зэрэг хүргүүлэх ажлыг зохион байгуулж, цахимаар хүргүүлнэ.

3.16.3.Тодруулгыг хүсэлт гаргасан этгээдийг дурдалгүйгээр бүх оролцогчид зэрэг цахимаар хүргүүлнэ. Тодруулга авах хүсэлтийг төслийн санал хүлээн авах эцсийн хугацаанаас 10 хоногийн өмнө ирүүлэх бөгөөд хоцорч ирсэн хүсэлтэд хариу өгөхгүй.

3.17.Ажлын хэсэг тодруулга хүсэх

3.17.1.ажлын хэсэг төслийн саналтай холбоотой аливаа тодруулга авах хүсэлтийг төрийн түншлэгчийн албан бичгээр оролцогчид цахимаар хүргүүлнэ. Оролцогч нь хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногийн дотор тодруулгыг цахимаар ирүүлнэ.

3.18.Төслийн санал хүлээн авахаас өмнөх уулзалт:

3.18.1.Ажлын хэсэг сонгон шалгаруулалт зарласан хугацаанд төрийн түншлэгч байгууллагатай хамтран нэгээс доошгүй удаа ажиглагчдыг байлцуулан уулзалтыг цахимаар зохион байгуулж, төсөлтэй холбогдох баримт бичгийн талаар мэдээлэл өгч, асуултад хариулж, тодруулга хийнэ;

3.18.2.Төслийн санал хүлээн авахаас өмнөх уулзалт болон төслийн талбайтай танилцахад ажиглагчаар оролцох оролцогчийн төлөөлөгчийн тоог хязгаарлаж болох ба гадаад улсын оролцогч нэг орчуулагчтай оролцож болно. Оролцогч 7 хоногийн өмнө уулзалтад оролцох эсэхээ ажлын хэсэгт цахимаар мэдэгдэх бөгөөд оролцох хүний нэрс, тодруулах асуултын жагсаалтыг ирүүлнэ;

3.18.3.Уулзалтын үеэр өгсөн хариулт нь Сонгон шалгаруулалтын баримт бичгийн 3.16.2-т заасны дагуу цахимаар өгсөн хариулттай зөрсөн тохиолдолд цахимаар өгсөн хариултыг хүчинтэйд тооцно;

3.18.4.Төслийн санал хүлээн авахаас өмнөх уулзалтын үеэр тавигдсан асуултууд тэдгээрийн хариултуудыг багтаасан уулзалтын тэмдэглэлийг бүх оролцогчид цахимаар хүргүүлнэ. Уулзалтад оролцоогүй, уулзалтын үеэр аливаа тодруулга хүсээгүй нь оролцогчийг шаардлага хангаагүйд тооцох үндэслэл болохгүй.

3.19.Төслийн саналын иж бүрдэл

3.19.1.Төслийн санал нь төслийн саналын маягтууд, тэдгээрийн дагалдах хавсралтууд, үндсэн шаардлага хангаагүй нөхцөл байдал үүсэж байсан бол үүссэн нөхцөлийг арилгасан тухай холбогдох баримт, нотолгооноос бүрдэнэ.

3.19.2.Төслийн саналын иж бүрдлийг сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагад нийцүүлэн бэлтгэнэ. Төслийн санал нь дараах иж бүрдэл хэсгээс бүрдэнэ:

- 3.19.2.1.төслийн саналын мэдүүлэг (Маягт 1);
- 3.19.2.2.төслийн саналын баталгаа (Маягт 2);
- 3.19.2.3.техникийн саналын багц;
- 3.19.2.4.санхүүгийн саналын багц.

3.20.Төслийн баталгааны шаардлага

3.20.1.Төслийн саналын баталгаа. Оролцогч [дүн] үнийн дүн бүхий төслийн саналын баталгааг Маягт 2-ын дагуу Монгол Улсын, эсхүл төрийн түншлэгчийн хүлээн зөвшөөрч болох банк, даатгалын байгууллагаас гаргуулж ирүүлнэ. Төслийн саналын баталгаа ирүүлээгүй тохиолдолд төслийн саналыг нээхгүйгээр буцааж үнэлгээнд тэнцээгүйд тооцно. Төслийн саналын баталгааны хүчинтэй хугацаа нь төслийн саналын хүчинтэй байх хугацаатай адил төслийн санал хүлээн авах эцсийн хугацаанаас хойш [.....] хоног байна. Ажлын хэсгээс ирүүлсэн төслийн саналын хүчинтэй байх хугацааг сунгах хүсэлтийг зөвшөөрсөн тохиолдолд төслийн саналын баталгааны хүчинтэй хугацааг шаардлагатай хоногоор сунгаж ажлын хэсэгт оролцогч өөрийн зардлаар хүргүүлнэ.

3.20.2.Оролцогч төслийн саналын хүчинтэй байх хугацааг сунгахаас татгалзсан, эсхүл энэ жишиг баримт бичгийн дагуу шаардсан хугацаанд хариу ирүүлээгүй тохиолдолд төслийн саналаа буцаан татсан гэж үзэж төслийн саналын баталгааг гүйцэтгүүлэхгүй цуцална.

3.20.3.Сонгон шалгаруулалтад шалгараагүй оролцогчийн төслийн саналын баталгааг төслийн санал хүчинтэй байх хугацаа, эсхүл шалгарсан оролцогч түншлэлийн гэрээнд гарын үсэг зурсан хоногийн аль өмнө өдөр цуцална.

3.20.4.Сонгон шалгаруулалтаар шалгарсан оролцогч энэ жишиг баримт бичгийн Маягт 3-т заасны дагуу түншлэлийн гэрээ байгуулах тухай мэдэгдэлд гарын үсэг зуран, гүйцэтгэлийн баталгааг ирүүлмэгц түүний төслийн саналын баталгааг цуцална.

3.20.5.Оролцогч төслийн саналын баталгааны хүчинтэй байх хугацаанд төслийн саналаа буцааж авах тохиолдолд төслийн саналын баталгааг гүйцэтгүүлэх бөгөөд шалгарсан оролцогчийн хувьд энэ жишиг баримт бичигт заасны дагуу түншлэлийн гэрээ байгуулах тухай мэдэгдэлд гарын үсэг зураагүй, эсхүл гүйцэтгэлийн баталгааг ирүүлээгүй тохиолдолд төслийн саналын баталгааг гүйцэтгүүлнэ.

3.21.Техникийн саналын багц бэлтгэх

3.21.1.Техникийн саналыг Microsoft Word файлаар нэг хувь, тооцоолол хийсэн хэсгийг тусад нь томъёотой Microsoft Excel файлаар нэг хувь бэлтгэх ба уг хоёр файлыг нэгтгэж PDF файлаар нэг цахим хувь техникийн саналын багцыг үүсгэнэ. Техникийн саналын багцад орох дээрх гурван (Microsoft Word, Microsoft Excel, PDF) файлыг нууц үгээр хамгаална.

3.21.2.Оролцогчийн ирүүлэх техникийн санал нь тухайн оролцогч төслийн үр дүнд тавигдах шаардлага болон түншлэлийн гэрээний дагуу хувийн хэвшлийн түншлэгчийн зайлшгүй гүйцэтгэх үйл ажиллагааг явуулах чадвартай гэдгийг батлан харуулах шаардлагатай. Техникийн саналд дараах мэдээллийг тусгана:

3.21.2.1.Техникийн төлөвлөгөө. Төслийн үр дүнд тавигдах шаардлагыг хэрхэн хангах талаар техникийн төлөвлөгөө, бусад нэмэлт мэдээллийг тусгах;

3.21.2.2.Түншлэлийн гэрээний төсөлд оруулсан өөрчлөлт. Түншлэлийн гэрээний төсөлд оруулсан өөрчлөлт, өөрчлөлт оруулсан үндэслэлийг тайлбарлах;

3.21.2.3.Түншлэлийн гэрээний төслийн хавсралтууд. Түншлэлийн гэрээний төслийн дараах хавсралтыг бэлтгэж ирүүлнэ:

3.21.2.3.1. зураг төсөл, техникийн үзүүлэлт;

3.21.2.3.2. барилгын ажлын төлөвлөгөө;

3.21.2.3.3. шалгах, хүлээлгэн өгөх төлөвлөгөө;

3.21.2.3.4. ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө (байгаль орчныг хамгаалах арга хэмжээг тусгасан байх);

3.21.2.3.5. засвар, арчлалтын төлөвлөгөө;

3.21.2.3.6. шилжүүлэн өгөх төлөвлөгөө.

3.21.2.4. Бусад мэдээллүүд. Оролцогчийн зүгээс шаардлагатай гэж үзсэн бусад нэмэлт мэдээлэл, лавлагаа.

3.22. Санхүүгийн саналын багц бэлтгэх

3.22.1. Санхүүгийн саналыг Microsoft Word файлаар нэг хувь, тооцоолол хийсэн хэсгийг тусад нь томъёотой Microsoft Excel файлаар нэг хувь бэлтгэх ба уг хоёр файлыг нэгтгэж PDF файлаар нэг цахим хувь санхүүгийн саналын багцыг үүсгэнэ. Санхүүгийн саналын багцад орох дээрх гурван (Microsoft Word, Microsoft Excel, PDF) файлыг нууц үгээр хамгаална.

3.22.2. Оролцогчийн ирүүлэх санхүүгийн санал нь тухайн оролцогч түншлэлийн гэрээний дагуу хувийн хэвшлийн түншлэгчийн зайлшгүй гүйцэтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх боломжтойг нотлон харуулах шаардлагатай. Санхүүгийн саналд дараах мэдээллийг тусгана:

3.22.2.1. Төслийн зардлын задаргаа. Төслийн хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны зардлын дэлгэрэнгүй задаргаа;

3.22.2.2. Санхүүжилтийн төлөвлөгөө. Оролцогч төслийн санхүүжилтийн дэлгэрэнгүй төлөвлөгөөг Маягт 7-ын дагуу бэлтгэж ирүүлнэ. Санхүүжилтийн төлөвлөгөөнд хувь эзэмшигч бүрээр өөрийн хөрөнгийг харуулсан задаргаа, зээлийн хөрөнгийг санхүүжүүлэгч бүрээр харуулсан задаргаа, зээлийн эргэн төлөлтийн хуваарь, зээлийн хүү болон бусад төлбөр хураамжийг дэлгэрэнгүй тусгана. Санхүүжилтийн төлөвлөгөө нь түншлэлийн гэрээний нийт хугацааг хамарсан байна;

3.22.2.3. Санхүүгийн загвар. Дараах шаардлагыг хангасан байна:

3.22.2.3.1. түншлэлийн гэрээ, бусад нэмэлт гэрээ, санхүүжилтийн төлөвлөгөөтэй уялдаатай байх;

3.22.2.3.2. Microsoft Excel файлаар бэлтгэсэн, дэлгэрэнгүй тайлбартай байх;

3.22.2.3.3. санхүүгийн загварын суурь огноо нь [тоо] байх;

3.22.2.3.4. барилгын ажлын үед сар бүрээр, түүнээс хойш хагас жилээр огноог оруулж, жилийн тоймыг жил тус бүрээр түншлэлийн гэрээний хугацааны турш харуулсан байх;

3.22.2.3.5. бүх тоон өгөгдлийг нэрлэсэн, бодит үнээр харуулсан байх (тооцоонд ашиглах хөнгөлөлтийн хувь [хувь] байна);

3.22.2.3.6. санхүүгийн загвар нь дараах зүйлсийг харуулах боломжтой байна:

- Инфляцын таамаглал;
- Гадаад валютын ханшийн нөлөө, төгрөгийн ханшны тооцоо;
- Санхүүгийн загварт тусгасан татваруудын тодорхойлолт, тайлбар;
- Төслийн санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалтын хүснэгт;
- Хөрөнгө оруулалтын зардлын задаргаа;
- Төсөл эхлэлтийн зардал;
- Зээлийн санхүүжилтийн хувьд санхүүжүүлэгч бүрээр зээлийн үйлчилгээний хуваарь;
- Нийт хөрөнгө оруулалт;
- Үйл ажиллагааны зардлын тооцоо;
- Засвар арчлалтын зардлын тооцоо;
- Баланс, орлого үр дүн, мөнгөн урсгалын тооцоо;
- Гадаад валютаар тооцоо хийгдэх бүтээгдэхүүн, үйлчилгээ;
- Бүх төрлийн татваруудын таамаглал, татварыг тооцох, үл тооцох тохиолдлуудыг харуулах боломжтой байх;
- Энэхүү баримт бичигт тусгасан хөнгөлөлтийн хувиар тооцсон бодит орлогын өнөөгийн үнэ цэн;
- Татварын өмнөх болон татварын дараах бодит болон нэрлэсэн өгөөжийн дотоод хувь;
- Бодит болон нэрлэсэн өөрийн хөрөнгийн өгөөж;
- Хөрөнгө оруулалтын зардлын мэдрэмжийн шинжилгээ;
- Үйл ажиллагааны зардлын мэдрэмжийн шинжилгээ;
- Хүүгийн мэдрэмжийн шинжилгээ;
- Зээлийн хугацааны мэдрэмжийн шинжилгээ;
- Инфляцын мэдрэмжийн шинжилгээ;
- Төгрөгийн ханшийн өөрчлөлт, валютын ханшийн өөрчлөлтийн мэдрэмжийн шинжилгээ;
- Өр, өөрийн хөрөнгийн харьцаа;
- Санхүүжүүлэгчийн шаардсан бусад харьцаанууд.

3.22.3.Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөний танилцуулга. Оролцогч тус төслийг хэрэгжүүлснээр улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөний талаар дэлгэрэнгүй мэдээллийг бэлтгэж ирүүлнэ.

3.22.4.Бусад санхүүгийн мэдээлэл. Оролцогч энэхүү баримт бичгийн Хавсралтад заасан Маягт 4-ийн дагуу бэлтгэсэн Зээл олгохыг зөвшөөрсөн тухай мэдэгдэл, Маягт 5-ын дагуу бэлтгэсэн Хөрөнгө оруулах тухай мэдэгдлийг шаардлагатай тоо хэмжээгээр бэлтгэж ирүүлнэ.

3.23.Төслийн саналд нэмэлт өөрчлөлт оруулах, буцаан авах

3.23.1.Оролцогч нь төслийн санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө өөрийн хүргүүлсэн төслийн саналдаа нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Ийнхүү нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд төслийн санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө нэмэлт, өөрчлөлт оруулсан төслийн саналыг өмнөх саналыг хүчингүйд тооцсон мэдэгдлийн хамт цахимаар ирүүлж, ажлын хэсгийн нарийн бичгийн даргад мэдэгдэнэ.

3.23.2.Оролцогч өөрийн төслийн саналыг буцаан авах хүсэлтийг төслийн санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө хэдийд ч цахимаар мэдэгдэж болно. Ажлын хэсэг төслийн саналаа буцаан авах хүсэлтэд үндэслэн оролцогчийн төслийн саналыг нээлгүйгээр буцаасан талаар цахимаар мэдэгдсэнээр төслийн саналыг буцаан авсанд тооцно.

3.24.Төслийн санал хүчинтэй байх хугацаа

3.24.1.Оролцогчийн ирүүлсэн төслийн санал нь төслийн санал хүлээн авах эцсийн хугацаанаас хойш [хугацаа] хоног хүчинтэй байна. Энэ хугацаанд түншлэлийн гэрээнд гарын үсэг зурж амжаагүй бол ажлын хэсэг төслийн санал хүчинтэй байх хугацаа дуусахаас 10-аас доошгүй хоногийн өмнө оролцогчдод төслийн санал хүчинтэй байх хугацааг сунгах, ямар хугацаагаар сунгах талаар цахимаар мэдэгдэж хүчинтэй байх хугацааг сунгаж болно.

3.24.2.Оролцогч төслийн санал хүчинтэй байх хугацааг сунгахыг зөвшөөрсөн тохиолдолд төслийн санал хүчинтэй байх хугацааг сунгах тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор зөвшөөрсөн тухай мэдэгдлийг хүчинтэй хугацааг шаардлагатай хугацаагаар сунгасан төслийн саналын баталгааны хамт ирүүлнэ. Төслийн саналын хүчинтэй байх хугацааг сунгахаас татгалзсан, эсхүл шаардсан хугацаанд хариу ирүүлээгүй тохиолдолд төслийн саналыг буцаан татсанд тооцно.

3.25.Төслийн санал хүлээн авах

3.25.1.Оролцогч санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө төслийн саналаа нууц үгээр хамгаалан сонгон шалгаруулалтын баримт бичгийн 1.4-т заасан ажлын хэсгийн нарийн бичгийн дарга болон хариуцсан ажилтны хаягаар цахимаар ирүүлж, ажлын хэсгийн нарийн бичгийн даргад мэдэгдэнэ.

3.25.2.Оролцогч нь нууц үгийг төслийн санал нээх үед ажлын хэсэгт өгөх ба төслийн санал авах эцсийн хугацаанаас хоцорсон, нууц үгээр хамгаалаагүй төслийн саналыг хүлээж авахгүй.

3.25.3.Сонгон шалгаруулалтад нэг буюу түүнээс дээш оролцогч төслийн санал ирүүлсэн тохиолдолд тухайн оролцогчийг сонгон шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу үнэлж, түншлэлийн гэрээ байгуулах хэлэлцээ хийнэ.

3.26.Төслийн санал нээх

3.26.1.Төслийн саналыг нээх ажиллагааг төслийн санал хүлээн авах эцсийн хугацаа дууссан өдөр ажиглагчдыг байлцуулан цахимаар зохион байгуулж, дараах ажиллагааг хийнэ:

3.26.1.1.төслийн санал хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө ирүүлсэн болон хугацаа хоцорсон төслийн саналыг тодорхойлох, оролцогчдын жагсаалт гаргах;

3.26.1.2.оролцогчоос ирүүлсэн төслийн саналын нууц үгийг хүлээн авч, төслийн саналыг нээх.

3.26.2.Төслийн санал нээсний дараа оролцогчдын жагсаалтыг аймаг, нийслэлийн болон холбогдох бусад цахим хуудсанд нээлттэй байршуулж, сонгон шалгаруулалтын ил тод байдлыг хангаж ажиллана.

3.27.Нууцлал

3.27.1.Ажлын хэсэг нь төслийн саналд ирүүлсэн аливаа мэдээллийг шалгах, үнэлэх зорилгоор зохицуулах байгууллага, зөвлөхүүдэд танилцуулах эрхтэй. Төрийн түншлэгч, ажлын хэсэг, төслийн саналын мэдээлэлтэй танилцсан бусад этгээд нь оролцогчийн төслийн саналд ирүүлсэн мэдээллийг шалгах, үнэлэхээс бусад зорилгоор задруулахыг хориглоно.

3.27.2.Сонгон шалгаруулалт явагдаж дуусмагц оролцогчийн ирүүлсэн төслийн саналыг зохих журмын дагуу сонгон шалгаруулалтын хавтаст хэргийн хамт архивд шилжүүлнэ.

4.ТӨСЛИЙН САНАЛЫН ҮНЭЛГЭЭ

4.1.Үнэлгээний дараалал

4.1.1.Төслийн саналыг "Хувийн хэвшлийн түншлэгчийг болон зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах журам"-ын дагуу үнэлэх бөгөөд эхлээд техникийн саналыг үнэлнэ. Үнэлгээгээр техникийн санал нь тэнцсэн оролцогчдын санхүүгийн саналыг үнэлж, дараалуулсан жагсаалтыг гаргана.

4.1.2.Ажлын хэсэг төслийн саналыг үнэлж, шаардлага хангасан эсэх мэдэгдлийг оролцогчид хүргүүлж, оролцогчдын үнэлгээний дарааллуулсан жагсаалт гаргах бөгөөд хамгийн сайн нөхцөлтэй саналаас эхлүүлэн түншлэлийн гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээ хийнэ.

4.2.Төслийн саналаас татгалзах эрх

4.2.1.Ажлын хэсэг нь оролцогчийн төслийн санал худал хуурмаг, бүрэн бус, зарим мэдээллийг нуун дарагдуулсан гэж үзсэн, эсхүл оролцогчид сонгон шалгаруулалтын үед тавигдсан ерөнхий шаардлага болон чадварын шалгууртай холбоотой ямар нэг өөрчлөлт гарсныг сонгон шалгаруулалтын ажлын хэсэгт мэдэгдээгүй, эсхүл мэдэгдсэн боловч сонгон шалгаруулалтын ажлын хэсэг тухайн өөрчлөлт нь оролцогчийг ерөнхий шаардлага болон чадварын шалгуурыг хангахгүй болгож байгаа гэж үзэх тохиолдолд тухайн төслийн саналаас татгалзах эрхтэй байна.

4.2.2.Төслийн саналыг хянан үзэх, үнэлэх явцад оролцогчоос нөлөөлөх гэсэн аливаа оролдлого нь тухайн оролцогчийн төслийн саналаас татгалзах үндэслэл болж болно.

4.3.Давуу эрхийн оноо

4.3.1.[Ажлын хэсэг давуу эрхийн оноог хэрхэн тооцож олгох талаар энэ хэсэгт оруулна.]

4.4.Үнэлгээний шалгуур үзүүлэлтүүд:

4.4.1.үндсэн шаардлага;

4.4.2.техникийн саналыг үнэлэх шалгуур;

4.4.3.санхүүгийн саналыг үнэлэх шалгуур.

4.4.4.Ажлын хэсэг нь оролцогчийн төслийн саналын үнэлгээнд авсан нийлбэр дүнг гаргахдаа техникийн болон санхүүгийн саналын үнэлгээний дүнг жигнэн нэгтгэж тооцно. Техникийн саналын үнэлгээний нийт оноонд эзлэх жин [...], санхүүгийн саналын үнэлгээний нийт оноонд эзлэх жин [...] байна.

4.5.Үндсэн шаардлагыг үнэлэх

4.5.1.Оролцогч нь үндсэн шаардлагыг хангасан эсэхийг дараах мэдээлэл, нотлох баримтад үндэслэн тогтооно:

4.5.1.1.хуулийн этгээд, эсхүл гишүүн компанийн бүртгүүлсэн газар, бизнесийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, хаягийг тодорхойлсон улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, эсхүл үүсгэн байгуулагдсаныг нотлох түүнтэй адилтгах бусад баримт бичиг;

4.5.1.2.оролцогч, эсхүл хувийн хэвшлийн түншлэгч, түүний гишүүн компаниудыг төлөөлөх эрх олгосон этгээдийн итгэмжлэл;

4.5.1.3.хамтран оролцогчдын хувьд талууд хамтран ажиллахаа илэрхийлсэн түншээр хамтран ажиллах гэрээний хуулбар;

4.5.1.4.үндсэн шаардлага хангаагүй нөхцөл байдал үүсэж байсан бол энэ тухайгаа ажлын хэсэгт мэдэгдэж, холбогдох эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэр, тухайн нөхцөл байдал арилсан тухай холбогдох баримт, нотолгоо.

4.5.2.Төслийн санал бүрэн эсэх, зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлсэн эсэх, оролцогчдод тавих ерөнхий шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгаж, "шаардлага хангасан/шаардлага хангаагүй" гэсэн үнэлгээ тавина. Зөвхөн "шаардлага хангасан" үнэлгээ авсан төслийн саналд техникийн болон санхүүгийн саналыг үнэлнэ. "шаардлага хангаагүй" үнэлгээ авсан төслийн саналыг сонгон шалгаруулалтад тэнцээгүйд тооцно.

4.6.Техникийн саналын үнэлгээ

4.6.1.Оролцогчийн ирүүлсэн техникийн санал бүрэн бус бол техникийн саналын үнэлгээгээр тэнцээгүйд тооцно. Техникийн саналыг шалгуур үзүүлэлт тус бүрээр оноогоор үнэлнэ. Техникийн саналын үнэлгээгээр тэнцэхийн тулд шалгуур үзүүлэлтүүдийн оноог жигнэн нэгтгэсний дараа дундаж оноо хамгийн багадаа 60 байна.

Техникийн саналыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийн хүснэгт*

Шалгуур үзүүлэлтүүд	Жин (хувь)
Техникийн үзүүлэлт, үйл ажиллагааны үнэлгээ: Оролцогчийн ирүүлсэн техникийн төлөвлөгөө, Түншлэлийн гэрээний хавсралт болох зураг төсөл, техникийн үзүүлэлтүүд, барилгын ажлын төлөвлөгөө, шалгах, хүлээлгэн өгөх төлөвлөгөө, ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, Засвар, арчлалтын төлөвлөгөө, Шилжүүлэн өгөх төлөвлөгөө зэрэгт үндэслэн үнэлгээг хийнэ	(хувь)

Үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж: Оролцогчийн ирүүлсэн Түншлэлийн гэрээний хавсралт болох Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, Шилжүүлэн өгөх төлөвлөгөө зэрэгт үндэслэн үнэлгээг хийнэ	(хувь)
Түншлэлийн гэрээний төслийн ерөнхий нөхцөлийн үнэлгээ: Оролцогчийн ирүүлсэн төслийн гэрээнүүдийн төсөлд оруулсан өөрчлөлтийн тоймд үндэслэн үнэлгээг хийнэ	(хувь)
Байгаль орчныг хамгаалах шаардлага хангаж байгаа эсэх: Оролцогчийн ирүүлсэн Түншлэлийн гэрээний хавсралт болох Ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндэслэн үнэлгээг хийнэ	(хувь)

*Техникийн болон санхүүгийн санал үнэлэх шалгуур үзүүлэлтүүдэд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасны дагуу шаардлагатай гэж үзсэн бусад шалгуур үзүүлэлтийг нэмж болно.

4.7.Санхүүгийн саналын үнэлгээ

4.7.1.Санхүүгийн саналыг үнэлэх шалгуур үзүүлэлт тус бүрээр оноогоор үнэлж, авсан оноонуудыг жигнэн нэгтгэх замаар дундаж оноог тооцож гаргана.

Санхүүгийн саналыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийн хүснэгт*

Шалгуур үзүүлэлтүүд	Жин (хувь)
Санхүүгийн загварын үнэлгээ: Оролцогчийн ирүүлсэн Санхүүгийн загварт үндэслэн түншлэлийн гэрээний хугацаанд гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний үнэ, төлбөрийн тухайн үеийн нийт хэмжээ, тэдгээрийн өнөөгийн үнэ цэнийг харгалзан үзэж үнэлгээг хийнэ	(хувь)
Төслийн зардлын үнэлгээ: Оролцогчийн ирүүлсэн Төслийн зардлын задаргаанд үндэслэн зураг төсөл, барилгын ажлын өртөг, урсгал зардал, нийт хөрөнгө оруулалтын хэмжээ, өнөөгийн үнэ цэнийг харгалзан үзэж үнэлгээг хийнэ	(хувь)
Санхүүжилтийн төлөвлөгөө: Оролцогчийн ирүүлсэн Санхүүжилтийн төлөвлөгөөнд үндэслэн үнэлгээг хийнэ	(хувь)
Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөө: Оролцогчийн ирүүлсэн тус төслийг хэрэгжүүлснээр улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөний танилцуулгад үндэслэн үнэлгээг хийнэ	(хувь)

*Техникийн болон санхүүгийн санал үнэлэх шалгуур үзүүлэлтүүдэд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасны дагуу шаардлагатай гэж үзсэн бусад шалгуур үзүүлэлтийг нэмж болно.

4.8.Түншлэлийн гэрээ байгуулах хэлэлцээ хийх

4.8.1.Ажлын хэсэг нь дараалуулсан жагсаалтын эхний оролцогчийг түншлэлийн болон холбогдох бусад гэрээний нөхцөлийн талаар хэлэлцээнд урина. Дараалуулсан жагсаалтын эхний оролцогчтой хэлэлцээ хийгээд гэрээний нөхцөлийг харилцан тохирч чадаагүй тохиолдолд жагсаалтын дараагийн оролцогчийг хэлэлцээнд урьж болно.

4.8.2.Ажлын хэсэг хэлэлцээ, үнэлгээний үр дүнд гэрээний нөхцөлийг хамгийн сайн харилцан тохиролцсон нэг оролцогчтой түншлэлийн гэрээ байгуулах дүгнэлт гарган, ажлын 5 өдөрт багтаан холбогдох баримт бичгийн хамт Засаг даргад хүргүүлж, сонгон шалгаруулалтын үр дүнгийн талаар [аймаг, нийслэлийн] болон холбогдох бусад цахим хуудсаар нээлттэй мэдээлж, сонгон шалгаруулалтын ил тод байдлыг хангаж ажиллана.

4.8.3.Засаг дарга түншлэлийн гэрээний нөхцөлийг хамгийн сайн харилцан тохиролцсон нэг оролцогчтой гэрээ байгуулах дүгнэлтийг түншлэлийн гэрээний төслийн хамт [аймаг, нийслэлийн] иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэн, түншлэлийн гэрээ байгуулах зөвшөөрөл авсан тохиолдолд тухайн оролцогчид түншлэлийн гэрээ байгуулах тухай мэдэгдэл ирүүлэх хүсэлтийг хүргүүлнэ.

4.8.4.Хүсэлт явуулсан өдрөөс хойш 10 (арав) хоногийн дотор түншлэлийн гэрээ байгуулах тухай мэдэгдлийг Маягт 3-ын дагуу гаргаж гүйцэтгэлийн баталгааны хамт ирүүлнэ.

4.8.5.Түншлэлийн гэрээг байгуулахаас өмнө тусгай зориулалтын компанийг байгуулаагүй тохиолдолд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах бөгөөд дараах баримт бичгийн баталгаажуулсан хуулбарыг ажлын хэсэгт ирүүлнэ:

4.8.5.1.Компанийн гэрчилгээ, үүсгэн байгуулах шийдвэр, дүрэм;

4.8.5.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн нэрсийн жагсаалт;

4.8.5.3.Бүртгэгдсэн ажлын байрны байршил.

4.9.Түншлэлийн гэрээг байгуулах зардал болон эрсдэл

4.9.1.Шалгарсан оролцогч нь түншлэлийн гэрээний хэлэлцээ хийх болон эцэслэн зурахтай холбогдон гарах аливаа зардал, мэргэжлийн зөвлөхийн зардал, бусад зардлыг бүрэн хариуцна. Төрийн түншлэгч, зохицуулах байгууллага, ажлын хэсэг, түүний гишүүд, тэдгээрийн төлөөлөгчдийн өгсөн мэдээлэл болон төсөлтэй холбогдуулан гаргасан оролцогчийн шийдвэрт аливаа хариуцлага хүлээхгүй.

4.10.Түншлэлийн гэрээ цуцалсны дараа хэлэлцээ хийх

4.10.1.Хувийн хэвшлийн түншлэгч төслийн саналаасаа татгалзсан, Түншлэлийн гэрээ байгуулсны дараа хууль, журам, Түншлэлийн гэрээнд заасны дагуу нэмэлт гэрээ, хавсралтуудыг байгуулаагүй болон бусад шалтгааны улмаас түншлэлийн гэрээг цуцалсан, дуусгавар болгосон тохиолдолд энэ баримт бичгийн 4.8.1-д заасны дагуу жагсаалтын дараагийн оролцогчийг хэлэлцээнд урьж, 4.8.2, 4.8.3-т заасан арга хэмжээг авч болно.

5.ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭ

5.1.Танилцуулга

5.1.1.Түншлэлийн гэрээ нь түншлэлийн [гэрээ, бусад нэмэлт] гэрээнээс бүрдэнэ. Сонгон шалгаруулалтын баримт бичигт төсөл хэрэгжүүлэх нөхцөлийг тусгасан түншлэлийн гэрээний төслийг [бусад нэмэлт гэрээнүүдийн төслийн хамт] (Хавсралт ...) хавсаргав.

5.1.2.Оролцогч нь түншлэлийн гэрээний [төсөл болон бусад нэмэлт гэрээний] төсөлд үндэслэн төслийн саналаа боловсруулж ирүүлэх бөгөөд зохих мэдээлэл, шаардлагатай

өөрчлөлтийг оруулсан төслийн гэрээний төсөл, оруулсан өөрчлөлтийн тоймыг техникийн саналд тусгана.

5.1.3.Оролцогчийн ирүүлсэн түншлэлийн гэрээний төсөл нь сонгон шалгаруулалтын баримт бичгийн түншлэлийн гэрээний төслөөс эрс өөрчлөгдсөн тохиолдолд төслийн саналыг үнэлэхэд оноог бууруулж тооцох үндэслэл болж болно.

5.2.Түншлэлийн гэрээ

5.2.1.Төрийн түншлэгч нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 11.1.5-д заасан гэрээ байгуулах зөвшөөрөл авч, шалгарсан оролцогчтой түншлэлийн гэрээг байгуулна. Шалгарсан оролцогч түншлэлийн гэрээг байгуулснаар хувийн хэвшлийн түншлэгч болно.

[Түншлэлийн гэрээнд түншлэлийн гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөлийг заана.]

5.3.Нэмэлт гэрээ

[Төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх, баталгаа гаргах, шаардлагатай зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл авах, газар чөлөөлөхөд дэмжлэг үзүүлэх гэх мэт Түншлэлийн гэрээнд тусгасан нөхцөлтэй уялдуулан төрийн байгууллагатай нэмэлт гэрээ байгуулах шаардлагатай гэж үзвэл тодорхойлж бичих. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан болон бусад асуудлаар төрийн түншлэгч, хувийн хэвшлийн түншлэгч, аливаа гуравдагч этгээд хооронд нэмэлт гэрээ байгуулах шаардлагатай гэж үзвэл тодорхойлж бичих.]

6.ХАВСРАЛТУУД

6.1.Төслийн саналын маягт

Маягт 1.Төслийн саналын мэдүүлэг

Огноо:

Хэнд: [Эрх бүхий этгээдийн нэр]

[Сонгон шалгаруулалтын баримт бичгийн дугаар]

[Төслийн нэр]

ТӨСЛИЙН САНАЛЫН МЭДҮҮЛЭГ

Бид сонгон шалгаруулалтын баримт бичиг, түүний бүх хавсралт, тэдгээрт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг бүрэн хүлээн авсан бөгөөд эдгээртэй сайтар танилцаж, бүрэн ойлгосон гэдгээ үүгээр нотолж байна.

Бид сонгон шалгаруулалтын баримт бичигт тусгасан шаардлагуудад нийцүүлэн, оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу, төслийн саналаа үнэн зөв, бүрэн гүйцэд бэлтгэсэн бөгөөд, төслийн санал нь төслийн санал хүлээн авах эцсийн хугацаанаас хойш [төслийн санал хүчинтэй байх хугацааг бичих] хоног хүртэл хүчинтэй, үл буцаах гэдгийг баталж, үүгээр хүргүүлж байна.

Сонгон шалгаруулалтыг дуусах хүртэл бидэнтэй харилцах хаяг:

[Оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр, холбоо барих хаяг]

Хүндэтгэсэн,

[Оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр, албан тушаал, гарын үсэг]

Хавсралт:

- Төслийн саналын баталгаа;
- Техник-эдийн засгийн үндэслэл;
- Техникийн саналын багц;
- Санхүүгийн саналын багц.

Маягт 2.Төслийн саналын баталгаа

Огноо:

Хэнд: [Эрх бүхий этгээдийн нэр]

[Сонгон шалгаруулалтын баримт бичгийн дугаар]

[Төслийн нэр]

ТӨСЛИЙН САНАЛЫН БАТАЛГАА

[Банк, даатгалын байгууллагын нэрийг бичих] банк нь Танай зарласан сонгон шалгаруулалтын жишиг баримт бичгийн 3.20.1 -д заасны дагуу [Оролцогчийн нэр] (цаашид "Оролцогч" гэх)-ийн төслийн саналд [төслийн саналын баталгааны үнийн дүн] төгрөгийн үл буцаах баталгааг дараах нөхцөлийн дагуу гаргаж байна:

1.Танай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг хүлээн авснаар оролцогч, эсхүл аливаа гуравдагч этгээдийн эсэргүүцлээс үл хамааран, тус баталгааг гүйцэтгүүлэх эрхтэй эсэх талаар нотолгоо шаардахгүйгээр дээр дурдсан үнийн дүнг танай заасан аль ч банкны дансанд нэн даруй шилжүүлэх буюу танай хүссэн хэлбэрээр төлөх болно.

2.Энэхүү баталгааг гаргаснаар бид үл маргалдах, үл буцах шууд үүргийг хүлээж байгаа бөгөөд ямар ч шалтгаанаар энэхүү үүргээсээ чөлөөлөгдөхгүй болно.

3.Энэхүү баталгаа нь [Төслийн санал хүчинтэй байх эцсийн хугацаа] өдрийг хүртэл хүчинтэй байх бөгөөд хүчинтэй хугацаа дуусахаас өмнө танайхаас гарын үсэг зурж албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу заасан хугацаагаар сунгах болно.

4.Энэхүү баталгаатай холбоотой аливаа асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

[Баталгаа гаргасан банк, даатгалын байгууллагын нэр, эрх бүхий албан тушаалтны нэр, албан тушаал, гарын үсгийг оруулах]

Маягт 3.Түншлэлийн гэрээ байгуулах тухай мэдэгдэл

Огноо:

Хэнд: [Эрх бүхий этгээдийн нэр]

[Сонгон шалгаруулалтын баримт бичгийн дугаар]

[Төслийн нэр]

ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ТУХАЙ МЭДЭГДЭЛ

Танай [огноо]-ний [түншлэлийн гэрээ байгуулах тухай мэдэгдэл ирүүлэх хүсэлтийг гаргасан албан бичгийн дугаар] албан бичгийн хариуд, сонгон шалгаруулалтын жишиг баримт бичгийн 4.8.3-т заасны дагуу хүргүүлсэн төслийн санал, түншлэлийн гэрээний нөхцөлийн талаар хийсэн хэлэлцээнд үндэслэн, түншлэлийн гэрээг [түншлэлийн гэрээ байгуулах тухай мэдэгдэл ирүүлэх хүсэлтэд заасан огноо]-с өмнө байгуулах хүсэлтэй байгаа бөгөөд тус сонгон шалгаруулалтын жишиг баримт бичгийн 5.3-т заасан нэмэлт гэрээг [огноо]-с өмнө байгуулах эрмэлзэлтэй, боломжтой гэдгээ үүгээр нотолж байна.

Үүнтэй холбогдуулан [төслийн компанийн гэрчилгээ, төлөөлөн удирдах зөвлөлийн нэрсийн жагсаалт, бүртгэгдсэн ажлын байршлын мэдээлэлтэй хамт] хавсралтаар хүргүүлж байна.

[Оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр, албан тушаал, гарын үсэг]

Хавсралт:

- Төслийн компанийн гэрчилгээ;
- Төлөөлөн удирдах зөвлөлийн нэрсийн жагсаалт;
- Бүртгэгдсэн ажлын байршил.

Маягт 4.3ээл олгохыг зөвшөөрсөн тухай мэдэгдэл

Огноо:

Хэнд: [Оролцогчийн нэр]

[Сонгон шалгаруулалтын баримт бичгийн дугаар]

[Төслийн нэр]

ЗЭЭЛ ОЛГОХЫГ ЗӨВШӨӨРСӨН ТУХАЙ МЭДЭГДЭЛ

Бид [сонгон шалгаруулалтын баримт бичгийн дугаар] бүхий сонгон шалгаруулалтын баримт бичиг, холбогдох гэрээний төсөл, төслийн материалтай танилцсан бөгөөд [түншлэл, эсхүл байгууллага] тус сонгон шалгаруулалтад ялбал [банкны нэр] банкны зээлийн хорооны шийдвэрээс шалтгаалан [үнийн дүн] төгрөгийн зээл олгохыг зөвшөөрч байна.

Мөн түүнчлэн [эрх бүхий этгээдийн нэр]-ийн эрх ашигт нийцүүлэн доор дурдсан зүйлийг батламжилж байна:

- Төслийн санал, гэрээнд нэмэлтээр аливаа өөрчлөлт оруулахыг шаардахгүй;
- Тус сонгон шалгаруулалтад заасан хугацаанд багтаан санхүүжилтийн гэрээг байгуулахад ямар нэгэн хүндрэл байхгүй болно.

Зээлийн нөхцөлийг энэхүү мэдэгдлийн хавсралтад тусгасан болно.

Хүндэтгэсэн,

[Санхүүжүүлэгчийн эрх бүхий албан тушаалтны гарын үсэг] Дээр дурдсан нөхцөлийг бид хүлээн зөвшөөрөв:

[Оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гарын үсэг]

Хавсралт:

(1) Зээлийн нөхцөл

Маягт 5.Хөрөнгө оруулах тухай мэдэгдэл

Огноо:

Хэнд: [Эрх бүхий этгээдийн нэр]

[Сонгон шалгаруулалтын баримт бичгийн дугаар]

[Төслийн нэр]

ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ТУХАЙ МЭДЭГДЭЛ

Бидний хүргүүлсэн төслийн санал сонгон шалгаруулалтад ялбал төслийн компанид энэхүү мэдэгдлийн хавсралтад тусгасан адилаар хөрөнгө оруулалт хийхээ нотолж, тус хөрөнгө оруулалтыг хийх чадвартайгаа харуулсан нотолгоог хавсралтаар хүргүүлж байна.

Хүндэтгэсэн,

[Төслийн компанид хөрөнгө оруулах түншлэлийн гишүүний удирдлагын нэр, албан тушаал, гарын үсэг]

Хавсралт:

-Хөрөнгө оруулах хувь хэмжээ, үнийн дүнгийн мэдээлэл;

-Тус хөрөнгө оруулалтыг хийх чадвартайг харуулсан нотолгоо.

*Энэхүү маягтыг хөрөнгө оруулагчаар оролцож буй бүх гишүүн компаниуд бөглөж ирүүлнэ.

Маягт 6.Төслийн саналын хүчинтэй хугацааг сунгах тухай

Огноо:

Хэнд: [Эрх бүхий этгээдийн нэр]

[Сонгон шалгаруулалтын баримт бичгийн дугаар]

[Төслийн нэр]

ТӨСЛИЙН САНАЛЫН ХҮЧИНТЭЙ ХУГАЦААГ СУНГАХ ТУХАЙ

Танай [огноо]-ний [төслийн саналын хүчинтэй хугацааг сунгах тухай хүсэлтийг гаргасан албан бичгийн дугаар] албан бичгийн хариуд, сонгон шалгаруулалтын жишиг баримт бичгийн 3.20.1-д заасны дагуу төслийн саналын хүчинтэй хугацааг [эрх бүхий этгээдээс ирүүлсэн төслийн саналын хүчинтэй хугацааг сунгах тухай хүсэлтэд заасан хугацаа] өдрөөр сунгахыг зөвшөөрч байна.

Үүнтэй холбогдуулан [төслийн саналын баталгааг гаргасан банк, даатгалын байгууллагын нэр]-аас гаргуулсан төслийн саналын баталгааг [дээрхтэй адил хугацаа] өдрөөр сунгахыг зөвшөөрч байгаагаа үүгээр нотлов.

Хүндэтгэсэн,

[Оролцогчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр, албан тушаал, гарын үсэг]

Маягт 7. Санхүүжилтийн төлөвлөгөө

Огноо:

Хэнд: [Эрх бүхий этгээдийн нэр]

[Сонгон шалгаруулалтын баримт бичгийн дугаар]

[Төслийн нэр]

Санхүүжилтийн төлөвлөгөө

Агуулга	Дүн (төгрөг)
Шаардлагатай санхүүжилт: [Шаардлагатай санхүүжилтийн задаргаа]	
Нийт шаардлагатай санхүүжилт	
Санхүүжилтийн эх үүсвэр: Өөрийн хөрөнгө [Зээлийн задаргаа]	
Нийт бүрдүүлсэн санхүүжилт	
Татахад бэлэн санхүүжилт: Өөрийн хөрөнгө [Зээлийн задаргаа]	
Нийт татахад бэлэн санхүүжилт	

*Санхүүжилтийн графикийг дэлгэрэнгүй харуулсан санхүүжилтийн төлөвлөгөөг Санхүүгийн загварт тусгасан байх шаардлагатай.

Маягт 8.Гүйцэтгэлийн баталгаа

Огноо:

Хэнд: [Эрх бүхий этгээдийн нэр]

[Сонгон шалгаруулалтын баримт бичгийн дугаар]

[Төслийн нэр]

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАТАЛГАА

[Банкны нэр] банк нь тус сонгон шалгаруулалтад ялсан [Оролцогчийн нэр] (цаашид "Оролцогч" гэх)-ийн хүсэлтээр, Танай зарласан сонгон шалгаруулалтын жишиг баримт бичгийн 4.8.4-т заасны дагуу [гүйцэтгэлийн баталгааны үнийн дүн] төгрөгийн үл буцаах баталгааг дараах нөхцөлийн дагуу гаргаж байна.

1.Танай албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг хүлээн авах бүрд, оролцогч, эсхүл аливаа гуравдагч этгээдийн эсэргүүцлээс үл хамааран тус баталгааг гүйцэтгүүлэх эрхтэй эсэх талаар нотолгоо шаардахгүйгээр хүсэлтэд ирүүлсэн үнийн дүнг (төлбөрийн нийт хэмжээ дээр дурдсан үнийн дүнгээс хэтрэхгүйгээр) танай заасан аль ч банкны дансанд нэн даруй шилжүүлэх буюу танай хүссэн хэлбэрээр төлөх болно.

2.Энэхүү баталгааг гаргаснаар бид үл маргалдах, үл буцах шууд үүргийг хүлээж байгаа бөгөөд ямар ч шалтгаанаар энэхүү үүргээсээ чөлөөлөгдөхгүй болно.

3.Энэхүү баталгаа нь [Гүйцэтгэлийн баталгааны хүчинтэй байх эцсийн хугацаа] өдрийг хүртэл хүчинтэй байна.

4.Энэхүү баталгаатай холбоотой аливаа асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

[Баталгаа гаргасан банкны нэр, эрх бүхий албан тушаалтны нэр, албан тушаал, гарын үсгийг оруулах]

6.2.Түншлэлийн гэрээний төсөл

[Түншлэлийн гэрээний төслийг боловсруулж, оруулах]

---oOo---

Засгийн газрын 2026 оны 06 дугаар
сарын 03-ны өдрийн 228 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 13.2-т заасан салбарын хүрээнд аймаг, нийслэл түншлэлийн төсөл хэрэгжүүлэхэд зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 13.3-т заасан зөвлөх үйлчилгээг сонгох сонгон шалгаруулалт (цаашид "сонгон шалгаруулалт" гэх)-ыг зохион байгуулахад энэ журмыг баримтална.

1.3.Сонгон шалгаруулалтад Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 24.5-д заасан зарчмыг баримтлах бөгөөд сонгон шалгаруулалтын үе шат, үйл ажиллагаа үр дүнг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.

1.4.Энэ журамд дурдсан нэр томъёог Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан утгаар хэрэглэнэ.

Хоёр.Сонгон шалгаруулалтын ажлын хэсэг

2.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтын ажлын хэсэг (цаашид "Ажлын хэсэг" гэх)-ийг байгуулах бөгөөд уг Ажлын хэсэг сонгон шалгаруулалтыг цахим системээр зохион байгуулна.

2.2.Ажлын хэсэг байгуулах шийдвэрт Ажлын хэсгийн бүрэлдэхүүн, чиг үүрэг, удирдамжийг тусгана.

2.3.Ажлын хэсэг 5-аас доошгүй сондгой тооны бүрэлдэхүүнтэй байх бөгөөд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.4.Ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтыг зохион байгуулахтай холбоотой үйл ажиллагаанд ашиглах цахим шуудан, утасны дугаар, албан ёсны хаягтай байна.

2.5.Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аймаг, нийслэлийн холбогдох байгууллагын төлөөлөл орох бөгөөд төсөл нь эдийн засгийн тусгай бүс, үйлдвэрлэл технологийн парк, үндэсний хэмжээний дэд бүтэц, тээвэр, логистик, олон улсын худалдааны чиглэлээр хэрэгжих тохиолдолд тухайн асуудлыг эрхэлсэн төрийн захиргааны төв болон захиргааны байгууллагын төлөөлөл, санхүү, эдийн засаг, хууль, эрх зүй, нийгэм, байгаль орчин болон холбогдох бусад салбарын үндэсний, олон улсын мэргэжлийн судлаач, зөвлөх, хөндлөнгийн хараат бус зөвлөх гишүүнийг оруулж болно.

2.6.Ажлын хэсэг сонгон шалгаруулалтын тухай мэдээллийг ил тод, нээлттэй зарлах, саадгүй олгох, өрсөлдөөний тэнцвэрийг хангах зорилгоор мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангаж ажиллана.

2.7.Ажлын хэсгийн гишүүн ашиг сонирхлын зөрчилгүй байх бөгөөд албан үүргээ хэрэгжүүлэх явцад үүссэн эсхүл, үүсэж болзошгүй ашиг сонирхлын зөрчил, нөлөөллийн мэдүүлгийг холбогдох хуулийн дагуу үнэн зөв гаргана.

2.8.Ажлын хэсгийн гишүүн төр, хувийн хэвшлийн түншлэлийн чиглэлээр шаардлагатай мэдлэг, чадавх олгох сургалтад хамрагдсан байна. Сургалтыг түншлэлийн асуудал хариуцсан нэгж, байгууллага, Түншлэлийн төвөөр хийлгэж болно.

2.9.Түншлэлийн төслийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн чиглэлээр сургалтад хамруулахад аймаг, нийслэлийн холбогдох байгууллага шаардлагатай мэдээллээр хангаж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлнэ.

Гурав.Зөвлөх үйлчилгээ, ажлын даалгавар

3.1.Ажлын хэсэг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан дараах чиглэлээр хамтран ажиллах зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтыг зохион байгуулж болно:

3.1.1.төслийн урьдчилсан үнэлгээ, төслийн бүрэн шинжилгээ, түншлэлийн эх төсөл боловсруулах болон төсөвт үзүүлэх нөлөөллийн тооцоо, шинжилгээ хийх, мөнгөний үнэ цэнийн судалгаа хийхэд мэргэжлийн зөвлөх үйлчилгээ;

3.1.2.түншлэлийн төслийн техник хяналтын гэрээг гүйцэтгэх зөвлөх үйлчилгээ;

3.1.3.түншлэлийн гэрээнд заасан тохиолдолд төсөл хэрэгжих хугацаанд хувийн хэвшлийн түншлэгчийн үйл ажиллагаа, хэрэгжилт, гүйцэтгэлд гэрээний дагуу хяналт тавих, хөндлөнгийн үнэлгээ хийлгэх зөвлөх үйлчилгээ;

3.1.4.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, журмын дагуу хувийн хэвшлийн түншлэгчийг сонгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулахад зайлшгүй шаардлагатай дотоодын болон гадаадын шинжээч, зөвлөх, мэргэжлийн багийн зөвлөх үйлчилгээ.

3.2.Зөвлөх үйлчилгээний зардлыг аймаг, нийслэлийн холбогдох төсөв, сан болон хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс шийдвэрлэнэ.

3.3.Ажлын хэсэг нь шаардлагатай зөвлөх үйлчилгээг захиалагчийн хүсэлтийн дагуу тодорхойлж, зөвлөх үйлчилгээний зорилт, хүрэх үр дүн, үнэлгээний арга болон бусад шаардлагатай мэдээллийг агуулсан ажлын даалгавар, төсөвт өртгийг тооцож бэлтгэнэ.

3.4.Сонгон шалгаруулалтад оролцогчийн шаардлагыг ажлын даалгаварт тусгаж болно.

3.5.Зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар, уг даалгаварт оруулсан нэмэлт, өөрчлөлт нь тухайн зөвлөхтэй байгуулах гэрээний салшгүй хэсэг болно.

Дөрөв.Сонгон шалгаруулалтад оролцогч

4.1.Сонгон шалгаруулалтад хуулийн этгээд, хувь хүн, тэдгээрийн түншлэл оролцож болно.

4.2.Зөвлөх үйлчилгээний оролцогчийн жагсаалтад орох санал ирүүлэх урилгыг аймаг, нийслэлийн болон холбогдох бусад цахим хуудсаар, эсхүл өдөр тутмын сонин болон бусад хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэлнэ.

4.3. Жагсаалтад орох саналыг урилгад заасан хугацаа, шаардлагын дагуу цахимаар гаргах бөгөөд саналыг Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга хүлээн авч, оролцогчийг бүртгэснийг цахимаар баталгаажуулна.

4.4. Дэлгэрэнгүй жагсаалтад орсон оролцогчдоос захиалагчаас тогтоосон шаардлагыг хангасан, хамгийн сайн гэж үнэлэгдсэн 5 хүртэлх оролцогчийг сонгож, хураангуй жагсаалтад оруулна.

4.5. Хураангуй жагсаалтад багтсан оролцогчдод саналын урилга болон ажлын даалгаврыг цахимаар хүргүүлнэ.

4.6. Зөвлөх үйлчилгээний саналын урилгад дараах зүйлийг тусгана:

4.6.1. уригдсан оролцогчийн нэр;

4.6.2. зөвлөх үйлчилгээ болон санхүүжилтийн эх үүсвэрийн мэдээлэл;

4.6.3. ажлын даалгавар;

4.6.4. захиалагчийн тогтоосон чадавхын шаардлага, үнэлгээний шалгуур үзүүлэлт, аргачлал;

4.6.5. гэрээний төсөл;

4.6.6. санал ирүүлэхэд баримтлах зааварчилгаа;

4.6.7. сонгосон үнэлгээний арга.

4.7. Санал ирүүлэх хугацааг 7-оос дээш хоногоор тогтоож саналын урилгад тодорхой тусгана.

4.8. Сонгон шалгаруулалтад оролцогч нь ажлын даалгавартай холбоотой тодруулга, мэдээлэл авах хүсэлтийг цахимаар гаргаж болно. Ажлын хэсэг хүсэлтийн хариуг ажлын 2 өдрийн дотор нийт бүртгүүлсэн оролцогчдод нэгэн зэрэг цахимаар хүргүүлнэ.

Тав.Зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах

5.1. Зөвлөх нь хувь хүн бол мэргэжлийн ур чадвар, туршлага, харин хуулийн этгээд бол голлох мэргэжилтэн, үйл ажиллагааны чиглэл, туршлагатай холбоотой мэдээллийг тусгасан техникийн болон гэрээний үнийн саналыг Ажлын хэсэгт хүргүүлнэ.

5.2. Ажлын хэсэг захиалагчаас урьдчилан тодорхойлсон үнэлгээний аргыг ашиглан оролцогчоос ирүүлсэн саналыг үнэлж, шалгарсан оролцогчтой дарааллын дагуу хэлэлцээр хийж, хамгийн сайн шаардлага хангасан оролцогчтой гэрээ байгуулах дүгнэлт гаргана.

5.3. Ажлын хэсэг нь үнэлгээ, хэлэлцээрийн явц бүрийг тэмдэглэл хөтөлж баталгаажуулах ба хэлэлцээрийн үр дүн, шалгарсан оролцогчтой гэрээ байгуулах дүгнэлтийг Ажлын хэсгийн бүх гишүүдээр гарын үсэг зуруулан, холбогдох баримт бичгийн бүрдлийг хангаж аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.

5.4. Аймаг, нийслэлийн Засаг дарга зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулна.

5.5. Зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт амжилтгүй болсон тохиолдолд энэ журамд заасны дагуу сонгон шалгаруулалтыг дахин зарлана.

5.6.Зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт 2 удаа амжилтгүй болсон тохиолдолд хураангуй жагсаалтад тэнцсэн оролцогчоос хамгийн бага үнийн санал ирүүлсэн зөвлөхтэй шууд гэрээ байгуулж болно.

Зургаа.Бусад

6.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга сонгон шалгаруулалтын үр дүнг олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлж, цахим хуудаст холбогдох мэдээллийг байршуулна.

6.2.Зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулахтай холбоотой гомдол гаргах, маргаан шийдвэрлэх асуудлыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 56, 57 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

---o0o---

Засгийн газрын 2024 оны 12 дугаар
сарын 04-ний өдрийн 210 дугаар
тогтоолын 3 дугаар хавсралт

ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ХЭЛЭЛЦЭЭ ХИЙЖ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТГҮЙ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 13.2-т заасан түншлэлийн төслийн хүрээнд аймаг, нийслэл нь төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ (цаашид "түншлэлийн гэрээ" гэх)-г байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэ журмын дагуу түншлэлийн гэрээ байгуулахад Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Иргэний хууль, бусад холбогдох хууль тогтоомж болон энэ журмыг дагаж мөрдөнө.

1.3.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасны дагуу түншлэлийн гэрээ болон дагалдах бусад гэрээнүүд нь Захиргааны ерөнхий хуулийн зохицуулалтад хамаарахгүй.

1.4.Түншлэлийн төсөл хэрэгжүүлэгч хувийн хэвшлийн түншлэгч болон зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах, сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд зааснаар зохицуулна.

1.5.Энэ журамд хэрэглэсэн нэр томьёог Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан утгаар ойлгоно.

1.6.Түншлэлийн гэрээний төслийг боловсруулахад Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 7.2.3-т заасны дагуу баталсан төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний стандарт загварыг ашиглана.

1.7.Түншлэлийн төсөл нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 18.1-д заасан түншлэлийн нийтлэг шаардлага болон түншлэлийн гэрээ байгуулж, хэрэгжүүлэх төсөл нь тус хуулийн 18.2-т заасан тусгай шаардлагыг хангасан байна.

Хоёр.Түншлэлийн гэрээ, түүний төрөл, нөхцөл, гэрээний талууд, эрх, үүрэг

2.1.Түншлэлийн гэрээ нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 5.1.20-д заасны дагуу төрийн түншлэгч болон хувийн хэвшлийн түншлэгч талуудын хооронд түншлэлийн төслийг хэрэгжүүлэхээр харилцан тохиролцож, талуудын эрх, үүрэг болон бусад асуудлыг тодорхойлж байгуулсан иргэний эрх зүйн гэрээ байна.

2.2.Түншлэлийн төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэлбэр, төслийн дагуу гүйцэтгэх ажлын онцлогоос хамаарч гэрээний төрлийг тодорхойлох бөгөөд түншлэлийн гэрээ нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 15.1-д заасан төрөлтэй байна.

2.3.Түншлэлийн гэрээний талууд нь төрийн түншлэгч талаас аймаг, нийслэлийн Засаг дарга, нөгөө талаас хувийн хэвшлийн түншлэгч буюу төсөл хэрэгжүүлэгч компани, төслийн санхүүжүүлэгч хуулийн этгээд байна.

2.4.Төрийн түншлэгч нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 28.1-д заасан нийтлэг чиг үүргээс гадна дараах үүрэгтэй:

2.4.1.хувийн хэвшлийн түншлэгч газрыг түншлэлийн гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглахад саад учруулахгүй байх, тухайн газар дээр ажил, үйлчилгээгээ явуулах нөхцөл, боломжоор хангах;

2.4.2.нийтэд зориулсан барилга байгууламжийн ашиглалт, үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хэрэглэгчээс төлсөн төлбөр, хураамжийг түншлэлийн гэрээнд заасны дагуу хувийн хэвшлийн түншлэгчид шилжүүлэх;

2.4.3.төслийн онцлогт нийцүүлэн хэрэглэгчийн төлбөр, хураамж, тарифын хэмжээг тогтоох аргачлалыг өгөөжийн түвшин тооцох болон үнийн хязгаарлалтын, эсхүл энэ хоёрын холимог аргын хүрээнд боловсруулж, түншлэлийн гэрээнд тусгах;

2.4.4.түншлэлийн гэрээ байгуулагдсан даруйд тухайн түншлэлийн гэрээ болон дагалдах гэрээний хуулбарыг түншлэлийн мэдээллийн нэгдсэн санд байршуулах арга хэмжээ авч, олон нийтэд мэдээлэх.

2.5.Хувийн хэвшлийн түншлэгч нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 28.2-т заасан нийтлэг чиг үүргээс гадна дараах үүрэгтэй:

2.5.1.түншлэлийн үндсэн болон дагалдах гэрээнд заасан хугацаа, стандарт болон зардлын дагуу түншлэлийн төслийг хугацаанд нь гүйцэтгэх төсөл хэрэгжүүлэх баталгааг гаргаж, төлбөрийг гэрээнд заасны дагуу төрийн түншлэгчийн дансанд гэрээ байгуулахаас ажлын 5 өдрийн өмнө шилжүүлэх;

2.5.2.түншлэлийн гэрээгээр тогтоосон төлбөр, хураамж, тарифын хэмжээний хязгаарлалтыг дагаж мөрдөх.

2.6.Түншлэлийн төслийг санхүүжүүлэгч нь түншлэлийн төслийг санхүүжүүлэх, татан төвлөрүүлсэн зээлийн эргэн төлөлтийн үүрэгтэй холбоотойгоор гэрээг хугацаанаас нь өмнө цуцалсан тохиолдолд санхүүжүүлэгчийн хөндлөнгөөс оролцох эрхийг хууль болон түншлэлийн гэрээнд заасны дагуу хэрэгжүүлнэ.

2.7.Түншлэлийн гэрээний нөхцөлийг тодорхойлохдоо түншлэгч талуудын чиг үүрэг, тухайн төслийг хэрэгжүүлэх салбарын онцлог, нөхцөл байдалтай уялдуулах бөгөөд хуульд заасан түншлэлийн зарчмыг удирдлага болгон Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 35.2-т заасан гол нөхцөлөөс гадна дараах нөхцөлийг тусгана:

2.7.1.түншлэгч талуудын хооронд эрсдэл хуваарилах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, үүссэн эрсдэлийг шийдвэрлэх арга зам;

2.7.2.хуульд заасан хүрээнд аймаг, нийслэлээс дэмжлэг үзүүлэх эсэх;

2.7.3.түншлэлийн гэрээг цуцлах тохиолдолд талуудад олгох нөхөн төлбөрийг тооцох аргачлал;

- 2.7.4.төсөл хэрэгжих газрын эрх, түүнийг шилжүүлэх асуудал;
- 2.7.5.төслийг тусгай зориулалтын компани байгуулж хэрэгжүүлэх тохиолдолд тусгай зориулалтын компанийг хуулийн этгээдээр бүртгүүлснээс хойших хугацаанд компани өөрийн хөрөнгийн хэмжээг өөрчлөх, төрийн түншлэгчээс зөвшөөрөл авах журам, эдгээрт зарчмын өөрчлөлт оруулах нөхцөл;
- 2.7.6.төрийн түншлэгчид шилжүүлэх хөрөнгө, төрийн түншлэгч өөрийн сонголтоор худалдан авах хөрөнгө, хувийн хэвшлийн түншлэгчийн эзэмшилд үлдэх хөрөнгийн өмчлөлийн талаар талууд тохиролцсон тохиолдолд энэ талаарх зохицуулалт;
- 2.7.7.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 47.4-т заасан нийтийн зориулалттай дэд бүтэц, барилга байгууламж төслийн ашиглалттай холбоотой асуудал;
- 2.7.8.хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн гэрээний дагуу нийтэд зориулсан барилга байгууламжийн ашиглалт, үйлчилгээтэй холбоотой түрээс, төлбөр, хураамж авах тохиолдолд төлбөр, хураамжийн хэмжээ тогтоох, түүнийг өөрчлөх аргачлал;
- 2.7.9.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 46.2-т заасан тохиолдолд төрийн түншлэгчээс гуравдагч этгээдэд эрх, үүрэг шилжүүлэх зөвшөөрөл өгөх нөхцөл болзол, гэрээний үүргийг бүхэлд нь хүлээн авсан шинэ түншийг хүлээн зөвшөөрөх, үйлчилгээ үзүүлэхэд тавигдах техникийн болон санхүүгийн чадавх;
- 2.7.10.түншлэлийн зүйлийн барьцааны зүйлтэй холбоотой Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 44.4-т заасан асуудал;
- 2.7.11.түншлэлийн гэрээ дуусгавар болсонтой холбоотой түншлэгч талууд болон санхүүжүүлэгч талын хүлээх эрх, үүрэг;
- 2.7.12.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 48.5-д заасан түншлэлийн гэрээ дуусгавар болох, эрх шилжүүлэхтэй холбогдсон асуудал;
- 2.7.13.төрийн түншлэгчээс хэрэгжүүлэх хяналтын асуудал;
- 2.7.14.хувийн хэвшлийн түншлэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас төрийн түншлэгчээс гэрээг цуцлах эрхтэй болох, эсхүл гэрээг цуцлах болон гэрээнд заасан бусад нөхцөл үүссэн тохиолдолд төслийн санхүүжүүлэгч, эсхүл зээлдүүлэгч нь гэрээнд заасны дагуу санхүүжүүлэгчийн хөндлөнгөөс оролцох эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой журам.
- 2.8.Түншлэлийн гэрээний талууд гэрээгээр хүлээсэн үүрэг, хариуцлагыг бүрэн хариуцаж, биелүүлэх үүрэгтэй бөгөөд хууль, журмын болон гэрээнд заасан чиг үүрэг, бүрэн эрхийн хүрээнд тухайн түншлэлийн харилцаанд оролцоно.
- 2.9.Түншлэлийн гэрээний хугацааг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 36.3-т заасан хүчин зүйл, төслийг хэрэгжүүлэх салбар, төслийн үндсэн шинж болон гэрээний төрлөөс хамаарч талуудын харилцан тохиролцсоноор тогтоох бөгөөд мөн хуулийн 36.2-т заасны дагуу гэрээний хугацаа 30 жилээс илүүгүй байна.

Гурав.Түншлэлийн гэрээ байгуулах ажлын зохион байгуулалт

3.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ журмын дагуу түншлэлийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулна.

3.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга түншлэлийн гэрээ байгуулах тухай санал, дүгнэлтийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

3.3.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас түншлэлийн гэрээ байгуулах эрх олгосон тохиолдолд аймаг, нийслэлийн Засаг дарга 10 хоногийн дотор шалгарсан оролцогчид гэрээ байгуулах тухай мэдэгдлийг хүргүүлнэ.

3.4.Хувийн хэвшлийн түншлэгч түншлэлийн гэрээ байгуулахын өмнө дараах баримт бичгийг бүрдүүлэн аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ. Үүнд:

3.4.1.төсөл хэрэгжүүлэх баталгааны талаарх мэдээлэл;

3.4.2.төслийн санхүүжүүлэгч, эсхүл зээлдүүлэгч байгууллагын албан бичиг, бусад нотлох баримт;

3.4.3.тусгай зориулалтын компани байгуулах тохиолдолд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, хувьцаа эзэмшигчдийн гэрээ, компанийн дүрэм;

3.4.4.консорциум байх тохиолдолд бүх гишүүн хооронд байгуулсан түншлэлийн төслийг хэрэгжүүлэх хамтран ажиллах гэрээ;

3.4.5.хувийн хэвшлийн түншлэгчийг төлөөлж түншлэлийн гэрээнд гарын үсэг зурах эрх бүхий этгээд мөн болохыг нотлох шийдвэр, хуулийн этгээд нь нэг хувьцаа эзэмшигчтэй бол эрх олгосон хувьцаа эзэмшигчийн шийдвэр, нэг ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчтэй бол хувьцаа эзэмшигчдийн тогтоол, хурлын тэмдэглэл зэрэг баримт бичиг.

3.5.Хувийн хэвшлийн түншлэгч энэ журмын 3.3-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор энэ журмын 3.4-т заасан баримт бичгийг бүрдүүлж, гэрээнд гарын үсэг зурна.

3.6.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь энэ журмын 3.4-т заасан баримт бичгийг хүлээн авч, хянасны үндсэн дээр гэрээнд гарын үсэг зурах товыг товлон хувийн хэвшлийн түншлэгчид мэдэгдэнэ.

3.7.Түншлэлийн гэрээнд аймаг, нийслэлийн Засаг дарга, хувийн хэвшлийн түншлэгчийг төлөөлж хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна. Хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан нь хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, түүний эрх олгосноор төлөөлөн удирдах зөвлөл, түүний эрх олгосноор гүйцэтгэх удирдлага байна.

3.8.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь түншлэлийн гэрээ байгуулагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор түншлэлийн, санхүү, төсвийн болон тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад түншлэлийн гэрээний хуулбарыг хүргүүлнэ.

3.9.Түншлэлийн гэрээ цуцлагдсан бол цуцлагдсан өдрөөс хойш 7 хоногийн дотор аймаг, нийслэлийн Засаг дарга түншлэлийн, санхүү, төсвийн болон тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудад тус тус мэдэгдэнэ.

Дөрөв.Хэлэлцээ хийж сонгон шалгаруулалтгүй гэрээ байгуулах

4.1.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд сонгон шалгаруулалтгүйгээр хэлэлцээ хийж, гэрээ байгуулахаар заасан түншлэлийн гэрээг аймаг, нийслэлийн Засаг дарга хувийн хэвшлийн түншлэгчтэй зохих журмын дагуу байгуулж болно.

4.2.Энэ журмын 4.1-д заасны дагуу сонгон шалгаруулалтгүйгээр хэлэлцээ хийж гэрээ байгуулах тохиолдолд аймаг, нийслэлийн Засаг дарга хэлэлцээ хийж, гэрээний төсөл боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг (цаашид "ажлын хэсэг" гэх)-ийг байгуулж, томилно.

4.3.Ажлын хэсэг 7-оос доошгүй сондгой тооны бүрэлдэхүүнтэй, дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэх бөгөөд бүрэлдэхүүнд аймаг, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын төлөөлөл, хөндлөнгийн хараат бус гишүүнийг оруулна.

4.4.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулалтгүйгээр хэлэлцээ хийж, гэрээ байгуулахад энэ журмаас гадна хуулийн 37.12-т заасан журмыг баримтална.

4.5.Ажлын хэсэг хувийн хэвшлийн түншлэгчтэй хэлэлцээ хийж, түншлэлийн гэрээний төслийг боловсруулж, дүгнэлтийн хамт аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.

4.6.Аймаг, нийслэлийн Засаг дарга түншлэлийн гэрээ байгуулах тухай дүгнэлтийг баталгаажуулж, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 37.12.6-д заасны дагуу түншлэлийн гэрээ байгуулах эсэх шийдвэр гаргуулахаар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

4.7.Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал энэ журмын 4.6-д заасан дүгнэлтийг хэлэлцэж, түншлэлийн гэрээ байгуулах эсэх шийдвэрийг гаргана. Түншлэлийн гэрээ байгуулахыг дэмжсэн тохиолдолд гэрээ байгуулах эрхийг аймаг, нийслэлийн Засаг даргад олгоно. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас хувийн хэвшлийн түншлэгчтэй дахин хэлэлцээ хийхээр буцааж болно.

4.8.Аймаг, нийслэлийн Засаг дарга түншлэлийн гэрээг байгуулахдаа энэ журмын 3.3-3.7-д заасан зохицуулалтыг баримтална.

Тав.Түншлэлийн гэрээний хэрэгжилт, хяналт

5.1.Төрийн түншлэгч нь түншлэлийн төслийн бүх үе шатанд түншлэлийн гэрээнд заасан хяналтын эрхийг хэрэгжүүлнэ.

5.2.Түншлэлийн гэрээний хэрэгжилт, санхүүжилт, тайлагналт, хяналт тавихтай холбогдсон харилцаанд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 7.2.8-д заасан журмыг баримтална.

Зургаа.Түншлэлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг сунгах, цуцлах, дуусгавар болгох

6.1.Аймаг, нийслэлийн Засаг даргын саналаар дараах тохиолдолд түншлэлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шийдвэрлэнэ:

6.1.1.түншлэлийн гэрээний агуулгын ач холбогдол бүхий харилцаа тухайн гэрээг байгуулснаас хойш бүхэлдээ, мэдэгдэхүйц өөрчлөгдсөн, гэрээний аль нэг тал гэрээний анхны зохицуулалтыг цаашид баримтлах боломжгүй болох нь тогтоогдсон бөгөөд талуудаас түншлэлийн гэрээнд өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан бол;

6.1.2.гэнэтийн болон давагдашгүй, урьдчилан таамаглаагүй нөхцөл байдлын улмаас төслийн техникийн үзүүлэлт, хөрөнгө оруулалтын тохиролцсон нийт хэмжээ өөрчлөгдсөн, хуульд зааснаар нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэлийн тайланд өөрчлөлт орсон, эсхүл гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлс бий болсон бөгөөд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахаар талууд харилцан тохиролцсон бол;

6.1.3.төрийн түншлэгчээс түншлэлийн гэрээний хамрах хүрээг өргөжүүлэн анхны гэрээнд тусгаагүй боловч зайлшгүй шаардлагатай ажил, үйлчилгээг хувийн хэвшлийн түншлэгчээр нэмэлтээр хийлгэх шаардлагатай болсон бол.

6.2.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 6.1.3-т заасан түншлэлийн төслийн нэмэлт ажил, үйлчилгээ дараах шаардлагыг хангасан байна:

6.2.1.эдийн засаг, техникийн шийдлийн хувьд одоо ашиглаж байгаа тоног төхөөрөмж, анхны гэрээний хүрээнд хийсэн ажил, үйлчилгээтэй уялдаатай, харилцан хамааралтай, сэлгэн ажиллуулах боломжтой байх;

6.2.2.хувийн хэвшлийн өөр түншээр хийлгэх нь нийтийн ашиг сонирхолд үл нийцэх, төрийн түншлэгчийн хувьд илүү их ажиллагаа, хугацаа шаардах, нэмэлт зардал гарахаар бол.

6.3.Түншлэлийн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал нь анх тохирсон гэрээний үнийн дүнг 15-аас дээш хувиар өсгөхөөр бол, эсхүл анхны гэрээнд заагаагүй ажил, үйлчилгээг хувийн хэвшлийн түншлэгч нэмэлтээр үзүүлэх үр дагавартай бол гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх талаар аймаг, нийслэлийн Засаг дарга нь санхүү, төсвийн болон түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авч, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

6.4.Төрийн түншлэгч түншлэлийн гэрээний хугацаа дуусгавар болох үед гэрээг дахин сунгахгүйгээр дуусгавар болгох эрхтэй бөгөөд дараах тохиолдолд гэрээний хугацааг сунгахаар талууд зөвшилцөж болно:

6.4.1.гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн улмаас гэрээний аль нэг талын хяналтаас давсан нөхцөл байдал үүссэнээс төслийн үйл ажиллагаа зогссон;

6.4.2.төрийн түншлэгчээс гаргасан түншлэлийн гэрээнд тусгагдаагүй шаардлагыг хангахад төслийн нийт өртөг өссөн бөгөөд хувийн хэвшлийн түншлэгч уг зардлыг гэрээний хугацаа сунгахгүйгээр нөхөх боломжгүй болсон.

6.5.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 36.2-т заасан хугацааг тус хуулийн болон гэрээнд заасан шаардлага, үндэслэлээр аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвшөөрлийн үндсэн дээр талууд гэрээний хугацааг нэг удаа 10 хүртэлх жилээр сунгаж болно.

6.6.Түншлэлийн гэрээг цуцлах, дуусгавар болгох асуудлыг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулна.

Долоо.Бусад

7.1.Түншлэлийн гэрээг Монгол хэлээр үйлдэх бөгөөд гэрээний талуудын сонгон авсан бусад хэлээр үйлдэж болно.

7.2.Энэ журмын 3.3, 4.7-д заасан эрхийг аваагүй байгуулсан гэрээ хүчин төгөлдөр бус байна.

7.3.Түншлэлийн гэрээнд талууд гарын үсэг зурснаар сонгон шалгаруулалтад оролцогчдын сонгон шалгаруулалтын баталгааг чөлөөлнө.

7.4.Энэ журмын 3.5-д заасан хугацаанд түншлэлийн гэрээнд талууд гарын үсэг зураагүй, зурах боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд зарласан сонгон шалгаруулалтыг хүчингүйд тооцож, уг түншлэлийн төслийн сонгон шалгаруулалтыг дахин зарлана.

7.5.Төрийн түншлэгч байгууллагын холбогдох албан тушаалтан түншлэлийн гэрээ байгуулах болон хэлэлцээ хийх явцад хувийн хэвшлийн этгээдээс ирүүлсэн хуулиар хамгаалагдсан мэдээллийн нууцлалыг хадгална.

7.6.Түншлэлийн гэрээ байгуулсан аймаг, нийслэлийн Засаг дарга гэрээний эх хувийг дараах баримт бичгийн хамт хадгална:

7.6.1.аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гэрээ байгуулах эрх олгосон шийдвэр;

7.6.2.гэрээний эх хувь;

7.6.3.дагалдах гэрээ, төслийн үе шат, гэрээний төлбөр, санхүүжилтийн хуваарь, хэрэгжилтийн төлөвлөгөө;

7.6.4.гэрээний төслийн талаар хэлэлцээ хийсэн уулзалтын тэмдэглэл, холбогдох бусад баримт бичиг.

Засгийн газрын 2024 оны 12 дугаар
сарын 04-ний өдрийн 210 дугаар
тогтоолын 4 дүгээр хавсралт

ТҮНШЛЭЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТ, САНХҮҮЖИЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ТАЙЛАГНАЛТ БОЛОН ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 13.2-т заасны дагуу аймаг, нийслэлийн хэрэгжүүлж байгаа төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийн хэрэгжилт, санхүүжилт, зохион байгуулалт, тайлагналт болон түншлэлийн төслийн хэрэгжилтэд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэ журамд хэрэглэсэн нэр томьёог Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан утгаар ойлгоно.

1.3.Түншлэлийн төслийн хэрэгжилт, санхүүжилт, зохион байгуулалт, тайлагналт болон түншлэлийн төслийн хэрэгжилтэд хяналт тавихтай холбоотой энэ журмаар зохицуулснаас бусад харилцааг холбогдох хууль тогтоомж, түншлэлийн гэрээнд заасны дагуу зохицуулна.

1.4.Түншлэлийн төслийн хэрэгжилт, санхүүжилт, зохион байгуулалт, тайлагналт болон хяналт тавих үйл ажиллагаанд үнэн зөв, бодитой байх, ил тод байх, шударга, хариуцлагатай байх, тасралтгүй, тогтмол хийгддэг байх зарчмыг баримтална.

Хоёр.Үйлчлэх хүрээ

2.1.Энэ журмыг дараах этгээд үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө:

2.1.1.аймаг, нийслэлийн Засаг дарга;

2.1.2.холбогдох байгууллага;

2.1.3.хувийн хэвшлийн түншлэгч;

2.1.4.төрийн түншлэгчийн өмнөөс хяналт тавих, зөвлөх үйлчилгээний үүргийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, тэдгээрийн түншлэл

2.1.5.түншлэлийн төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцож байгаа энэ журмын 2.1.4-т зааснаас бусад иргэн, хуулийн этгээд;

2.1.6.хуульд заасан бусад.

Гурав.Түншлэлийн төслийн хэрэгжилт

3.1.Түншлэлийн гэрээнд талууд гарын үсэг зурж, хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн түншлэлийн төслийн хэрэгжилтийг хангаж эхэлнэ.

3.2.Хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвшөөрлийг холбогдох хууль, журмын дагуу эрх бүхий байгууллагаас авна.

3.3.Хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн гэрээнд заасан төсөл хэрэгжүүлэх газрыг эзэмших, эсхүл ашиглах эрхийг холбогдох хууль тогтоомжийн дагуу авах бөгөөд төрийн түншлэгч нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 41.3-т заасан газартай холбоотой үүрэг хүлээнэ.

3.4.Хувийн хэвшлийн түншлэгч нь барилга байгууламж, дэд бүтцийн бүтээн байгуулалт, ажлын зураг төслийг холбогдох хууль тогтоомж, түншлэлийн гэрээнд заасан нөхцөл, шаардлага, стандартын дагуу гүйцэтгэж, ашиглалтад оруулах бөгөөд энэ талаар төрийн түншлэгчид мэдэгдэж, холбогдох төрийн байгууллагаас үйл ажиллагаа эхлүүлэх зөвшөөрөл авна.

3.5.Энэ журмын 3.4-т заасан үйл ажиллагаа эхлүүлэх зөвшөөрөл олгосон тохиолдолд тухайн барилга байгууламж, дэд бүтэц, хөрөнгө оруулалтын зардалтай уялдуулан төсөл хэрэгжүүлэх баталгааны тодорхой хувийг түншлэлийн гэрээнд заасан нөхцөлийн дагуу чөлөөлж болно.

3.6.Хувийн хэвшлийн түншлэгч нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 47.6-д заасны дагуу нийтийн зориулалттай дэд бүтцийн болон барилга байгууламжийн ашиглалтын дүрэм тогтоож мөрдүүлэх эрхтэй бөгөөд энэ тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллагаар хянан баталгаажуулна.

3.7.Хувийн хэвшлийн түншлэгч нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 44.9-д заасны дагуу нийтэд зориулсан барилга байгууламжийн ашиглалт, үйлчилгээтэй холбоотой түрээс, төлбөр, хураамж, түүний өөрчлөлтийг түншлэлийн гэрээнд заасан хэмжээ, аргачлалын дагуу тогтоож, холбогдох эрх бүхий байгууллагаар батлуулан мөрдөж ажиллана. Холбогдох эрх бүхий байгууллага нь уг шийдвэрийг өөрийн цахим хуудсанд олон нийтэд ил тод, нээлттэй байршуулна.

3.8.Хувийн хэвшлийн түншлэгч нь техникийн аюулгүй байдал, түншлэлийн гэрээний нөхцөл, шаардлага, холбогдох стандартыг хангаж ажиллаагүйн улмаас бусдад учруулсан аливаа хохирлыг бие даан хариуцаж, өөрийн хөрөнгөөр барагдуулах бөгөөд хохирлын хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу тогтооно.

3.9.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 42.7-д заасны дагуу төслийн хэрэгжилтийн явцад хувийн хэвшлийн түншлэгч тусгай зориулалтын компанийн дүрэмд өөрчлөлт оруулах шаардлагатай болсон, эсхүл компанийн өмчлөгч өөрчлөгдөх тохиолдолд аймаг, нийслэлийн Засаг даргад мэдэгдэж зөвшөөрөл авах бөгөөд зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэх хугацаа ажлын 10 өдрөөс хэтрэхгүй.

3.10.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 46.2-т заасан санхүүжүүлэгчийн хөндлөнгөөс оролцох эрхийг хэрэгжүүлэх тохиолдолд аймаг, нийслэлийн Засаг дарга холбогдох талуудыг оролцуулан ажлын хэсэг байгуулж, түншлэлийн гэрээнд заасан арга хэмжээ авах эсэх асуудлыг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, шийдвэрлүүлнэ.

3.11.Түншлэлийн гэрээний хугацаа дуусгавар болж, хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн хүрээнд бий болсон, эсхүл түншлэлд хамаарах аливаа хөрөнгийг түншлэлийн гэрээнд заасны дагуу шилжүүлсэн тохиолдолд төсөл хэрэгжүүлэх баталгааны хөрөнгийг гэрээнд заасны дагуу бүрэн чөлөөлнө.

Дөрөв.Түншлэлийн төслийн зохион байгуулалт

4.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь түншлэлийн төслийн хэрэгжилт, түншлэлийн гэрээний биелэлтийг хангаж, нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэн, хяналт тавих бөгөөд хууль тогтоомжоор олгогдсон эрх, үүргийн хүрээнд түншлэлийн төслийг амжилттай хэрэгжүүлэхэд холбогдох дэмжлэг үзүүлж болно.

4.2.Хувийн хэвшлийн түншлэгч төрийн түншлэгчтэй харилцах албан ёсны бүтэцтэй байх бөгөөд түншлэлийн гэрээ, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар шуурхай харилцах тогтолцоог бүрдүүлж, харилцах талуудын мэдээлэлд өөрчлөлт орох тухай бүрд даруй мэдэгдэнэ.

4.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь түншлэлийн гэрээ, түншлэлийн төслийн хэрэгжилтийн мэдээллийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 51.1-д зааснаас бусад тохиолдолд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу нийтэд мэдээлж, ил тод байдлыг хангаж ажиллана.

4.4.Хууль тогтоомжид заасан хүрээнд нийтийн зориулалттай дэд бүтцийн барилга байгууламжийн ашиглалтад салбарын асуудал эрхэлсэн холбогдох төрийн байгууллага болон тухайн салбарын мэргэжлийн байгууллага хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Тав.Түншлэлийн төслийн санхүүжилт

5.1.Хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын санхүүжилтийг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 44.1-д заасан эх үүсвэрээр санхүүжүүлэх бөгөөд санхүүжилтийг түншлэлийн гэрээнд заасан хугацаанд бүрдүүлнэ.

5.2.Хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын санхүүжилтийн саналд өөрчлөлт оруулах тохиолдолд энэ тухай үндэслэл бүхий саналыг аймаг, нийслэлийн Засаг даргад холбогдох баримтын хамт хүргүүлж, бичгээр зөвшөөрөл авна. Аймаг, нийслэлийн Засаг дарга санхүүжилтийн саналд өөрчлөлт оруулах нь төслийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлөхүйц эрсдэлтэй гэж үзвэл зөвшөөрөл өгөхөөс татгалзаж болно.

5.3.Хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын санхүүжилттэй холбогдох гэрээ, бүрдүүлбэр, бусад баримт бичгийг аймаг, нийслэлийн Засаг даргад тухайн санхүүжилтийн гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор ирүүлнэ.

5.4.Хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн төслийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг хийж дууссанаас хойш 3 сарын дотор төслийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэлийн тайланг гаргаж, аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ.

5.5.Хувийн хэвшлийн түншлэгч нь Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 14.1-д заасан буюу орон нутгийн төсвөөс түншлэлийн төслийн зардлыг санхүүжүүлэхтэй холбоотой дараах мэдээллийг жил бүрийн 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлнэ:

5.5.1.түншлэлийн төслийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан;

5.5.2.түншлэлийн төслийн орлогын гүйцэтгэл;

5.5.3.дараа жилийн санхүүжилтийн санал.

5.6.Аймаг, нийслэлийн Засаг дарга энэ журмын 5.5.3-т заасан дараа жилийн санхүүжилтийн санал, гүйцэтгэлийн үнэлгээг хянаж нэгтгэн, орон нутгийн төсвийн төсөлд тусгуулахаар аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

5.7.Аймаг, нийслэлийн Засаг дарга иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж, орон нутгийн төсөвт тусгасан санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, түншлэлийн гэрээнд заасны дагуу олгоно.

Зургаа.Түншлэлийн төслийн тайлагналт

6.1.Хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн төслийн хэрэгжилт, үр дүнгийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, түншлэлийн гэрээний биелэлт, гүйцэтгэлийн үнэлгээг улирал тутам үнэн зөв, бодитой гаргаж аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлж, тайлагнана.

6.2.Хувийн хэвшлийн түншлэгч нь түншлэлийн гэрээний хугацаанд санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасны дагуу үнэн зөв бүртгэн тайлагнаж, хөндлөнгийн хараат бус аудитын байгууллагаар аудит хийлгэн, аймаг, нийслэлийн Засаг даргад жил бүрийн 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор хүргүүлнэ.

6.3.Хувийн хэвшлийн түншлэгч нь аймаг, нийслэлийн Засаг дарга болон холбогдох бусад байгууллага Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай тайлан, мэдээллээр тогтоосон хугацаанд хангаж, үнэн зөв, найдвартай байдлыг хариуцна.

6.4.Хувийн хэвшлийн түншлэгч нь жил бүрийн 2 дугаар сард багтаан түншлэлийн төслийн хүрээнд тухайн жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан аймаг, нийслэлийн Засаг даргад хянан баталгаажуулахаар хүргүүлнэ.

6.5.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь түншлэлийн төслийн хэрэгжилт, түншлэлийн гэрээний биелэлтийг үнэлж, холбогдох мэдээллийг тусгасан тайланг бэлтгэж жил бүрийн 04 дүгээр сарын 10-ны өдрийн дотор түншлэлийн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

6.6.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь түншлэлийн гэрээ цуцлагдсанаас хойш 7 хоногийн дотор түншлэлийн төслийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, мэдээллийг түншлэлийн, санхүү, төсвийн болон тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

6.7.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь түншлэлийн төслийн хэрэгжилт, үр дүн, түншлэлийн гэрээний биелэлтийг орон нутгийн төсвийн гүйцэтгэлтэй хамт аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

Долоо.Түншлэлийн төсөлд хяналт тавих

7.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга түншлэлийн төсөлд хяналт тавих чиглэлээр дараах хяналт, арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

7.1.1.хувийн хэвшлийн түншлэгчээс тайлан, мэдээг гаргуулан авч, гэрээний биелэлтэд хяналт тавих;

7.1.2.түншлэлийн төслийн хяналтыг хэрэгжүүлэхдээ аймаг, нийслэлийн харьяа байгууллага, хяналтын чиг үүрэг бүхий бусад байгууллага, мэргэжлийн холбоод, мэргэшсэн инженер, зөвлөх, мэргэжлийн зөвлөх компанийг татан оролцуулах;

7.1.3.түншлэлийн төслийн хэрэгжилттэй газар дээр нь жилд нэгээс доошгүй удаа очиж танилцах;

7.1.4.төсөл, хөтөлбөрт хяналт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагатай хяналтын зөвлөхийн гэрээг байгуулан хамтран ажиллах;

7.1.5.хувийн хэвшлийн түншлэгчийн түншлэлийн төсөл хэрэгжүүлэх санал ирүүлэх үед тооцоолж байсан төслийн орлого нь тооцоолсон хэмжээндээ хүрч буй эсэх болон төслийн барилга угсралт дууссанаас хойш төслийн гүйцэтгэлд 3-5 жил тутамд үнэлгээ хийж, холбогдох санал, дүгнэлтийг гаргах;

7.1.6.түншлэлийн төслийн хэрэгжилт, түүний санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв тайлагнасан эсэхийг нягтлан шалгах, энэ хүрээнд төрийн аудитын байгууллага, олон улсын болон дотоодын аудитын байгууллага, хөндлөнгийн хараат бус зөвлөх компанийг татан оролцуулах.

7.2.Энэ журмын 7.1.4-т заасны дагуу гэрээ байгуулж хамтран ажиллах хяналтын зөвлөх нь түншлэлийн төсөлд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

7.2.1.түншлэлийн төслийн хэрэгжилтэд мэргэжлийн түвшинд хяналт тавьж, зөвлөх үйлчилгээ үзүүлэн, төслийн хэрэгжилтийн явц, чанар байдлын талаар тайлагнаж, тайлангийн үнэн зөв, бодит байдлыг бүрэн хариуцах;

7.2.2.түншлэлийн төслийн зураг төсөл, техникийн үзүүлэлт, үзүүлэх ажил үйлчилгээнд өөрчлөлт оруулах, сайжруулах санал гаргаж болох бөгөөд саналыг түншлэлийн талууд харилцан зөвшилцөж шийдвэрлэх.

7.3.Хувийн хэвшлийн түншлэгч нь төрийн түншлэгч, төрийн аудитын байгууллага болон холбогдох бусад байгууллагаас хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд түншлэлийн төслийн хэрэгжилттэй газар дээр нь танилцах, хяналт тавихад хамтран ажиллаж, төслийн хэрэгжилттэй холбоотой шаардсан бүх мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж танилцуулна.

7.4.Төрийн аудитын байгууллага Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хэрэгжилт, түншлэлийн төслийн төлөвлөлт, хувийн хэвшлийн түншлэгчийн сонгон шалгаруулалт, түншлэлийн төслийн хэрэгжилт болон гэрээний биелэлтэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, аудитын тайланг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

7.5.Хуульд заасны дагуу түншлэлийн, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн болон салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хяналт хэрэгжүүлэх эрх бүхий

бусад байгууллага түншлэлийн төсөлд хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд хяналт тавьж, үр дүнг аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэн хамтран ажиллана.

7.6.Төрийн түншлэгч нь холбогдох хууль болон энэ журамд заасны дагуу түншлэлийн төслийн хэрэгжилтэд хяналт хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг дараах эх үүсвэрээс санхүүжүүлж болно:

7.6.1.аймаг, нийслэлийн төсвийн хөрөнгө;

7.6.2.аймаг, нийслэлийн холбогдох сангийн эх үүсвэр;

7.6.3.түншлэлийн гэрээнд заасан тохиолдолд хувийн хэвшлийн түншлэгчээс;

7.6.4.хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр.

7.7.Энэ журмын 7.1-д заасан хяналт шалгалтаар хувийн хэвшлийн түншлэгч санхүүгийн тайланг алдаатай тайлагнасан нь тогтоогдвол тус хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг хувийн хэвшлийн түншлэгч хариуцах бөгөөд уг асуудлыг түншлэлийн гэрээгээр нарийвчлан зохицуулна.

7.8.Хувийн хэвшлийн түншлэгч энэ журмын 7.7-д заасан алдаатай тайланг засварлаж, шинэчилсэн тайланг аймаг, нийслэлийн Засаг даргад дахин хүргүүлнэ.

Найм.Бусад

8.1.Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж, түншлэлийн гэрээгээр хориглосноос бусад түншлэлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл, бүртгэл, тайланг түншлэлийн мэдээллийн нэгдсэн санд байршуулах арга хэмжээ авч, холбогдох цахим хуудсанд олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлнэ.

8.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шаардсан түншлэлтэй холбоотой мэдээллийг тухай бүр хүргүүлж тайлагнана.

-----oOo-----

ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН
ТҮНШЛЭЛИЙН ХУУЛЬ
ХУУЛЬ ТОГТООМЖИЙН
ЭМХЭТГЭЛ

